

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс

ХҮНИЙ ЭРХ

Онол, арга зүйн сэтгүүл

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

“Хүний эрх, эрх чөлөөг орон даяар,
цаг ямагт, хүн бүрт”

(23 дахь жилдээ)

2024/02

Дугаарыг эрхлэн гаргасан:

Б.Энхболд	Ерөнхий редактор Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Хууль зүйн ухааны доктор, дэд профессор
Х.Цэцгээ	Нарийн бичгийн дарга Хүний эрхийн Үндэсний Комиссын Хүний эрхийн боловсролын хэлтсийн дарга

Сэтгүүлд нийтлэгдсэн бүтээл нь
Хүний эрхийн Үндэсний Комиссын бодлогыг илэрхийлэхгүй,
зөвхөн зохиогчийн үзэл бодол болно.

АГУУЛГА

ӨГҮҮЛЭЛ, НИЙТЛЭЛ

Г.Агар-Эрдэнэ Жендэр ба Үндсэн хууль: Хэлбэрийн тэгш байдлаас агуулгын тэгш байдлыг эрхэмлэх нь.....	5
С.Эрдэнэболор, О.Хишигмөнх Шаардлагад нийцсэн орон байртай байх эрх: Эзэмшлийн аюулгүй байдал, соёлын онцлогт нийцсэн байх шаардлага Алсын хараа 2050-д тусгагдсан байдалд хийсэн дүн шинжилгээ	16
М.Хатанзориг Хувийн халдашгүй байх эрхийн орчин үеийн үзэл баримтлал	31
Я.Цэцэнзаяа, Э.Сундуй Иргэний үл захирагдахуйг хүлээн зөвшөөрч, эрх зүйн орчинг бүрдүүлэх хэрэгцээ шаардлага	47
С.Номынбаясгалан Худал мэдээлэл тараах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтын асуудал.....	63
О.Хишигмөнх, Г.Гантөмөр Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдэд хэрэглэх албадан сургалтын мөн чанар, онцлог.....	101
Фернанда Пирие Эрх зүйн антропологи. Легализм.....	118

МОНГОЛ ХЭЛЭЭР ЗӨВХӨН МАНАЙ ХУУДАСНАА

ЗОЧНЫ ЯРИЛЦЛАГА

Г.Золжаргал Өнөөдөр та бусдын хувийн амьдрал руу өнгийж, хувийн нууцыг дэлгэж байгаа бол маргааш таны хувийн орон зайд хэн нэгэн халдана гэсэн үг.....	142
---	-----

CONTENT

ARTICLES

Agar-Erdene. G
Gender and the Constitution: Prioritizing substantive equality over formal equality 5

Erdenebolor. S., Khishigmunkh.O
The right to have a suitable accommodation: an analysis of the security of ownership and cultural compliance requirements as outlined in vision 2050 16

Khatanzorig.M
Contemporary conception of right to privacy 31

Tsetsenzaya.Ya., Sundui.E
The need to create a legal environment that accepts civil disobedience 47

Nomiinbayasgalan. S
Legal issues on the regulation of Misinformation crime 63

Khishigmunkh.O., G.Gantumur
The essence and features of enforced training on legal persons that committed crimes and criminal actions 101

ONLY IN MONGOLIAN

Fernanda Pirie
The Anthropology of Law 118

GUEST INTERVIEW

Zoljargal. G
If you invade you private space of others and reveal their personal information today, it means your private space could be invaded tomorrow 142



Г. АГАР-ЭРДЭНЭ

Хуульч, докторант

ЖЕНДЭР БА ҮНДСЭН ХУУЛЬ: ХЭЛБЭРИЙН ТЭГШ БАЙДЛААС АГУУЛГЫН ТЭГШ БАЙДЛЫГ ЭРХЭМЛЭХ НЬ

GENDER AND THE CONSTITUTION: PRIORITIZING SUBSTANTIVE EQUALITY OVER FORMAL EQUALITY

Хураангуй: Энэхүү өгүүллээр жендэрийн тэгш байдлыг хангахад Үндсэн хууль чухал үүрэг гүйцэтгэдэг талаар авч үзнэ. Хуулиар хэлбэрийн буюу формаль тэгш байдлыг баталгаажуулах нь зайлшгүй боловч жендэрийн тэгш байдлыг хангахад учирч буй бүтцийн болон нийгмийн саад бэрхшээлийг шийдвэрлэхэд агуулгын буюу субстантив тэгш байдал мөн адил чухал юм. Ингэснээр Үндсэн хуулийн заалтуудад агуулгын тэгш байдлыг эрхэмлэхийг санал болгож, эерэг арга хэмжээ авах, хувьсан өөрчлөгдөх хэрэгцээ шаардлага буйг өгүүлэх болно. Үндсэн хуулиуд нь агуулгын тэгш байдлыг эрхэмлэснээр жендэрийн шударга ёсыг хөхиүлэн дэмжиж, тэгш нийгмийг бий болгож чадах юм.

Abstract: This article delves into the critical role of constitutions in advancing gender equality. It argues that while formal equality, which guarantees equal treatment under the law, is a necessary foundation, substantive equality, which addresses the underlying structural and societal barriers to gender equality, is equally essential. It proposes a framework for prioritizing substantive equality in constitutional provisions, emphasizing the need for affirmative action measures,

intersectional approaches, and a focus on transformative change. By prioritizing substantive equality, constitutions can effectively promote gender justice and create a more equitable society.

Түлхүүр үг: Үндсэн хууль, жендэрийн эрх тэгш байдал, хэлбэрийн тэгш байдал, агуулгын тэгш байдал

Keywords: Constitution, gender equality, formal equality, substantive equality;

I. УДИРТГАЛ

Үндсэн хуулийг тухайн улс орны эрх зүйн тогтолцооны дээд эрэмбийн баримт бичиг талаас нь төдийгүй нийгэм, эдийн засаг, соёл, уламжлал, зан заншлын зэрэг олон өнцгөөс чанар, агуулгын хувьд судлах болоод уджээ. Нэрт эрдэмтэн Б.Чимид “Үндсэн хууль бол алганд багтсан Монгол Улс юм” хэмээсэн нь Үндсэн хууль нь улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхэт байдал, төрийн байгууллыг бэхжүүлж төр, иргэний харилцааг зохицуулаад зогсохгүй нийгэм, эдийн засгийн амьдрал, иргэд хоорондын харилцааны агуулгыг үндэс сууриар нь тодорхойлдог болохыг дахин нэг сануулсан хэрэг юм.

Сүүлийн үед олон улсад Үндсэн хууль боловсруулах үйл явц, Үндсэн хуулийн загварчлалыг жендэрийн нүдээр харах явдал өсөн нэмэгдэж байна. Энэ агуулгаар Үндсэн хууль болон Үндсэн хуулийн төсөл боловсруулах үйл явцыг жендэрийн нүдээр харах, судлан шинжлэх, үнэлж дүгнэх хандлага эрчимтэй хөгжин хууль зүйн шинжлэх ухаанд Жендэр ба Үндсэн хууль (Gender and the Constitution) гэсэн шинэ судлагдахуун бий болжээ. Жендэр ба Үндсэн хуулийн хүрээнд улс орнуудын Үндсэн хуулийн зохицуулалт, тэдгээрийн жендэрийн эрх тэгш байдлыг бүрдүүлэхэд гүйцэтгэж буй үүрэг, үзүүлж буй нөлөөлөл, уялдаа холбоо зэргийг нарийвчлан авч үздэг байна.

II. ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫН ЗАРЧМЫГ ҮНДСЭН ХУУЛЬД ТУСГАХЫН АЧ ХОЛБОГДОЛ

Жендэр ба Үндсэн хуулийн судлагдахуун нь Үндсэн хуулийн текстийг жендэрийн чиг хандлагаар судалдаг ба ялангуяа ардчилал урт хугацаанд хөгжсөн улс орнуудын Үндсэн хуулийг, ардчиллыг шинээр сэргээн тогтоосон улс орнуудын Үндсэн хуультай харьцуулан судалж, жендэр ба Үндсэн хуулийн мөн чанарын уялдаа, холбоог судлан шинжлэх нь нэмэгдэж байна. Энэ төрлийн судалгаанууд нь Үндсэн хууль ямар зорилготой, юуны тулд оршин байдаг талаарх уламжлалт ойлголтод шинэ салхи оруулж байгаа талаар Австралийн Сиднейн их сургуулийн Эмерит профессор, Үндсэн хуулийн эрх зүй судлаач Элен Ирвинг хөндсөн байдаг¹.

Үүнийг дэлгэрүүлэн авч үзэхийн өмнө жендэрийн эрх тэгш байдал гэж юу

болох, ямар ач холбогдолтойг дурдах нь зүйтэй. Зарим үед жендэрийн эрх тэгш байдлыг зөвхөн эмэгтэйчүүдэд хамаатай асуудал гэж ташаа ойлгохоос гадна эмэгтэйчүүдийн эрх мэдэлд хүрэх гэсэн арга зам гэж тайлбарлах нь ч сонсогддог. Угтаа эрэгтэй, эмэгтэй хүн бүр нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын болон бусад харилцаанд эрх тэгш оролцох, бие даан шийдвэр гаргах, аливаа ялгаварлал, гадуурхлаас ангид байх учиртай ч хэвшиж тогтсон хэвшмэл хандлага, зан заншил, шашин шүтлэг, тухайн нийгмийн хөгжлийн хүрсэн түвшин зэргээс шалтгаалаад нийгэм, гэр бүлийн харилцаанд эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг нь ялгаатай болно. Энэ ялгаа нь хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх, тэгш бус байдал газар авах, шийдвэр гаргах үйл явц зөвхөн нэг хүйсийн мэдэлд орох зэрэг тоочихын аргагүй үр дагавар дагуулдагийг түүхийн жишээ сургамжаар нотолж болно. Улмаар жендэрийн эрх тэгш байдал нь тухайн улс орны төр засгийн хүлээн зөвшөөрөгдөх байдал буюу легитим шинжийн чухал эх сурвалж болдогийг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга онцлон тэмдэглэж байв.

Үндсэн хуульд тухайн улсын үнэт зүйл, түүх, соёл, алсын хараа, зорилгыг тусган бэхжүүлдэг учир жендэрийн эрх тэгш байдлыг түүгээр баталгаажуулах нь нэн чухал. Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч агсан, төр, нийгмийн зүтгэлтэн Нелсон Мандела “эмэгтэйчүүдэд чиглэсэн аливаа хавчлага, дарамтаас ангижрахгүйгээр эрх чөлөөний тухай санахын ч хэрэггүй гэдгийг төр засгийн бүх түвшинд нэг мөр ойлгож ухамсарлах нь тун чухал”² гэж тэмдэглэжээ. Ийм нэг мөр ойлголт, төлөвшил, зөвшилцлийг бүрдүүлэх хамгийн үр дүнтэй арга зам нь Үндсэн хууль юм.

Энэ талаар НҮБ-ын Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай 1979 оны конвенцод тун тодорхой зааж өгсөн. Уг конвенцын 2 дугаар зүйлийн (а) хэсэгт “эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхийн зарчмыг үндэсний Үндсэн хуульдаа буюу зохих бусад хууль тогтоомждоо тусгаагүй бол ийнхүү тусгаж, энэ зарчмыг хууль болон бусад зохистой аргаар хэрэгжүүлэх” үүргийг конвенцын гишүүн улс орнуудад хүлээлгэжээ.

Улс орны дээд хууль болохын хувьд төрийн бүтцийг тодорхойлж, улс төрийн эрх мэдлийг хуваарилж, ард түмний эрхийг Үндсэн хууль хүлээн зөвшөөрч хамгаалдаг. Жендэрийн эрх тэгш байдал нь ардчилал, шударга нийгмийн тулгын чулуу гэж тооцогддог болсон тул Үндсэн хууль боловсруулах үйл явц нь эмэгтэйчүүд болон жендэрийн эрх тэгш байдлыг дэмжигчдэд ардчилсан засаглалыг бий болгоход оролцох, өнөөгийн сорилтод хариу өгөх, эмэгтэйчүүдийн улс төр, эдийн засаг, нийгмийн тэгш байдлыг хангах ирээдүйн хүсэл эрмэлзлийг илэрхийлэх онцгой боломж олгодог. Жендэрийн эрх тэгш байдал нь ардчиллын чанарт нөлөөлдөг тул Үндсэн хуулийн, эсхүл Үндсэн хуулийн төслийн үг хэллэг, заалтуудыг жендэрийн чиг хандлагын

¹ Irving, H. (2008). *Gender and the Constitution: Equity and Agency in Comparative Constitutional Design*. New York: Cambridge University Press

² Mandela, N. (1994). *President Mandela, State Of the Nation Address*, <https://www.sahistory.org.za/archive/1994president-mandela-state-nation-address-24-may-1994-after-national-elections>

үүднээс системтэй судлах нь чухал гэж үзэх болжээ.

Эдгээр үндсэн чиг үүргээс гадна Үндсэн хууль нь тухайн улсын үнэт зүйл, түүх, алсын хараа, ирээдүйн зорилгыг тусгасан байдаг. Үндсэн хууль нь бат бөх ардчилалд хүрэх замын зураглалыг харуулж чаддаг тул Үндсэн хуулийн шинэчлэл нь эмэгтэйчүүдийн эрхийн баталгаа, агуулгын тэгш байдлыг хамгаалж, дэмжих институци, үйл явцыг бий болгох замаар засаглалын үндсэн бүтцийг өөрчлөх онцгой боломж олгодог талаар жендэр ба Үндсэн хуулийн харилцан хамаарлыг судалдаг М.Аллен нарын эрдэмтэд судалгаандаа дурдсан байдаг³.

Үндсэн хууль нь зөвхөн төр, иргэний хоорондын харилцаанаас гадна хувь хүн, албан байгууллага, хуулийн этгээд хоорондын харилцааг зохицуулж байдаг тул улс төрийн амьдрал төдийгүй эдийн засаг, нийгмийн амьдралд эмэгтэйчүүдийн нөхцөлийг ахиулахад үндэсний хэмжээний үндэс суурь болохуйц үндсэн баримт бичиг юм. Ингэснээр Үндсэн хууль нь жендэрийн эрх тэгш байдлыг хангахад дор хаяж дөрвөн хэлбэрээр хувь нэмэр оруулдаг байна⁴.

Нэгдүгээрт, Үндсэн хуульд эрхээ тодорхой, хэрэгжүүлэх боломжтой хамгаалалт агуулсан, төрөөс эдгээр эрхийг хамгаалж, биелүүлэх үүрэг хүлээсэн, жендэрийн эрх тэгш байдлыг хангах төрийн үүрэг амлалтын хүчтэй илэрхийлэл болох заалтуудыг багтааж болно.

Хоёрдугаарт, Эмэгтэйчүүдийн эрх, тэгш байдлыг хүлээн зөвшөөрч, дэмжсэн заалтуудыг Үндсэн хуульд оруулах нь ард түмэнд, тэр дундаа жендэрийн эрх тэгш байдлын бодлогыг эсэргүүцэж болзошгүй бүлгийнхэнд үндэсний үнэт зүйлсийн талаарх хүчтэй дохио болж өгдөг.

Гуравдугаарт, Үндсэн хуулийг өөрчлөх нь энгийн хуулиас илүү төвөгтэй, улс төрчид, улс төрийн намуудын байнга өөрчлөгддөг бодлогод захирагддаггүй тул жендэрийн эрх тэгш байдлыг хамгаалах, дэмжих тусгай заалтуудыг Үндсэн хуульд оруулах нь ердийн хуулиас илүү үр дүнтэй байдаг.

Дөрөвдүгээрт, жендэрийн эрх тэгш байдлыг хангах Үндсэн хуулийн заалтууд нь хууль тогтоомж, гүйцэтгэх засаглалын бодлогын агуулгыг тодорхойлж, шүүхээс жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн эерэг шийдвэр гаргах боломжийг нэмэгдүүлдэг.

³ Allen, M., 'Women and constitution-building in 2014', *Annual Review of Constitution-Building Processes: 2014* (2015) pp. 17

⁴ Lambert, P. A. and Scribner, D. L., 'A Politics of difference versus a Politics of Equality: Do Constitutions Matter?', *Comparative Politics*, 41/3 (2009), pp. 337–57

III. ХЭЛБЭРИЙН ТЭГШ БАЙДЛААС АГУУЛГЫН ТЭГШ БАЙДЛЫГ ЭРХЭМЛЭХ НЬ

Энгийнээр тайлбарлавал дэлхийн улс орнуудын Үндсэн хуулиуд жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэхийг ерөнхийд нь хоёр ангилалд хуваан авч үзэж байна. Эхнийх нь формаль буюу хэлбэрийн тэгш байдал, хоёр дахь нь субстантив буюу агуулгын тэгш байдал юм.

Хэлбэрийн шинжтэй зохицуулалтад хүйсээр үл ялгаварлах, хүйсийн хувьд эрх тэгш байх зэрэг Үндсэн хуулийн ерөнхий заалтууд багтана. Эдгээр нь Үндсэн хуулийн бусад хэсэгтэй хамт хэрэгждэг онцлогтой. Тодруулбал, иргэний үг хэлэх, эвлэлдэн нэгдэх, итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх, халдашгүй байх зэрэг эрх, эрх чөлөө нь аль ч хүйсийн хувьд адил тэгш байна.

Дэлхийн 2-р дайнаас хойш боловсруулсан бараг бүх Үндсэн хуульд хэлбэрийн тэгш байдлыг хангасан үндсэн заалт болох хүйсийн тэгш байдал, ялгаварлан гадуурхахгүй байх заалтууд орсон байдаг. Гэсэн хэдий ч сүүлийн 20 жилийн хугацаанд бичигдсэн Үндсэн хуулиудад агуулгын тэгш байдлыг хүлээн зөвшөөрөх, хамгаалах, дэмжих зорилгоор жендэрийн онцлогтой заалтууд, жендэрийн оролцоог хангасан төсөл боловсруулах хэв маяг орсон байна.

Хэлбэрийн тэгш байдал нь шийдвэр гаргах орон зай, төлөөллийг олж авахад зайлшгүй шаардлагатай урьдчилсан нөхцөл боловч энэ нь хангалтгүй юм.

Сүүлийн хэдэн арван жилийн Үндсэн хуулийн шинэчлэлийн хамгийн чухал чиг хандлага бол бүх нийтийн оролцоотойгоор Үндсэн хуулийг бий болгох үйл явцад шилжих явдал болж байна. Үндсэн хуулийг бүтээх нь зөвхөн үндсэн хуулийн эрх зүйчид, өндөр түвшний улс төрчдөд зориулагдсан зүйл биш, бүх иргэд Үндсэн хууль бүтээх үйл явцад оролцож, түүнд юу багтаж болох талаар саналаа хэлэх эрхтэй гэж үзэх болсон.

Хэлбэрийн тэгш байдал нь хуулийн өмнө эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд тэгш хандах үндсэн зарчим юм. Энэ төрлийн тэгш байдлыг Үндсэн хуулиудад (а) хүйсээр ялгаварлан гадуурхахыг хориглох (ялгаварлан гадуурхахгүй байх заалт), (б) эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд эрх тэгш байх (тэгш байдлын заалт) заалтуудаар тусгасан байдаг. Хэлбэрийн тэгш байдал нь үг хэлэх эрх чөлөө, зохих журмын дагуу (шударга, тэгш эрх зүйн журам) зэрэг олон эрхийг хэрэгжүүлэх хүрээнд чухал ач холбогдолтой юм. Жишээлбэл, хэрэв хүн гэмт хэрэг үйлдсэн гэж буруутгагдвал хүйс харгалзахгүйгээр шударга шүүхээр шүүлгэх эрхтэй.

Гэвч ийм хэлбэрийн шинжтэй зохицуулалтууд зарим талаараа жендэрийн эрх тэгш байдлыг бүрэн дүүрэн хангаж чаддаггүй гэж үздэг. Тодруулбал, анхнаасаа адил тэгш гараанаас эхэлж чадаагүй бол хэлбэрийн хувьд эрх тэгш байх зохицуулалт байлаа ч үр дүн ялгаагүй тэгш бус байх тул түүнийг ахиулсан зохицуулалт шаардлагатай гэж тайлбарладаг.

Агуулгын тэгш байдал нь хэлбэрийн тэгш байдлаас хальж, өнгөрсөн үеийн ялгаварлан гадуурхалт, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд боломжоо олж авах, эрхээ хэрэгжүүлэх, амьдралдаа нөлөөлөх шийдвэр гаргахад нь тулгарч буй улс төр, эдийн засаг, нийгмийн саад бэрхшээлийг хүлээн зөвшөөрдөг. Мөн агуулгын тэгш байдал нь эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн чадавхиас шалтгаалж эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хоорондын ялгааг хүлээн зөвшөөрдөг. Агуулгын тэгш байдал нь эмэгтэйчүүдийн амьдарч буй бодит байдлыг харгалзан үзэх замаар боломж бүгдэд хүртээмжтэй байх, үр дүнгийн тэгш байдлыг хангах зорилготой бөгөөд ингэснээр тэгш байдлын тухай илүү өргөн хүрээтэй ойлголт болж өгдөг юм.

Агуулгын тэгш байдлыг боломж тэгш байх, үр дүн тэгш байх, нэр төрийн хувьд тэгш байх гэх мэт нэг утгаар холбохоор оролдохын оронд харилцан бие биенээ нөхдөг дөрвөн талт хэмжүүрийн хүрээнд тайлбарлагддаг, олон талт ойлголт гэж ойлгох хэрэгтэй гэж С.Фридман үзсэн байдаг. Ингэхдээ тэрээр дөрвөн талт хэмжүүрийг: сул талыг арилгах (дахин хуваарилах хэмжүүр); гутаан доромжлол, хэвшмэл ойлголт, өрөөсгөл үзэл, хүчирхийллийг шийдвэрлэх (хүлээн зөвшөөрөгдэх хэмжүүр); оролцоог хөнгөвчлөх (оролцооны хэмжүүр); бүтцийн өөрчлөлтөөр дамжуулан ялгаатай байдалд дасан зохицох (хувирган өөрчлөгч хэмжүүр) хэмээн тодорхойлжээ.⁵

Үндсэндээ агуулгын шинжтэй зохицуулалтын хувьд дээрх ялгааг анхаарч, эмэгтэйчүүдийн аж амьдрал, эрх, эрх чөлөө, нийгмийн амьдралд оролцоо боломж, бололцоог нь хязгаарладаг улс төр, нийгэм, эдийн засгийн шинжтэй олон саад бэрхшээлийг арилгаж, “гарааны тэгш байдал” бүрдүүлэхэд чиглэдэг бөгөөд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг хориглох, ялгаварлахгүй байх, улсын болон орон нутгийн түвшний тодорхой албан тушаалд жендэрийн квот тогтоох зэрэг олон төрөл, хэлбэр бий.

НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллага Олон улсын хуульчдын холбооны Хүний эрхийн институт (IBAHRI), Шведийн олон улсын хөгжлийн агентлаг (SIDA)-тай хамтран дэлхийн 194 улсын Үндсэн хуулийн холбогдох зохицуулалтыг харьцуулан судалжээ⁶. Уг судалгаанд дурдсанаар хүн бүр эрх тэгш байх, ялгаварлан гадуурхагдахгүй байх (98 хувь), хүчирхийлэл, дарамтаас ангид байх (94 хувь), сурч боловсрох (86 хувь), жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн бодлогын шийдмэг арга хэмжээ авах (44 хувь), эмэгтэйчүүдийн тодорхой эрхийн талаарх тусгайлсан заалт (12 хувь), улсын түвшний тодорхой албан тушаалын квот тогтоосон (10 хувь), орон нутгийн түвшний тодорхой албан тушаалын квот тогтоосон (6 хувь) заалтуудыг тусгасан байна.

⁵ Fredman, S, *Emerging from the Shadows: Substantive Equality and Article 14 of the European Convention on Human Rights*, (2016) Human Rights Law Review, 2016, 0, 10p

⁶ Global Gender Equality Constitutional Database <https://constitutions.unwomen.org/en>

Жишээлбэл, Эквадор Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Бүх хүмүүс адил тэгш эрх, үүрэг, боломжийг эдэлнэ. Хэнийг ч үндэс угсаа, төрсөн газар, нас, хүйс, соёлын онцлог, иргэний байдал, хэл, шашин шүтлэг, үзэл суртал, улс төрийн харьяалал, хууль эрх зүйн бүртгэл, нийгэм-эдийн засгийн байдал, шилжилт хөдөлгөөний байдал, бэлгийн чиг баримжаа, эрүүл мэндийн байдал, ХДХВ-ийн халдвар тээгч, хөгжлийн бэрхшээл, бие махбодийн ялгаа, эсхүл эрхээ хүлээн зөвшөөрөх, эдлэх, хэрэгжүүлэхийг хязгаарлах, хүчингүй болгоход чиглэсэн, эсхүл ийм үр дүнд хүргэж болзошгүй түр зуурын, эсхүл байнгын шинжтэй байдлаар ялгаварлан гадуурхаж болохгүй. Ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг хуулиар шийтгэнэ. Төр нь тэгш бус байдалд байгаа эрх эдлэгчдийн эрх ашгийн төлөө тэгш байдлыг дэмжих эерэг, бодитой арга хэмжээ авна.” гэж заасан⁷. Үүнийг харьцангуй жендэрийн мэдрэмжтэй буюу агуулгын тэгш байдалд ойртсон заалт гэж үзэж болох юм.

Зарим Үндсэн хуулиудад төрөөс жендэрийн эрх тэгш байдлыг хангах амлалтыг илэрхийлж, үндэсний үнэт зүйлс болгон шууд тодорхойлсон байдаг. Үүнийг шүүх шууд хэрэглэх боломжгүй байж болох ч энэ нь олон нийтийн дунд хүчтэй итгэл үнэмшлийг бий болгодог. Шүүхээс Үндсэн хууль, хууль тогтоомжийг тайлбарлахдаа агуулгын тэгш байдлыг илэрхийлсэн үндэсний үнэт зүйлсийн зарчмыг ашиглах боломжтой байдаг.

Тухайлбал, Гаитийн Үндсэн хуулийн оршил хэсэгт “Гаитийн ард түмэн бид... хүний үндсэн эрх, эрх чөлөөг хүндэтгэх, нийгмийн амгалан тайван байдал, эдийн засгийн тэгш байдал, хүйсийн тэгш байдал, хамтын үйл ажиллагаа, үндэсний амьдралыг хамарсан томоохон шийдвэр гаргахад төвлөрлийг үр дүнтэй сааруулах замаар нийт хүн амын оролцоонд суурилсан төрийн дэглэмийг бий болгох; хүйсийн тэгш байдалд нийцсэн байдлаар эрх мэдэлд хүрэх, шийдвэр гаргах үйл явцад эмэгтэйчүүдийн төлөөллийг хангахын тулд энэхүү Үндсэн хуулийг тунхаглаж байна.” гэж заасан⁸.

Мөн Замбийн Үндсэн хуулийн оршил хэсэгт “Замбийн ард түмэн бид ... улс төр, эдийн засаг, нийгмийн тогтолцоог өөрсдөө чөлөөтэй сонгож тодорхойлох эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн оролцооны эрх тэгш үнэлэмжийг хүлээн зөвшөөрч... энэхүү Үндсэн хуулиа тунхаглан зарлаж байна” гэсэн нь бий.

Эдгээрээс гадна шийдвэр гаргах түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн зохицуулалтын жишээг авч үзье. Эмэгтэйчүүдийн хувьд шийдвэр гаргах түвшний албан тушаалд томилогдон ажиллахын тулд хүүхэд төрүүлэх, өсгөн хүмүүжүүлэх, сурч боловсрох, тэдний талаар нийгэмд тогтсон хэвшмэл хандлагыг тэсвэрлэх, даван туулах зэргээр эрэгтэйчүүдийн өмнө тэр бүр тулгардаггүй олон саад бэрхшээлийг туулж гарах шаардлагатай болдог тул энэ төрлийн зохицуулалтыг хууль тогтоомжид тухайлан тусгаж өгдөг.

⁷ The Constitute Project (2024), https://www.constituteproject.org/constitution/Ecuador_2021

⁸ The Constitute Project (2024), https://www.constituteproject.org/constitution/Haiti_2012

Одоогийн байдлаар Афганистан, Балба, Бельги, Бурунди, Бангладеш, Мексик, Гайти, Египет, Замби, Кени, Никарагуа, Папуа Шинэ Гвиней, Руанда, Филлиппин, Танзани, Уганда, Өмнөд Судан, Самоа, Серби, Судан, Танзани, Ирак, Тунис зэрэг улсын Үндсэн хуульд хууль тогтоох дээд байгууллага буюу парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөллийн квотын талаар заажээ. Эдгээрийн дотор ардчиллыг урт хугацаанд төлөвшүүлэн хөгжүүлсэн цөөн улсаас гадна саяхныг хүртэл зөрчил мөргөлдөөнтэй, эсхүл колоничлолд байсан, шинэ тутам Үндсэн хуулиа баталсан улсууд дийлэнх байгаа нь анхаарал татдаг бөгөөд энэ нь он удаан жил үргэлжилсэн зөрчил тэмцэл, хямрал, дарангуйлал зэргийн дараа шийдвэр гаргах албан тушаалд эмэгтэйчүүд сонгогдож, улмаар шинэ Үндсэн хуулийн төсөл боловсруулах үйл явцад эмэгтэйчүүдийн дуу хоолой, оролцоог өргөн хүрээнд хангасантай холбоотой гэж тайлбарладаг.⁹

Олон улсын парламентын холбооноос гаргасан 2023 оны статистик мэдээгээр дэлхийн улсуудын парламентын гишүүдийн 26.9 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.¹⁰ Үүнийг 20 гаруй жилийн өмнөхтэй харьцуулбал хоёр дахин нэмэгдсэн үзүүлэлт боловч энэ явцаар явбал хүйсийн хувьд эн тэнцүү төлөөлөл бүрдсэн парламентуудтай болох хүртэл дахиад 60 жил шаардлагатайг мөн уг тайланд дурджээ.

Энэ мэтээр улс орнуудын Үндсэн хуулийн текст, зүйл, хэсэг, заалт бүрийг жендэрийн үүднээс судалж болно. Эндээс сонирхолтой үр дүн гарах боломжтой юм.

IV. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ ДАХЬ ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫН ЗОХИЦУУЛАЛТ

Монгол Улсын хувьд Үндсэн хуулийн Хүний эрх, эрх чөлөө гэсэн хоёрдугаар бүлэгт хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, хүнийг нас, хүйс зэргээр ялгаварлан гадуурхахгүй байх зэрэг суурь зохицуулалтыг тусгасан нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах үүднээс авч үзвэл **хэлбэрийн шинжтэй зохицуулалтад** тооцогдоно. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.” гэж тодорхойлсон. Энэ бол харьцангуй хэлбэрийн тэгш байдлын заалт юм.

Цаашлаад Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай бие даасан хуулийг баталж мөрдүүлсний зэрэгцээ жендэрийн эрх тэгш байдлыг хангах, жендэрт

⁹ UN Women, Why and How Constitutions Matter (Policy Brief), p.2, <https://www.unwomen.org/sites/default/files/Headquarters/Attachments/Sections/Library/Publications/2017/Whyand-How-Constitutions-Matter-en.pdf>

¹⁰ The Inter-Parliamentary Union, Women in Parliament in 2023: The year in review, p.2, <https://www.ipu.org/resources/publications/reports/2024-03/women-in-parliament-2023>

суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх талаар олон улсын цөөнгүй гэрээ, конвенцод нэгдэн орж соёрхон баталсан. Үндсэн хууль болон олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой цөөнгүй арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлсний үр дүнд тодорхой ахиц дэвшил гарсныг тэмдэглэх нь зүйн хэрэг боловч цаашид анхаарч шийдвэрлэх шаардлагатай асуудал цөөнгүй байна.

Дэлхийн эдийн засгийн форумын “Жендэрийн ялгаатай байдлын тайлан”-д улс орнуудын жендэрийн ялгаатай байдлыг эдийн засгийн оролцоо болон боломж, боловсролын түвшин, эрүүл мэнд, улс төрийн эрх мэдэл зэрэг дөрвөн үзүүлэлтээр хэмждэг. Монгол Улсын хувьд 2024 онд нийт 146 улсаас 85 дугаарт орсон бөгөөд эдийн засгийн оролцооны үзүүлэлтээр 43 дугаарт, боловсролын түвшин, хүрэлцээтэй байдлын үзүүлэлтээр 1 дүгээрт, эрүүл мэндийн үзүүлэлтээр 1 дүгээрт эрэмбэлэгдсэн бол улс төрийн эрх мэдлийн үзүүлэлтээр 120 дугаарт оржээ.¹¹ Улс төрийн эрх мэдлийн үзүүлэлтийн хувьд парламент дахь эмэгтэй гишүүдийн эзлэх хувь, сайдын албан тушаалд эзлэх эмэгтэйчүүдийн хувь, төрийн тэргүүний албан тушаалыг эрэгтэй/эмэгтэй хүйсийн хүн хашиж байсан хугацаа гэсэн гурван дэд үзүүлэлтээр хэмждэг. Эдгээрийг дэлгэрүүлбэл, парламент дахь эмэгтэй гишүүдийн эзлэх хувиар 108 дугаарт, сайдын албан тушаал хашиж буй эмэгтэйчүүдийн эзлэх хувиар 112 дугаарт, төрийн тэргүүний албан тушаалын хугацааны хувьд 76 дугаарт тус тус эрэмбэлэгдсэн нь голлон нөлөөлжээ.⁶ Монгол Улсын хувьд “Жендэрийн ялгаатай байдлын тайлан”-д үнэлэгдэж буй байр жил тутам ухарч байгаад (2022 онд 70 дугаарт, 2023 онд 80 дугаарт гэх мэт) дүгнэлт хийх шаардлагатай юм.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос гаргасан Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын талаарх илтгэлд улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхээр Үндсэн хууль болон бусад хуульд жендэрийн эрх тэгш байдлын зарчим, квотыг тусгаж, эмэгтэйчүүдийг дэмжихэд чиглэсэн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үр нөлөөтэй тогтолцоог бүрдүүлэх зэргээр үе шаттай арга хэмжээ авч байгаа ч бүрэн хангагдахгүй хэвээр байгааг тэмдэглэжээ.¹²

Цаашлаад УИХ-ын гишүүдийн 17.1 хувь, сайд нарын 18.7 хувь, аймаг, нийслэлийн Засаг даргын 4.5 хувь, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга нарын 9 хувь нь эмэгтэйчүүд байгаа нь хангалтгүй үзүүлэлт бөгөөд нийт сонгогчдын 51 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлдэг боловч УИХ дахь тэдний төлөөлөл 17.3 хувь байгаа нь дэлхийн дунджаас 7.6 хувиар бага байгаа талаар дурдаж байв.¹³

¹¹ World Economic Forum, Global Gender Gap Report 2024, <https://www.weforum.org/publications/global-gender-gap-report-2024/> ⁶ Мөн тэнд.

¹² Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, 2023, 529 дэх тал.

¹³ Мөн тэнд 509 дэх тал.

Эндээс товч дүгнэж үзвэл Монгол Улсын Үндсэн хуулиар хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, хэнийг ч ялгаварлан гадуурхахгүй байх зэрэг жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн хэлбэрийн зохицуулалтууд боломжийн хэмжээнд бүрдсэн нь олон улсын нийтлэг жишигтэй нийцэж байгаа юм. Гэвч төлөөллийн ардчиллын зарчмын үүднээс авч үзвэл шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо хангалтгүй байна. Энэ байдал нь жендэрийн эрх тэгш байдлыг агуулгын хувьд хангахад чиглэсэн зохицуулалтыг Үндсэн хууль болон бусад хууль тогтоомждоо тусгах шаардлага тулгамдаж буйн илрэл гэж дүгнэж болно.

Монгол Улсын хувьд жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой тухайлсан зохицуулалтыг Үндсэн хуульдаа тусгах эсэхийг нийгэм, улс төр, хууль зүйн үүднээс иж бүрэн судлах, шинжлэх, шаардлагатай хууль тогтоомжийн өөрчлөлтийг хийх цаг нь болсон гэж үзэж болох юм. Ингэснээр жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль зүйн баталгаа бүрдэх төдийгүй Монгол Улс олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд тустай.

V. ДҮГНЭЛТ, САНАЛ

Өгүүлсэн бүхнээс товч дүгнэвэл, жендэрийн эрх тэгш байдлын ач холбогдлыг дэлхийн улс орнууд хэрхэн үнэлж, ямар түвшинд авч үзэж байгааг Үндсэн хуулиас нь харах боломжтой юм. Цаашлаад хэлбэрийн тэгш байдлаас илүүтэй агуулгын тэгш байдлыг илтгэсэн Үндсэн хуулийн зарчим, хэм хэмжээг шингээж өгсөн эсэхээр нь Үндсэн хуулиудыг судалж, тухайн улс орны ардчиллын чанарыг хэмжих боломжтой юм.

Тэр дундаа Монгол Улсын Үндсэн хуулийг жендэрийн үүднээс судалж, улмаар агуулгын тэгш байдлыг хангаснаар гарах үр дүнг тоймолбол, нэгдүгээрт, Үндсэн хуулиар тодорхой эрхийг хамгаалж, хэрэгжүүлэх баталгааг тогтоосноор жендэрийн эрх тэгш байдлыг хангах тодорхой үүрэг төрд ногдоно. Хоёрдугаарт, жендэрийн эрх тэгш байдал нь тодорхой хугацааны дараа улс орны үнэт зүйл болох бөгөөд түүнийг эсэргүүцэх, алдагдуулах бололцоог хязгаарлана. Гуравдугаарт, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журам нь ердийн хууль тогтоомжоос ялгаатай тул илүү үр дүнтэй, урт хугацаанд хэрэгжих бололцоотой. Дөрөвдүгээрт, эрх зүйн дээд эрэмбийн актад хуульчлагдсан учир жендэрийн эрх тэгш байдлыг хангах нь төрийн бодлогын нэг үндсэн агуулга болох учиртай юм.

VI. НОМ ЗҮЙ:

Монгол эх сурвалж:

1. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, 2023

Гадаад эх сурвалж:

1. Allen, M, *Women and constitution-building in 2014*, in Annual Review of Constitution-Building Processes: 2014 (2015)
 2. Fredman. S, *Emerging from the Shadows: Substantive Equality and Article 14 of the European Convention on Human Rights*, (2016) Human Rights Law Review, 2016, 0
 3. Global Gender Equality Constitutional Database <https://constitutions.unwomen.org/en>
 4. Irving, H. (2008). *Gender and the Constitution: Equity and Agency in Comparative Constitutional Design*. New York: Cambridge University Press
 5. Lambert, P. A. and Scribner, D. L., 'A Politics of difference versus a Politics of Equality: Do Constitutions Matter?', *Comparative Politics*, 41/3 (2009)
 6. Mandela, N, 1994 - President Mandela, State Of the Nation Address, <https://www.sahistory.org.za/archive/1994president-mandela-state-nation-address-24-may-1994-after-national-elections>
 7. The Constitute Project (2024), https://www.constituteproject.org/constitution/Ecuador_2021
 8. The Constitute Project (2024), https://www.constituteproject.org/constitution/Haiti_2012
 9. The Inter-Parliamentary Union, Women in Parliament in 2023: The year in review, <https://www.ipu.org/resources/publications/reports/2024-03/women-in-parliament-2023>
 10. UN Women, *Why and How Constitutions Matter* (Policy Brief), p.2, <https://www.unwomen.org/sites/default/files/Headquarters/Attachments/Sections/Library/Publications/2017/Whyand-How-Constitutions-Matter-en.pdf>
- World Economic Forum, Global Gender Gap Report 2024, <https://www.weforum.org/publications/global-gender-gap-report-2024/>



С.ЭРДЭНЭБОЛОР

Доктор, хуульч, өмгөөлөгч,
ОТИС, Хууль, эдийн засгийн
сургуулийн захирал



О.ХИШИГМӨНХ

ОТИС, Хууль, эдийн засгийн
сургуулийн хувийн эрх зүйн
тэнхимийн эрхлэгч, хуульч,
докторант

ШААРДЛАГАД НИЙЦСЭН ОРОН БАЙРТАЙ БАЙХ
ЭРХ: ЭЗЭМШЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, СОЁЛЫН
ОНЦЛОГТ НИЙЦСЭН БАЙХ ШААРДЛАГА АЛСЫН
ХАРАА 2050-Д ТУСГАГДСАН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН
ШИНЖИЛГЭЭ¹

THE RIGHT TO HAVE A SUITABLE ACCOMMODATION:
AN ANALYSIS OF THE SECURITY OF OWNERSHIP AND
CULTURAL COMPLIANCE REQUIREMENTS AS OUTLINED
IN VISION 2050

Хураангуй: Хууль тогтоомж нь бодлогын баримт бичигтээ нийцсэн байх нь улсын хөгжил болон хүний эрхийг хамгаалах, бэхжүүлэхтэй салшгүй холбоотой. Шаардлагад нийцсэн орон байртай байх эрх нь эзэмшлийн аюулгүй байдал, үйлчилгээ, материал, байгууламж, дэд бүтцийн хүртээмж, худалдан авч болохуйц байх, оршин суухад тохиромжтой байх, байрлал алслагдаагүй, эсүл орчны бохирдолгүй, соёлын онцлогт нийцсэн гэсэн шалгуурыг хангасан байхыг олон улсын эрх зүйгээр тодорхойлсон. Эдгээр шалгуурын ихэнх нь алсын хараа бодлогын баримт бичигт тодорхой хэмжээнд тусгалаа олж цаашид хэрэгжих боломжтой байна. Харин эзэмшлийн

¹ “УЛСЫН ЭРХ-110” эрдэм шинжилгээний хуралд шалгарсан бүтээл

аюулгүй байдал, соёлын онцлогт нийцсэн байх тухай асуудал алсын хараа урт хугацааны бодлогын баримт тусгагдсан байдал хангалтгүй байна. Иймд энэхүү сэдвийн хүрээнд дүн шинжилгээ хийх, сайжруулах боломжийг эрэлхийлэхийг зорилго.

Abstract: This is a related to ompliance of legislation with its policy documents is inextricably linked with the development of the state and the protection and strengthening of human rights. The right to adequate accommodation is defined by international law as security of ownership, availability of services, materials, facilities and infrastructure, affordability, convenience of residence, non-remoteness of accommodation, non-pollution of the environment and compliance with cultural characteristics. Most of these criteria are reflected in the vision policy document and can be implemented in the future. However, issues of security and cultural conformity are not reflected in the long-term policy evidence of the vision. Therefore, we aim to explore opportunities for analysis and improvement within this topic.

Түлхүүр үг: Хүний эрх, Бодлогын баримт бичиг, Өв уламжлал, Тогтвортой хөгжил, Албадан нүүлгэлт, Аюулгүй байдал

Keywords: Human Rights, Policy document, Heritage, Sustainable Development, Eviction, Safety

I. УДИРТГАЛ

Хөгжил дэвшил нь гарцаагүй зайлшгүй хэдий ч түүнд хүрэхийн тулд бид аюулгүй байдлаа хангахгүйгээр, хүний эрхийг хүндэтгэхгүйгээр хөгжилд хүрч чадахгүй. Хүн бүр Үндсэн хууль болон олон улсын гэрээгээр баталгаажсан амьд явах эрхтэй, үүнийг нь төрөөс баталгаатай эдлүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, холбогдох эрхүүдийг баталгаатай болгох нь төрийн үүрэг. Хүний амьд явах, аюулгүй байх, өмчтэй байх зэрэг эрхтэй салшгүй холбоотой эрх бол орон байртай байх эрх юм. Шаардлагад нийцсэн байх нь оршин суух газар, эд зүйл, ая тухын тухай асуудал бус гэр бүл, улс орон, шударга ёс, хүний нэр төрийг агуулсан хүний үндсэн эрх²ийн тухай асуудал юм. Нэг удаагийн илтгэлээр шаардлагад нийцсэн орон байртай байх наад захын 7 шаардлагыг хангасан эсэхийг судлах нь боломжгүй өргөн агуулгыг хамрах учраас сэдвийн хүрээнд “эзэмшлийн аюулгүй байдал, соёлын онцлогт нийцсэн эсэх асуудлыг Алсын хараа 2050 хэрхэн тусгасан” талаар авч үзсэн болно. Сэдвийг нийтэд хамааралтай, тулгамдсан асуудал ихтэй, нийгэм, эдийн засгийн хэрэгцээ шаардлагатай уялдах практик ач холбогдолтой гэж үзж сонгон авсан. Судалгааг гүйцэтгэхдээ эрх зүйн зохицуулалтыг түүхчлэх, харьцуулах, PDCA болон TOWS аргаар дүн шинжилгээ хийх, түүврийн аргаар судаллаа.

² Филиппины хүний эрхийн зүтгэлтэн Имелда Марксын хэлсэн үгнээс иш татав.

II. ШААРДЛАГАД НИЙЦСЭН ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХ БА АЛСЫН ХАРАА 2050

Шаардлагад нийцсэн орон байртай байх ухагдахууныг “аливаа хүн аюулгүй, амар амаглан, нэр төртэй амьдрах орчин юм³ гэж Нэгдсэн Үндэстний байгууллагын Эдийн Засаг, Нийгэм Соёлын эрхийн хорооноос тодорхойлсон.

Шаардлагад нийцсэн орон байртай байх эрх нь өөртөө албадан нүүлгэх болон орон байрыг хүч хэрэглэж нураах, эвдэх явдлаас хамгаалагдсан байх, орон байр, хувийн болон гэр бүлийн амьдралд нь хөндлөнгөөс дур мэдэн оролцох явдлаас ангид байх эрх, оршин суух болон амьдрах газраа сонгох, чөлөөтэй шилжин суурьших эрх гэсэн эрх чөлөөг агуулахын зэрэгцээ эзэмшлийн аюулын байдал, орон байр, газар болон эд хөрөнгийн нөхөн олговор, шаардлагад нийцсэн орон байртай байх эрхээ тэгш, аливаа ялгаварлалгүйгээр эдлэх, үндэстний болон орон нутгийн түвшинд орон байртай холбоотой шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох эрхийг тус тус илэрхийлдэг байна. Үүнээс үзэхэд энэхүү ойлголт нь хүний эрх, эрх чөлөөний олон агуулгыг өөртөө багтаасан, хүн бүрд хамааралтай хүний эрх юм. Орон байр гэдэгт хүний амьдарч буй орон сууц, гэр, урц, майхан, толгой хорогдох, богино, дунд, урт хугацаанд оршин сууж байгаа бүхий л объектуудыг хамааруулж ойлгоно⁴.

Шаардлагад нийцсэн орон байртай байх эрх нь:

- Эзэмшлийн аюулгүй байдал
- Үйлчилгээ, материал, байгууламж, дэд бүтцийн хүртээмж
- Худалдан авч болохуйц байх, оршин суухад тохиромжтой байх
- Байрлал алслагдаагүй, эсүл орчны бохирдолгүй
- Соёлын онцлогт нийцсэн гэсэн шалгуурыг хангасан байх шалгуурыг хангасан байна.

Эзэмшлийн аюулгүй байдал гэж албадан нүүлгэлт, хүчирхийлэл болон аливаа халдлагаас ангид байх талаарх оршин суугчдын эзэмшлийн аюулгүй байдлыг хуулиар хамгаалсан байх асуудал юм. Албадан нүүлгэлт нь ямар нэг урьдчилсан мэдэгдэл, хууль эрх зүйн хамгаалалт, хохирлын нөхөн олговоргүйгээр, тухайн хүмүүсийг хүсээгүй байхад нь орон байрнаас нь, эсвэл эзэмшиж буйн газраас нүүлгэх явдлыг хэлнэ⁵.

³ НҮБ-ын хүний эрхийн дээд комиссарын газар, НҮБ-ын ХАБИТАТ гаргасан Шаардлагад нийцсэн орон байртай байх эрх мэргэжлийн гарын авлага №21 шинэчилсэн товхимол Эмнести интернэшнл ТББ, Нээлттэй нийгэм форумаас орчуулан гаргасан гарын авлага УБ., 2019 х. 1 дэх тал

⁴ Орон байртай байх эрхийг дээр дурьдснаас гадна түрээсийн байр, нийтийн байр, хоргодох байр, албан бус сууринг хүртэл хамаарах заавал эзэмшигч, өмчлөгчид хамаарах ойлголт биш болохыг дурьдсан байдаг.

⁵ Эмнести интернэшнл ТББ “Үүргээ мэд” албадан нүүлгэхээс урьдчилан сэргийлэх гарын авлага УБ., 2012 х.5 дах тал

Соёлын онцлогт нийцсэн байхыг соёлын онцлогоо илэрхийлэх хэрэгцээ, шаардлагыг харгалзсан, уг асуудлыг хүндэтгэсэн байхыг ойлгоно. Энэхүү эрхийг олон улсын эрх зүйн болон үндэстний эрх зүйн хэм хэмжээгээр тодорхойлж холбогдох эрх зүйн зохицуулалтаар хуульчлан бэхжүүлсэн байдаг. Олон улсын эрх зүйн хэмжээгээр уг эрхийг Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал, Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пактад амьдралын хүрэлцээтэй түвшинд буюу орон байр халдашгүй байх, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрх, орон байр., амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх⁶ зэрэг эрхүүдээр баталгаажуулж өгсөн. Мөн 1996 оны Истанбулын гэрээ, Амьдрах орчны хөтөлбөрт хэлэлцсэн гол сэдэв нь шаардлагад нийцсэн орон сууцтай болох эрхийн тухай⁷ байжээ.

Улсын эрх бүтээлд “Хүмүүний хөдөлгөх, үл хөдөлгөх хөрөнгө хогшил, эд таваарын зэргийг учиргүйгээр булаан авч болохгүй”, Хааяа улсын тусыг бодож хүмүүний газар орон, орон байшин, гэр зэргийн хөрөнгийг хураахад хүрвээс энэхүү уул эзэнд олгуулваас зохимуй, Хүмүүний суух орон гэрт учиргүйгээр эзэрхэн орж үл болмуй⁸ хэмээн одоогийн Үндсэн хуулийн зохицуулалтыг тусгаж байсан нь тодорхой харагддаг. Монгол Улс 1940, 1960 оны Үндсэн хуулиндаа ард иргэний орон сууцанд халдаж үл болох⁹, улсын нутаг дэвсгэр дотроо өөрийн биеэр чөлөөтэйгээр шилжин явах ба оршин суух газраа шилэн сонгох эрхтэй¹⁰, ард иргэдийг ялгаварлан гадуурхах, тэдгээрийн эрхийг ямар нэг аргаар шууд буюу далимдуулан хязгаарлах., явдлыг хуулиар залхаана¹¹ гэж тус тус зохицуулж байсан.

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Үндсэн хуульд өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаалах¹², Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, ялгаварлан гадуурхалтад өртөхгүй байх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах, ...төр түүний байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийг дайчлан авбал нөхөх олговор, үүнийг төлөх, халдашгүй чөлөөтэй байх, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална, улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, оршин суух газраа сонгох гэх мэт шаардлагад нийцсэн орон байртай байх эрхтэй холбоотой эрхүүдийг өмнөх үндсэн хуулиудаас илүү өргөн хүрээнд бэхжүүлсэн онцлогтой.

⁶ Хүний эрхийн түгээмэл тунхаглал 1948 он 12,13, 25 дугаар зүйл, Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пакт 1966 он 11 дүгээр зүйлийн 11.1,

⁷ Өнөөгийн байдлаар 84 улс орон Үндсэн хуулиндаа орон сууцны эрхийн талаар тодорхой заасан байдаг. The right to adequate housing (Art.11 (1)). CESCR General comment 4 – see para. 8

⁸ Ж.Цэвээн “Улсын эрх 1914” Цогц хөгжлийн төвөөс хэвлэн гаргасан нийгэм цуврал №1, 2023 х.38 дах тал

⁹ Монгол Улсын Үндсэн хууль 1940 он 87 дугаар зүйл, 1960 оны Үндсэн хуулийн 88 дугаар зүйл

¹⁰ Монгол Улсын Үндсэн хууль 1940 он 84 дугаар зүйл

¹¹ Монгол Улсын Үндсэн хууль 1940 он 79 дугаар зүйл, 1960 оны Үндсэн хуулийн 83 дугаар зүйл.

¹² Монгол Улсын Үндсэн хууль 1992 он 5.2, 14.1, 14.2,16.2, 16.3, 16.13, 16.18

Алсын хараа 2050 нь Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг юм. Уг баримт бичигт хүнд ээлтэй амьдрах орчныг бүрдүүлэх хүрээнд амьдралын хэрэгцээг хангасан эрүүл, ая тухтай, таатай орчныг бүрдүүлэх, нэг хүнд ногдох орон сууцны талбайн хэмжээг нэмэгдүүлж дэлхийн жишигт хүргэнэ, орон сууцны чанар, стандартыг ханган, гал түймэр, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшигт үзэгдэлд тэсвэртэй байх нөхцөлийг бүрдүүлнэ.

Хот суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн шугам сүлжээнд холбогдсон орон сууцны хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлнэ, нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлж дэлхийн жишигт хүргэнэ, хог хаягдлын цогц менежмент нэвтрүүлнэ, орчны эрүүл мэндийн үзүүлэлтийн шаардлага, стандарт, тохирлуудыг олон улсын стандартад ойртуулан тохируулж, шинэчилнэ¹³.

Орлогот нийцсэн орон байртай байх өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй, эрэлт хэрэгцээнд нийцсэн орон байраар хангах нөхцөлийг бүрдүүлнэ, зайлшгүй орон байраар хангагдах зорилтот бүлгийн иргэдийг төрийн өмчийн халамжийн түр орон сууцаар хангадаг тогтолцоог нэвтрүүлнэ, орон сууцны төлөвлөлтөд оршин суугчид амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх нийгмийн дэд бүтэц, ногоон байгууламж, усан сан, биеийн тамирын талбай бүхий тохилог орчныг бүрдүүлэх стандарт хэрэгжүүлнэ.

Гэр хорооллын өрхийн газрыг өөрсдийн идэвх, санаачилга, оролцоонд тулгуурлан дахин зохион байгуулах, нийгмийн болон инженерийн дэд бүтэц, ногоон байгууламж, тоглоомын талбай бий болгох, гэр хорооллын дундын бүсийг тэргүүн ээлжинд инженерийн дэд бүтэцтэй болгоход улс, орон нутгийн төсөв болон бусад хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг зориулах¹⁴ гэх мэтээр цөөнгүй ажлуудыг 2030 он хүртэлх хугацаанд хийж хэрэгжүүлэхээр заажээ. Тухайлбал: Алсын хараа 2050-ын зорилт 3.2-д Өрх гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй, эрэлт хэрэгцээнд нийцсэн байр сууцаар хангах нөхцөлийг бүрдүүлнэ.Энэ зорилтын хүрээнд дараах үе шаттайгаар ажлуудыг хийхээр төлөвлөсөн байна. Үүнд:

Хүснэгт 1. Алсын хараа 2050 хэрэгжих үе шат бүрд хийгдэхээр төлөвлөсөн ажил

I үе шат (2020–2030)	II үе шат (2031–2040)	III үе шат (2041–2050)
Худалдан авах чадварт нийцсэн орон сууц	Чанартай байр, сууц	Тохилог байр, сууц
Өрх, гэр бүлийг худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй сууцаар хангах нөхцөлийг бүрдүүлэх үе	Худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй ногоон хөгжлийн загварт нийцсэн орон сууцны чанар, стандартыг сайжруулах үе	Хэрэгцээнд нийцсэн чанартай, тохилог орон сууцны хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх үе
Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй сууцаар хангах тогтолцоог бий болгох Төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны санхүүжилтийн тогтолцоог бэхжүүлэх	Гэр хорооллын нөхцөлийг сайжруулж, хүн амын худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй, ногоон шийдэл бүхий чанартай орон сууцны хүрэлцээ, хангамжийг сайжруулах	Өрх, гэр бүлийг эрэлдтэд нийцтэй, худалдан авах чадварт тохирсон, чанартай, тохилог орон сууцаар хангах

Шаардлагад нийцсэн орон байртай байх эрх нь зарим талаараа амьдралын чанар гэсэн ойлголттой холбоотой. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас амьдралын чанар гэдэг нь “хувь хүний өөрийн амьдарч буй соёл, үнэт зүйлсийн тогтолцооны хүрээнд, зорилго, хүлээлт, стандарт, санаа зовоосон асуудалтай нь уялдуулан амьдрал дахь байр сууриа олж авах ойлголт” гэж тодорхойлсон¹⁵ байдаг. Амьдралын чанарын стандарт үзүүлэлтүүдэд эд баялаг, хөдөлмөр эрхлэлт, хүрээлэн буй орчин, орон сууцны байдал, бие махбодийн болон сэтгэцийн эрүүл мэнд, боловсрол, амралт, чөлөөт цаг, нийгмийн харьяалал, шашны итгэл үнэмшил, аюулгүй байдал, эрх чөлөө хамаарах¹⁶аар заасан байна.

Улс орны хөгжлийн гол үзүүлэлт бол хүн амын амьдралын чанар байдаг. Хүн амын тогтвортой өсөлтийг хангаж, идэвхтэй бүтээлч гэр бүлийг төлөвшүүлэн, хэрэгцээндээ нийцсэн орон сууц бүхий, хөрөнгө оруулалтай тайтай орчин, нөхцөлд өрсөлдөхүйц бичил, жижиг, дунд бизнес эрхлэн өрх, гэр бүл, өөрийгөө тэтгэн амьдрах боломжтой, идэвхтэй амьдралын зөв дадал хэвшилтэй, сэтгэл хангалуун амьрах нөхцөлөөр тэтгэгдсэн дундаж давхаргыг 2050 он гэхэд нийт хүн амын 80 хувьд хүргэх бодлого хэрэгжүүлэхээр дээрх баримт бичигт тусгагдсан байна. Уг баримт бичгийн зорилт 2.5-д Амьдралын хэрэгцээ хангасан эрүүл, ая тухтай, таатай орчин бүрдүүлэх талаар тусгасныг авч үзвэл:

¹³ Монгол Улсын Их Хурлын тогтоол “Алсын хараа 2050” 2020 он Зорилт 2.5

¹⁴ Монгол Улсын Их Хурлын тогтоол “Алсын хараа 2050” 2020 он Зорилт 3.2

¹⁵ “WHOQOL: Measuring Quality of Life”. World Health Organization. Archived from the original on 15 May 2020. Retrieved 22 May 2020.

¹⁶ Martha Nussbaum and Amartya Sen, ed. (1993). *The Quality of Life*, Oxford: Clarendon Press.

Хүснэгт 2. Алсын хараа 2050-д тусгагдсан байдал

I үе шат (2020-2030)	II үе шат (2031-2040)	III үе шат (2041-2050)
Эрүүл баталгаат орчин	Амьдрах таатай орчин	Өрх, хүн амд ээлтэй амьдрах орчин
Орон сууц, ногоон байгууламжийн стандартыг мөрдөж, эрүүл баталгаат амьдрах орчныг бий болгох Агаар, ус, хөрс, дуу чимээний бохирдлыг багасгаж, цэвэр ногоон байгууламж бүхий орчинтой болох	Тохилог тайтай орчин бүрдүүлж, орон сууцны хотхон, хорооллын төлөвлөлийг олон улсын стандарт, шаардлагад нийцүүлэн хог хаягдлын зохистой менежментийг хэвшүүлэх. Ногоон бүс, бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах, нэг хүнд ноогдох цэцэрлэгжсэн талбайн хэмжээг нэмэгдүүлэх замаар хот, суурин газрын ногоон байгууламжийг хот төлөвлөлтийн стандартад нийцүүлэх	Орчны бохирдлоос шалгагдсан хүний эрүүл мэнд, эдийн засагт учрах сөрөг нөлөөлөл бүрэн арилж, хот, сум, суурингуудад авто зогсоол, оршин суугчид амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх зориулсан ногоон байгууламж, усан сан, бие тамирын талбай бүхий тохилог эко орчин бүрдүүлэх

Алсын хараа-2050 бодлогын баримт бичгийн зорилт 9.3.Орон зайн оновчтой төлөвлөлт бүхий суурьшлын зөв тогтолцоотой, эрчимтэй хөгжиж байгаа дагуул хотуудтай олон улсад өрсөлдөгч метрополитан болж хөгжинө.

Хүснэгт 3. Алсын хараа 2050-д төлөвлөгдсөн байдал

I үе шат (2020-2030)	II үе шат (2031-2040)	III үе шат (2041-2050)
Орон зайн төлөвлөлт	Олон төвтэй хот	Метрополитан
<ol style="list-style-type: none"> Улаанбаатар хотын төвлөрөл, суурьшсан нутаг дэвсгэрийн тэлэлт, хязгаарлалт, газар зохион байгуулалт, авто замын сүлжээ, нийтийн тээвэр, газар доорх орон зай гэх мэт шаардлагатай төлөвлөлтийг тооцон хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, мэдээллийн нэгдсэн системд холбон хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Соёл, боловсрол, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн дэд бүтцийн хангамж бүхий хотын шинэ төв, дэд төв, төрөлжсөн төв, олон нийтийн төвүүдийг шинээр байгуулж, хот доторх төвлөрлийг багасгана. Хотыг дахин хөгжүүлэх төслийн хүрээнд орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ. Олон төрлийн (орлогод нийцсэн, түрээсийн, ногоон) орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, 150,000 айлын орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. 	<ol style="list-style-type: none"> Улаанбаатар хот доторх төвлөрлийг задлах зорилгоор соёл, боловсрол, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн дэд бүтцийн хангамж бүхий хотын шинэ төв, дэд төв, төрөлжсөн төв, олон нийтийн төвүүдийг шинээр байгуулж, тэдгээрийг холбосон хөгжлийн коридорыг бий болгоно. Цахим суурьтай санхүүгийн технологи, цахим банк, цахим мөнгө, хиймэл оюун ухаан, блокчэйн технологи, автоматжуулалт, үүлэн технологи, хатуу болон зөөлөн дэд бүтцийг хүчирхэгжүүлнэ. Нийт эрчим хүчний баланст эрчим хүчний шинэ эх үүсвэрүүдийн хувийн жинг нэмэгдүүлж, бүс нутгийг цахилгаан эрчим хүчээр хангана 	<ol style="list-style-type: none"> Амьдралын таатай орчин бүрдсэн метрополитан хот болж хөгжинө. Хиймэл оюун ухаанд суурилсан ухаалаг системийн шинэ үе шатны технологийг хот байгуулалтын үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна. Бүс нутгийг Улаанбаатар хоттой холбосон орчин үеийн өндөр хурдтай тээврийн сүлжээтэй болно.

Зураг 1. SWOT шинжилгээний илэрхийлэл




Зураг 2. Худалдан авахуйц байх шаардлагад хийсэн SWOT шинжилгээ



Зураг 3. Дэд бүтцийн хүртээмжтэй байх шаардлагад хийсэн SWOT шинжилгээ



Зураг 4. Эзэмшлийн байдлын хангасан байх шаардлагад хийсэн SWOT шинжилгээ



Зураг 5. Соёлын онцлогт нийцсэн байх шалгуурт хийсэн SWOT шинжилгээ



Дээрх байдлаар алсын хараа 2050-д тусгагдсан байдлаас дүгнэн үзэхэд үйлчилгээ, материал, байгууламж, дэд бүтцийн хүртээмж, худалдан авч болохуйц байх, оршин суухад тохиромжтой байх, байрлал алслагдаагүй, эсүл орчны бохирдолгүй байх гэсэн шаардлагыг хангах тухай асуудлууд нь бодлогын баримт бичигт тусгагдаж цаашид үе шаттайгаар хэрэгжих явцад хангагдах боломжтой байна. Харин эзэмшлийн аюулгүй байдал буюу албадан нүүлгэлт, хүчирхийлэл болон аливаа халдлагаас ангид байх талаарх оршин суугчдын эзэмшлийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой зохицуулалт хангалтгүй байна. Энэ нь иргэд албадан нүүлгэлтэд өртөх, эрх зүйн хамгаалалт сулрах, хяналт тавихгүй, нөхөн олговор өгөхгүй байх,

хүсээгүй ч оршин суух газраасаа нүүхээс аргагүй болоход хүргэж буй өнөөгийн асуудал хэвээр байх эрсдлийг дагуулж байна.

Монгол Улсад албадан нүүлгэхтэй холбоотой асуудлыг газрын тухай хууль, хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль, нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх журмаар тус тус зохицуулж байна. (дэлгэрэнгүйг дүн шинжилгээ хийсэн хүснэгт 4,5-аас харах) Албадан нүүлгэлтийн үндэслэлийг гаргахдаа олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцүүлэн, эрх тэгш байх зарчмын дагуу Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад заасан хүний орон байранд хууль бусаар хөндлөнгөөс оролцож болохгүй гэж заасныг харгалзан үзэж, хуульд хөдлөнгөөс оролцохыг зөвшөөрсөн тодорхой нөхцлүүдийг нарийвчлан тусгахыг эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо зөвлөсөн байна.

Мөн соёлын онцлогт нийцсэн байхыг соёлын онцлогоо илэрхийлэх хэрэгцээ, шаардлагыг харгалзсан байхыг шаардлагад нийцсэн орон байртай байх эрх талаас харж тусгасан зохицуулалт Алсын хараа бодлогын баримт бичигт тусгагдаагүй байна. Соёлын онцлогт нийцсэн байх нь уламжлалт гэрээс байранд оруулах, орчин нөхцлийг бүрдүүлэхтэй суурин л газарт анхаарах бус байгаа газар нь уламжлалт хэв маяг, соёлын ав уламжлалыг орон гэрийнх хувьд хэвээр авч үлдэх Үндэсний аюулгүй байдал, соёлоо хадгалах, үлдээх, уламжлуулахтай салшгүй холбоотой. Хууль журмын зохицуулалтуудыг харахад гэр хороололд зориулсан, түүнийг орон сууцжуулахад зориулж гарч байгаа нь уламжлалт сууцыг хязгаарлах асуудал үүний цаана хөндөгдөх үр дагаварт хүргэж байгааг анхаарах шаардлагатай.

Гадаадын зарим улсын хуульд шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн агуулгад хамаарах эзэмшлийн аюулгүй байдал, соёлын онцлогт нийцсэн байдлыг хэрхэн тусгасныг авч үзвэл Оросын Холбооны улсын Үндсэн хуулийн 40 дүгээр зүйлийн 1-т Хүн бүр орон байртай байх эрхтэй. хэнийг ч орон байрнаас нь хүчээр хагацааж болохгүй. Өмнөд Африкийн Үндсэн хуульд Хүн бүр шаардлагад нийцсэн орон байртай байх эрхтэй. Төрөөс шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг баталгаатай хэрэгжүүлэхэд улсынхаа боломжит нөөц, эх үүсвэрийн хүрээнд хууль эрх зүйн болон бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй, холбогдох нөхцөл байдлыг хянан үзэж гаргасан шүүхийн шийдвэргүйгээр хэнийг ч орон байрнаас нь хөөх эсхүл орон байрыг нь нураан, эвдэн сүйтгэж болохгүй. Хууль бусаар нүүлгэн шилжүүлэхийг хориглоно. Португаль Улсын Үндсэн хуульд Хүн бүр өөрийн болон гэр бүлийн хэрэгцээнд зориулан эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, тохь тухтай, хувийн болон гэр бүлийн аюулгүй байдлаа хангахуйц зохистой хэмжээ бүхий орон байртай байх эрхтэй¹⁷ гэж тус тус заасан байна. Манай


¹⁷ НҮБ-ын хүний эрхийн дээд комиссарын газар, НҮБ-ын ХАБИТАТ гаргасан Шаардлагад нийцсэн орон байртай байх эрх мэргэжлийн гарын авлага №21 шинэчилсэн товхимол Эмнести интернэшнл ТББ, Нээлттэй нийгэм форумаас орчуулан гаргасан гарын авлага УБ.,2019 х.16 дах тал

улсын зохицуулалтаас ялгаатай нь үндсэн хуулиараа шууд агуулгаар эрхийг хамгаалсны зэрэгцээ шүүхийн шийдвэр гарсны дараа нөхцөл байдлыг нарийн тогтоосны дараа нүүлгэхээр заасан давуу талтай байна.

III. ДҮГНЭЛТ, САНАЛ

Алсын хараа-2050 бодлогын баримт бичгийг сэдвийн хүрээнд PDCA арга¹⁸ дээр тулгуурлан бичигдэж гэж дүгнэж болохоор байгааг дараах байдлаар харж болохоор байна.

Зураг 5. Алсын хараа 2050 PDCA дагуу хийгдсэн байдал



Судалгаандаа ашигласан PDCA аргаар дүгнэлт хийхэд шалгуурыг дараах байдлаар хангасан гэж үзлээ. (Дэлгэрэнгүйг Зураг 6,7-аас харах)

Зураг 6. PDCA-д зохих шалгуурууд нийцсэн байдал

Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн шалгуур:	P	D	C	A
Эзэмшлийн аюулгүй байдал	✓	✗	✗	✓
Үйлчилгээ, материал, байгууламж, дэд бүтцийн хүргээмж	✓	✓	✓	✓
Худалдан авч болохуйц байх, оршин суухад тохиромжтой байх	✓	✓	✓	✓

¹⁸ “PDCA” бол үр дүнтэй ажиллах арга юм. Энэ арга нь дөрвөн үе шаттай бөгөөд тэдгээр үе шатуудыг давтах байдлаар үйл ажиллагаагаа сайжруулж, ажлыг тогтвортой үргэлжлүүлэх боломжтой. Уолтер Эндрью Шеварт анх санал болгосон чанарын менежментийн хүрээнд ашиглагддаг арга буюу бүтээгдэхүүний чанар болон орчин нөхцлийг сайжруулах асуудлыг шийдвэрлэх ерөнхий арга болгон “PDCA цикл” гэдэг аргыг ихэвчлэн ашигладаг.

Зураг 7. PDCA-д зохих шалгуурууд нийцсэн байдал

Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн шалгуур	P	D	C	A
Оршин суухад тохиромжтой байх	✓	✓	✓	✓
Байрлал алслагдвалгүй, эсүл орчны бохирдолгүй	✓	✓	✓	✓
Совлын онцлогт нийцсэн байх	✓	✗	✗	✓

Дүгнэлт, саналыг TOWS аргаар тодорхойлж давуу тал, сул тал, сайжруулалтыг хэрхэн хийх талаар сэдвийн хүрээнд тус бүрд нь авч үзэв.

Шаардлага нийцсэн орон байртай байх эрх: Эзэмшлийн аюулгүй байдлын талаар “Алсын хараа 2050”-д хийсэн TOWS шинжилгээг авч үзвэл:



Хүснэгт 4. TOWS шинжилгээ

TOWS		Дотоод орчин	
		Давуу тал (S)	Сул тал (W)
Гадаад орчин	Боломж	<p>S-O буюу боломжийг давуу тал болгох стратеги:</p> <ul style="list-style-type: none"> - 3.2.3.Хот, суурин газрын хөгжлийн төлөвлөлтийн дагуу орон сууцжуулах хөтөлбөр, төслийг үе шаттай хэрэгжүүлж, иргэдийг орлогод нийцсэн аюулгүй, ая тухтай орон байртай болоход дэмжлэг үзүүлнэ. - 7.3.Уламжлалт бус аюулын эрсдэлийг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, хүн-нийгмийн амар тайван орчныг бүрдүүлнэ. - 7.3.8.Нийслэл, орон нутгийн төвүүдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор хяналтын камерын нэгдсэн төв бий болгож, мэдээлэл, харилцаа холбоо, барилга байгууламжийн дэд бүтцийг орчин үеийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хөгжүүлнэ. - 9.2.40.Гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлж бүрэн камержуулан, ард иргэдийн аюулгүй байдлыг хангаж, гудамж, талбайн нэр, байшин барилгын хаягийн нэгдсэн стандарт хангуулж, хотын соёлыг нэмэгдүүлнэ зэрэг зохицуулалт байна. 	<p>W-O буюу боломжид тулгуурлан сул талаа үгүй хийх стратеги:</p> <ul style="list-style-type: none"> - Хууль бусаар албадан нүүлгэлтээс ангид байх эрхийн байх эрхийг асуудал тусгагдаагүй. - Хууль ёсны итгэлийг хамгаалах зохицуулалт орон сууцны болон газрын холбогдох хууль тогтоомжид тусгагдаагүй байна. - Газар, үл хөдлөх хөрөнгийг өмчлөх, эзэмших, ашиглах үеийн албадан нүүлгэх эрх зүйн зохицуулалтыг, эрхийн зөрчилтэй эсэх харгалзаж газрын болон хот дахин төлөвлөлт, орон сууцны тухай хуулиуд боловсронгуй болгох - хууль ёсны өмчлөгч, эзэмшигч нь зах зээлийн үнэ ханшаар нөхөн олговрыг өөрөө тогтоох, үнэлгээ өгөх эрхийг нарийвчлан зохицуулах боломжтой.
	Эрсдэл	<p>S-T буюу давуу талаа ашиглан аюулаас зайлсхийх стратеги:</p> <ul style="list-style-type: none"> - Иргэдийн орон сууц болон газрыг чөлөөлөх албадан нүүлгэх бодлогын зохицуулалт тодорхойгүйгээс эрх хөндөгдөх эрсдэлтэй. - Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх журам - 4.15.Санал асуулгын үр дүнд нөлөөлөлд өртөгчийн 70-аас доошгүй хувь нь дэмжсэн тохиолдолд энэ талаар олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia.mn) болон газрын кадастрын нэгдсэн цахим систем (e-gazar.gov.mn)-ээр дамжуулан олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлнэ. - 4.16.Энэ журмын 4.15-д заасан нөхцөл бүрдсэн бол Нийслэлийн Засаг дарга нөлөөлөлд өртөгч бусад өмчлөгч, эзэмшигчийн газрыг албадан чөлөөлөх шийдвэр гаргана. - 4.17.Газрыг албадан чөлөөлөх шийдвэрт газрыг албадан чөлөөлөх болсон үндэслэлийг тодорхой зааж, нөхөх олговрын үнэлгээ хийлгэх талаар тусгах бөгөөд шийдвэрийг нөлөөлөлд өртөгчид хүргүүлнэ. - 4.18.Газрыг албадан чөлөөлөх шийдвэрийн дагуу хөрөнгийн үнэлгээ хийж, нөхөх олговрыг олгоно. 	<p>W-T буюу сул талаа багасгаж, аюулаас зайлсхийх стратеги:</p> <ul style="list-style-type: none"> - Газрын тухай хууль - 1.4.Энэ хуулийн 41.1-д заасан хугацаанд газраа чөлөөлөөгүй бол тухайн шатны Засаг дарга албадан гүүлгэх ажлыг зохих хууль тогтоомжийн дагуу зохион байгуулна. - 59.1.Газар чөлөөлүүлэх, албадан нүүлгэхэд цагдаагийн байгууллага дараахь үүрэгтэй: <ul style="list-style-type: none"> - 59.1.1.хууль, гэрээнд заасан үндэслэлээр газар эзэмших, ашиглах эрх дуусгавар болсон, эсхүл зохих зөвшөөрөлгүйгээр газар эзэмшсэн, ашигласан бол албадан нүүлгэх тухай Засаг даргын шийдвэрийн биелэлтийг хангах; - 59.1.2.газар чөлөөлүүлэх, албадан нүүлгэхэд хүч хэрэглэсэн буюу зохион байгуулалттайгаар саатуулсан, эсэргүүцсэн бол зохих журмын дагуу арга хэмжээ авах.

Шаардлагад нийцсэн орон суутай байх эрхийн соёлын онцлогт нийцсэн байх талаар алсын хараа 2050"-д хийсэн TOWS шинжилгээ авч үзвэл:

Хүснэгт 5. TOWS шинжилгээ

TOWS		Дотоод орчин	
		Давуу тал (S)	Сул тал (W)
Гадаад орчин	Боломж	<p>S-O буюу боломжийг давуу тал болгох стратеги:</p> <ul style="list-style-type: none"> - II үе шат (2031-2040): Худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй, ногоон хөгжлийн загварт нийцсэн орон сууцны чанар, стандартыг сайжруулах үе. - 1. Гэр хорооллын нөхцөлийг сайжруулж, хүн амын худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй, ногоон шийдэл бүхий чанартай орон сууцны хүрэлцээ, хангамжийг сайжруулна. - 5. Гэр хорооллын болон ногоон бүсийн айл өрхүүдийн эрчим хүчний хэрэглээг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт шилжүүлж, өрхийн үйлдвэрлэсэн цахилгааныг төвийн сүлжээнд нийлүүлэх боломжийг бүрдүүлнэ. - Нүүдлийн уламжлалт өв соёлыг хадгалсан, экологид ээлтэй, органик мал аж ахуйг тогтвортой эрхлэх, хөдөө аж ахуйн эрчимжсэн үйлдвэрлэлийг төрөлжүүлж, кластер, логистик, санхүүгийн түрээсийн үйлчилгээг хөгжүүлж, төлөвшүүлнэ. 	<p>W-O буюу боломжид тулгуурлан сул талаа үгүй хийх стратеги:</p> <ul style="list-style-type: none"> - Уламжлалт орон байр болох гэрийн талаар энэхүү бодлогын баримт бичигт тусгагдаагүй - Нүүдэлчдийн соёлын гол илэрхийлэл болсон гэрийн уламжлалт хэлбэрийг хадгалах, хамгаалах талаар бодлого боловсруулах боломжтой - Гэр хороолол гэдэг ойлголт уламжлалт гэр сууцыг зөвхөн хамаарах мэт ойлголтыг бодлогын баримтаараа тусгахгүй байх - 2002 оны ОРОН СУУЦ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР-д тусгагдаж байсан нүүдлийн маягаар амьдардаг хүмүүст тэдний уламжлалт ахуйд зохицсон, орчин үеийн материалаар бүтээсэн гэр оронтой болоход нь дэмжлэг үзүүлэх, нүүдлийн маягаар аж төрдөг хүн амыг гэр оронтой болоход нь дэмжлэг үзүүлнэ зэргээр өмнө тусгагдаж байсан бодлогын баримт бичгийг үргэлжүүлэх боломжтой.
	Эрсдэл	<p>S-T буюу давуу талаа ашиглан аюулаас зайлсхийх стратеги:</p> <ul style="list-style-type: none"> - Бодлогын баримт бичигт тусгагдаагүйгээс холбогдох хууль тогтоомжид тусгалаа олохгүй байх боломжтой. - ингэснээр соёлын өвийг хамгаалах, авч үлдэхэд дэмжлэг дутагдана. Тиймээс соёлын өвийг хамгаалах тухай хуулиар зохицуулалтыг хийх 	<p>W-T буюу сул талаа багасгаж, аюулаас зайлсхийх стратеги:</p> <ul style="list-style-type: none"> - Аялал жуулчлалын бодлогыг уламжлалт монгол гэр сууцны хүрээнд тодорхойлох боломжтой. - Гэр нь өөрөө харьцангуй өртөг багатай, нүүдлийн соёлын өвийг хадгалсан сууц юм. Гэр сууцад амьдарч байгаа иргэнд цаашид үргэлжлүүлж амьдрах тохиолдолд дэд бүтцийг оновчтой шийдвэрлэх, татварын хөнгөлөлт өгөх зэргээр нүүдэлчдийн соёлын өвийг устах мартагдахаас сэргийлж болно.

Гагцхүү гэр суурьшлийн бүсийн цэгцтэй зөв төлөвлөлт нь байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах болон гэрийн онцлогийг хадгалан улам сайжруулан төлөвлөх нь архитекторуудын голчлон анхаарах асуудал төдийгүй дэлхийн нийтийн хөгжлийн чиг баримжааг тодорхойлох тогтвортой хөгжлийн зорилгод нийцэх юм.

IV. НОМ ЗҮЙ:

Эрх зүйн эх сурвалж:

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992
2. Монгол Улсын Үндсэн хууль 1940
3. Монгол Улсын Үндсэн хууль 1960
4. Газрын тухай хууль 2002
5. Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль 2015
6. нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль 2023
7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017
8. Хүний эрхийн түгээмэл тунхаглал 1948
9. Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пакт 1966
10. Нэгдсэн Үндэстний байгууллагын эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо “Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн талаарх ерөнхий зөвлөмж №4 1991
11. Нэгдсэн Үндэстний байгууллагын эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо “Албадан нүүлгэн шилжүүлэлтийн талаарх ерөнхий зөвлөмж №7 1997
12. Алсын хараа 2050 УИХ тогтоол 2020
13. Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөөний тодотгол 2030 оны хөгжлийн чиг хандлага
14. Газар шинэчлэн зохион байгуулах үйл ажиллагааны журам НИТХ 2016.02.08
15. Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 91 дүгээр тогтоолын хавсралт нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх журам

Монгол эх сурвалж:

1. Эмнести интернэшнл ТББ “Үүргээ мэд” албадан нүүлгэхээс урьдчилан сэргийлэх гарын авлага 2012
2. Ж.Цэвээн “Улсын эрх 1914” Цогц хөгжлийн төвөөс хэвлэн гаргасан нийгэм цуврал №1, 2023
3. НҮБ ын хүний эрхийн дээд комиссарын газар, НҮБ ын ХАБИТАТ гаргасан Шаардлагад нийцсэн орон байртай байх эрх мэргэжлийн гарын авлага №21 шинэчилсэн товхимол Эмнести интернэшнл ТББ, Нээлттэй нийгэм форумаас орчуулан гаргасан гарын авлага 2019

Гадаад эх сурвалж:

1. “WHOQOL: Measuring Quality of Life”. World Health Organization. Archived from the original on 15 May 2020. Retrieved 22 May 2020.
2. Martha Nussbaum and Amartya Sen, ed. (1993). *The Quality of Life*, Oxford: Clarendon Press
3. The right to adequate housing (Art.11 (1)). CESCR General comment 4 – see para. 8
4. World Economic Forum, Global Gender Gap Report 2024, <https://www.weforum.org/publications/global-gender-gap-report-2024/>



М.ХАТАНЗОРИГ

Хуульч, багш, Хууль зүйн ухааны доктор, дэд профессор

ХУВИЙН ХАЛДАШГҮЙ БАЙХ ЭРХИЙН ОРЧИН ҮЕИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ¹

CONTEMPORARY CONCEPTION OF RIGHT TO PRIVACY

Хураангуй: Хувийн халдашгүй байх эрх цахим технологиос шалтгаалан дэлхий даяар ноцтой зөрчигдөж байгаа боловч агуулга, хүрээг нь ончтой тодорхойлоход нэн бэрх. Уг эрхийн агуулга нь хуульд заасан объектоор хязгаарлагдахгүй бөгөөд нийгмийн харилцааны төрөл бүрт ялгаатай байдлаар хэрэгжиж, зөрчигдөж байдаг. Энэ өгүүлэлд эл эрхийн эрх зүйн зохицуулалт, түгээмэл танигдсан онолуудын нэн хураангуйг танилцуулахын хамт, уг эрхийн агуулгыг тодорхойлсон “харилцан хүлцлийн үзэл баримтлал”-ын тоймыг авч үзнэ. Уг үзэл баримтлалаар уг эрхийн агуулгыг зөв тодорхойлоод зогсохгүй, зөрчигдсөн эсэхийг тодорхойлох шалгуурыг санал болгоно. Уг үзэл баримтлалыг хууль тогтоох, гүйцэтгэх аль ч үйл ажиллагаанд тулгуур болгох боломжтой бөгөөд шүүхээс халдашгүй байх эрхтэй холбоотой маргаан шийдвэрлэхэд хууль тайлбарлан ашиглах боломжтой..

Abstract: The right to privacy is being seriously violated worldwide due to electronic technology, but its content and scope are very difficult to define. The content of this right is not limited to the objects stipulated in the law, and is implemented and violated differently in each type of social relationship. This

¹ “УЛСЫН ЭРХ-110” эрдэм шинжилгээний хуралд шалгарсан бүтээл

article presents an overview of the legal regulation of this right and popular theories. It also introduces the concept of "Privacy as mutual tolerance" that defines the content of this right. This concept not only correctly defines the content of this right, but also proposes criteria for determining whether it has been violated. This concept can be used as a basis for any legislative and executive action, and can be used by the courts to interpret the law in resolving disputes related to the right to privacy.

Түлхүүр үгс: Халдашгүй байх эрх, хувийн халдашгүй байх эрх, харилцан хүлцлийн үзэл баримтлал, үндсэн эрх, хувийн мэдээлэл хамгаалал, улсын эрх

Key words: Privacy, right to privacy, personal information protection, privacy as mutual tolerance, privacy law

I. УДИРТГАЛ

Хувийн халдашгүй байх эрх бол орчин үед хамгийн их зөрчигдөж буй, хууль зүйн хамгаалалт хамгийн сул эрх мөн. Ялангуяа зөрчигдөх онцлогоос шалтгаалан², бүх нийтийн эрх зүйн боловсрол харьцангуй сул Монгол Улсад цахим орчинд төдийгүй, объектив бодит хэлбэрээр зөрчигдөх үзэгдэл их боловч тэдгээр зөрчил нь нийгмийн ухамсарт тусаж өртөх, хариу хамгаалалтын арга хэмжээ авах нь бага.³ Төрийн байгууллагуудын хувьд ч эл эрхийг хамгаалах хандлага, ухамсар сул.⁴

Дэлхий нийтийн цахимжилт энэ эрхийн зөрчлийг улам хурцатгаж буй. Мэдээлэл, харилцааны технологи (ICT) асар эрчимтэй хөгжихийн сацуу хүний хэрэглээнд хурдацтай нэвтэрч дэлхийн ихэнх улсад нийгмийн өдөр

² Хувийн халдашгүй байх эрх хүнд бодит зовиур, хүний бие махбодийн халдлага, нийгмийн харилцаанд оролцоход хүчтэй хязгаарлалт мэдрүүлэхгүйгээр зөрчигдөх боломжтой. Цөөнгүй тохиолдолд хүн уг эрхээ зөрчигдөж буйг өөрөө мэдэхгүй, мэдэрсэн нь түүнийгээ эрх нь зөрчигдөж байна хэмээн ухамсарладаггүй.

³ Тухайлбал, хүний хувийн орон зайг зөвхөн орон байр, өрөө тасалгаа зэрэг бодит хаалтаар явцууруулж ойлгох; банкууд цахим аппликейшндээ хүний хувийн мэдээллийг цуглуулах, дамжуулах нөхцөлийг хэрэглэгчид тулгах; төрөөс татвар авах нэрийдлээр иргэдийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг тогтмол хянах боломж бүрдүүлэх гэх мэт.

⁴ ҮХЦ-ийн 2023 онд "Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх" маргааныг хянан шийдвэрлэхэд УИХ, ТЕГ, УЕПГ "иргэн тагнах, чагнах төхөөрөмжийг илрүүлэгч төхөөрөмжтэй байж болохгүй зохицуулалт нь хүний халдашгүй байх эрхийг зөрчөөгүй" гэх тайлбарыг тууштай баримталж байв. Олон улсын жишгээр иргэн тагнах төхөөрөмж эзэмшиж болохгүй боловч илрүүлэх төхөөрөмж ашиглах эрхтэй байдаг. Уг хэргийг хянан шийдвэрлэхэд МУИС-ын ХЗС-ын дэргэдэх ҮХЭЗХ-ээс дүгнэлт гаргуулж, ҮХЦ мөн оны 03 дүгнэлтээр Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн хэдий ч, 2023.11.15 өдрийн 04 дугаар тогтоолоор уг дүгнэлтийг хүчингүй болгосон байна. Дэлгэрэнгүйг: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16960262179051>

тутмын амьдралын салшгүй хэсэг болжээ.⁵ Эдийн засаг⁶, боловсрол⁷, эрүүл мэнд⁸, мэдээлэл, харилцаа холбоо⁹, төрийн үйлчилгээ¹⁰ зэрэг бүхий л салбар тодорхой хэмжээнд цахим, тоон системд тулгуурлах болсон. Монгол Улсад ч интернэт хэрэглэгчийн тоо 2001-2011 онд 10.300-аас 457.300 болж 44.3 дахин, 2021 онд 4.137.300-д хүрч 2011 оны тоон үзүүлэлтээс 9.04 дахин¹¹ өсчээ¹².

Эл үзэгдэл хүний хувийн халдашгүй байх эрхийн агуулгыг хууль зүйн хувьд зөв тодорхойлох, түүнийг хамгаалах үндэсний механизмыг оновчтой зохион байгуулах шаардлагад хөтөлж байна.

Уг өгүүллээр хувийн халдашгүй байх эрхийн онол, номлолуудыг төрөлжүүлж, Үндсэн хуулиар баталгаажуулсан агуулгыг нь оновчтой тогтоох үзэл баримтлалыг тодорхойлох зорилготой.

Судалгаанд хувийн халдашгүй байх эрхийг ямар агуулгаар ойлгох, ямар тохиолдолд зөрчигдсөн болон зөрчигдөөгүй гэж үзэх талаар үндсэн асуултыг дэвшүүлж онолын ба эмпирик судалгааны аргуудыг ашиглав.

II. ХУВИЙН ХАЛДАШГҮЙ БАЙХ ЭРХИЙН ЭРХ ЗҮЙ, ФИЛОСОФИЙН НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Хууль зүйн харьцуулалт

Хүний халдашгүй байх эрхийн талаар Монгол Улсын Үндсэн хуулийн §16.13-

⁵ Дэлхийн интернэт хэрэглэгчийн тоо 4.9 тэрбумд хүрсэн байна. Гуравдугаар хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү.

⁶ Тухайлбал, цахим банкны хэрэглээ хөгжингүй улсуудад 62.9%, Азийн хөгжиж буй улсуудад 34.8%; Бараа бүтээгдэхүүний талаар интернэтээс мэдээлэл авч буй байдал хөгжингүй улсуудад 83.9, Азийн хөгжиж буй улсуудад 68% байна. Цахим худалдаа тус бүсүүдэд 53.9%, 29.1%; аялал жуулчлалын цахим үйлчилгээний хэрэглээ 55%, 25.2%-ийн үзүүлэлттэй байна (UNCTAD/DER/2021).

⁷ 2025 он гэхэд олон улсын цахим боловсролын тэлэлт эдийн засгийн үзүүлэлтээрээ 325 тэрбум америк долларт хүрэх нь 10 жилийн өмнөхөөсөө (2014 – 165.36 тэрбум) нэг дахин өсөх төлөвтэй байна (Форбес сэтгүүл, Дэлхийн эдийн засгийн форум); Онлайн сургалтын "Coursera" платформын бүртгэлтэй хэрэглэгч сүүлийн 5 жилд 438% өссөн. Хөгжингүй улсуудын 76.4%, хөгжиж буй Азийн улсуудын 46% нь цахим ном, сонин, сэтгүүл хэрэглэж буй. Мөн Азийн хөгжиж буй улсуудад албан ёсны онлайн курсын хэрэглээ 15.9%; суралцах зорилгоор цахим орчин ашиглалт 13.2%-ийн үзүүлэлттэй байна (UNCTAD/DER/2021).

⁸ Интернэтээс эрүүл мэндийн мэдээлэл эрэлхийлэх үзүүлэлт 62.4%, онлайнар эмчилгээний цаг товлох 16.4%. Цахим эрүүл мэндийн салбарын эдийн засгийн үнэлгээ 2020 онд 216 тэрбум а.доллар байсан бол 2022 онд 334, 2025 онд 657 тэрбумд хүрэх төлөвтэй байна (UNCTAD/DER/2021).

⁹ Олон нийтийн цахим сүлжээний хэрэглээ хөгжингүй орнуудад 70.4%, Азийн хөгжиж буй орнуудад 87.2%; вебэд тулгуурласан радио ашиглалт 61.2%, 20.9%; вебэд тулгуурласан зурагтын хэрэглээ 41.1%, 33.1%, өөрийн бүтээсэн контентэд интернэтэд байршуулах явдал 38.8% 21.3%; цахим шуудан ашиглалт 84.9%, 59.7%, цахим дуудлага хийх явдал 56.9%, 63.2% гэх мэт үзүүлэлттэй байна (UNCTAD/DER/2021).

¹⁰ Засгийн газрын байгууллага, нэгжээс мэдээлэл авах явдал хөгжингүй орнуудад 55.1%, хөгжиж буй Азийн орнуудад 20.9%; Засгийн газрын байгууллага, нэгжтэй цахимаар харилцах явдал 54.5%, 25.6%-ийн үзүүлэлттэй байна (UNCTAD/DER/2021).

¹¹ Сүүлийн 20 жилд 401.6 дахин өссөн.

¹² Үндэсний статистикийн хорооны тайлан.

т заасантай төстэйгөөр Алжир¹³, Бутан¹⁴, Болив¹⁵, Бразил¹⁶, Камбож¹⁷, Хятад¹⁸ зэрэг дэлхийн 180 гаруй улсын Үндсэн хуульд янз бүрээр тусгагдсан байна. Тухайлбал, Энэтхэгийн Үндсэн хуулийн 21-р зүйл¹⁹ АНУ-н Үндсэн хуулийн 1, 4 ба хэд хэдэн нэмэлт өөрчлөлтөд²⁰ ч мөн хуульчлагджээ. Түүнчлэн Африк тивийн 25 улс²¹ Үндсэн хуулиар эл эрхийг бататгаснаас тодруулбал Өмнөд Африкт “Хүн бүр халдашгүй байх эрхтэй: хүнийг болон түүний орон байрыг нэгжих; өмчийг нь нэгжих; эд хөрөнгийг нь хураан авах; харилцаа холбоо нь тагнахыг хориглоно” гэсэн байна.

Дэлхийн 137 улс халдашгүй байх эрхийн талаар буюу хүний хувийн мэдээллийг хамгаалах хууль тогтоомжийг тодорхой хэмжээнд нэвтрүүлсэн байна. Африк болон Ази тивийн улсууд 61 болон 57 хувь нь энэ төрлийн зохицуулалт тогтоосон бол хөгжиж буй улсуудын 48 хувь нь хувийн мэдээлэл хамгаалах хууль тогтоомж баталжээ.²² Эдгээрээс гадна олон улсын ба бүс нутгийн шинжтэй зохицуулалтаар уг эрхийг хамгаалсан.

Философийн үзэл хандлагуудын төлөөлөл

Хувийн халдашгүй байх эрх герман, франц, ялануяа англи хэл дээр түлхүү судлагдсан нь түүхэн хүчин зүйлсийн нөлөөнөөс шалтгаалсан гэж болно. Англи хэл дээрх эх сурвалжуудаас хувийн халдашгүй байх эрхийн үзэл баримтлал, үндэслэлийг тодорхойлох чиглэлээр гүйцэтгэсэн судалгаануудаас:

- Цаг хугацааны хувьд анхлан дэвшүүлсэн онол болох “дангаар байх эрх”-ийн баримтлалыг Л.Брандейс, С.Варрен нарын дэвшүүлсэн өнцгийн хүрээнд²³;

¹³ Үндсэн хуулийн (2020) §47-д “Хүн бүр нэр төр, хувийн амьдралаа хамгаалуулах эрхтэй”.

¹⁴ Үндсэн хуулийн (2008) §7.19-д “Хэний ч хувийн амьдрал, орон байр, ... нэр төрд хууль бусаар халдаж болохгүй”

¹⁵ Үндсэн хуулийн (2009) §21.2-т “Боливын иргэд дараах эрхтэй: Эрхэм чанар, дангааршил, ... нэр төр. Үндсэн хуулийн (1988 онд батлагдаж 2017 онд шинэчлэн найруулсан) §5-д “...хууль шүүхийн өмнө тэгш байж ... эрх эдэлнэ: 10. ... хувийн амьдралтай байх, нэр төртэй байх ...”

¹⁶ Үндсэн хуулийн (1988 онд батлагдаж 2017 онд шинэчлэн найруулсан) §5-д “...хууль шүүхийн өмнө тэгш байж ... эрх эдэлнэ: 10. ... хувийн амьдралтай байх, нэр төртэй байх ...”

¹⁷ Үндсэн хуулийн (1993 онд батлагдаж 2008 онд шинэчлэн найруулсан) §40-д “... орон байр, шуудан, телеграм, утас зэрэг ... дангааршил эрхтэй.

¹⁸ Үндсэн хуулийн (1982) §40-д “БНХАУ-н иргэний харилцаа холбооны халдашгүй байдал, эрх чөлөөг хуулиар хамгаална”

¹⁹ “Хуульд зааснаас бусдаар хүний хувийн амьдрал, эрх чөлөөнд халдахыг хориглоно”. БНЭУ-д Үндсэн хуулийн уг заалтын агуулгыг тайлбарлан шийдвэрлэсэн хэд хэдэн чухал хэрэг маргаан бий. Тухайлбал, Smt. Maneka Gandhi v. Union of India & Anr.(1978); Govind vs State Of Madhya Pradesh & Anr (1975); Naz Foundation v. Govt. of NCT of Delhi (2009).

²⁰ АНУ дангааршил эрхийн хөгжилд багагүй нөлөө үзүүлсэн. Үндсэн хуулийн эдгээр заалтаас гадна Griswold v. Connecticut, 381 U.S. 479 (1965); Katz v. United States, 389 U.S. 347 (1967) зэрэг олон алдартай хэргүүдэд хийсэн Дээд шүүхийн тайлбар нь хүний мэдээлэл, шийдвэр халдашгүй байх талаар үзэл санаанд өөрсдийн хувь нэмрийг оруулжээ. Флорида, Хавай, Монтана, Луизиана зэрэг олон мужууд нь мөн дангааршлын талаар өөрсдийн Үндсэн хуулинд тусгасан байна.

²¹ Зимбаб, Бүрүнди, Лесото, Өмнөд Африк, Намиби, Ботсвана, Замби, Нигер, Либер, Кени, Гвен, Гана, Уганда гэх мэт.

²² Нэгдсэн Үндэсний Байгууллагын (UNCTAD) статистик. (<https://unctad.org/page/data-protection-and-privacy-legislation-worldwide>)

²³ Голлох эх сурвалжууд: The right to privacy, Harvard law review, vol. 4 №5, 1890; Cooley, 1880 / The General Principles of Constitutional Law in the United States of America. Шүүмжлэх хандлага: Gavison, 1980; O'Brien, 1979; Allen, 1988; Schoeman, 1984; Bloustein, 1964; Solove, 2002 ба бусад.

- Сонгодог үзэл баримтлалуудын нэг “хүртэхүйн хязгаарлалт”-ыг С.Бок, А.Аллен, Р.Гависон, А.Мүүр, Х.Гросс, В.Ден Хаг нарын гол төлөөлөгчдийн ерөнхий үзлийн хүрээнд²⁴;
- Сонгодог үзэл баримтлалуудын нэг “хувийн мэдээллийн удирдлага”-ын баримтлалыг А.Вестин, А.Мүүр, А.Миллер, Р.Паркер нарын нийтлэг хандлагын хүрээнд²⁵;
- Нийтлэг танигдсан ч төдийлэн хүлээн зөвшөөрөгддөггүй “нууцлалын баримтлал”-ыг Р.Поснер, С.М.Жоурард, А.Этциони нарын хандлагын хүрээнд²⁶;
- Халдашгүй байдлын үндэслэлийг дэвшүүлэхэд ач холбогдол өндөртэй “персонхүүд”-ийн баримтлалыг П.Фрейд, Ж.Реймэн, С.Бенн, Э.Блоуштейн нарын нийтлэг хандлагад тулгуурлан²⁷;
- Юнитар онолуудын нэг “интимеси-дотно байдал”-ын онолыг Ч.Фрейд, Ж.Речелс, Том Герети, Жефри Росен нарын нийтлэг баримтлалын

²⁴ Голлох эх сурвалжууд: Bok, S. (1983), *Secrets: On the Ethics of Concealment and Revelation*, Pantheon Books, New York; Allen, A. L. (1988), *Uneasy Access: Privacy for Women in a Free Society*, Rowman & Littlefield, Totowa, NJ; Gavison, R. (1980), “Privacy and the Limits of Law”, *Yale Law Journal*, vol. 89; Moore, A. D. (2003), “Privacy: Its Meaning and Value”, *American Philosophical Quarterly*, vol. 40; Gross, H. (1967), “The Concept of Privacy”, *New York University Law Review*, vol. 42; Van Den Haag, E. (1971), “On Privacy” in Pennock, R. and Chapman, J. (eds.), *Privacy Nomos XIII*, Atherton, New York. Шүүмжлэх хандлага: DeCew, J. W. (1997), *In Pursuit of Privacy: Law, Ethics, and the Rise of Technology* Cornell University Press, Ithaca, NY; Solove, D. J. (2002), “Conceptualizing Privacy”, *California Law Review*, vol. 90; David M. O'Brien, *Privacy, Law, And Public Policy* 16 (1979); Barrington Moore, Jr., *Privacy: Studies in Social and Cultural History* 73 (1984); Бусад.

²⁵ Голлох эх сурвалжууд: Westin, A. (1968), *Privacy and Freedom*, Atheneum, New York; Moore, A. D. (2001, 2004), *Intellectual Property and Information Control: Philosophic Foundations and Contemporary Issues*, Transaction Publishing, New Brunswick, NJ; Miller, A. R. (1971), *The Assault on Privacy: Computers, Data Banks, and Dossiers*, Univ. of Michigan Press, Ann Arbor, MI; Parker, R. B. (1974), “A Definition of Privacy”, *Rutgers Law Review*, vol. 27; Adam Carlyle Breckenridge, *The Right to Privacy* 1 (1970). Шүүмжлэх хандлага: Schoeman, F. (ed.), 1984, *Philosophical Dimensions of Privacy: An Anthology*, Cambridge: Cambridge University Press; Inness, J. (1992), *Privacy, Intimacy, and Isolation*, Oxford University Press, New York; Parent, W. A. (1983), “Privacy, Morality, and the Law”, *Philosophy and Public Affairs*, vol. 12; Thomson, J. J. (1975), “The Right to Privacy”, *Philosophy and Public Affairs*, vol. 4; Solove, D. J. (2002), “Conceptualizing Privacy”, *California Law Review*, vol. 90; DeCew, J. W. (1997), *In Pursuit of Privacy: Law, Ethics, and the Rise of Technology* Cornell University Press, Ithaca, NY ба бусад.

²⁶ Голлох эх сурвалжууд: Richard Posner, *Economic Analysis of Law*, Little, Brown, Boston. 1998; Jourard, S. M., *Some Psychological Aspects of Privacy, Law and contemporary problems*, 1966, vol. 31; Etzioni, A. (1999), *The Limits of Privacy*, Basic Books, New York. Шүүмжлэх хандлага: DeCew, J. W. (1997), *In Pursuit of Privacy: Law, Ethics, and the Rise of Technology* Cornell University Press, Ithaca, NY; Inness, J. (1992), *Privacy, Intimacy, and Isolation*, Oxford University Press, New York; Benn, S. I. (1971), “Privacy, Freedom, and Respect for Persons”, in Pennock, R. And Chapman, J. (eds.), *Privacy Nomos XIII*, Atherton, New York ба бусад.

²⁷ Голлох эх сурвалжууд: Freund, P. A. (1971), “Privacy: One Concept or Many?” in Pennock, R. and Chapman, J. (eds.), *Privacy Nomos XIII*, Atherton, New York; Reiman, J. (1976), “Privacy, Intimacy, and Personhood”, *Philosophy and Public Affairs*, vol. 6, pp. 26-44; Benn, S. I. (1971), “Privacy, Freedom, and Respect for Persons”, in Pennock, R. and Chapman, J. (eds.), *Privacy Nomos XIII*, Atherton, New York; Bloustein, E. (1964), “Privacy and an Aspect of Human Dignity: An Answer to Dean Prosser,” *New York University Law Review*, vol. 39. Шүүмжлэх хандлага: Rubinfeld, J. (1989), “The Right of Privacy”, *Harvard Law Review*, vol. 102; Gavison, R. (1980), “Privacy and the Limits of Law”, *Yale Law Journal*, vol. 89; Solove, D. J. (2002), “Conceptualizing Privacy”, *California Law Review*, vol. 90 ба бусад.

хүрээнд²⁸ эх сурвалжуудыг ерөнхийлөн дурдаж болно.

"Улсын эрх"-д тусгагдсан нь:

Жамсрангийн Цэвээн халдашгүй байх эрхийн ач холбогдлыг тэмдэглэхдээ, зөвхөн субъектив эрхийн хүрээнд ч бус, үндэсний дотоод аюулгүй байдлын баталгаа болох талаар "Улсын эрх" судалгааны тайландаа: "Улсын харьяат хүний хувийн эрх. Эрх хэмээгчийг улсын эзэн ба, улсын хэрэг шийтгэх сайдууд, улсын хурал, жич их бага яамд гагцаар онцгойлон эзэрхэх нь бус, яамд гагцаар онцгойлон эзэрхэх нь бус, эдгээрийн эзэрхэж бүхий эрх нь болбоос улс төр олон түмэнд холбогдсон эрх мөн болой. Энэхүү эрхээс гадна хүмүүс хувийн эрх хэмээх буй бөгөөд одоо цагийн дэлхий дээрх олон хүчирхэг улс хууль дүрэмд хүмүүсийн хувийн эрхийг эрхэм болгож, маш нарийнаар тогтоосон зүйлүүдийг товчлон өгүүлбээс ийн: Нэгэн зүйл. Хүн болгон бие, хэл, сэтгэл гурван чадал эрдмийг мандуулан гаргаж илтгэж өөрийн дураар, өөрийн хувийн тусыг бүтээх эрх буй тул, улсын засаг захиргааны газар буюу эсхүл энгийн хүн хэн ч атугай ёсонгүйгээр энэхүү хүний хувийн эрхийг дарлан эвдэж үл болно. Учир иймийн тул улсын засгийн хэрэг шийтгэх газар нь хүний хувийн эрхийг осолдуулалгүй нэгэн адил хамгаалбаас зохино. ... Нэгэн зүйл. Хүний суух орон гэрт учиргүйгээр эзэрхэн орж үл болно хэмээвч хааяа галын аюул зэрэг ба, гэм будлиан бүхий учирт гэрийн эзнийг асуулгүй ороход хүрвээс тухайд тогтоосон хууль дүрмийг журамлан дагаваас зохино. Нэгэн зүйл. Хүн хэн ч атугай дотроо санасанаа илтгэн гаргаж хэлэх ба, санасан мэдсэнээ бичиглэн бусад хүн лүгээ харилцан захиа авалцах эрх буй. Энэхүү хувийн эрхийг засгийн газраас буюу, эсхүл энгийн хүн алин боловч хориглож, цаазаж битүүмжилснийг задлан үзэж болохгүй... Дээр жагсаасан хувийн эрхүүдийг дарлах, цаазлахгүйгээр мандуулан хэрэглэж чадваас улс сая хүчирхэг болно хэмээн олон мэргэд номложээ. Хэрэв ард түмний хувийн эрх тусыг хөнгөнд үзэж үл ойшоон талхидан дарлаваас ард албат хүн нарын сэтгэл догширон хөдөлж улс төр самууран эвдэрсэн нь олон үзэгдэнэ" гэсэн байна.²⁹

²⁸ Голлох эх сурвалжууд: Charles Fried, Privacy, 77 Yale L.J. (1968); Rachels, J. (1975), "Why Privacy is Important", Philosophy and Public Affairs, vol. 4; Gerety, T. (1977), "Redefining Privacy," Harvard Civil Rights and Civil Liberties Law Review, vol. 12; Rosen, J. (2000), The Unwanted Gaze: The Destruction of Privacy in America, Random House, New York; Cohen, J., 2002, Regulating Intimacy: A New Legal Paradigm, Princeton: Princeton University Press; Gerstein, R., 1978, "Intimacy and Privacy", Ethics, 89: 76-81. Шүүмжлэх хандлага: Jeffrey H. Reiman, Privacy, Intimacy, and Personhood, In Philosophical Dimensions Of Privacy; Daniel Solove. Conceptualizing Privacy. 2002; Daniel A. Farber, Book Review: Privacy, Intimacy, And Isolation By Julie C. Inness, 10 Const. Comment. 510, 514-15 (1993), 515; Judith Wagner Decew, In Pursuit Of Privacy: Law, Ethics, And The Rise Of Technology 48 (1997); W.L. Weinstein, The Private and the Free: A Conceptual Inquiry, in Nomos XIII; Priscilla M. Regan, Legislating Privacy: Technology, Social Values, and Public Policy 213 (1995).

²⁹ Ж.Цэвээн - Улсын эрх. Хөрвүүлэг: Эрх зүйт ёс сан 2014 он. 26-30 тал

III. ХАРИЛЦАН ХҮЛЦЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ТОЙМ

Үзэл баримтлалын зарчмууд

Энэ эрхийн үзэл баримтлалыг түүхчлэн сурвалчлахад багагүй агуулга, баримтуудыг үзэх боломжтой.³⁰ Харин орчин үеийн эрх зүйн үзэл санааг тодорхойлоход хэд хэдэн зарчмыг харгалзах ёстой:

- **Олон талбарт ойлголт гэдгийг хүлээн зөвшөөрөх:** Хуульд "халдашгүй байх эрхтэй" хэмээн тусгасан ерөнхий агуулгын цаана энэ эрхийг зөвхөн нэг ухагдахуунаар хязгаарлаж тодорхойлж болохгүй. Тухайлбал хүний зөвхөн бие махбодь халдашгүй байх бус, хувийн орон зай, хувийн мэдээлэл, шийдвэрийн талбарууд халдашгүй байна. Хуульд нэрлэсэн захидал, орон байр гэх мэт объектууд нь уг эрхийн хамгаалалтыг зөвхөн эдгээр объектоор хязгаарлах үндэслэл болохгүй.
- **Харилцааны хам утгыг харгалзах:** Нийгмийн ямар төрлийн харилцаа гэдгээс шалтгаалан яг адилхан үйлдлээр энэ эрх нэг бол зөрчигдөж, эсвэл зөрчигдөхгүй байх боломжтой. Жишээ нь ажлын байранд нүцгэн байх, эмнэлэгт нүцгэн байх ялгаатай. Улс төрийн итгэл үнэмшлийг ямар нэг сонирлыг клубын ярилцлагын үед асуух, ажлын ярилцлагын үед асуух ялгаатай гэх мэт.
- **Нийгмийн соёл, уламжлалын ялгааг зөв харгалзах:** Нэг нийгэмд хүнтэй мэндлээд тэврэх буюу үнсэх соёл нь халдашгүй байх эрхийг зөрчсөнд тооцогдохгүй байхад өөр нийгэмд хүртэхүйн хувьд уг эрхийг зөрчсөнд тооцогдох тул ийм ялгааг харгалзах ёстой. Гэвч, глобал цахимжилт нь ийм соёлын хэм хэмжээгээр зохицуулах боломжгүй хурдацтай явагдаж байгаа тул цахим орчны хувьд нийгэм соёлын онцлогоос үл шалтгаалан эрхийн хамгаалалтыг хуульчлах шаардлагатай.

Харилцан хүлцлийн үзэл баримтлал энгийнээр

Дээрх зарчмууд буюу дүрмүүдэд тулгуурлан харилцан хүлцлийн үзэл баримтлал бүрэлддэг. Уг баримтлалыг энгийнээр тайлбарлавал, хүн бүр өөрийн мэдээлэл, хүртэхүй (хүрэх, мэдрэх), шийдвэрийн орон зайг өөрийнхөөрөө удирдах эрмэлзэлтэй байдаг. Үүнийг хүн "хэнд нууцаа хэлэх, хэний хувийн асуудлыг сонсох, өрөөндөө хэнийг оруулах, хэний биед хүрэх буюу өөртөө хүргэх, үнэртэх, өдрийн хоолоо эсвэл ерөнхийлөгчөө сонгохдоо хэний саналыг сонсох..." гэх мэт энгийн зүйлсээр төлөөлүүлэн ойлгож болно. Харин энэхүү эрмэлзэл бусдын ижил эрмэлзлээр хязгаарлагддаг бөгөөд хүмүүс бие биеийнхээ эрмэлзэл, оршихуйг харилцан хүлцэхээс өөр аргагүйд хүрдэг.

³⁰ Хувийн халдашгүй байх эрхийг түүхэн хөгжлийн хувьд: Хувийн халдашгүй байдлын үзэл сэтгэлгээ бүрэлдэж эхэлсэн үе; Хувийн халдашгүй байх эрхийн тулгуур үзэл санаа бүрэлдсэн үе; Орчин үеийн үзэл хандлага төлөвшсөн үе хэмээн ангилах боломжтой.

Жишээ нь хэн нэгэн бусдаас ангид, ганцаар байхыг эрмэлзэх ч нийтийн тээвэр, гудамж талбайд бусад хүнтэй тухайн орон зайг хуваалцахаас өөр аргагүй тул хүлцэх ёстой. Энэ тохиолдолд автобусны сандал дээр үл таних хүн зэрэгцэж сууснаар хүний халдашгүй байдал буюу эрмэлзэл зөрчигдөх боловч тухайн этгээдийн халдашгүй байх эрх зөрчигдөхгүй (хүлцэх ёстой учраас). Харин хүний гэрт танихгүй этгээд зөвшөөрөлгүй нэвтрэх нь эрхийн зөрчил болно (хүлцэх ёсгүй учраас). Биен дээрх содон тэмдгээ бусдаас нууцлахыг хүсэвч эмчид үзүүлэх зорилгоор бусдад нүцгэн биеэ харуулах шаардлагатай. Ингэснээр халдашгүй байдал алдагдаж байгаа хэдий ч харилцах хүлцлийн үүднээс эрх зөрчигдсөн гэх үндэслэлгүй байна.

Хүний халдашгүй байх эрмэлзэл буюу халдашгүй байдал нийгэмд бусадтай хамтран орших үед заавал хязгаарлагддаг. Энэхүү хязгаарлалт нь хүмүүсийн хүлцэх хэмжээнд байснаар уг эрх зөрчигдөхгүй бөгөөд хүлцлийн хил заагаас хэтэрснээр халдашгүй байх эрх зөрчигдөх юм. Үүнийг харилцан хүлцлийн үзэл баримтлал хэмээн ойлгож болно.

Тоймловол, хүн мэдээлэл, хүртэхүй, шийдвэр гэсэн талбаруудад бусдаас ангид байх, эсвэл тодорхой этгээдүүдтэй энэхүү талбараа хуваалцах буюу эл талбаруудыг өөрөө удирдах эрмэлзэлтэй боловч хүмүүсийн ийм эрмэлзлүүд харилцан эсрэг үйлчилснээр бие биеэ хүлцэхээс өөр аргагүй болдог. Тэрхүү хүлцлийн хил зааг нь нийгмийн олон янз хэм хэмжээгээр тогтоогддог бөгөөд зөрчигдсөн үед халдашгүй байх эрхийн зөрчил болно.

Харилцан хүлцлийн үзэл баримтлалын дагуу:

- Хувийн халдашгүй байдлыг хүний [бие даасан] үндсэн эрх мөн гэдгийг баталгаажуулсан байх (Өмчлөх болон амьд явах зэрэг бусад эрхийн дэд хэсэг биш);
- Хувийн халдашгүй байх эрхийн хүртэхүй, мэдээлэл, шийдвэрийн талбаруудыг харилцан уялдаат байдлаар хүлээн зөвшөөрсөн байх (зөвхөн нууц, орон байр зэрэг объектив хамгаалалтаар үл хязгаарлагдах);
- Тус хувийн халдашгүй байдлын талбаруудаа үндэслэл бүхий хуулийн хязгаарлалтаас бусад тохиолдолд хувь хүн өөрөө удирдах эрхтэй байх (тухайлан хамгаалснаас бусад үед хязгаарлагдах бус, хязгаарласнаас бусад үед хамгаалагдах);
- Хувийн халдашгүй байдлын талбараа удирдах эрхийг бусдын хууль бус халдлагаас хамгаалах төрийн үүргийг тогтоосон байх (хязгаарлалтын баримтлал).

Шалгуур

Хуульд халдашгүй байх эрхийг баталгаажуулсан боловч ямар тохиолдолд зөрчигдсөн буюу хангагдсан байх вэ гэдгийг нарийн заах боломжгүй. Харилцан хүлцлийн үзэл баримтлал нь субъектив харилцаа бүрт уг эрхийн зөрчил, хамгаалалтын агуулгыг тодорхойлж өгөх боломжтой юм. Хүлцлийн зааг зөрчигдсөн эсэхийг тодорхойлох нийтлэг хоёр арга бий.

Нийгмийн норм. Х.Ниссанбаум (Nissenbaum Н., 2010, р. 3) нийгмийн нормд үндэслэсэн онолоо тайлбарлахдаа³¹ Г.Х.Врайт (Von Wright, 1963) нормын дөрвөн элементийг иш татжээ:

1. Заавал дагах шинж – ёстой, шаардлагатай гэдгийг зааварласан заавал дагах ёстой шинж;
2. Нормын субъект – тухайн нормд агуулагдах үүргийг хүлээж буй этгээд;
3. Нормын үйлдэл – тухайн нормын агуулгад зааварласан үйлдэл, үйл ажиллагаа;
4. Хэрэглэгдэх нөхцөл – нормын үйлдэл нь үүрэг бүхий этгээдэд заавал дагах ёстой хэмээн тогтоогдож буй нөхцөл.³²

Катзын тест. АНУ-ын иргэн Катзтай холбоотой, утасны бүхээг дэх яриаг нь цагдаагийн байгууллага чагнах төхөөрөмжөөр хураан авснаа түүний эсрэг хэрэглэсэн нь халдашгүй байх эрхийн зөрчил мөн эсэх талаарх маргаанд шүүгч II-р Жонн Маршалл Харланы уг хэрэгт дэвшүүлсэн сорил нь Катзын сорил хэмээн нэрлэгдэж хожим өөр хэрэгт ч хэрэглэгджээ. Катзын сорилын дагуу хувийн орон зай, халдашгүй байх эрхийн талаар хоёр төрлийн төсөөлөл байдаг бөгөөд тэрхүү хоёр төсөөлөл нь хоорондоо нийцсэн буюу давхцсан тохиолдолд дангаарших эрх хууль ёсоор хэрэгжиж буй гэж үздэг. Тэдгээр нь: (1) хэн нэгэн этгээдийн аливаа объектыг хувийн орон зай, нууцад хамаарах буюу дангаарших эрхийн объект мөн гэж бодсон хүлээлт, бодомж (субъектив төсөөлөл), (2) тухайн объектыг мөн этгээдийн эрхэд хамаарна гэж хүлээн зөвшөөрсөн нийгмийн нийтлэг үзэл, төсөөлөл (объектив үнэлэмж) юм.

³¹ “...миний онолын дагуу ялгаатай нийгмийн контекстэд (боловсрол, улс төр гэх мэт) үйлчилж буй нийгмийн норм, дүрмүүд нь мэдээллийн урсгалыг зохицуулдаг ... ба эдгээр контекстээс хамаарсан мэдээллийн норм нь тухайн контекстэд голлох харилцаа, сонирхол, үйл ажиллагаа зэргийг тодорхойлж хүмүүсийг хор уршгаас хамгаалдаг. Түүхийн, соёлын, тэр бүүхэл газар зүйн ялгаанаас шалтгаалан мэдээллийн норм цаг хугацааны явцад тогтмол хувьсаж иржээ. ... Үйлдэл, практик нь нормоор зохицуулагддаг гэдэгт би ердөө ихэнх хүмүүс тухайн нормыг дагадаг талаар бус тэдгээр хүмүүс тийнхүү дагах ёстой хэмээн итгэж буйг илэрхийлж байна” (Nissenbaum Н., 2010, р. 138)

³² Мөн Философич Кристина Бичиери (Bicchieri, 2000) “Нийгмийн норм гэдэгт хоёр үндсэн ойлголтыг хамааруулж болно. Нэгдүгээрт тодорхой нөхцөлд хүмүүсийн нийтлэг үйлддэг үйлдэл буюу аливааг ‘хэвийн’ зан араншинд тооцох хэм хэмжээ. Хоёрдугаарт нийгэмд түгээмэл хүлээн зөвшөөрөгддөг эсвэл үл зөвшөөрдөг, хүмүүсийн байх ёстой хэмээн итгэдэг зүйлс. Эхнийх нь дискритив, удаах нь норматив утгыг агуулж буй” гэсэн байна.

IV. МОНГОЛ УЛС ДАХЬ ХУВИЙН ХАЛДАШГҮЙ БАЙХ ЭРХИЙН ХУУЛЬ ЗҮЙН ХАМГААЛАЛТ БА ХАРИЛЦАН ХҮЛЦЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Монгол Улсын 1992 онд баталсан шинэ Үндсэн хуулиар хүний эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрч, баталгаажуулсан. Уг хууль үндэсний эрх зүйн тогтолцоонд хэм хэмжээний төдийгүй үзэл баримтлалын суурь болно. Энэ утгаараа, хувийн халдашгүй байдал хүний эрх болохын хувьд тус хуульд хэрхэн баталгаажсанаас шалтгаалж салбар эрх зүй, салбар дундын буюу холимог эрх зүйн бусад хэм хэмжээнд тусгагдсан агуулгыг нь тодорхойлох боломжтой.

Монгол Улсын Үндсэн хуулийн §16.13-т “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, ... мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. ...” хэмээн заасан нь **хувийн халдашгүй байх эрхийн Үндсэн хуулийн баталгаа** мөн.

Үүнээс “халдашгүй ... байх эрхтэй... Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, ... мөрдөн мөшгих ... –ийг хориглоно” хэмээн заасан нь хувийн халдашгүй байдлын **хүртэхүй, мэдээллийн талбарыг шууд хамгаалсан** ба “... чөлөөтэй байх эрхтэй ... Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч ... эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно...” хэмээсэн нь хувийн **шийдвэрийн талбарын шууд хамгаалалтыг агуулсан** байна.

Мөн заалтад “... Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална” гэсэн нь хувийн мэдээллийн халдашгүй байдлын талбарт багтах “нууц”-ыг; хувийн орон зайг хамгаалдаг утгаараа хүртэхүйн халдашгүй байдлын талбарт багтах “орон байр”-ыг улам чухалчилж, эдгээр объектыг тухайлан хамгаалсан хууль баталж мөрдүүлэх шаардлагыг тодорхойлжээ. Энэхүү тухайлсан агуулга нь уг заалтын эхний хэсгүүдэд тусгагдсан өргөн хүрээний агуулгыг үгүйсгэхгүй. Өөрөөр хэлбэл нууц болон орон байр нь хүний хувийн халдашгүй байх эрхийн объектууд мөн боловч Үндсэн хуульд нэрлэн зохицуулсан нь тус эрхийн агуулгыг эдгээр объектын хүрээнд явцуу утгаар тайлбарлах үндэслэл болохгүй. Энэ утгаараа Үндсэн хуульд заасан “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй” гэсэн хувийн халдашгүй байх эрхийн тулгуур агуулгыг харилцан хүлцлийн үзэл баримтлалын үүднээс үзвэл зөвхөн аль нэг талбараар хязгаарлалгүй хүртэхүй, мэдээлэл, шийдвэрийн харилцан уялдаат байдлаар нь тодорхойлох боломжтой байна.

Хувийн халдашгүй байдлын эдгээр талбарууд нь үндэсний эрх зүйн тогтолцоонд тодорхой хэмжээнд хамгаалагдсан, зохицуулагдсан байна.

Хүртэхүйн халдашгүй байдал: Хүн хүртэхүйн хувьд халдашгүй байна. Үүнд зөвхөн бие махбодь, орон байр зэрэг хил хязгаарыг нь объектив байдлаар шууд нэрлэн тодорхойлох боломжтой объектоос гадна хувийн орон зай

бүхэлдээ хамаарна. Энэ эрхийн агуулгад ямар объект халдашгүй байхаас илүүтэй ямар орон зай халдашгүй байх тухай субъектив нөхцөл чухал байна. Такси, хоолны ширээ, утасны бүхээг, ариун цэврийн өрөө зэрэг тухайн нөхцөлд хүн бусдаас ангид байх харилцан хүлцлийн зааг бүхий бүх орон зайг үүнд хамааруулна. Хамгаалагдах аргын хувьд тухайн орон зайд бусад этгээд нэвтрэн орохоос гадна технологийн тусламжтай халдах, тэр бүүхэл хүсээгүй дуу чимээ, үнэр, харагдац зэргээр энэ талбарыг зөрчих боломжтой.

Үндэсний эрх зүйн тогтолцоонд Монгол Улсын олон улсын гэрээний зохицуулалтаас гадна органик ба ердийн хууль тогтоомжиор энэ эрхийг тодорхой хэмжээнд хамгаалсан байна. Тухайлбал, хүний орон байр зэрэг (1) хүртэхүйн халдашгүй байдалд хамаарах бөгөөд (2) өмчийн эрх зүйн зохицуулалтад хамаарах боломжтой объектуудын (өмч, эзэмшлийн зүйл) хамгаалалт нь *шууд бусаар* энэ эрхийн хамгаалалт болдог. Өмчийн хамгаалалт нь иргэний эрх зүйн хэм хэмжээгээр баталгаажсанаас³³ гадна энэ эрхийн зөрчил тодорхой нөхцөл, шинжийг агуулсан тохиолдолд захиргааны³⁴ болон эрүүгийн³⁵ хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан байдаг. Нөгөө талаас хүртэхүйн халдашгүй байдлыг хамгаалах өнцгөөс биш ч хүний зан үйлийг зохицуулах хэлбэрээр³⁶ үндэсний эрх зүйн тогтолцоонд хүртэхүйн халдашгүй байдал мөн шууд бусаар хамгаалагддаг.

Гэвч өмчлөх эрхийг зөрчихгүйгээр хувийн орон зайд халдах боломж бүрэн бий. Өмчийн буюу эзэмшлийн эрхээр хамгаалагдаагүй орон зайд халдахаас гадна өмчлөгчийн зөвшөөрөлтэйгөөр өмчлөлийн зүйлтэй харьцахдаа хүртэхүйн халдашгүй байдлыг зөрчих боломжтой. Нөгөө талаас хүний зан үйл, үйлдлийн талаарх эрх зүйн нэг бүрчлэн нэрлэсэн зохицуулалтаар хүртэхүйн халдашгүй байдлын бүхий л нөхцөлийг хамгаалах боломжгүй. Энэ утгаараа хүртэхүйн халдашгүй байдлыг нэрлэн зохицуулснаас бусад тохиолдолд зөрчигдөхөөс эрсдэлтэй салбарчилсан зохицуулалтаас илүүтэй хязгаарласнаас бусад тохиолдолд хамгаалагдах ерөнхий буюу төвлөрсөн зохицуулалт тогтоох шаардлага байна. Монголын эрх зүйн тогтолцоонд, зарим харилцаанд хувийн орон зайг хуулиар шууд зохицуулсан³⁷ нь

³³ Тухайлбал, Иргэний хуулийн §101.1-т “Өмчлөгч ... өмчлөлийн зүйлээ ... аливаа халдлагаас хамгаалах эрхтэй” гэжээ. Түүнчлэн сервитут зэрэг өмчлөгчийн эрхийг хязгаарласан тохиолдолд үүсэх үүргийн талаарх зохицуулалт энэ хэсэгт хамаарна.

³⁴ Тухайлбал, Зөрчлийн тухай хуулийн §8.1.1-т “1.Бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газарт нэвтрэх ... нэвтрэсэн бол хүнийг хорин таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

³⁵ Тухайлбал, Эрүүгийн хуулийн §13.6 (Бусдын орон байранд хууль бусаар нэвтрэн орох); §13.7 (Хууль бусаар нэгжих, хураан авах, битүүмжлэх); 13.12 (Хууль бусаар мөрдөж мөшгих).

³⁶ Тухайлбал, Эрүүгийн ба Зөрчлийн тухай хуулиар бусдын буюу олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулахыг хориглосон хэм хэмжээг тогтоосон. Уг агуулга мөн чанартаа хүний дангаарших эрхийг хамгаалахад чиглэгдсэн бөгөөд буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэхэд хохирогч буюу эрх нь зөрчигдсөн этгээд тухайн үед “амгалан, тайван” байсан эсэх нь хууль хэрэглээний шалгуур болохгүй. Өөрөөр хэлбэл хохирогч этгээд сандарсан, бухимдсан болон сэтгэл зүйн ямар төлөвт байсан нь түүний эрхийг зөрчигдсөн эсэхийг тодорхойлох үндэслэл биш.

³⁷ Хүүхдийн эрхийн тухай хуулийн §10.1.6-д эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь “хүүхдийн ... хувийн орон зайг хамгаалах үүрэгтэй”, §7.3-т “Хүүхэд өөрийн нэр төр ... орон байрны

салбарчилсан загвар дотроо ач холбогдолтой.

Мэдээллийн халдашгүй байдал: Хүний хувийн мэдээлэл халдашгүй байна. Нууцаас гадна нууцад үл хамаарах хувийн мэдээллийг хуульд зааснаас бусад үндэслэлээр цуглуулах, ашиглах буюу түгээхийг хориглоно. Монголын үндэсний эрх зүйн тогтолцоонд мэдээллийн халдашгүй байдлыг эрүү³⁸, иргэн³⁹, захиргааны⁴⁰ эрх зүйн хүрээнд тодорхой хэмжээгээр хамгаалсан байна. Мөн 2021 онд хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг баталж мөрдүүлсэн нь энэ талбарын зохицуулалтад өндөр ач холбогдолтой.

Энэ эрхийн агуулгад хүн өөрийн хувийн мэдээллээ хэнтэй хуваалцахаа өөрөө шийдвэрлэх эрхээс гадна хэний хувийн мэдээллийг хүлээн авахаа ч өөрөө шийдвэрлэх эрх хамаарна. Хүсээгүй мессеж, хүний хувийн шинжтэй дуу, дүрс агуулсан мэдээлэл, эсвэл улс төр, шашны үзэл суртлын шинжтэй мэдээлэл, бараа үйлчилгээний талаарх зар сурталчилгаа гэх мэтийг хүлээн авахаас татгалзах эрхтэй.

Шийдвэрийн халдашгүй байдал: Хувийн шинжтэй шийдвэрүүдээ хүн бие даан, хараат бусаар гаргах эрхтэй. Өдөр тутамдаа ямар хувцас өмсөх, хаана хооллох, ямар төрлийн хөгжим сонсох, гар утсандаа ямар нэгэн программ суулгах эсэх зэргээ өөрөө шийдвэрлэнэ. Түүнчлэн хэнтэй гэрлэх, найз нөхдийн харилцаа үүсгэх, үр хүүхэдтэй болох эсэх, ямар мэргэжил эзэмших, ямар өнгөтэй тээврийн хэрэгсэл худалдаж авах нь энэ эрхэд хамаарна. Засгийн газар буюу бусад хүн, байгууллага хүний өмнөөс шийдвэр гаргах, шийдвэр гаргуулахаар албадахыг хориглоно. Хүний хувийн шийдвэрт зориудаар нөлөөлөх аливаа ажиллагаа нь зохих ёсны зарчимд нийцсэн байх бөгөөд мэдээллийн ил тод байдлыг хангасан байх (тухайлбал төлбөртэй нэвтрүүлэг, сурталчилгааг төлбөртэй талаар мэдээлэх) шаардлагатай.

Шийдвэрийн халдашгүй байх эрхийг зарим харилцаанд шууд зохицуулахаас (тухайлбал гэрээний эрх чөлөөний зарчим) гадна ерөнхийд нь мэдээллийн урсгалын зохицуулалтаар шууд бус хамгаалалт тогтоодог (хувийн мэдээллийн хамгаалалт, мэдээллийн ил тод байдлын зохицуулалт).

халдашгүй байдал, хувийн орон зайгаа хамгаалуулах эрхтэй” хэмээн тус тус заасан.

³⁸ Тухайлбал Эрүүгийн хуулийн §§13.8, 13.10, 13.11, 13.12-т энэ эрхийн зөрчлийг тодорхой нөхцөлөөр гэмт хэрэг тооцохоор хуульчилсан.

³⁹ Тухайлбал хувийн нууцыг эзнийх нь зөвшөөрөлгүй тараах (§21.4), иргэний дүрсийг олон нийтэд үзүүлэх (§21.5) явдлаас гэм хор учирсан бол шаардах эрхтэй байхаар хуульчилсан. Эдийн бус баялгийн гэм хорыг арилгахад мэдээ тараасан бус худал мэдээ тараасан тохиолдолд мөнгөөр нөхөн төлөх зохицуулалт нь хувийн халдашгүй байх эрхийн хамгаалалтыг явцууруулсан шинжийг агуулж байна.

⁴⁰ Тухайлбал Зөрчлийн тухай хуулийн §§6.22, 6.27 зүйлүүдийг үзэх.

V. ДҮГНЭЛТ, САНАЛ

Хувийн халдашгүй байх эрх нь нь өмчийн буюу бусад эрхийн дэд хэсэг биш, бие даасан үндсэн эрх бөгөөд агуулга нь Үндсэн хуульд нэрлэсэн “хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байр”-аар үл хязгаарлагдах ба **хүртэхүй, мэдээлэл, шийдвэр** гэсэн гурван талбарт хамгаалалт тогтоодог.

Халдашгүй байх эрх нийгмийн харилцаа бүрт янз бүрээр хангагдаж, зөрчигдөж байдаг учраас агуулгын хувьд динамик ойлголт. Тиймээс түүнийг хамгаалах хууль зүйн механизм уг динамик агуулгыг бүхэлд нь багтаасан шаардлагатай. “Харилцан хүлцлийн үзэл баримтлал” Үндсэн хуулийн агуулгыг бүрэн тайлбарлах бөгөөд субъектив эрхийн хамгаалалтыг уг баримтлалд нийцүүлэн тогтоох (жишээ нь: АНУ-ын “privacy tort”-той төстэй гэм хорын зохицуулалтыг иргэний хуульд тогтоох) боломжтой.

Нэгдсэн үзэл баримтлал дутмаг байдлаас шалтгаалан нэгдүгээрт, Монгол Улсын эрх зүйн тогтолцоонд энэ эрхийн хамгаалалт тусгагдсан нь агуулгыг нь бүрэн хамарч чадаагүй, хоёрдугаарт энэ эрхийн талаарх олон нийтийн ухамсар, ойлголт маш хангалтгүй түвшинд байна. Энэ эрхийн динамик шинж нь (нийгмийн харилцаа бүрт өөр өөрөөр хэрэгждэг) түүний хамгаалалтыг эрх зүйн харилцаанд оролцогчдын мэдрэмж, ухамсраас ихээхэн хамааралтай болгодог. Олон улсын жишгээр үзэхэд хуулийг зөв тогтоохоос гадна хувийн халдашгүй байдлын асуудлыг эрхлэх төрийн байгууллагын үйл ажиллагааг үлэмж идэвхжүүлэх, эрх зүйн соёлын нөлөөллийн ажлуудыг ч хэрэгжүүлэх шаардлагатай байдаг.

Энэ өгүүллээр судалгааны зорилгын хүрээнд хувийн халдашгүй байх эрхийн үзэл баримтлалд төвлөрсөн бөгөөд цаашид сэдвийн талаар өргөн хүрээний ажлыг хэрэгжүүлэх шаардлагатай.

VI. НОМ ЗҮЙ:

Монгол эх сурвалж:

1. Амархүү.О. Эрх зүйн онол. УБ., 2018 он
2. Буянхишиг.Б. Эдийн засгийн эрх чөлөөг үндсэн хуулиар хангалттай хамгаалсан уу?. Үндсэн хууль ба эрх зүйт ёс VII эмхэтгэл. УБ., 2016 он
3. Бямбаа.Ж, Эрхэсхулан.Ж. Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал. УБ., 2018 он
4. Бямбаа.Ж. Арванзургадугаар зүйлийн 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14 зүйлийн тайлбар, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. Ханнс Зайделийн сан. УБ., 2009 он
5. Бямбажаргал.А, Өнөрбаяр.Ч. Үндсэн хуулийн эрх зүйн судалгаа шинжилгээний тойм. УБ., 2019
6. Дворкин.Р. Хуулийн эзэнт гүрэн. Орч Я.Очирсүх. УБ., 2015 он
7. Жалбажав.Н. Үндэсний эв нэгдлийг хангах, эв эеэ хичээх сэтгэлгээг

- төлөвшүүлэх арга зүйн үндэс. (Шихихутуг сэтгүүлийн тусгай дугаар. УБ., 2021 он
8. Лүндээжанцан.Д, Жалбажав.Н нар. Эрх зүйн философи. УБ., 2014 он
 9. Мөнхсайхан.О. Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний үндсэн эрхийн хүрээг тодорхойлох нь. Хүний эрх сэтгүүл. УБ., 2016 он
 10. Нарангэрэл.С. Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001 он
 11. Нямсүрэн.Ч. Эрх зүйн ерөнхий онол. УБ., 2017 он
 12. Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн. Үндсэн хууль манай сургуульд: НҮБ-ын Хүний эрхийн ерөнхий хороодын ерөнхий тайлбар, сургалтын хөтөлбөр. УБ., 2023 он
 13. Хатанзориг.М нар. Эртний хуулиуд - Ойрх дорнод. УБ., 2021 он
 14. Хатанзориг.М. Хүний дангаарших эрхийн талаар АНУ-ын Дээд шүүхийн голлох шийдвэрүүд. №2Катзын маргаан. Шихихутуг сэтгүүлийн тусгай дугаар. УБ., 2021 он
 15. Хатанзориг.М. Хүний дангаарших эрхийн талаар АНУ-ын Дээд шүүхийн голлох шийдвэрүүд. №1Грийсволдын маргаан. Шихихутуг сэтгүүл. УБ., 2021 он
 16. Хатанзориг.М. Хүний хувийн мэдээллийн ашиглалт, хамгаалалт үндэсний аюулгүй бадйлын уламжлалт бус сорилт болох нь: эрх зүйн шинэтгэлээр шийдвэрлэх арга зам. УБ., Дотоод аюулгүй байдал хурлын эмхэтгэл. 2022 он
 17. Цэвээн.Ж. Улсын эрх. Эрх зүйн ёс сан. УБ., 2014 он
 18. Чимид.Б. Үндсэн хуулийн мэдлэг. УБ., 2008 он
 19. Чимид.Б. Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл. УБ., 2004 он
 20. Чинбат.Н. Иргэний эрх зүйн лекцийн хураангуй. УБ., 2014 он
 21. Энхбаатар. Ч. Үндсэн хуулийн эрх зүй. УБ., 2007 он

Гадаад эх сурвалж:

1. Adrienn, L. (2016). "What is Privacy? The History and Definition of Privacy."
2. Allen, A. L. (1988). *Uneasy Access: Privacy for Women in a Free Society*. Totowa, NJ.: Rowman & Littlefield.
3. Allen, A. L. (2013). An Ethical Duty to Protect One's Own Information Privacy? 64 ALA. L. REV. 845.
4. Arius, P. (1993). Introduction. In P. Arius, Introduction, in *A History of Private Life III*.
5. Bell, A., & Parchomovsky, G. (2019). The Privacy Interest in Property. Faculty Scholarship at Penn Law.
6. Benn, S. I. (1971). Privacy, Freedom, and Respect for Persons. In R. a. Pennock, *Privacy Nomos XIII*. Atherton, New York.

7. Burke, S. (2000). *Delos: Investigating the notion of privacy within the ancient Greek house*.
8. Decew, J. W. (1997). In *Pursuit Of Privacy: Law, Ethics, And The Rise Of Technology*.
9. Dewey, J. (1988). *Logic, The Theory of Inquiry* (Jo Ann Boydston ed.,).
10. Flaherty, D. H. (1972). *Privacy in Colonial New England*.
11. Floridi, L. (2005). The Ontological Interpretation of Informational Privacy. *Ethics and Information Technology*, 7(4), 185-200.
12. Fried, C. (1968). *Privacy*. 77 YALE W.
13. Gavison, R. (1980). Privacy and limits of law. *Yale law journal*, vol 89.
14. Gerety, T. (1977). *Redefining Privacy*. *Harvard Civil Rights and Civil Liberties Law Review*, vol. 12.
15. Gerstein, R. (1978). *Intimacy and Privacy*. *Ethics*, 89, 76-81.
16. Gross, H. (1967). *The concept of privacy*. New York.
17. Habermas, J. (1991). *The Structural Transformation of the Public Sphere*. Thomas Burger trans.
18. Ian Goldberg, A. H. (2001). Trust, ethics, and privacy. 81 B.U.L. Rev.
19. Inness, J. C. (1992). *Privacy, Intimacy, And Isolation*.
20. Jourard, S. M. (1966). *Some Psychological Aspects of Privacy*. 31 *Law & Contemp. Probs.*, 307.
21. Kang, J. (2004). *Information Privacy in Cyberspace Transactions*. 50 *Stan. L. Rev.*
22. Lindsay, D. (2005). *An Exploration of the Conceptual Basis of Privacy and the Implications for the Future of Australian Privacy Law*. *MelbULawRw* 4.
23. Moore, A. D. (2003). *Privacy: Its meaning and value*. *American Philosophical Quarterly* 40.
24. Murphy, R. S. (1996). *Property Rights in Personal Information: An Economic Defense of Privacy*. 84 *Geo. L.J.* .
25. Nissenbaum, H. (2010). *Privacy in Context: Technology, Policy, and the Integrity of Social Life*.
26. O'brien, D. M. (1979). *Privacy. Law, And Public Policy* 16.
27. Parent, W. A. (1983). "Privacy, Morality, and the Law. *Philosophy and Public Affairs*, vol. 12.
28. Parker, R. B. (1974). *A Definition of Privacy*. *Rutgers Law Review*, vol. 27.
29. Regan, P. M. (1995). *Legislating Privacy: Technology, Social Values, and Public Policy*.
30. Reiman, J. H. (1984). *Privacy, Intimacy, and Personhood* . In F. D. Schoeman, *Philosophical Dimensions of Privacy* (pp. 300-316).
31. Rosen, J. (2000). *The Unwanted Gaze: The Destruction of Privacy in America*. New York: Random House.
32. Rubenfeld, J. (1989). *The Right of Privacy*. 102 *Harv. L. Rev.* , 737, 750.
33. Ruebhausen, O. M., & Orville G. Brim, J. (1965). *Privacy and Behavioral*

- Research. 65 Colum. L Rev.
34. Samuel D. Warren, L. D. (1890 Vol.4,). The right to privacy. Harvard law review, №5, 193-220.
 35. Solove, D. (2002). Conceptualizing privacy.
 36. T. Tavani, H. (2008). Informational Privacy: Concepts, Theories, and Controversies. The handbook of Information and Computer Ethics.
 37. Thomson, J. J. (1975). The Right to Privacy. Philosophy and Public Affairs, Vol. 4, No. 4., 295-314.
 38. Van Den Haag, E. (1971). On Privacy. In R. Pennock, & J. Chapman, Privacy Nomos XIII. New York.
 39. Weinstein, W. (1971). The Private and the Free: A Conceptual Inquiry. In J. R. Pennock, & C. J., Nomos XIII.
 40. Westin, A. (1968). Privacy and Freedom. Atheneum, New York.
 41. Zimmer, M. (2005). Surveillance, Privacy and the Ethics of Vehicle Safety Communication Technologies. Ethics and Information Technology volume 7, 201–210.



Я.ЦЭЦЭНЗАЯА

Судлаач



Э.СУНДУЙ

Судлаач

ИРГЭНИЙ ҮЛ ЗАХИРАГДАХУЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ, ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ БҮРДҮҮЛЭХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА¹

THE NEED TO CREATE A LEGAL ENVIRONMENT THAT ACCEPTS CIVIL DISOBEDIENCE

Хураангуй: Техник, технологийн хөгжил, олон улсын хандлага, эдийн засаг хурдацтай өөрчлөгдөхийн хэрээр манай нийгмийн харилцаа улам нарийн, олон шинэ сорилтууд бий болж байна. Үүнтэй холбоотойгоор нийгмийн харилцааг зохицуулж буй эрх зүйн орчныг сайжруулах, тухайн нөхцөлд тохируулах мөн шинэ харилцааг танин мэдэх, нийтээр нэгдсэн ойлголтод хүрэх шаардлага бий болж байна. Үүний нэг жишээ бол нийтийн эрх ашгийг хөндсөн, бодит нөхцөлд хэрэгжих боломжгүй хууль тогтоомж, тушаал шийдвэр эсвэл шударга ёс, нийтийн хэм хэмжээнд нийцэхгүй үйл явдлыг эсэргүүцэх, таслан зогсоох, зөв шийдэлд хүргэх зорилгоор иргэн эсвэл байгууллага, бүлгүүд ухамсарт үйлдэл үзүүлэх, эс үйлдэхүй хийх тохиолдол гарах боллоо. Энэ нь нэг талаар хууль, дүрэм, журам зөрчсөн үйлдэл мэт боловч зорилго нь нийтийн сайн сайхан, нийтийн үнэт зүйлийг хамгаалсан шинжтэй бол цаашид хэрхэн авч үзэх, олон улсад болоод манай улсын эрх зүйн хэм хэмжээний хүрээнд хэрхэн зохицуулж буй талаар энэхүү өгүүлэлээр

¹ “УЛСЫН ЭРХ-110” эрдэм шинжилгээний хуралд шалгарсан бүтээл

авч үзнэ. Энэхүү сэдвийг судлах нь манай улсад шинэ тутам үүсэж буй иргэн хууль, дүрэм, журмыг үл биелүүлэх, эс үйлдэхүйтэй холбоотой харилцааг тодруулж, хууль эрх зүйн орчинд үүсэж буй нөхцөл байдлыг тодруулах ач холбогдолтой.

Abstract: As technology, international relations, and the economy rapidly evolve, social dynamics are becoming increasingly complex, creating new challenges. This calls for an updated legal framework to regulate these relations, adapt to current realities, recognize emerging issues, and foster a shared understanding. A notable example is when citizens, civic movements, or community groups take action or fail to in opposition to laws, orders, or decisions that impact the public interest but are unfeasible or unjust in practice. While such actions may seem to violate laws and regulations, they may also serve to protect public welfare and values. This article examines how such acts should be evaluated and how they are addressed internationally and within domestic legal norms. The study is crucial for clarifying the growing instances of non-compliance with laws and regulations and understanding their implications within our nation's legal framework.

Түлхүүр үг: үл захирагдахуй, өөрийгөө тодорхойлох эрх, иргэний эрхийн төлөө тэмцэгчид, апартеид бодлогыг эсэргүүцэгчид, үзэл бодлоо илэрхийлэх эрх

Keywords: Civil disobedience, Right to self-determination, Civil rights activists, Anti-apartheid activists, the rights of freedom of expression

I. ОРШИЛ

Энэхүү нийтлэлээр үл захирагдахуйн талаарх олон улсын болон дотоодын эрх зүйн ойлголтыг тодруулж, нийгэмд үүсэж буй зарим үйл ажиллагаанд үл захирахуйн шинж бий эсэхийг судалж, энэ асуудлаар санал, зөвлөмж боловсруулах зорилготой.

Иргэний үл захирагдахуйг хамгаалах олон улсын эрх зүйн хамгаалалт, Монгол Улсын эрх зүйн хүрээнд үл захирагдахуйг хэрхэн ойлгож, зохицуулж байгаа талаарх практик, манай улсад үл захирагдахуйг хүлээн зөвшөөрөх нөхцөл байдал үүссэн эсэхэд хариулт өгөх хүрээнд үл захирагдахуйн талаарх ойлголтыг олон улсын гэрээ, конвенц, пакт болон дотоодын хууль тогтоомжид баримт бичгийн шинжилгээ хийнэ. Түүнчлэн Монголын нийгэмд өрнөсөн үл захирагдахуйн шинжтэй зарим үйл явдлуудыг сонгон авч тохиолдол шинжлэх аргаар судална.

Үл захирагдахуйг Монгол Улсад либертари онолын нэг хэсэг байдлаар их сургуулийн судлагдахуун, зарим судлаачид олон нийтийн мэдээллийн хэрэгслээр философийн нэг ухагдахууны хэмжээнд хэрэглэж байна. Тухайлбал, Доктор Б.Батчулуун өөрийн бүтээлдээ Мишэль Монтэнь, Айн

Рэнд, Жон Стюарт Милл, Хэнри Дэвид Торөү нарын сэтгэгчдийн зохиол бүтээлүүдэд тусгагдсан “Ганцаар байх тухай”, “Иргэний дуулгаваргүй байдал” зэрэг манай сэдэвт хамаарах агуулгаар гаргасан үзэл баримтлалыг нарийвчлан авч үзсэн байна. Эдгээрт олонхийн санаа бодол ихэвчлэн сэтгэл хөдлөлд тулгуурладаг тул ямагт зөв байддаггүй тиймээс иргэн нийгмийн үйл явцад өөрийн оюун дүгнэлтийг хийж байх ёстой. Түүнчлэн, төрөөс гаргасан бодлого шийдвэр олон нийтийн сэтгэл хөдлөлийг чиглүүлэх шинжтэй тул нийтийн хэм хэмжээ, шударга ёсонд үл нийцвэл түүнийг дагахгүй, оролцохгүй байхыг зөвтгөсөн байна.² Мөн өнөөгийн Монгол Улсынх шиг нөхцөлд амьдарч буй хүмүүс тэмцэл хийх шаардлага үүсэж байна. Гэхдээ хүчирхийлэл бус аргаар Бойкот маягийн тэмцэл хийх нь чухал юм. Бид Махатма Ганди, Мартин Лютер Кингийн хүч үл хэрэглэх зарчим, “иргэний дуулгаваргүй байдлыг” их сонирхож, судалдаг.³

Харин судлаач Т.Энхжаргал иргэний үл захирагдахуйн тухай өгүүлэлдээ хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн Үндсэн хуульт ардчилсан Монгол Улсад дээрх сэдэв нь шинэ, энэ сэдвээр хийгдсэн судалгааны ажил байхгүй байгааг тэмдэглээд энэ сэдвээр судлах, уг нэр томъёог Үндсэн хуулийн эрх зүйн хүрээнд судалгааны эргэлтэнд оруулах зорилгоор суурь онолын болон Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүйн хүрээнд судласан гэдгээ илэрхийлсэн байна.⁴ Эдгээр ном, өгүүлэлд иргэний үл захирагдахуйг онол, эрх зүйн хувьд тодорхой судалсан боловч Монгол улсын нийгмийн үйл явц, эрх зүйн хэрэглээний хүрээнд хэрхэн илэрч буй талаар нарийвчлан судлаагүй байна.

II. ИРГЭНИЙ ҮЛ ЗАХИРАГДАХУЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Иргэний үл захирагдахуйн талаар нэгдсэн ойлголт одоогоор байхгүй байна.⁵ Иргэний үл захирагдахуйн тухай ойлголт нь эхэн үедээ ёс суртахуун, эрх зүйн философийн судлагдахуун байсан бөгөөд хожим дэлхий даяар хүний эрх, нийгмийн шударга ёсыг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэсэн.

Сэтгэгч Генри Дэвид Торөү (1817-1862) “Иргэний Засгийн газарт үзүүлэх эсэргүүцэл (1849) буюу “Үл захирагдах иргэний үүргийн тухай” эссэндээ иргэний үл захирагдахуй нь иргэний ёс суртахууны үүрэг хэмээн тодорхойлж байжээ. Орчин үеийн ардчилсан үндсэн хуульч үзлийн төлөөлөгч 18-р зууны нийгмийн гэрээний онолчид дарангуйлагч дэглэмийн эсрэг ард түмний хувьсгал хийх хамтын эрхийг хүлээн зөвшөөрсөн. Тухайлбал, Жон Локк өөрийгөө хамгаалах нь “Байгалийн хуулийн нэг хэсэг” бөгөөд хэрвээ хаан “нийгмийн эсрэг байж ... тэвчишгүй зүй бусаар нийгмийг бүхэлд нь харгис

² <https://news.mn/r/583535/>

³ Б.Батчулуун, Төр хэмээх мөсөн уул, УБ., 2022, х 292

⁴ <https://legaldata.mn/b/117.>, Д.Энхжаргал, Иргэний үл захирагдах ёс суртахууны үүрэг, 2013

⁵ The OSCE/ODIHR and the Venice Commission, however, describe civil disobedience, in their Guidelines on Freedom of Peaceful Assembly, 3rd edition (2020), as “non-violent actions that, while in violation of the law, are undertaken for the purpose of amplifying or otherwise assisting in the communication of a message.”

хэрцгийгээр дарангуйлах юм бол ард түмний нэлээд хэсэг нь энэ тохиолдолд “эсэргүүцэх, өөрийгөө хамгаалах эрхтэй.” гэж бичжээ. Жан-Жак Росо “... Ханхүү төрийг хуулийн дагуу удирдахаа больж, бүрэн эрхт эрх мэдлийг булаан авах үед төр бүхэлдээ татан буугдаж, түүний дотор зөвхөн засгийн газрын гишүүдээс бүрдэх, эзэн болон дарангуйлагчаас бусад хүмүүсийн хувьд ямар ч ач холбогдолгүй өөр нэг улс бий болно” гэж үзсэн. “Нэгэнт засгийн газар бүрэн эрхт байдлыг булаан авч, нийгмийн гэрээ эвдэрч, жирийн иргэд бүгд жам ёсны эрх чөлөөгөө сэргээж, ... ёс суртахууны хувьд дуулгавартай дагах үүрэг хүлээхгүй”.⁶ хэмээжээ.

Хожим XX зуунд Махатма Ганди, Мартин Лютер Кинг, Роза Паркс, Нелсон Мандела, Десмонд Туту зэрэг өөрийгөө тодорхойлох эрх, иргэний эрхийн төлөө тэмцэгчид, апартеид бодлогыг эсэргүүцэгчдийн үйлдэл нь иргэний үл захирагдахуйн сонгодог жишээ болж үлдсэн. Түүнчлэн дэлхий даяар маш олон хүний эрхийн идэвхтнүүд шууд болон хүчирхийллийн бус аргаар иргэний үл захирагдахуйн янз бүрийн арга хэрэглэж, хууль тогтоомжийг санаатайгаар зөрчиж байсан байна.

Хэдийгээр ардчилсан нийгэмд хууль дээдлэх зарчмыг дэмжих нь нэн чухал боловч иргэний үл захирагдахуй нь боолчлол, арьс өнгөөр ялгаварлан гадуурхалт, апартеид зэрэг хүний эрхийн бусад зөрчлийг системтэйгээр хүлээн зөвшөөрч хуульчилсан хууль, журам, институцийг эсэргүүцэх, эдгээр хууль, журмыг дагаж, биелүүлэх үүргээ гүйцэтгэхгүй байх нь эрх баригчдад шахалт үзүүлэх, шударга бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх зэрэг эерэг нөлөөллийн хэрэгсэл болдог. Иргэний үл захирагдахуй гэдэг нь үзэл бодлоо илэрхийлэх, чөлөөтэй эвлэлдэн нэгдэх улс төрийн эрхийн хэрэгжилтийн хэлбэр бөгөөд нийтийн ашиг сонирхлын үүднээс, хууль, засгийн газрын бодлогод өөрчлөлт оруулах зорилгоор⁷ хүчирхийллийн бус аргаар шударга бус хууль, журмыг зөрчих, түүнийгээ олон нийтэд ил тод мэдээллэх, эсэргүүцлээ илэрхийлэх үйлдэл юм⁸.

Иргэний үл захирагдахуй нь үйлдлийн зорилгоосоо шалтгаалан шууд болон шууд бус хэлбэрээр илэрдэг. Иргэний шууд үл захирагдахуй гэдэг нь тодорхой хуулийг санаатайгаар зөрчиж, тус хуулийг шударга бус гэдгийг нотлох⁹ үйлдэл юм. АНУ-ын 1950-60-аад оны иргэний эрхийн тэмцлийн гол зорилго нь шударга бус хуулийг зөрчих замаар шүүх дээр дуудагдах байв. Жишээ нь Роза Паркс 1955 оны 12 дугаар сарын 1-нд Алабама муж улсын Монтгомери хотын автобусны арын суудалд суухаас татгалзаж, цагаан арьстнуудын суух

⁶ J.J. ROSSEAU, THE SOCIAL CONTRACT (M. Cranston trans. 1968). 57. Id. at 133.

⁷ 1 JOHN RAWLS, A THEORY OF JUSTICE (2009), at 320.

⁸ State repression of environmental protest and civil disobedience: a major threat to human rights and democracy Position Paper by Michel Forst, UN Special Rapporteur on Environmental Defenders under the Aarhus Convention February 2024 page 5

⁹ Civil Disobedience and the Necessity Defense, John Alan Cohan, Western State Law School, The University of New Hampshire Law review, Volume 6, no.18 article 6 page 114, par 2 https://scholars.unh.edu/cgi/viewcontent.cgi?article=1093&context=unh_lr#:~:text=Indirect%20civil%20disobedience%2C%20which%20is,opinion%2C%20typically%20through%20symbolic%20action.

суудалд сууснаар хот даяар автобус бойкот зарласан байдаг. Түүний үйлдэл нь Монтгомеригийн “Тусгаарлах журам”-ыг дагаж мөрдөөгүй иргэний үл захирагдахуй байсан бөгөөд тус журам арьс өнгөөр алагчилсан, шударга бус, Үндсэн хууль зөрчсөн гэдэг нь батлагдсан юм.¹⁰

Харин эсрэгээрээ шууд бус иргэний үл захирагдахуйн хувьд хууль зөрчих нь гол зорилго биш¹¹ бөгөөд энэ нь эсэргүүцлийн хамгийн түгээмэл хэлбэр юм.¹² Иргэний шууд бус үл захирагдахуй нь ихэвчлэн бэлгэдлийн үйлдлээр олон нийтийн санаа бодлыг дайчлах, уриалах хэлбэрээр илэрдэг. Иргэний шууд бус үл захирагдахуй нь бизнесийн байгууллага, шинжлэх ухааны лаборатори, төрийн байгууламж, цэргийн гэрээлэгч эсвэл бусад байгууллагын шударга бус бодлого, хүний эрхийн зөрчилд чиглэж болдог. Тухайлбал цөмийн зэвсгийг эсэргүүцэгчид атомын цахилгаан станц руу хүрэх усан онгоцны замыг хаах зэргээр эсэргүүцлээ илэрхийлж болно. Энэ тухайд хууль зөрчих нь тэдний зорилго биш харин эсэргүүцлээ илэрхийлэх нь гол зорилго байдаг.

III. МОНГОЛ УЛСАД ИРГЭНИЙ ҮЛ ЗАХИРАГДАХУЙ ҮҮССЭН ТОХИОЛДЛУУД: ЗОХИЦУУЛСАН ТУРШЛАГА

Нийгэм хөгжихийн хэрээр иргэд өөрийн эрх ашгийг илэрхийлдэг, хамгаалдаг, бие даасан шинжтэй байж, төрийн шударга бус шийдвэрийг эсэргүүцэж, улмаар хүний эрхийн зарчим, нийтийн эрх ашигт нийцүүлж байх зайлшгүй шаардлага үүссэн байна. Энэ нь иргэний нийгмийн төлөвшлийн нэг шалгуур бөгөөд иргэний нийгэм энэ чадвараа алдахад төрийн хүлээн зөвшөөрдөх чадвар буурч, төрийн бодлого шийдвэр оновчтой бус болох эрсдэлтэй. Нөгөөтэйгүүр нийгмийн харилцаа гүнзгийрч, эрх ашиг бүхий олон бүлгүүд бий болж урьд өмнө нь төрийн чадамж, хүлээн зөвшөөрөгдөх чадвар, төрийн албан хаагчийн ёс суртахуунаар хэмжигддэг байсан харилцаанууд хяналтгүй болж иргэний үл захирагдахуйг хүлээн зөвшөөрөх шаардлагатай болж байна. Өөрөөр хэлбэл холбогдох хууль ёсны шаардлагад нийцээгүй, шударга бус төрийн шийдвэрийг иргэд биелүүлэхгүй байх, нийгэмд үүссэн шударга бус үйл явдлыг хүлээн зөвшөөрөхгүй өөрийн болон бусдын эрхийг хамгаалах, энэ мэт асуудалд төр, иргэдийн анхаарлыг хандуулсан тохиолдлууд сүүлийн жилүүдэд цөөнгүй ажиглагдах боллоо. Олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр үл захирагдахуйг үзэл бодлоо илэрхийлэх, тайван замаар хуран чуулах, эвлэлдэн нэгдэх эрхийн бүрэлдэхүүн гэж үздэг байна.

Улс төрийн эрхийг эдлэх төрөл бүрийн арга бий бөгөөд жишээлбэл эд зүйлсийн жагсаал, цахим жагсаал, үл захирагдахуй зэрэг юм. Онол, эрх

¹⁰ Browder v. Gayle, 142 F. Supp. 707, 717 (M.D. Ala. 1956), aff'd per curiam, 352 U.S. 903 (1956).

¹¹ fense of the Civilly Disobedient, 13 N.C. Cent. L.J. 158, 159-60 (1982); Note, supra note 7, at 105 n.13; Comment, supra note 7, at 906

¹² Civil Disobedience and the Necessity Defense, John Alan Cohan, Western State Law School, The University of New Hampshire Law review, Volume 6, no.18 article 6 page 114, para 3 https://scholars.unh.edu/cgi/viewcontent.cgi?article=1093&context=unh_lr#:~:text=Indirect%20civil%20disobedience%2C%20which%20is,opinion%2C%20typically%20through%20symbolic%20action.

зүйн хандлагын хувьд үл захирагдахуйн нэг гол шинж бол бусдын эрх, эрх чөлөөнд хүндэтгэлтэй хандаж хүчирхийллийн бус тайван замаар эсэргүүцлээ илэрхийлэх, эс үйлдэхүйг үзүүлэхийг тодорхой анхааруулсан байна. Түүнчлэн сүүлийн жилүүдэд манай улсад өрнөсөн зарим үйл явдлуудад иргэний үл захирагдахуйн шинж илэрсэн эсэхийг тодруулж, тухайн иргэн, бүлгийн үл захирдах эрхэд хүндэтгэлтэй хандаж, асуудлыг шийдвэрлэсэн эсэх, шийдвэрлэх явц болон шийдвэрлэлгүй орхиход хүний эрхийн зөрчил үүссэн эсэхийг дор авч үзье.

Шигтгээ 1:

Нийслэлийн Засаг дарга Х.Нямбаатарын 2023 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/1429 дугаартай “Замын хөдөлгөөний ачааллыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” захирамжаар “1.1. ... улсын дугаарын сүүлчийн орон нь сондгой тоо (1,3,5,7,9)-оор төгссөн тээврийн хэрэгслийг Даваа, Лхагва, Баасан гарагт, тэгш тоо (0,2,4,6,8)-оор төгссөн тээврийн хэрэгслийг Мягмар, Пүрэв, Бямба гарагт тус тус 08:00-20:00 цагийн хооронд замын хөдөлгөөнд оролцуулах ...” -аар шийдвэрлэсэн. Энэ арга хэмжээг 2023 оын 12 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн дагаж мөрдүүлэхээр тус захирамжид заасан. Амралтын өдөр гаргасан энэхүү шийдвэрийг 1 хоногийн дараа хэрэгжүүлж эхэлсэн нь Улаанбаатар хотын иргэдийн эрх ашигтай зөрчилдсөн бөгөөд мэдээллийн хэрэгслүүд энэхүү шийдвэрийг иргэд хэрхэн хүлээн авч байгаа болон хэрэгжилтийн талаар сурвалжууд бэлтгэсэн. Энэ дундаас NTV телевизийн цахим хуудсаараа дамжуулсан 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн бичлэгт “нэгэн иргэн тухайн өдөр улсын дугаар нь зорчихгүй тээврийн хэрэгслээрээ замын хөдөлгөөнд оролцож явсныг замын цагдаагийн алба хаагч зогсоосноор маргаан өрнөж”¹³ буй нь гардаг. Тус бичлэгт иргэн сэтгүүлчид “Үгүй үгүй бид биелүүлэхгүй. ... Цагдаагийн байгууллага нь бууны нохой шиг дандаа эд нарын гар хөл болж явах шаардлагагүй. Дандаа ард иргэдийгээ хууль нэрийн дор дарамтална. Ийм юм байхгүй. Ажилдаа явмаар байна. Эд нарын шаардлагыг биелүүлэхгүй. Х.Нямбаатар өөрөө энэ дугаарын хязгаарлалтаараа явдаг юм байгаа биз. Бид нар яагаад ч биелүүлэхгүй.” гэсэн бөгөөд үргэлжлээд Цагдаагийн алба хаагчид хандан “Бид нар хар өглөөгүүр наагуур цаагуур тойрсон түлш бензиний мөнгийг та нар бидэнд өгөх юм уу?” гэхэд “Цагдаагийн алба хаагч: Та машинаа замын зорчих хэсгээс гаргаад зогс. Та нийтийн тээвэр, өнөөдөр явж байгаа машинууд болон бусдын хөдөлгөөнд саад учруулаад байна.” гэхэд “Иргэн: Явж байгаа гэдэг чинь юу гэсэн үг юм. Бид нар тэгээд хүн биш юм уу? Нэг л хууль нэрийн дор та нар хүмүүсийг дарамталсан хүмүүс. Цагдаагийн байгууллагыг татан буулгамаар юм.” гэсэн байна. Улмаар уг иргэн Д-д 2023

¹³ https://x.com/NTVmn/status/1736671981867798866?ref_src=twsrc%5Etfw%7Ctwcamp%5Etweet-embed%7Ctwterm%5E1736671981867798866%7Ctwgr%5Eb83f87c45d034d82a1f4f297bdd130f1deb1a767%7Ctwcon%5Es1_&ref_url=https%3A%2F%2Fisee.mn%2F%2F58831

оны 12 дугаар сарын 18-ны өдөр нийтээр дагаж мөрдөхөөр эрх бүхий албан тушаалтны гаргасан шийдвэр, алба хаагчийн хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд тавьсан хууль ёсны шаардлагыг эсэргүүцсэн үйлдэл тогтоогдсон тул Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт зааснаар 250 нэгжээр торгох шийтгэл оногдуулсан. Энэ асуудлаар иргэн Д нь БГД-ийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд гомдол гаргахад шүүх хүлээж аваагүй бол 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэрээр дээрх торгуулийг хүчингүйд тооцсон.¹⁴

Дээрх тохиолдолд Нийслэлийн засаг даргын А/1429 дугаартай захирамжийг Захиргааны ерөнхий хуулийн 63.1. дэх хэсгийн “Захиргааны хэм хэмжээний актыг нэн даруй батлах шаардлагатай хойшлуулшгүй тохиолдолд энэ хуулийн 62 дугаар зүйлд заасан санал авах ажиллагааг хийхийг шаардахгүй.” гэсэнд үндэслэн гаргасан ч нэн даруй батлах шаардлагатай хойшлуулшгүй тохиолдол үүссэн эсэхийг дурдаагүй, хойшлуулашгүй тохиолдол үүссэн эсэх нь эргэлзээтэй байна. Энэ захирамжийг гаргахдаа Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6. дахь заалтад заасан “бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах тохиолдолд тэдгээрт урьдчилан мэдэгдэх, оролцоог нь хангах;” зарчмыг баримтлаагүй буюу Улаанбаатар хотын авто машинтай иргэдийн нийтлэг эрх ашгийг хөндсөн асуудал тул Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлд заасны дагуу төсөлд санал авах шаардлагатай байсан байж болох юм. Түүнчлэн хэрэгжүүлэх хугацааг тогтоохдоо олон нийтэд мэдээлэл хүрэх, иргэд шийдвэрт тохируулан ажлаа төлөвлөх боломжийг олгоогүй буюу Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.5 дахь заалтад заасан “... бодит нөхцөлд тохирсон, ...;” байх зарчмыг баримтлаагүй байх магадлалтай байна. Тиймээс иргэний зорчих эрхийг хязгаарлахдаа иргэдийн саналыг тусгаагүй, мэдээлэл иргэдэд хүрэх, ажлаа төлөвлөх хугацаа олгоогүй тул энэ судалгааны хүрээнд тус иргэнийг үл захирагдах эрхээ эдэлсэн гэж үзлээ. Түүнчлэн иргэн Д-ийн дээрх үйлдэл нь НҮБ-ын Хүний эрхийн хорооны тайван замаар хуран чуулах эрхийн талаарх 37 дугаар Ерөнхий тайлбарт (2020) тодорхойлсон хүчирхийллийн бус байх зарчмыг хангаж байна.

Шигтгээ 2:

2022 оны 4 дүгээр сарын 7-9-ний өдрүүдэд Улаанбаатар хотын Сүхбаатарын талбай, Хан-Уул дүүргийн Маршалын гүүр орчимд болон зарим аймгууд, гадаад улс орнуудад амьдарч буй Монгол Улсын иргэд “Ажлаа хий” жагсаалыг зохион байгуулсан. Ковид-19 цар тахлын нөлөөллөөс үүдсэн эдийн засгийн хохирол, үнийн өсөлт, амьжиргааны доройтол, цэцэрлэгийн сугалаа, Засгийн газар ажлаа зохих ёсоор хийхгүй байгааг эсэргүүцсэн

¹⁴ https://www.facebook.com/NTVNewsMN/posts/pfbid0ui18eFFgGMGnYWnzZ4BKLZYeeA4Q5eUTS-RyQ4pcZFS3Cwtk57iAzPveYYK69Gb1wl?locale=uk_UA

иргэд 4 дүгээр сарын 7-ны өдөр Сүхбаатарын талбайд цуглаж 15 зүйл бүхий шаардлагыг Засгийн газарт хүргүүлсэн. Уг жагсаалд давхардсан тоогоор 10,000 – 15,000 хүн оролцсон бөгөөд Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасны дагуу Нийслэл, дүүргийн засаг даргад бүртгүүлээгүй¹⁵, нэгдсэн зохион байгуулалтгүй, аяндаа үүссэн жагсаал юм.

Монгол Улсад жагсаал, цуглаан хийхдээ холбогдох сум, дүүргийн засаг даргад бүртгүүлэхийг хуульчилсан тул дээрх жагсаал хууль бус үйл ажиллагаа гэсэн үг юм. Гэхдээ аяндаа үүссэн жагсаал, цуглааныг бүртгэгдээгүй гэх үндэслэлээр албадан тараах нь хүний эрхийн зөрчил тул холбогдох байгууллагууд албадан тараагаагүй байна.¹⁶ Манай улсад жил ирэх бүр бүртгэлгүй жагсаал, цуглааны тоо нэмэгдэж байна. Тухайлбал, 2020 онд 1, 2021 онд 91, 2022 онд 191 жагсаал, цуглаан бүртгэлгүй зохион байгуулагдсан байна.¹⁷ Аяндаа үүссэн жагсаал нь үл захирагдахуйн нэг хэлбэр бөгөөд энэ тохиолдолд манай улс харьцангуй тайван байдлаар хүний эрхийг зөрчихгүй, хүлээн зөвшөөрч байна.

Шигтгээ 3:

Ковид-19 цар тахлын үед гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдалд шилжсэн үед нэг дор олон хүн цугларахыг хориглосон тул Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас (МХАҮТ) үүнийг эсэргүүцэн 2020 оны 5 дугаар сарын 1-ний өдөр хүний оролцоогүй “ээнээ хүлээсэн ажлын байрны багаж хэрэгслийн цуглаан”-ыг Спортын төв ордны өмнөх талбайд, “Ажлын байраа хамгаалъя” цахим цуглааныг интернэт орчинд зохион байгуулсан байна. Уг цуглаанд иргэд, аж ахуйн нэгжүүд цахим байдлаар нэгдэж, үзэл бодлоо илэрхийлэн оролцжээ.¹⁸ Энэ нь Монгол улсад зохион байгуулагдсан нийгмийн өргөн хүрээг хамарсан томоохон цахим цуглаан юм.

Тодруулбал, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн А/930 тоот захирамжаар гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд олон нийтийг хамарсан жагсаал, цуглааныг түр зогсоохоор, түүнчлэн иргэн, хуулийн этгээдээс зохион байгуулах олон нийтийг хамарсан арга хэмжээ, жагсаал, цуглааныг

¹⁵ “Монгол Улсад тайван замаар жагсах, цуглах эрхийг дэмжих нь” төсөл, Монгол Улсад тайван замаар жагсах, цуглах эрхийг бэхжүүлэх нь төслийн кэйс судалгааны тайлан, УБ., 2024, х 48, 49

¹⁶ НҮБ-ын Хүний эрхийн хорооны 21 дүгээр зүйлийн талаар гаргасан 37 дугаар Ерөнхий тайлбар (2020 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр UN Doc CCPR/C/GC/37), 72 дахь догол мөр. Тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний талаарх Венецийн удирдамж, ЕАБХАБ-ын Ардчилсан институци, хүний эрхийн алба (ЕАБХАБ/ АИХЭА). Страсбург/Варшав хот (2020 оны 7 дугаар сарын 15-ны өдөр CDL-AD(2019)017rev 3 дахь хэвлэл), 123-р догол мөр.

¹⁷ Монгол улс дахь хүний эрх эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, УБ., 2023, х 155

¹⁸ Монголын Эмнести Интернэшнл, Ковид 19 цар тахал хууль сахиулах ажиллагаа, Монгол Улс: Цагдаагийн байгууллага, алба хаагчдын үйлдсэн хүний эрхийн зөрчил, тохиолдол, тайлан., х 15

бүртгэхгүй байхыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон дүүргийн Засаг дарга нарт даалгасан байна. Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хуульд жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг хязгаарлах бүрэн эрхийг Нийслэлийн Засаг даргад олгоогүй байхад ийнхүү иргэдийн жагсаал, цуглаан зохион байгуулах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлаж Зөрчлийн тухай хуулиар торгууль ногдуулж, зарим тохиолдолд баривчлах нөхцлийг бүрдүүлсэн байна. Ийм нөхцөлд МХАҮТ-аас зохион байгуулсан энэхүү үйл ажиллагаа нь үл захирагдахуйн томоохон жишээ болсон юм. Энэхүү арга хэмжээнд хариуцлага тооцсон мэдээ, баримт байхгүй байгаа бөгөөд төрөөс үл захирагдахуйг хүлээн зөвшөөрсөн үйлдэл болжээ. Үүнээс гадна Ковид-19 цар тахлын үед жаглаан цуглаан зохион байгуулсан тохиолдлууд нэлээдгүй гарсан бөгөөд зарим иргэн, байгууллагад торгууль ногдуулсан, баривчилсан, зарим иргэнээс тайлбар авсан зэрэг үйлдлийг Монголын Эмнести Интернэшнлээс тайландаа дэлгэрэнгүй дурдсан байна. Энэ цаг үед жагсаал, цуглаан зохион байгуулсан эдгээр үйлдлүүдийг хүчирхийллийн бус аргаар явагдсан бол бүгд үл захирагдахуй гэж үзэж болох юм.

Шигтгээ 4:

Нэгэн өмгөөлөгч үйлчлүүлэгчийг нь хууль бусаар албадан саатуулсан талаар хэвлэлд мэдээлэл өгсөн байна. Миний үйлчлүүлэгч ...-г ... байгууллагын алба хаагчид хууль бусаар албадан саатуулаад байна. Өмгөөлөгчид нь огт мэдэгдэлгүй гэрт нь дайрч ороод нэгжлэг хийж, ... албадан баривчилсан байгаа юм. Өмнө нь нэг ч удаа ... байгууллагаас дуудаагүй мөртлөө шууд ингэж албадан баривчилж өмгөөлөгчгүй мэдүүлэг авах эрх байхгүй. Энэ бол хууль зөрчсөн асуудал. Тэд яаж байцаалт авч байгааг одоо болтол мэдээгүй байна. Үйлчлүүлэгчийг баривчлагдсан гэдгийг сонсоод ...-т ирсэн. Гэвч намайг дотогш нэвтрүүлсэнгүй. Хаана ямар өрөөнд байгааг нь мэдэж чадаагүй. Ямар мөрдөн байцаагч албадан байцаалт авч байгааг ч мэдэх боломж байсангүй. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өмгөөлөгч үйлчлүүлэгчтэйгээ хаана, хэдийд ч уулзах эрхтэй гээд заачихсан байдаг. Үүнийг ... байгууллагынхан шууд зөрчиж байна. “Үйлчлүүлэгчээ хаана байцаалт авч байгааг мэдмээр байна. Хуулийн дагуу уулзмаар байна” гэх хүсэлтийг ...-ын бүх удирдлагуудад тавьсан. Гэвч миний хүсэлтийг хүлээж авсангүй. Арга ядаад ...-ын үүдний өрөөнөөс үйлчлүүлэгчийнхээ нэрийг дуудаж хашгирлаа. Мөн телевиз дуудаж ярилцлага өгсөн. Тэгсэн “Чи яасан их хэл амтай юм. Чамайг цагдаад шалгуулна гээд хоёр мөрдөн байцаагч өрөө рүүгээ чирч оруулах гэж оролдлоо. Юу гэсэн үг вэ? Хуулийн байгууллага ингэж авирлаж болохгүй биз дээ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт сэжигтэн өмгөөлөгчтэйгөө уулзах

эрхтэй, өмгөөлөгчтэйгөө байцаалт өгөх эрхтэй гээд тодорхой заачихсан байхад ...-ынхан ингэж авирлаж байна.¹⁹

Өмгөөлөгчийн энэхүү үйлдэл нь олон нийтэд мэдээлэх замаар тухайн байгууллагын алба хаагчдад хууль бус үйлдлийг нь мэдээлж, нөлөөлөхийг оролдож, төрийн хамгаалалт бүхий тухайн барилгаас үйлчлүүлэгчээ хайж чөлөөтэй зорчихыг оролдож, нэрийг нь чангаар дуудсан нь нэг талаар хууль зөрчиж буй мэт боловч тохиолдолд дурдсан хууль ёсыг мөрдүүлэх зорилгоор хийж буй тул үл захирагдахуй юм. Мөн энэ тохиолдолд сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчилсныг дурдсан байгаа юм. Шүүхийн зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй баривчилсан судалгааг харвал, 2020 онд 793 буюу 99.3 хувь, 2021 онд 809 буюу 98.5 хувь, 2022 онд 1075 буюу 99.7 хувь нь шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах ажиллагаа байсан байна.²⁰ Мөн энэхүү илтгэлд Шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах тухай Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтыг нарийвчлах шаардлагатайг тэмдэглэсэн байгаа юм. ХЭҮК-ын судалгаагаар шүүхийн зөвшөөрөлгүй баривчлагдсан 864 сэжигтний 242 нь өмгөөлөгч авсан талаар хувийн хэрэгт нь тэмдэглэгдсэн бол 622 буюу 72 хувьд нь баривчлагдах хугацаандаа өмгөөлөгч аваагүй байна. Хэдийгээр өмгөөлөгч авах эрх нь тухайн хүний эрхийн асуудал боловч өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах, өмгөөлөгчтэй мэдүүлэг өгөх эрхтэй талаар тайлбарлаж, хуульд заасан хугацаанд мэдэгдэж байх нь хүний эрхийн зарчимд нийцнэ. Манай авч үзэж буй тохиолдолд өмгөөлөгч нь үйлчлүүлэгчийнхээ өмгөөлөх эрхийг хангах хүсэлтээ төрөл бүрийн хэлбэрээр илэрхийлсэн ч хүлээн аваагүй байна.

IV. ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ, ЭСЭРГҮҮЦЭЛ ҮЗҮҮЛЭХ ЭРХИЙГ ХАНГАХТАЙ ХОЛБООТОЙ ОЛОН УЛСЫН БОЛОН МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН: ЗОХИЦУУЛАЛТ, НИЙТЛЭГ ХАНДЛАГА

Үл захирагдахуйн талаарх олон улсын эрх зүйн хэм хэмжээ хамгаалалт

Иргэний үл захирагдахуй нь үндэсний хууль тогтоомжийн дагуу хууль бус гэж тооцогдох эсэхээс үл хамааран иргэний эсэргүүцлийн тайван үйлдлийг тайван замаар хуран чуулах, үзэл бодлоо илэрхийлэх олон улсын эрх зүйн хүрээнд хамгаалдаг.

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын оршил хэсэгт өөрийн улс орны засгийн газрын хүний эрхийн зөрчлийг эсэргүүцэх эрхийг: “ хүмүүс эзэрхэг засаглал, дарлалын эсрэг өөрийн эрхгүй эцсийн арга болгон зэвсэглэн босоход хүргэхгүйн тулд хүний эрхийг хуулиар хамгаалах нь нэн чухал”²¹ гэж тодотгосон байдаг бөгөөд тунхаглалын 21 дүгээр зүйлд “Ард түмний хүсэл

¹⁹ <https://dnn.mn/news/17020>

²⁰ Монгол улс дахь хүний эрх эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, УБ., 2023, х 13

²¹ Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, 12 сарын 10, 1948, 217(11 I), U.N. Doc. A/810, at 7 (1948).

зориг нь засгийн газрын эрх мэдлийн үндэс байх ёстой. ²²” хэмээн заажээ.

Олон улсын Хүний эрхийн эрх зүйд иргэний үл захирагдахуйг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт (ИУТЭОП)-ын 19, 21 дүгээр зүйлд тус тус баталгаажсан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөг хэрэгжүүлэх нэг хэлбэр гэж хүлээн зөвшөөрдөг.

Тайван жагсаал нь олон хэлбэртэй байж болох бөгөөд ихэнхдээ хуулийн дагуу үргэлжилдэг. Гэхдээ иргэний үл захирагдахуй нь хууль санаатайгаар зөрчсөн үйлдэлтэй холбоотой байдаг ч иргэний үл захирагдахуйн бүх үйлдэл нь эсэргүүцлийн нэг хэлбэр бөгөөд хүчирхийллийн бус аргаар тайван замаар өрнөсөн бол үзэл бодлоо илэрхийлэх, тайван замаар эвлэлдэн нэгдэх эрхээ хууль ёсны дагуу хэрэгжүүлж байна гэж үзнэ. НҮБ-ын Хүний эрхийн хороо тайван замаар хуран чуулах эрхийн талаарх 37 дугаар Ерөнхий тайлбартаа (2020) “Иргэний үл захирагдахуй эсвэл нь хүчирхийллийн бус байх тохиолдолд ИУТЭОП-ын 21 дүгээр зүйлд хамаарна” ²³ гэж тайлбарласан. Түүнчлэн “Түлхэлцэх, тээврийн хэрэгсэл, явган хүний хөдөлгөөн, өдөр тутмын үйл ажиллагаанд саад учруулах” зэрэг эмх замбараагүй байдал нь хүчирхийлэлд тооцогдохгүй²⁴ гэжээ.

Тиймээс гадаад орнууд хүний эрхийн олон улсын эрх зүйн дагуу тайван замаар хуран чуулах эрхийг хамгаалах, тэр дундаа иргэний үл захирагдахуйн эсэргүүцлийн хэлбэрт зохих хариу арга хэмжээ авах үндсэн үүрэг хүлээдэг. Улс орнууд тайван замаар хуран чуулах эрхийг хүндэтгэж, хангах үүрэгтэй шигээ иргэний үл захирагдахуйн үйлдлийг бүхий л орчинд тухайлбал, гадаа талбай, дотор, цахим орчинд, олон нийтийн болон хувийн хэвшлийн эзэмшилд зохион байгуулж байгаа эсэхээс үл хамааран иргэний үл захирагдахуйн үйлдлийг хүндэтгэж, хамгаалах үүрэгтэй.²⁵

Замын түгжрэл үүсгэх, бизнесийн үйл ажиллагаанд саад учруулах зэрэг иргэний үл захирагдахуйн үйлдлээс үүдэн гарч болох аливаа хохирол нь санаатай эсэхээс үл хамааран олон улсын хүний эрхийн стандартын дагуу хамгаалагдсан хэвээр байх ёстой. НҮБ-ын Хүний эрхийн хорооноос тайван жагсаал хийх эрхийг хэрэгжүүлсний үр дүнд “хувийн хэвшлийн үйл ажиллагаа болон нийгмийн бусад салбарт тодорхой хэмжээний саад тотгор учирч магадгүй” гэдгийг тодорхой тайлбарласан байдаг.²⁶

Европын Аюулгүй байдал, Хамтын Ажиллагааны Байгууллага (ЕАБХАБ) болон Европын зөвлөл Венецийн комиссоор дамжуулан иргэний үл захирагдахуйд

²² ХЭТТ. 21.3 зүйл

²³ Human Rights Committee, General comment No. 37 (2020) on the right of peaceful assembly (article 21), para 16.

²⁴ Ibid., para 15

²⁵ State repression of environmental protest and civil disobedience: a major threat to human rights and democracy Position Paper by Michel Forst, UN Special Rapporteur on Environmental Defenders under the Aarhus Convention February 2024, page 48 para 1

²⁶ Ibid., para 31.

төрөөс үзүүлэх хариу арга хэмжээ нь тэнцвэртэй байх ёстой бөгөөд үйл ажиллагааны илэрхийлэл зорилгыг ухамсарласан байх ёстой гэдгийг дахин нотолсон.²⁷ ЕАБХАБ-ын Ардчилал, хүний эрхийн институци Тайван замаар хуран чуулах эрх чөлөөний тухай удирдамждаа иргэний үл захирагдахуйг (тайван замаар үйлдэгдсэн) хамгаалахын ач холбогдлын талаар дэлгэрэнгүй тайлбарлаж, “Төрийн хариу арга хэмжээ, түүний дотор баривчлах, шийтгэх нь тухайн гэмт хэрэгтэй тэнцвэртэй байх ёстой”²⁸, “хууль сахиулах албан тушаалтнуудад олгогдсон аливаа эрх мэдлийг нарийн хязгаарлах ёстой”, иргэний үл захирагдахуй, эсэргүүцлийн хэлбэрийг хамруулахгүйн тулд “терроризм, экстремизмтэй тэмцэхэд чиглэсэн дотоодын хууль тогтоомжид “терроризм” болон “экстремизм” гэсэн нэр томъёог нарийн тодорхойлох ёстой гэжээ.²⁹

Аархусын конвенцын байгаль орчныг хамгаалагчдын асуудлаарх НҮБ-ын тусгай илтгэгч Мишель Форст тусгай илтгэлдээ³⁰, “...Улс орнууд иргэний үл захирагдахуйг иргэний орон зай, үндсэн эрх чөлөөг хэрэгжүүлэхийг хязгаарлах шалтаг болгон ашиглах ёсгүй. Улс орнууд үзэл бодлоо илэрхийлэх, тайван замаар жагсах, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөгөө хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж, тэдэнд аюулгүй, таатай орчныг бүрдүүлэх үүрэгтэй. Улс орнууд иргэний үл захирагдахуйг зохицуулж буй болон/эсвэл зохицуулахаар санал болгож буй буй аливаа хууль тогтоомж нь олон улсын хүний эрхийн стандартад нийцэж байгаа эсэхийг үнэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, тайван замаар жагсах, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хэрэгжүүлэхэд саад учруулсан аливаа шинэ хууль, бодлого батлахаас татгалзах ёстой. Мөн улс орнууд бүх түвшний төрийн албан хаагчдаа олон улсын хүний эрхийн хэм хэмжээний дагуу тайван жагсаал, тэр дундаа иргэний үл захирагдахуйг зохицуулахад сургаж, тайван жагсаалыг зүй бусаар хязгаарлах, хориглох арга хэмжээ авахгүй байхыг баталгаажуулах ёстой. Улс орнууд иргэний үл захирагдахуй нь тайван замаар хуран чуулах эрхтэй адил хамгаалалттай байх ёстой бөгөөд аливаа хязгаарлалтыг хамгийн бага хэмжээнд байлгаж, хатуу хяналт тавьж, олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцүүлэх ёстой...” хэмээн зөвлөмж хүргүүлжээ.

Үл захирагдахуйн талаарх Монгол Улсын эрх зүйн орчин

Монгол Улс ИУТЭОП-д нэгдэн орсны хувьд НҮБ-ын Хүний эрхийн хороо, бусад олон улсын байгууллагын хүлээн зөвшөөрч буй тус пактын 19, 21 дүгээр зүйлийн нэг хэсэг хэмээн үзсэн үл захирагдах эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрх зүйн хэм хэмжээний хувьд зайлшгүй нөхцөл юм. Мөн Үндсэн хууль

²⁷ Venice Commission, OSCE/ODIHR, Guidelines on Freedom of Peaceful Assembly, 3rd edition, 2019, para 11: at: [https://www.venice.coe.int/webforms/documents/?pdf=CDL-AD\(2019\)017-e](https://www.venice.coe.int/webforms/documents/?pdf=CDL-AD(2019)017-e)

²⁸ Venice Commission and OSCE/ODIHR Guidelines on Freedom of Peaceful Assembly, 3rd edition (2020), para 11

²⁹ 5 OSCE/ODIHR, Guidelines on Freedom of Peaceful Assembly, 2nd edition, (2010), para 91

³⁰ Ibid., page 21

болон бусад хуулиар иргэний үл захирагдах эрхийг шууд хүлээн зөвшөөрч баталгаажуулаагүй боловч агуулга үзэл баримтлалын хувьд дэмжсэн төдийгүй үгүйсгээгүй байгааг онцлох нь зүйтэй. Тухайлбал,

Монгол Улсын Үндсэн хуулийн оршил хэсэгт:

“Монголын ард түмэн бид:

- хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж,
- эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно.” гэж улсынхаа суурь зарчим, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон. Энэ агуулгаас үзэхэд иргэд иргэний ардчилсан нийгэмд үл зохилдох хууль, дүрэм, журмуудыг хүлээн зөвшөөрөлгүй үзэл бодлоо илэрхийлэх, тухайн хууль, дүрэм, журмыг үндсэн хуульд нийцүүлэхээр холбогдох байгууллагад хандах, шийдвэрлүүлэх боломжтойг тунхагласан байна.

Мөн Пактын тус зүйлүүдийн үзэл санааг Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлгийн Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалт буюу Монгол Улсын иргэний баталгаатай эдлэх үндсэн эрх, эрх чөлөө хэсэгт оруулан баталгаажуулсан байна.³¹

Харин Үндсэн хуулийн далдугаар зүйлийн 1 дэх заалтын “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэсэн нь холбогдох хууль, дүрэм, журмуудад дээрх үзэл санааг тусгаж, нийцүүлэн мөрдөхийг тодотгосон байна.

Нэг талаар Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсын иргэнийг “Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх”-ийг үүрэгжүүлсэн байна. Гэтэл бидний судалж буй үзэл санаа нь нэг талаараа нийгмийн нийтлэг үзэл санаа, шударга ёсонд нийцээгүй хууль, дүрэм, журмыг биелүүлэхээс татгалзах, биелүүлэхгүй байхыг бусдад уриалах тухай юм. Энэ тохиолдолд тухайн хууль, дүрэм, журам, албан тушаалтны шийдвэр нь үнэхээр тухайн иргэний болоод нийтийн эрх ашигт харшилж байна уу? Үндсэн хууль болоод олон улсын гэрээ, конвенцоор баталгаажуулсан эрх, эрх чөлөөг зөрчиж байна уу? Тухайн иргэн, иргэний бүлгийн эсэргүүцлийн хэлбэр нь хүчирхийллийн бус аргаар явагдаж байна уу? гэдгийг нарийвчлан авч үзэх нь чухал.

Нөгөө талаар Хууль тогтоомжийн тухай хуулийн 4, 8, 12, 13 дугаар зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 24, 25, 26, 27, 47 дугаар зүйлүүд болон бусад

³¹ Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйл, 16/итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно;

хэсэгт нийтээр дагаж мөрдөх хууль, дүрэм, журам, захирамж, тушаал, шийдвэр бусад захиргааны хэм хэмжээний актыг бодит нөхцөл байдалд хэрэгжих боломжтой эсэхийг тооцоолж, олон нийтээр хэлэлцүүлж, эрх ашиг нь зөрчигдөж буй этгээдүүдэд урьдчилан мэдэгдэхээр нарийвчлан зохицуулсан. Эдгээр шаардлагуудын аль нэг нь эсвэл тодорхой нэг хэсэг нь хангагдаагүй гэж үзвэл Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу болон бусад хууль тогтоомжид заасны дагуу тухайн эрх зүйн баримтыг хүчингүй болгуулахаар холбогдох байгууллага, албан тушаалтан болон шүүхэд хандаж хуулийн хугацаанд шийдвэрлүүлэхээр зохицуулсан. Тиймээс үүнийг дам утгаар үл захирагдах эрхийг дэмжиж буй хэлбэр гэж үзэж болох юм. Гэхдээ ихэнх тохиолдолд төрийн байгууллагын шат дамжлага, хугацаа алддаг байдал нь өргөдөл, гомдлыг төрийн байгууллагаар шийдвэрлүүлэх идэвхийг бууруулдаг төдийгүй үл захирагдахуйн нэг шалтгаан болж байх магадлалтай.

V. ДҮГНЭЛТ

Иргэний үл захирагдахуйн талаар сэтгэгчид эрх зүйн философийн хүрээнд нэлээдгүй авч үзсэн. Эдгээрт нийгмийн нийтлэг үнэт зүйл, ёс суртахууны болоод эрх зүйн үндсэн зарчмыг зөрчсөн хууль, дүрэм журмууд, албан тушаалтны дур зоргын эсрэг хүчирхийллийн бус аргаар тухайн зохицуулалтыг зөрчих олон нийтийн анхааралд хандуулах үйлдлийг үл захирдахуй гэж үзсэн байна. Энэ ухагдахууныг ИБУТЭОП-ын үзэл бодлоо илэрхийлэх, тайван замаар жагсаал цуглаан хийх эрх чөлөөний хүрээнд авч үздэг байна. Харин Монгол Улсын хууль, дүрэм, журмуудад үл захирагдахуйг нарийвчлан тодорхойлж хүлээн зөвшөөрөөгүй боловч хууль тогтоомжийн хүрээнд иргэн болон иргэний бүлгүүд шударга бус хууль, дүрэм, журмыг эсэргүүцэж, биелүүлээгүй тохиолдолд үзэл бодлоо илэрхийлэх, маргаан, гомдлоо шийдвэрлүүлэх хүрээнд ойлгож хуулиар хүлээн зөвшөөрч, зохицуулсан. Гэсэн хэдий ч захиргааны болон Зөрчлийн тухай хуулиар торгож, баривчлах зэргээр дэмжихгүй, ялгавартай шийдвэрлэж байгааг тэмдэглэх нь зүйтэй. Манай улс дээрх олон улсын эрх зүйн баримт бичигт нэгдэн орсон тул үл захирагдахуйг хүлээн зөвшөөрсөн гэж үзэж болох юм. Энэ нөхцөл байдал энэхүү судалгааны ажилд сонгон авсан тохиолдлуудад ч илэрсэн. Түүнчлэн бидний анх тавьсан асуултын хувьд манай улс иргэний үл захирагдахуйг хүлээн зөвшөөрч, эрх зүйн орчныг бий болгох шаардлага үүссэн байна.

Үл захирагдахуйг хүлээн зөвшөөрснөөр төрийн байгууллага, албан тушаалтан бодит байдалд хэрэгжих боломжгүй, судалгаа мэдээлэл дутуу, иргэдээр хэлэлцүүлээгүй гэнэтийн шийдвэр гаргах, хэт цаг үеийн нөхцөл байдалд хөтлөгдөх зэрэг эрсдэлээс сэргийлэх боломжтой. Нэг талаар манаачийг хэн манах вэ? буюу төрийг хянах, төрийн эрх мэдлийг хязгаарлах тухай улс төрийн үзэл санааны бодит байдал дахь нэг гаргалгаа байж болох юм.

VI. САНАЛ

- Манай улсад Үндсэн хуулиар баталгаажуулсан иргэний үндсэн эрх зөрчсөн тухай гомдол мэдээллийг хүлээн авч шийдвэрлэдэг болох нь үл захирагдахуйг хүлээн зөвшөөрч, шийдвэрлэх том хөшүүрэг болох юм. Түүнчлэн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан хууль, дүрэм, журам, захирамж нь Үндсэн хууль, Хууль тогтоомжийн тухай хууль, Захиргааны ерөнхий хуулийг зөрчсөн эсэхийг шийдвэрлэх ажиллагааг хялбаршуулж шүүхийн журмаар яаралтай шийдвэрлэдэг жишиг тогтоох шаардлагатай байна. Энэ нь иргэний үл захирагдахуйн нөхцөл бол шүүх болон Үндсэн хуулийн цэцийн хүрээнд хүлээн авч шийдвэрлэх хүртэл тухайн иргэн, иргэний бүлэгт арга хэмжээ авалгүй тусгай тэмдэглэл үйлдээд, шийтгэл, арга хэмжээг түр түтгэлзүүлдэг тогтолцоо бүрдүүлэх;
- Цаашлаад эрх зүйн тогтолцоондоо үл захирагдахуйг хүлээн зөвшөөрч, хууль тогтоомж, захиргааны эрх хэмжээний акт боловсруулахдаа мөрдөх зарчим болгох;
- Хүний эрхийн Үндэсний Комисс үл захирагдахуйг хүний эрхийн нэг хэсэг хэмээн хүлээн зөвшөөрч, үйл ажиллагааны үндсэн чиглэлд тусган, энэ талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч шийдвэрлэдэг болох;

VII. НОМ ЗҮЙ

Монгол эх сурвалж:

1. Б.Батчулуун, Төр хэмээх мөсөн уул. УБ., 2022
2. “Монгол Улсад тайван замаар жагсах, цуглах эрхийг дэмжих нь” төсөл, Монгол Улсад тайван замаар жагсах, цуглах эрхийг бэхжүүлэх нь төслийн кэйс судалгааны тайлан, УБ., 2024
3. Монгол улс дахь хүний эрх эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, УБ., 2023
4. Монгол Улсын Үндсэн хууль
5. Монголын Эмнести Интернэшнл, Ковид 19 цар тахал хууль сахиулах ажиллагаа, Монгол Улс: Цагдаагийн байгууллага, алба хаагчдын үйлдсэн хүний эрхийн зөрчил, тохиолдол, тайлан
6. НҮБ-ын Хүний эрхийн хорооны 21 дүгээр зүйлийн талаар гаргасан 37 дугаар Ерөнхий тайлбар (2020 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр UN Doc CCPR/C/GC/37)
7. Тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний талаарх Венецийн удирдамж, ЕАБХАБ-ын Ардчилсан институци, хүний эрхийн алба (ЕАБХАБ/АИХЭА). Страсбург/Варшав хот (2020 оны 7 дугаар сарын 15-ны өдөр CDL-AD(2019)017rev 3 дахь хэвлэл)

8. Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, 12 сарын 10, 1948
9. Д.Энхжаргал, Иргэний үл захирагдах ёс суртахууны үүрэг., 2013

Гадаад эх сурвалж:

1. Browder v. Gayle, 142 F. Supp. 707, 717 (M.D. Ala. 1956)
2. Civil Disobedience and the Necessity Defense, John Alan Cohan, Western State Law School, The University of New Hampshire Law Review, Volume 6
3. Defense of the Civilly Disobedient, 13 N.C. Cent. L.J.
4. Letter from a Birmingham Jail (1963), in 1 A.J. Muste Memorial Institute Essay Series 21
5. Necessity and International Law: Arguments for the Legality of Civil Disobedience Bernard D. Lambek
6. J.J. ROSSEAU, THE SOCIAL CONTRACT (M. Cranston trans. 1968)
7. JOHN RAWLS, A THEORY OF JUSTICE (2009)
8. Ibid
9. Human Rights Committee, General comment No. 37 (2020)
10. The OSCE/ODIHR and the Venice Commission, however, describe civil disobedience, in their Guidelines on Freedom of Peaceful Assembly, 3rd edition (2020)
11. OSCE/ODIHR, Guidelines on Freedom of Peaceful Assembly, 2nd edition, (2010)
12. State repression of environmental protest and civil disobedience: a major threat to human rights and democracy Position Paper by Michel Forst, UN Special Rapporteur on Environmental Defenders under the Aarhus Convention February
13. Venice Commission, OSCE/ODIHR, Guidelines on Freedom of Peaceful Assembly, 3rd edition, 2019
14. Venice Commission and OSCE/ODIHR Guidelines on Freedom of Peaceful Assembly, 3rd edition (2020)



С.НОМЫНБАЯСГАЛАН

Монголын Криминологичдын холбооны ахлах судлаач, Хууль зүйн магистр

ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААХ ГЭМТ ХЭРГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН АСУУДАЛ¹

LEGAL ISSUES ON THE REGULATION OF MISINFORMATION CRIME

Хураангуй: Энэхүү өгүүллийн сэдвийг “Худал мэдээлэл тараах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтын асуудал” гэж томъёолон, агуулгыг тодорхой эрх зүйн зохицуулалтын асуудлаар хязгаарлав. Эрх зүйн хэм хэмжээг бүтээхэд хууль зүйн техникийн хувьд тодорхой шаардлагыг баримталдаг. Ийнхүү зохих шаардлага тавих нь тухайн эрх зүйн хэм хэмжээ хүний эрх, эрх чөлөөг санаатай, санамсаргүй байдлаар зөрчихөөс сэргийлнэ. Өөрөөр хэлбэл, эрх зүйн хэм хэмжээ нь тодорхой шаардлагын дагуу бүтээгдсэнээрээ хүний эрх, эрх чөлөөг зөрчих байдлыг багасгах боломж, нөхцөлийг бүрдүүлнэ. Тус улсын хувьд эрх зүйн шинэтгэл үргэлжилж байна. Шинэтгэлийн хүрээнд зохих өөрчлөлт дэвшил гарч буй гэдэгт эргэлзэхгүй байгаа хэдий ч болохгүй, бүтэхгүй байгаа тухай ихээхэн санал шүүмжлэл өрнөж байна. Иймд энэхүү өгүүллээр уламжлал шинэчлэлийг хослуулах замаар өөрийн Монгол хувилбарыг бүтээхэд тулгамдаж буй зарим асуудлыг хөндсөн билээ.

Abstract: The article is named as the “Legal issues on the regulation of misinformation crime” and its content is conducted within legal issues on the particular regulation. There are certain legal and technical requirements for drafting legislation. Such appropriate requirements shall prevent intentional or unintentional violations of human rights and freedom. In other words, legal acts

¹ “УЛСЫН ЭРХ-110” эрдэм шинжилгээний хуралд шалгарсан бүтээл

that are drafted in accordance with certain requirements create opportunities and conditions to reduce violations of human rights and freedoms. Legal reform in Mongolia is still in process. Although certain progress has been made within the scope of legal reform, there are also many criticisms on this matter. This paper analyzes methodological issues and approaches, and find out some challenging issues to develop Mongol model by combining traditional and contemporary approaches..

Түлхүүр үг: Хэвлэл мэдээллийн эрх зүй, эрүүгийн эрх зүй, иргэний эрх зүй, эрүүгийн хууль, гэмт хэрэг, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, гүтгэлэг, мэдээлэл, хуурамч мэдээлэл, алдаатай мэдээлэл, буруу сэдэлтэй мэдээлэл, зөрчил.

Keywords: Media law, criminal law, civil law, criminal code, crime, freedom of opinion and expression, slander (calumny), information, disinformation, misinformation, mal – information, violation (conflict).

I. УДИРТГАЛ

Товчхондоо бол аливаа эрх зүйг зохицуулах зүйл, зохицуулалтын арга нийгэмд гүйцэтгэх үүргээр нь салбар эрх зүй мөн эсэхийг тодорхойлдог онолыг иш үндэс болговол хэвлэл мэдээллийн эрх зүй нь бие даасан нэг салбар эрх зүй мөн бөгөөд бусад эрх зүйтэй нэлээд холимог өвөрмөц зохицуулалтын салбар болон хөгжиж байна. Иймд салбарын дагнасан хууль гэх ойлголт хэвлэл мэдээллийн эрх зүйн орчинд үгүй.² Үүний зэрэгцээ чөлөөт хэвлэл, түүний эрх зүйн орчныг нь баталгаажуулсан эрх зүйн “сайн” зохицуулалт зайлшгүй шаардлагатай байгаа нь нэгэнт тодорхой юм.³ Энэ талаар М.Зулькафиль Монголын олон нийтийн мэдээлэл хэмээх бүтээлд “... сэтгүүл зүйн үйл ажиллагааг эрх зүйн үүднээс зохицуулж, хөгжүүлж ирсэн хэд хэдэн чиглэл байдаг. Үүнд: Нэгдүгээрт, энэ бол төр засгийн ашиг сонирхлыг хамгаалах; хоёрдугаарт, энэ бол хүний хуулийн ашиг сонирхол болон эрхийг хамгаалах явдал юм ...”⁴ гэж үзсэн байна. Ардчилсан эрх зүйт нийгмийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааны үндэс суурь нь мэдээллийн эрх чөлөө байдаг.⁵ Энэ утгаар хэвлэл мэдээллийн эрх зүйн амин сүнс нь иргэний улс төрийн суурь эрх, эрх чөлөө болох үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх болох учир энэхүү өгүүллийн гол утга учир үүнд л оршиж байна. Энэ бүлэг эрх хүний үзэл санааны эрх чөлөөг хамгаалсан байна. Үзэл санаа бол бие махбодийн эрх чөлөөг тодорхойлох шинжтэй, хүний уугуул мөн чанараас эх сурвалжтай, зөвхөн хүнд байдаг

² Х.Наранжаргал, Чөлөөт илэрхийлэл ба чөлөөт сэтгүүл зүй, Уб., Чөлөөт хэвлэл сан, 2021, 67 дахь тал.

³ Ж.Батбаатар, Суурь сэтгүүл зүй, Уб., Мөнхийн үсэг, 2023, 171 дэх тал.

⁴ М.Зулькафиль, Монголын олон нийтийн мэдээлэл: Нэг намын үзэл суртлаас олон ургальч үзэл хүртэл, Уб, Соёмбо, 2010, 201 – 202 дахь тал.

⁵ М.Зулькафиль, Ч.Чойсамба, Сэтгүүлчийн ёс зүй, Уб., МУИС–ийн хэвлэх үйлдвэр, 2004, 82 дахь тал.

төрөлх шинж юм.⁶

Гэвч өнөөгийн үндэсний эрх зүйн тогтолцоонд иргэн, эсвэл албан тушаалтан байна уу гэдгээс үл хамааран үг хэлэх эрх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хууль тогтоомжийн хүрээнд хязгаарлагдмал байдлаар тодорхойлсоор байна. Тодруулбал, Зөрчлийн тухай хуулийн 15.36 дугаар зүйл (Монгол Улсын шүүхийн тухай хууль зөрчих)—ийн “1.Хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн ажиллагааны явцад талуудын гаргасан гомдол, нэхэмжлэл, тайлбар, хүсэлт, шүүх хуралдааны тэмдэглэл, шүүхийн шийдвэрийг гуйвуулан, ташаа байдлаар бусдад түгээсэн бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”⁷ гэсний “... шүүхийн шийдвэрийг гуйвуулан, ташаа байдлаар бусдад түгээсэн бол ...” гэснийг болон Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйл (Бүлгийн эрх, үүрэг)—ийн 30.2 дахь хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 30.1.2–т заасны дагуу томилогдсоноос бусад тухайн бүлгийн гишүүд нэгдсэн хуралдаанд асуулт асууж, үг хэлэхгүй”⁸ гэж заасныг тус тус жишээ болгон дурдаж болох юм. Мөн түүнчлэн 2002 оны Эрүүгийн хуульд байсан доромжлох, гүтгэх гэмт хэргийг 2015 онд шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиас халснаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалахад нэг алхам урагшилсан. 2015 оны Зөрчлийн тухай хуулийн 7.3 дугаар зүйлд заасныг өмнөхөөсөө эерэг зохицуулалт болсон гэж үздэг. Эдгээр зүйлээс хорих ялыг хассан нь зөвхөн эхний алхам бөгөөд цаашид бусдыг гүтгэх, гутаан доромжлох үйлдэл бүхэлдээ иргэний хуулийн зохицуулалтын хүрээнд шилжих асуудал нээлттэй байна. ⁹ Энэ нь хэвлэл мэдээллийн ба эрүүгийн (зөрчлийн, эсвэл иргэний гэх зэргээр) эрх зүйн харилцан хамаарлын талаархи тухайлсан судалгаа хийх нийгмийн хэрэгцээ шаардлага үндэсний эрх зүйн тогтолцоонд үгүйлэгдэж байгааг илэрхийлж байна. Нөгөөтэйгүүр, хүн итгэл үнэмшил, үзэл бодолтой байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөгөө хэрэгжүүлэх суурь нөхцөл нь мэдээлэл хайх, олж авах эрх юм. Олон улсын эрх зүйгээс ялгаатай нь Монгол Улсын Үндсэн хуульд мэдээлэл хайх, хүлээн авах эрх чөлөөг үзэл бодолтой байх, илэрхийлэх эрх чөлөөнөөс тусад нь биеэ даасан үндсэн эрх болгож, баталгаажуулсан¹⁰ онцлогтой. Энэ утгаар, мэдээлэл хайх, хүлээн авах эрх нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, эрх чөлөөний агуулгад багтдаг тул үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх зөрчигдсөн тохиолдолд мэдээлэл хайх,

⁶ Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хууль: Шинжлэх ухааны тайлбар, Уб., Адмон принтинг, 2022, 294 дэх тал.

⁷ Энэ зүйлийг 2024 оны 6 дугаар сарын 5–ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2025 оны 1 дүгээр сарын 1–ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12695> [Сүүлд үзсэн огноо:2024.12.23]

⁸ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140610916031> [Сүүлд үзсэн огноо:2024.12.23]

⁹ Ч.Энхбаатар, Том Гинсбург, П.Амаржаргал, М.Батчимэг, Ц.Даваадулам, О.Мөнхсайхан, Д.Солонго, Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ, Уб., Бест Колор Интернэшнл, 2016, 59 дэх тал.

¹⁰ Үндсэн хууль манай сургуульд (НҮБ–ын Хүний эрхийн хороодын ерөнхий тайлбар, сургалтын хөтөлбөр), Уб., Арвай Бархан хэвлэлийн компани, 2022, 331 дэх тал.

хүлээн авах эрх зөрчигдөх боломжтой¹¹ гэж үзэж байна. Энэ нь нэг талаас, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө зэрэг үндсэн эрхийг хязгаарлахад Монгол Улсын Үндсэн хуулиар тавигдах суурь нөхцөлүүд юу вэ, түүнийг тухайн тохиолдолд хангасан эсэх талаархи номлолын үүднээс; нөгөө талаас, Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх гэмт хэргийн бүрэлдэхүүний номлолыг дөрвөн элементтэйгээр (уламжлалт байдлаар) буюу хоёр элементтэйгээр ойлгох, эсхүл бүр түүнийг халж гэмт хэргийн шинжийн үүднээс¹² зэрэгцүүлэн авч үзэх “практик”¹³ хэрэгцээ шаардлага үүссэн байна. Үүнээс гадна, криминологийн зарим бүтээлд “гэмт явдлын шалтгааныг антропологийн үүднээс авч үзэж болох” тухай тэмдэглэсэн байх нь бий.¹⁴ Энэ нь худал мэдээлэл тараах гэмт хэргийн криминологийн төдийгүй эрүүгийн эрх зүйн антропологийн тухайлсан судалгаа хийх нийгмийн хэрэгцээ шаардлага үгүйлэгдэж байгааг харуулсаар байна.

Энэхүү байдлыг харгалзан энэ өгүүллээр Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтаар “13.14 дүгээр зүйл. Худал мэдээлэл тараах”¹⁵ гэмт хэргийг нэмсэн бөгөөд энэ гэмт хэргийн “илт худал мэдээлэл” гэх ойлголтын эрүүгийн эрх зүйн учир холбогдлын талаар авч үзэхийг гол зорилгоо болгов. Иймд Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл (Худал мэдээлэл тараах)–ийн “1.Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ”¹⁶ гэсний “... илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол ...” гэсэн хэсгийн зохицуулалтын хүрээнд авч үзэх болно. Ийнхүү авч үзэхийн учир нь “гүтгэхийг гэмт хэрэгт

¹¹ НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 217 А (III) тогтоолоор баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйлд “Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэхүү эрхэнд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана” гэж заасан. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 2200 А (XXI) тогтоолоор баталсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана” гэж заасан.

¹² О.Мөнхсайхан, Эрх зүйн философи, анхны хэвлэл, Уб., 2022, 10 дахь тал.

¹³ Энэхүү өгүүллийн хавсралтаас “Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.14 дүгээр зүйл (Худал мэдээлэл тараах)–ийг хэрэглэн Монгол Улсын дээд шүүхээс шийдвэрлэсэн байдал”–ыг үзнэ үү.

¹⁴ Н.Жанцан, Криминологи, (Сурах бичиг), Уб., 2004, 118 дахь тал.

¹⁵ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=103674&showType=1> [Сүүлд үзсэн огноо:2024.12.23]

¹⁶ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11634> [Сүүлд үзсэн огноо:2024.12.23]

бус зөрчилд тооцож байсан”¹⁷ боловч зөрчилд тооцохгүй болсон¹⁸ зэрэгтэй холбоотой юм. Уг асуудлыг нийгэм, соёлын антропологийн дэд салбар болох эрх зүйн антропологийн онолын¹⁹ үзэл санааг удирдлага болгон хөндөхийг оролдов. Тиймээс худал мэдээлэл тараах гэмт хэргийн үндсэн асуудал болгон нэгдүгээрт, уг гэмт хэрэгт агуулгын товчхон шинжилгээ хийж ойлголт, үндсэн шинжийг тодруулах, бусад төстэй гэмт хэргээс хэрхэн ялган зүйлчлэх болон гадаадын зарим улсын зохицуулалттай харьцуулан судлахын зэрэгцээ хоёрдугаарт, гүтгэх гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтын түүхэн хөгжлийн талаар эргэцүүлэн уг гэмт хэргийн хуульчлагдсан байдал, түүхэн уламжлал, гүтгэхийг зөрчилд тооцсон нь, гэм хорын асуудлыг цухасхан авч үзэв. Энэ үндсэн дээр худал мэдээлэл тараах гэмт хэрэг нь үндэсний эрх зүйн соёлд төдийгүй эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал зэрэгт хэрхэн нийцэж, эсвэл эсрэгцэж (ондоошиж) байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөхөөс гадна, эцэст нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.14 дүгээр зүйлийн холбогдох эрх зүйн зохицуулалтыг хэрхэн боловсронгуй болгох талаархи саналыг дэвшүүлэв.

Энэ хугацаанд (2020 – 2024 оны хооронд) Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.14 дүгээр зүйлээр “Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 13 хэргийг, Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шүүх 16 хэргийг, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 17 хэргийг”²⁰, “Хан

¹⁷ Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 4-ний өдөр баталсан Зөрчлийн тухай хуулийн 7.3 дугаар зүйл (Гүтгэх)–ийн 1 дэх хэсэгт “Хүний нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11645> [Сүүлд үзсэн огноо:2024.12.23]

Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдөр баталсан Зөрчлийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн 1 дүгээр зүйлээр 2015 оны 12 дугаар сарын 4-ний өдөр баталсан Зөрчлийн тухай хуулийг хүчингүй болгосон. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12706> [Сүүлд үзсэн огноо:2024.12.23]

Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдөр баталсан Зөрчлийн тухай хуулийн 6.21 дүгээр зүйл (Гүтгэх)–ийн 1 дэх хэсэгт “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан.

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=12695> болон <https://www.parliament.mn/nn/17688/> [Сүүлд үзсэн огноо:2024.12.23]

¹⁸ Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар Зөрчлийн тухай хуулийн 6.21 дүгээр зүйл (Гүтгэх)–ийг хүчингүй болсонд тооцсон.

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=103687&showType=1> [Сүүлд үзсэн огноо:2024.12.23]

¹⁹ <https://journal.num.edu.mn/MJAAE/article/view/6765/5997> [Сүүлд үзсэн огноо:2024.12.23]

²⁰ Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн “Харну хүргүүлэх тухай” 957 тоот албан бичигт “Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 10 –ны өдөр Эрүүгийн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр 13.14 дүгээр зүйл буюу худал мэдээлэл тараахыг гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан. Тухайн хууль батлагдсанаас хойш хугацаанд Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд 13 хэргийн 13 хүнд холбогдох хэргийг, Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд 16 хэргийн 18 хүнд холбогдох хэргийг, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны

– Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2 хэргийг, Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шүүх 2 хэргийг, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 5 хэргийг²¹, “Багахангай, Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 1 хэргийг²²—үүдийг анхан шатны журмаар, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх 37 хэргийг давж заалдах журмаар²³, Улсын дээд шүүх 2 хэргийг хяналтын журмаар²⁴ тус тус хянан шийдвэрлэсэн статистик тоон мэдээлэл байна. Энэ талаар зарим судлаачид шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх замаар өөрсдийн байр сууриа дараахь байдлаар илэрхийлсэн байна. Жишээ болгон дурдвал, Д.Оросоо нар “... гэмт хэрэг нь нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан гэж объектив талын шинжээр тодорхойлогдсон, 2002 оны Эрүүгийн хуульд байсан гүтгэх гэмт хэргээс өргөн агуулгатай, хүрээтэй, шинэ хэв шинж бүхий гэмт хэрэг болжээ ...”²⁵ гэж, Б.Пүрэвсүрэн “... худал мэдээлэл тараах гэмт хэргийн үндсэн шинж болох илт худал мэдээллийг хууль тогтоомжид тайлбарлаагүй, хохирогчийн зүгээс тийнхүү худал мэдээлэл тараахаас сэргийлэх, худал мэдээллийг залруулах хангалттай арга хэмжээ авсан эсэхийг харгалздаггүй, Иргэний

шүүхэд 17 хэргийн 23 хүнд холбогдох хэргийг тус тус хянан шийдвэрлэсэн бол Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд 1 хэргийн 2 хүнд холбогдох хэргийг Үндсэн хуулийн цэцэд маргаан үүссэн үндэслэлээр түдгэлзүүлсэн байгаа болохыг үүгээр мэдэгдье” гэж дурджээ.

²¹ Баянгол, Хан – Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын 2024 оны 11 дүгээр сарын 27–ны өдрийн 864 тоот албан бичигт “Баянгол, Хан – Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 2021 – 2024 онд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13 дугаар зүйлийн 13.14 дүгээр зүйлд заасан эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэсэн талаарх судалгааг хавсралтаар хүргүүлэв” гээд тус албан бичгийн Хавсралтад “Хан – Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021.04.08 №229, 2024.01.30 №99 дүгээр шийтгэх тогтоолууд; Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022.09.08 №680, 2022.11.08 №835 дугаар шийтгэх тогтоолууд; Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022.08.16 №1033, 2023.01.02 №41, 2023.09.20 №1116, 2023.10.13 №1218, 2024.03.14 №324 дүгээр шийтгэх тогтоолууд” гэж дурджээ.

²² Багахангай, Налайх дүүргийн шүүхийн Тамгын газрын 2024 оны 11 дүгээр сарын 27–ны өдрийн 1/265 тоот албан бичигт “Багахангай, Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд 2020 оноос 2024 оны хооронд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.14 дүгээр зүйлд зааснаар 2020 онд нэг эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэсэн байна” гэж дурджээ.

²³ Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн Тамгын газрын 2024 оны 11 дүгээр сарын 20–ны өдрийн 536 тоот албан бичигт “Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх 2020 – 2024 онуудад Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.14 дүгээр зүйлд заасан “Худал мэдээлэл тараах” гэмт хэрэгт холбогдуулан нийт 37 эрүүгийн хэргийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэсэн байна. Одоогоор дээрх гэмт хэрэгт холбогдуулан давж заалдах журмаар хянагдаж байгаа хэрэг байхгүй болно” гээд тус албан бичгийн Хавсралтад “2020 онд 1; 2021 онд 7; 2022 онд 5; 2023 онд 9; 2024 онд 15; нийт 37” гэж дурджээ.

²⁴ Монгол Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын Тэргүүн . . . –ын 2024 оны 11 дүгээр сарын 13–ны өдрийн “Хариу хүргүүлэх тухай” 02/5418 тоот албан бичигт “Монгол Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхим 2020 оны 01 дүгээр сарын 10–ны өдрийн хуулиар Эрүүгийн хуульд нэмэгдсэн 13.14 дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт (Худал мэдээлэл тараах) холбогдох 2 хэргийг хяналтын журмаар хянан шийдвэрлэж 2024/ХШТ/76, 2024/ХШТ/110 дугаар тогтоолуудыг гаргажээ” гэж дурджээ.

²⁵ Д.Оросоо, Ц.Цэлмэг, С.Дэнсмаа, Г.Туул, Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик, (Илт худал мэдээлэл гэх ойлголтын эрүүгийн эрх зүйн асуудал), Уб., 2021, 59 дэх тал. https://forum.mn/uploads/users/3092/files/Misinformation%20Crime_Web%20version.pdf [Сүүлд үзсэн огноо:2024.12.23]

хуулийн 21 дүгээр зүйлийн дагуу шийдвэрлэж болох иргэний гэм хорын асуудлыг эрүүжүүлсэн (гэмт хэрэгт тооцсон) нь Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн хувьд ухралт болсон ...”²⁶ гэх зэргээр тус тус бичсэн байна.

Мөн түүнчлэн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.14 дүгээр зүйлд заасан “Худал мэдээлэл тараах” гэмт хэргийг тайлбарласан албан ёсны тайлбарыг Улсын дээд шүүхээс гаргаагүй байна.²⁷ Харин үндэсний эрүүгийн эрх зүйн бүтээлүүдэд нэгд, С.Гантулга нар “... 2002 оны Эрүүгийн хуулийн 111 дүгээр зүйлд хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэг тараасан бол гүтгэх гэмт хэрэгт тооцож байсан бол 2015 оны Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцохгүй болсон нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад “Хэний ч нэр төрийг гутаан доромжилж болохгүй” гэж тунхагласан хүний эрхийг хамгаалахад сөргөөр нөлөөлсөн. Иймд Улсын Их Хурлаас 2020 оны 1 дүгээр сарын 10–ны өдөр Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж, худал мэдээлэл тараах үйлдлийг гэмт хэрэгт тооцсон ...”²⁸ гэж; хоёрт, Х.Доржпалам “... Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад заасан хүний халдашгүй эрхийн нэг бол хүний нэр төр, алдар хүнд юм. 2015 онд Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулж даган мөрдүүлэх хүртэл “гүтгэх” гэмт хэрэг гэсэн агуулгаар хуульчилсан байсныг эрх зүйн зөрчил болгож Зөрчлийн тухай хуульд оруулсан байв. 2020 онд Эрүүгийн хуульд дахин нэмэлт, өөрчлөлт оруулахад “худал мэдээлэл тараах” гэмт хэрэг болгосон. Ийнхүү богино хугацаанд дахин өөрчлөх болсон нь зөвхөн хүний төдийгүй хуулийн этгээдийн бизнесийн нэр хүндэд халдсан худал мэдээлэл тараадаг гаж үзэгдэл бодит байдал болж, тийм этгээдүүдэд хүлээлгэх хариуцлагыг чангатгах нийгмийн захиалгатай холбоотой байсан ...”²⁹ гэж; гуравт, Б.Ганболд “... 2015 онд анх хуулийн төслийн үзэл баримтлалд гүтгэх нь судалгаанаас үзэхэд гол төлөв сэтгүүлч рүү, эсхүл хүний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарласан гаж хэлбэртэй байгаа тул энэхүү ердийн гүтгэхийг зөрчил гэж үзье, харин гэмт хэрэгт шууд холбогдуулж гүтгэвэл худал мэдүүлэг өгөх; сонгуулийн үед бол өөрөөр бие даасан гэмт хэрэгт хуульчлах нь зөв гэж үзсэн. Энэ үндсэн дээр Зөрчлийн тухай хуулиар “гүтгэх” гэмт хэргийг зохицуулж, эрүүггүйжүүлсэн боловч “энэ зүйлээр дахин агуулгаар нь сэргээж байгаа” явдал нь социалист төрийн ёс суртахууны хүрээнд доромжлох, гүтгэх, танхайрах үйлдлийг авч үздэг сэтгэлгээг дахин

²⁶ Б.Пүрэвсүрэн, “Худал мэдээлэл тараах гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ”, Шүүхийн шийдвэрийн судалгаа, цуврал 2, Уб., 2021, 107 дахь тал.

²⁷ Монгол Улсын дээд шүүхийн 2024 оны 10 дугаар сарын 03–ны өдрийн “Хүсэлтэд хариу өгөх тухай” 02/4785 тоот албан бичигт

²⁸ С.Гантулга, Б.Энхболд, Эрүүгийн эрх зүй. Тусгай анги, Хоёр дахь хэвлэл, Уб., Мөнхийн үсэг, 2020, 90 дэх тал.

²⁹ Х.Доржпалам, Монгол Улсын эрүүгийн эрх зүй, (Тусгай анги), ред. Ж.Эрдэнэбулган, Уб., Сэлэнгэ пресс, 2021, 73 дахь тал.

амь оруулж байгаа хэрэг болжээ. Гүтгэх, доромжлох нь зүй бус үйлдэл хэдий мөн боловч хувь хүн өөрийн нэр төр, алдар хүндэд халдсан гэж үзвэл сэргээлгэхээр шүүхэд хандах нь маргааныг иргэний хэргийн журмаар шийдвэрлэх илүү зөв шийдэл юм. Иймд ч манайхаас өөр ийм хууль, шүүхтэй улс дэлхий дахинаа алга³⁰ гэж уг гэмт хэргийн талаар ийнхүү ялгамжтай байдлаар үзэж ирсэн байна.

II. ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААХ ГЭМТ ХЭРГИЙН АГУУЛГЫН ШИНЖИЛГЭЭ

Д.Оросоо, Ц.Цэлмэг нарын Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик хэмээх (2021) судалгаанд “анх өргөн мэдүүлсэн төслийн “гүтгэх” гэснийг “худал мэдээлэл тараах” гэж өөрчлөн “хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдаж илт худал мэдээллийг нийтийн сүлжээгээр тараах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр тараах” гэж ялгамжтай авч үзсэн байсныг нэгтгэн уг гэмт хэргийг “олон нийтэд тараасан бол” хэмээн объектив талын шинжээр нь тодорхойлж, субъектив талын шинжийг бүрхэгдүүлсэн, худал мэдээлэл нь “гутаасан, гутаах” агуулга, шинжтэй байх эсэхийг бүрэн тодорхойлоогүй, “халдсан” гэсэн хэт ерөнхий нэр томъёог хэрэглэсэн явдал нь хууль бүтээх ажиллагааны алдаа болж хууль хэрэглээ, шүүхийн практикт сөрөг үр дагавар үүсгэж буй гол шалтгаан болсон гэж үзэх үндэстэй³¹ гээд “хууль тогтоогч эрүүгийн хуульд байсан “гүтгэх” гэмт хэргийн ойлголтоос өргөн хүрээг хамрах “худал мэдээлэл тараах” гэсэн объектив талын шинжээр тодорхойлогдох, шинэ хэв шинж бүхий гэмт хэргийг эрүүгийн хуульд тусгажээ. Харин эрүүгийн хариуцлагын хувьд хорихоос өөр төрлийн ял шийтгэхээр тогтоосон нь өмнөх эрүүгийн хуулиудаас онцгой болсон³² гэж үзсэн байна. Тиймээс энэ гэмт хэргийн агуулгыг товчхон авч үзье.

А.Худал мэдээлэл тараах гэмт хэргийн ойлголт, үндсэн шинж

Энэ гэмт хэрэг нь хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэгт (бүлэгт) хамаарах бөгөөд энэ гэмт хэргийн ойлголт, шинжийн талаар үндэсний эрүүгийн эрх зүйн бүтээлүүдэд дараахь байдлаар тэмдэглэсэн байна. Тухайлбал,

1/ Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.14 дүгээр зүйлийн талаар:

Нэгд, Т.Золбоо Сургалтын эрүүгийн хууль хэмээх (2020, 2023) бүтээлд “Бодит хохирол үл шаардах хөнгөн гэмт хэрэг. Хуулиар хамгаалах эрх ашиг нь хувь хүний халдашгүй, чөлөөтэй байдал байх боломжгүй. Учир нь хүний халдашгүй, чөлөөтэй байх ойлголт нь тухайн хүний бие махбодитой

³⁰ Б.Ганболд, Монгол Улсын эрүүгийн хуулийн тайлбар, Уб., Соёмбо принтинг, 2024, 413 – 416 дахь тал.

³¹ Д.Оросоо, Ц.Цэлмэг, С.Дэнсмаа, Г.Туул, Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик, (Илт худал мэдээлэл гэх ойлголтын эрүүгийн эрх зүйн асуудал), Уб., 2021, 19 дэх тал.

³² Д.Оросоо, Ц.Цэлмэг, С.Дэнсмаа, Г.Туул, Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик, (Илт худал мэдээлэл гэх ойлголтын эрүүгийн эрх зүйн асуудал), Уб., 2021, 20 дахь тал.

холбоотойгоор үүснэ. Харин нэр төр, алдар хүндтэй холбоотой үүсэж байгаа харилцаанд хамгаалах эрх ашиг нь хүний нэр төр, алдар хүнд байна. Объектив шинжид хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан үйлдэл байна. Субъектив шинж нь санаатай; субъект нь 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай нийтлэг субъект байна. Тайлбар гээд “Хүний нэр төр” гэдгийг тухайн хүний хувийн болон ёс зүй, түүнчлэн ажил хэргийн чадвар, мэргэжлийн түвшингийн талаар бусдаас өгч буй үнэлэмж. “Хүний алдар хүнд” гэдгийг бусдаас өөрийнх нь талаар өгсөн үнэлгээнд тулгуурлан өөртөө өгсөн тухайн хүний үнэлэмж. “Хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүнд” гэдгийг аж ахуйн үйл ажиллагааны явцад олж авсан нийгмийн үнэлгээ, ажил хэргийн чанар, алдар хүндийн тухай ерөнхий буюу өргөн тархсан санал бодол, хуулиар хамгаалагдсан материаллаг бус баялгийн нэг. “Илт худал мэдээлэл” гэдгийг бодит байдалтай огт нийцэхгүй мэдээлэл. “Олон нийт” гэдгийг нийгмийн нэг хэсгийг тодорхойлсон ойлголт. Тухайн гэмт хэргийн бүрэлдэхүүнийг бий болгох нөхцөлийн хувьд заавал хоёр буюу түүнээс дээш хүн байхыг шаардахгүй нэг хүнд ч илт худал мэдээлэл тараасан байж болно³³ гэж бичсэн байна.

Хоёрт, С.Гантулга, Б.Энхболд нарын Эрүүгийн эрх зүй: Тусгай анги хэмээх (2020) бүтээлд “Худал мэдээлэл тараах гэмт хэргийн ойлголт, нийгмийн хор аюул: Худал мэдээлэл гэмт хэрэг гэдэг нь хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл юм. ... Худал мэдээлэл тараах гэмт хэргийн шинж: гээд Худал мэдээлэл тараах гэмт хэргийн объектив шинж: Объект: Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүнд байна. ... Илт худал мэдээлэл гэж огт үндэслэлгүй, худал хуурмаг мэдээ, баримт сэлтийг ойлгоно. Үнэн бодитой мэдээллийг дэгсдүүлж мэдээлэх нь энэ гэмт хэрэг болохгүй. Олон нийтэд тараасан гэж илт худал мэдээллийг нэг буюу түүнээс олон хүнд түгээсэн байхыг ойлгоно. Мэдээллийг амаар бичгээр, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчны аль алианаар нь тарааж болно. Худал мэдээлэл тараах гэмт хэргийн субъектив шинж: Субъектив тал: Гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ. Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдах, гутаах зорилготой байна. Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдах нь энэ гэмт хэргийн заавал байх шинж юм. ... Субъект: Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн хэн ч байж болно. ... Хэрэв бодит мэдээллийг олон нийтэд тараасан, дэгсдүүлж мэдээлсэн үйлдлийг илт худал мэдээлэл гэж үзэхгүй. Мэдээллийг илт худал гэж ойлгоогүй, хариуцлага

³³ Т.Золбоо, Сургалтын эрүүгийн хууль, Ред. Ж.Эрдэнэбулган, Уб, Соёмбо принтинг, 2020, 110 – 111 дэх тал.

алдаж болгоомжгүйгээр олон нийтэд тараасан бол энэ гэмт хэрэг болохгүй. Энэ тохиолдолд мэдээлэл олон нийтэд тараагдсан нөхцөл байдлыг шалгаж тогтоох шаардлагатай. Илт худал мэдээлэл нь бусдыг доромжилсон эсхүл худал сайшаасан агуулгатай байж болох бөгөөд хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан эсэхийг тухайн хүн, хуулийн этгээд өөрөө тодорхойлох ёстой. Өөрөөр хэлбэл хохирогч өөрийн нэр төр, алдар хүндэд халдсан гэж үзэж гомдол гаргасан тохиолдолд энэ зүйлд заасан гэмт хэрэг болно. Худал мэдээлэл тараах гэмт хэргийн хохирогч нь эрх зүйн чадамжаас үл хамааран эрх зүйн чадвар бүхий иргэн байна. Харин нас барсан хүний талаар илт худал мэдээлэл тараасан, гүтгэсэн бол Иргэний хуулийн 520 дугаар зүйлийн 520.1 – 520.3–д заасан хууль ёсны өвлөгч нь хохирогч байж болно”³⁴ гэж бичсэн байна.

Гуравт, Х.Доржпалам Монгол Улсын эрүүгийн эрх зүй: Тусгай анги (2021) хэмээх бүтээлд “Худал мэдээлэл тараах гэмт хэргийн үндсэн шинж: а.гэм буруутай этгээд бусдын хуулиар хамгаалагдсан халдашгүй эрхийг зөрчиж, илт худал мэдээллийг /амаар, бичгээр, олшруулж, дуу дүрс бичлэгээр, хэвлэл мэдээллийн хэрэгслээр/ тараасан; б.уг мэдээллийг нэг хоёрхон хүнд бус, олон хүнд буюу “олон нийтэд” түгээсэн; в.тараасан мэдээлэл хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн /бизнесийн/ нэр хүндийг гутаах агуулгатай байж гэмт хэргийн бүрдэл хангагдана. Ихэвчлэн нэр төр, алдар хүндийг унагах зорилготой, өш хонзон санах, атаархах, үзэн ядах сэдэлттэй байна. ... Худал мэдээллийг бодит байдалд андуу ташаа дүгнэлт хийснээс олон нийтэд тараасан нөхцөлд эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө. Гүтгэх гэмт хэрэг гэж байх үед хүндрүүлэх бүрэлдэхүүний шинж болгож байсан “хүнд гэмт хэрэгт холбогдуулан худал мэдээлэл тараасан этгээдэд”, мөн нэр төр, алдар хүнддээ харш илт худал мэдээлэл тарааснаа цочрол авсан хохирогч амь нас, эрүүл мэндээрээ хохирсон, бизнесийн байгууллага их хэмжээний хохирол амссан тохиолдлуудад энэ зүйлд тогтоосноос харьцангуй чанга хариуцлага хүлээлгэж байх нь зүйд нийцнэ”³⁵ гэж бичсэн байна.

Дөрөвт, Б.Ганболд Монгол Улсын эрүүгийн хуулийн тайлбар хэмээх (2024) бүтээлд “1.Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад зааснаар “хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, энэ эрхийг бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх; үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах үүднээс хуулиар хязгаарлаж” болно. Иймд эрүүгийн хуулийн энэ зүйлээр хамгаалж буй нэгэн чухал үнэт зүйл нь хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх төдийгүй биш харин хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүнд байна. Харин энэ зүйлээр эрүүгийн хариуцлага хүлээх этгээд нь 16 насанд

³⁴ С.Гантулга, Б.Энхболд, Эрүүгийн эрх зүй: Тусгай анги, Хоёр дахь хэвлэл, ред. Г.Гангомөр, Уб., Мөнхийн үсэг, 2020, 90 – 91 дэх тал.

³⁵ Х.Доржпалам, Монгол Улсын эрүүгийн эрх зүй (Тусгай анги), Ред. Ж.Эрдэнэбулган, Уб., Сэлэнгэпресс, 2021, 73 дахь тал.

хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, хүн байна. Энэ нь сэтгүүлч, сурвалжлагч зэргээр хязгаарлагдахгүй болно. 2.Энэ гэмт хэргийн субъектив шинж нь гэм буруугийн шууд санаатай хэлбэртэй, хувийн болон бусад сэдэлт, зорилготой, объектив шинж нь худал мэдээлэл тараасан үйлдэл байдаг бөгөөд энэ үйлдлийг хийснээр төгсдөг, хор уршиг заавал учирсан байхыг шаардахгүй учир хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэгт тооцогдоно. 3.Энэ зүйлд “хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараахыг гэмт хэрэг” гэж үзэхээр заасан нь өш хонзон, үзэн ядах, уур хорслоо тайлах, атаархах, эр эмийн хардлага зэрэг атгаг санаагаа хэрэгжүүлэх гэсэн хувийн болон бусад сэдэлттэй байж болох бөгөөд илт худал гүжирдлэгийн шинжтэй худал мэдээлэл, баримт сэлтийг нэг буюу түүнээс дээш хүнд түгээсэн байна. 4.Энэ гэмт хэргийн гол шинж нь “илт худал мэдээллийг тараасан” гэдэгт оршиж буй учир “илт” гэж үзэх ямар шинж байгаа талаар хууль зүйн зөв дүгнэлт өгөх нь шүүхийн шийдвэр хууль ёсны ба бодит үндэслэлтэй гаргахад шууд нөлөөлөх юм. 5.Хүний нэр болон хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг ашиглаж илт худал мэдээллийг олон нийтэд тараах замаар залилан мэхлэх үйлдлийг энэ гэмт хэргээс ялган зүйлчлэх учиртай”³⁶ гэж бичсэн байна.

Өмнө дурдсан эдгээр бүтээлүүдийн агуулгыг нэгтгэн дүгнэж үзвэл, худал мэдээлэл тараах гэмт хэргийн бүрэлдэхүүний үндсэн шинжийн хувьд зарим талаар ялгаатай төдийгүй хоёрдмол утгаар ойлгогдох нөхцөл байдлыг бүрдүүлэн тайлбарлаж байгаа болох нь тодорхой харагдаж байна.

2/ Худал мэдээлэл гэх ойлголтын талаар товчхон:

“Худал мэдээлэл” гэсэн ойлголтыг дотор нь (i) хуурамч мэдээлэл (disinformation), (ii) алдаатай мэдээлэл (misinformation), (iii) буруу сэдэлтэй мэдээлэл (mal-information) гэж ангилан авч үзэж байна.³⁷ Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.14 дүгээр зүйлд заасан худал мэдээлэл тараах гэмт хэрэгт хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан худал мэдээллийн хэлбэрүүд болох (i) хуурамч мэдээлэл, (ii) алдаатай мэдээлэл, (iii) буруу сэдэлтэй мэдээлэл тараасан үйлдлүүдийг “бүхэлд нь” хамруулан хуулийг хэрэглэх боломжтой байна. Учир нь эрх зүйн зохицуулалтын хувьд, бусдыг гутаах зорилгоор тараасан байх шаардлага эрүүгийн хуулиар тавигдаагүй тул ямар нэг байдлаар тараасан буюу нэр төрд халдсан бол худал мэдээлэл тараах гэмт хэрэгт шалгагдах, хариуцлагад татагдах эрсдэлтэй. Өөрөөр хэлбэл, илт худал мэдээлэл тараасан бол хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилго шаардахгүй бөгөөд тараасан буюу халдсан бол гэмт хэрэгт тооцогдох боломжтой гэсэн үг.³⁸

³⁶ Б.Ганболд, Монгол Улсын эрүүгийн хуулийн тайлбар, Уб., Соёмбо принтинг, 2024, 413 – 416 дахь тал.

³⁷ Д.Оросоо, Ц.Цэлмэг, С.Дэнсмаа, Г.Туул, Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик, (Илт худал мэдээлэл гэх ойлголтын эрүүгийн эрх зүйн асуудал), Уб., 2021, 32 дахь тал.

³⁸ Д.Оросоо, Ц.Цэлмэг, С.Дэнсмаа, Г.Туул, Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик, (Илт худал мэдээлэл гэх ойлголтын эрүүгийн эрх зүйн асуудал), Уб., 2021, 33 дахь тал.

З/ Гүтгэхийг гэмт хэрэгт тооцохгүй болсон нь:

Монгол Улсын 2002 ба 2015 оны Эрүүгийн хуулийн харьцуулсан судалгаа хэмээх (2016) бүтээлд “2002 оны Эрүүгийн хуулиар гүтгэхийг гэмт хэрэгт тооцож байсан бол 2015 оны Эрүүгийн хуульд гүтгэхийг гэмт хэрэгт тооцохгүй болсон”³⁹ нь эрх зүйн зохицуулалтын харьцуулалтаас харагдана. Энэ талаар хууль зүйн толь бичгүүдэд “гүтгэлэг – Монгол Улсын эрүүгийн эрх зүйд бусдын нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэг тараасан гэмт хэрэг”⁴⁰, “гүтгэх – энэ гэмт хэргийн онцлог шинж нь бусдын нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэг тарааснаар тодорхойлогдоно . . . Объектив тал нь илт худал гүжирдлэг тараасан идэвхтэй үйлдлээр илэрнэ. Илт худал гүжирдлэг гэж бодит байдалд огт нийцээгүй мэдээ сэлт байна. Энэхүү илт худал гүжирдлэг нь хохирогчийг гутаасан шинжийг агуулна”⁴¹ гэж тус тус үздэг байсан бөгөөд Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг (2021) хэмээх бүтээлд “Гүтгэлэг – (лат. calumnia; англ. slander, calumny; ор. клевета) эрх зүйд бусдын нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэг тараах. 2002 он болон түүнээс өмнөх Эрүүгийн хуульд гэмт хэрэгт тооцож байсан. Хүний сайн нэр амь настай дүйцэхүйц хэмжээнд хүрдэг учраас 2002 он болон түүнээс өмнөх Эрүүгийн хуульд гэмт хэрэгт тооцож байсан”⁴² гэж бичсэн байна. Үгийн утга агуулгыг Я.Цэвэлийн Монгол хэлний товч тайлбар толь хэмээх (2021) бүтээлд ““гүтгэх” гэдгийг оргүй хэргийг зохиож бусдыг муутган унагах, худал хэрэг тулгах буюу гөрлөх; гүтгэх гүжирдэх хорш;”⁴³ гэж тайлбарлахын зэрэгцээ ““гүжирдэх” гэдгийг гөрлөн гүтгэх, мэлзэх;”⁴⁴ ““гүжирлэх” гэдгийг гүтгэрдэх, гөрдөх, гүтгэх”⁴⁵ гэж тус тус тайлбарласан байна. Үүнээс гадна ““гөрдөх” гэдгийг 1.худал зүйлээр бусдыг бурангуйлан гүтгэх; шууд л гөрдөөд бай;”⁴⁶ гэж тайлбарласан байх нь бий. Мөн түүнчлэн С.Нарангэрэл, Ж.Эрдэнэбулган нарын Монгол Улсын эрүүгийн эрх зүй хэмээх (2019) бүтээлд “Гүтгэх гэмт хэргийг гэмт хэрэг биш гэж тооцсон асуудлыг ингэж тусгайлан авч үзэхийн учир шалтгаан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад хүний нэр төр, алдар хүндийг хүндэтгэх явдлыг Монгол Улсын иргэний үндсэн үүрэг болгосонд оршино. Хүнийг гүтгэх явдлыг

³⁹ МУИС–ийн Хууль зүйн сургууль, Монгол Улсын 2002 ба 2015 оны Эрүүгийн хуулийн харьцуулсан судалгаа, эмх. С.Нарангэрэл, Ж.Эрдэнэбулган, Б.Амарбаясгалан, С.Амартүвшин, Т.Золбоо, Уб., Адмон принтинг, 2016, 104 дэх тал.

⁴⁰ С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг, Хоёр дахь хэвлэл, Уб., Адмон принтинг, 2008, 123 дах тал.

⁴¹ Ж.Амарсанаа, Г.Баясгалан, Ж.Бямбаа, Т.Мөнхжаргал, С.Нарангэрэл, Г.Совд, Г.Уранцэцэг, Хууль зүйн тайлбар толь, ред. Г.Совд, С.Нарангэрэл, Уб., Митита принтинг, 2003, 68 – 69 дэх тал.

⁴² С.Нарангэрэл, Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг, ред. Х.Нямбаатаар, Уб., Адмон принтинг, 2021, 88 дахь тал.

⁴³ Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, Нэмж дэлгэрүүлсэн дөрөвдүгээр хэвлэл, Уб., Мөнхийн үсэг, 2021, 242 дахь тал.

⁴⁴ Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, Нэмж дэлгэрүүлсэн дөрөвдүгээр хэвлэл, Уб., Мөнхийн үсэг, 2021, 237 дахь тал.

⁴⁵ Мөн тэнд

⁴⁶ Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, Нэмж дэлгэрүүлсэн дөрөвдүгээр хэвлэл, Уб., Мөнхийн үсэг, 2021, 223 дахь тал.

манай улс 1926 оны Шүүх цаазын бичигт “Аливаа хүн бусдыг доромжлох хорт санаагаар худал хуурамч зүйлийг олонд тунхаглан зарлах бичиг зураг оруулан тарааваас” гэж тодорхойлсноос хойш бараг зуун жил шахам гэмт хэрэгт тооцож ирсэн юм. Нэрээ барахаар насаа бар гэсэн монгол ардын мэргэн үг нэр төрөө алдвал амьд явахад нэн бэрх болно гэх утга санааг агуулдаг. Зарим үед хүний нэр төр, алдар хүнд амь наснаас нь илүүтэй үнэлэгдэх тохиолдол энэ хорвоод цөөнгүй гардаг. Энэ учраас хүний цэвэр ариун нэр төр, алдар хүнд гэмт халдлагаас заавал хамгаалагдах учиртай”⁴⁷ гэж үзэж байв.

Б.Худал мэдээлэл тараах гэмт хэрэгтэй төстэй бусад гэмт хэрэг

Энэ гэмт хэрэгтэй төстэй бусад гэмт хэргийн талаар Х.Доржпалам Монгол Улсын эрүүгийн эрх зүй (Тусгай анги) хэмээх (2021) бүтээлд “Бүх шатны сонгуулийн сурталчилгааны ажлын цаг үеэр /объектив талын нэмэгдэл шинж/ сонгуульд нэр дэвшигчийн нэр хүндэд халдаж илт худал мэдээлэл тараасан бол 14.8–д заасан гэмт хэрэг болно. Сонгуулийн бус цаг үед илт худал мэдээлэл тараасан гэм буруутай этгээд 13.14–д заасан гэмт хэргийн субъект болно”⁴⁸ гэж бичсэн байна. Тус бүтээлд “сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах” гэмт хэргийн талаар “2015 оны Эрүүгийн хуулийн 14.8–д сонгуулийн үеэр сонгуульд оролцогч улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн нэр хүндэд халдаж бодит байдлаас зөрүүтэй илт худал мэдээлэл тараахыг анх удаа гэмт хэрэгт тооцон хориглож, зөрчсөн гэм буруутай этгээдэд оногдуулах ялын төрөл, хэмжээг тогтоосон. Энэхүү хэм хэмжээ зөвхөн сонгуулийн дүнд сөрөг нөлөөлж болох үзэгдлийг таслан зогсооход бус сонгуульд өрсөлдөгч улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчдийг улс төрийн соёлтойгоор шударга өрсөлдөхөд ач холбогдолтой. ... Нэр хүндэд халдаж, илт худал мэдээлэл тараахдаа гэмт буруутай этгээд сонгуульд оролцогч улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг сонгогчдын дотор унагаж, сонгуульд ялагдуулах сэдэлттэй байна. Илт худал мэдээлэл тараасан байх нь энэ хэргийн заавал байх шинж. Улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн хийгээгүй муу үйлийг хийсэн болгож, хийсэн сайн үйл, байгуулсан гавьяаг үгүйсгэж ор үндэсгүй худал мэдээллийг сонгогчидтой хийсэн уулзалтын үеэр амаар ярьсан, мэдээллийн хэрэгсэл /сонин хэвлэл, телевиз, радио, FM радио/, нийтийн сүлжээгээр тараасан идэвхтэй үйлдлээр илэрнэ. Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараасан эрүүгийн хариуцлага хүлээлгэх субъект энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан сонгуулийн хорооны албан тушаалтан, ажилтнаас бусад хэн ч байж болно. ... Хүндрүүлэх бүрэлдэхүүн – 14.8–ийн 2 дахь хэсэг: Сонгуулийн үеэр илт худал мэдээллийг тараасан гэм буруутай этгээд төрийн албан хаагч, сонгуулийн

⁴⁷ С.Нарангэрэл, Ж.Эрдэнэбулган, Монгол Улсын эрүүгийн эрх зүй: Үзэл баримтлал, уламжлал, сургаж, (Нэгэн сэдэвт бүтээл), Уб., Соёмбо принтинг, 2019, 240 дэх тал.

⁴⁸ Х.Доржпалам, Монгол Улсын эрүүгийн эрх зүй, (Тусгай анги), ред. Ж.Эрдэнэбулган, Уб., Сэлэнгэ пресс, 2021, 73 дахь тал.

хорооны албан тушаалтан, ажилтан байх аваас эрүүгийн хариуцлагыг энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас хүндрүүлэх нөхцөл байдал болгож, 1 – 3 жил хүртэл хугацаагаар нийтийн албанд томилогдох эрх хасаж, 1350 – 10 мянган нэгжтэй тэнцэх буюу 1.3 – 10 сая төгрөгөөр торгох, эсхүл 6 сараас 2 жил хүртэл хугацаагаар зорчих эрх хязгаарлах, эсхүл 6 сараас 2 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Төрийн албан хаагч үйлдсэн гэж Сонгуулийн ерөнхий хорооноос бусад төрийн байгууллагад ажилладаг, сонгуулийн тойрог, хэсгийн хороодод ажиллах үүрэг хүлээгээгүй, төсвөөс цалинждаг албан тушаалтнуудыг хамааруулна”⁴⁹ гэж бичсэн байна.

Харин С.Гантулга, Б.Энхболд нарын Эрүүгийн эрх зүй: Тусгай анги хэмээх (2020) бүтээлд “Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан худал мэдээлэл тараах, 14.8 дугаар зүйлд заасан сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах гэмт хэргүүд нь илт худал мэдээлэл тарааж байгаа цаг хугацаа, халдлагад өртөгчөөрөө ялгагдана. Сонгуульд оролцогч улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн нэр хүндэд халдаж, илт худал мэдээлэл тараасан бол Эрүүгийн хуулийн 14.8 дугаар зүйлд заасан сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах гэмт хэрэг гэж үзнэ. Сонгуульд нэр дэвшсэн хүнийг, эсхүл нэр дэвших гэж байгаатай нь холбогдуулж сонгуулийн бус үеэр илт худал мэдээлэл тараасан бол 13.14 дүгээр зүйлд заасан худал мэдээлэл тараах хэргээр зүйлчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Бусдыг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг шаардаж өөрт нь, түүний ойр дотны хүний эрх хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулж болохуйц илт худал баримт, мэдээлэл тараахаар сүрдүүлсэн бол Эрүүгийн хуулийн 13.5 дугаар зүйлд заасан заналхийлэх гэмт хэргээр, тухайн мэдээллээ тараасан бол Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан худал мэдээлэл тараах гэмт хэргээр зүйлчилнэ”⁵⁰ гэж бичсэн байна.

Тэгвэл Б.Ганболдын Монгол Улсын эрүүгийн хуулийн тайлбар хэмээх (2024) бүтээлд “1.Энэ зүйлийн хууль зүйн зохицуулалт нь сонгуулийг цэвэр, шударга, тэгш эрхийн зарчмаар явуулах, иргэд чөлөөт, бие даасан байдлаар саналаа чөлөөтэй илэрхийлж өгөх эрхийг хангах, улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн нэр хүндийг хамгаалах буюу бохир улс төрөөс ангид байх явдлыг баталгаажуулахад зориулагдсан болно. 2.Энэ зүйлээр сонгуульд оролцогч улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн нэр хүндийг хамгаалсан бөгөөд эрүүгийн хариуцлага хүлээх этгээд нь 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, хувь хүн байна, тусгай субъект бол хүндрүүлж зүйлчилнэ. 3.Энэ гэмт хэргийн субъектив шинж нь гэм буруугийн санаатай хэлбэртэй, хувийн болон улс төрийн сэдэлт, зорилготой байдаг бол, объектив шинж нь сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараасан хууль бус үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх бөгөөд бодит хор уршиг заавал шаардахгүй учир

⁴⁹ Х.Доржпалам, Монгол Улсын эрүүгийн эрх зүй, (Тусгай анги), ред. Ж.Эрдэнэбулган, Уб., Сэлэнгэ пресс, 2021, 88 – 90 дэх тал.

⁵⁰ С.Гантулга, Б.Энхболд, Эрүүгийн эрх зүй: Тусгай анги, Хоёр дахь хэвлэл, ред. Г.Гантөмөр, Уб., Мөнхийн үсэг, 2020, 90 – 91 дэх тал.

хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэгт тооцогдоно. 4.Энэ гэмт хэрэг нь зөвхөн сонгуулийн цаг хугацаанд үйлдэгдэн гардаг, хохирогч нь гагцхүү сонгуульд оролцогч /нэр дэвшигч/ байдаг онцлог шинжээрээ Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан худал мэдээлэл тараах гэмт хэргээс ялгагдана”⁵¹ гэж бичсэн байна.

Мөн түүнчлэн Монгол Улсын 2002 ба 2015 оны эрүүгийн хуулийн харьцуулсан судалгаа хэмээх (2016) бүтээлд “14.8 дугаар зүйл. Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах”⁵² гэмт хэрэг нь шинээр нэмэгдсэн гэмт хэрэг болох нь тодорхой харагдаж байна. Уг гэмт хэргийн бүрэлдэхүүний талаар Т.Золбоо Сургалтын эрүүгийн хууль хэмээх (2023) бүтээлд “Бодит хохирол үл шаардах хөнгөн гэмт хэрэг. Хуулиар хамгаалах эрх ашиг нь сонгуулийн хорооны үнэн зөв, хэвийн үйл ажиллагааны журам ба бусад сонгогдогчийн эрх ашиг. Объектив шинжид сонгуульд ажилтай нь холбогдуулан улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн нэр хүндэд халдсан илт худал мэдээлэл тараасан үйлдэл байна. Субъектив шинж нь санаатай. Субъект нь 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай нийтлэг, хүндрүүлэх нөхцөл байдалд тусгай субъект байна”⁵³ гэж бичсэн байна.

В.Гадаадын зарим улсын зохицуулалтын талаар

Гүтгэхийг гэмт хэрэгт тооцож байгаа нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг зөрчдөг гэж үздэг боловч Франц, Герман, Испани, Канад, Дани, Австри зэрэг өндөр хөгжилтэй ардчилсан улсад энэ төрлийн үйлдэлд эрүүгийн хариуцлага оногдуулах хуультай гэдгийг мартаж болохгүй. Гагцхүү эдгээр оронд энэ ялын хэрэглээг үг хэлэх эрх, бусад зарчим, шүүхийн практикаар ихээхэн хязгаарладагт гол ялгаа нь оршиж байна.⁵⁴ Гадаад орнуудын (ОХУ, ХБНГУ, БНХАУ зэрэг) эрүүгийн хуульд гүтгэх гэмт хэргийн талаар харилцан адилгүй хуульчилсан байна. Жишээлбэл, ОХУ-ын Эрүүгийн хуулийн 128



⁵¹ Б.Ганболд, Монгол Улсын эрүүгийн хуулийн тайлбар, Уб., Соёмбо принтинг, 2024, 436 дахь тал.

⁵² МУИС-ийн Хууль зүйн сургууль, Монгол Улсын 2002 ба 2015 оны Эрүүгийн хуулийн харьцуулсан судалгаа, эмх. С.Нарангэрэл, Ж.Эрдэнэбулган, Б.Амарбаясгалан, С.Амартүвшин, Т.Золбоо, Уб., Адмон принтинг, 2016, 134 дэх тал.

⁵³ Т.Золбоо, Сургалтын эрүүгийн хууль, Ред. Ж.Эрдэнэбулган, Уб., Удам соёл, 2023, 117 дахь тал.

⁵⁴ Ч.Энхбаатар, Том Гинсбург, П.Амаржаргал, М.Багчимэг, Ц.Даваадулам, О.Мөнхсайхан, Д.Солонго, Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ, Уб., Бест Колор Интернэшнл, 2016, 58 дахь тал.

дугаар зүйлд (Гүтгэх)⁵⁵, БНХАУ–ын Эрүүгийн хуулийн 243 дугаар зүйлд⁵⁶ тус тус заасан. Харин ХБНГУ–ын Эрүүгийн хуулийн 186 (Худал цуу яриа тараах)⁵⁷, 187 (Гүтгэх)⁵⁸ болон 188 (Улс төрийн хүнтэй холбоотой худал цуу яриа болон гүтгэлэг)⁵⁹ гэх зэргээр заасан бөгөөд тус улс нь зэрэгцэн эрүүгийн хуультай буюу эрүүгийн ерөнхий хуулиас гадна бусад хууль тогтоомжид эрүүгийн гэмт хэрэг, түүнд оногдуулах ялын төрөл, хэмжээний

⁵⁵ Энэ зүйлд “1.Бусдын нэр төрийг санаатайгаар гутааж буюу нэр хүндэд нь халдаж, хуурамч мэдээлэл тараасан бол таван зуун мянга хүртэл рубль эсхүл ялтны зургаан сар хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл зуун жаран цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх ял шийтгэнэ. 2.Олон нийтийн өмнө ярьсан, эсвэл нийтэд бүтээлээр үзүүлсэн, мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүний нэр төрд халдсан бол нэг сая хүртэл рубль эсхүл ялтны нэг жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл хоёр зуун дөчин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх ял шийтгэнэ. 3.Энэ хэргийг албан тушаалын байдлаа ашиглан үйлдсэн бол хоёр сая хүртэл рубль эсхүл ялтны хоёр жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл гурван зуун хорин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх ял шийтгэнэ. 4.Бусад аюул учруулж болзошгүй хүнд өвчтэй гэж гүтгэсэн бол гурван сая хүртэл рубль эсхүл ялтны гурван жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл дөрвөн зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл дөрвөн жил хүртэл хугацаагаар албадан хөдөлмөр хийлгэх, эсхүл зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 5.Бэлгийн хүчирхийллийн хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн гэж гүтгэсэн бол таван сая хүртэл рубль эсвэл ялтны гурван жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл дөрвөн зуун наян цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл дөрвөн жил хүртэл хугацаагаар албадан хөдөлмөр хийлгэх, эсхүл дөрөвөөс зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заасан. Монгол, Орос, Хятад, Герман улсын эрүүгийн хууль, (Орчуулж нэгтгэсэн анхны хэвлэл), орч. Ж.Эрдэнэбулган, М.Уянга, Б.Тамир, Б.Батбаяр, Т.Золбоо, Уб., Соёмбо принтинг, 2021, 144 – 145 дахь тал.

⁵⁶ Энэ зүйлд “Бусдыг эрүүгийн хэргээр нэхэмжлүүлэх зорилгоор оргүй хэрэг учрыг зохион гаргаж бусдыг гүтгэн гүжирлээд үйл байдал нь хүнд ноцтой байвал гурван жилээс доош хугацаатай хорих, хорьж хөдөлмөрлүүлэх буюу захиран хамаарахаар шийтгэнэ; хүнд ноцтой уршиг татсан байвал гурван жилээс дээш арван жилээс доош хугацаатай хорихоор шийтгэнэ. Төрийн байгууллагын ажилтан өмнөх бадагт тогтоосон ялыг хийсэн байвал хүндээр шийтгэнэ. Санаатайгаар гүтгэн гүжирлэсэн биш, харин буруу заалдсан буюу илчилсэн нь бодитой байдалтай нийцээгүй байвал өмнөх хоёр бадгийн тогтоолыг хэрэглэхгүй” гэж заасан. Монгол, Орос, Хятад, Герман улсын эрүүгийн хууль, (Орчуулж нэгтгэсэн анхны хэвлэл), орч. Ж.Эрдэнэбулган, М.Уянга, Б.Тамир, Б.Батбаяр, Т.Золбоо, Уб., Соёмбо принтинг, 2021, 309 дэх тал.

⁵⁷ Энэ зүйлд “Бусдын нэр хүндийг унагааж, олон нийтийн өмнө гутаан доромжлуулахын тулд түүний талаар нотлогдоогүй баримтыг зарласан эсвэл тараасан бол нэг жил хүртэл хугацаагаар хорих эсвэл торгох ял шийтгэх бөгөөд, хэрэв олон нийтэд хэвлэмэл баримт (энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг) тараах байдлаар энэхүү гэмт хэргийг үйлдсэн бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих эсвэл торгох ял шийтгэнэ” гэж заасан. Монгол, Орос, Хятад, Герман улсын эрүүгийн хууль, (Орчуулж нэгтгэсэн анхны хэвлэл), орч. Ж.Эрдэнэбулган, М.Уянга, Б.Тамир, Б.Батбаяр, Т.Золбоо, Уб., Соёмбо принтинг, 2021, 433 дахь тал.

⁵⁸ Энэ зүйлд “Бусадтай холбоотой баримтыг худал гэдгийг мэдсээр байж түүнийг олон нийтийн өмнө гутаан доромжлуулж, зээлийн чадварт нь эрсдэл учруулахын тулд түүний талаар худал баримтыг зарласан эсвэл тараасан бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх бөгөөд, хэрэв хурал цуглааны үеэр эсвэл хэвлэмэл баримт (энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг) тараах байдлаар энэхүү гэмт хэргийг үйлдсэн бол таван жил хүртэл хугацаагаар хорих эсвэл торгох ял шийтгэнэ” гэж заасан. Монгол, Орос, Хятад, Герман улсын эрүүгийн хууль, (Орчуулж нэгтгэсэн анхны хэвлэл), орч. Ж.Эрдэнэбулган, М.Уянга, Б.Тамир, Б.Батбаяр, Т.Золбоо, Уб., Соёмбо принтинг, 2021, 434 дэх тал.

⁵⁹ Энэ зүйлд “(1)Хүнийг улс төрийн байдалтай холбоотойгоор нь олон нийтийн өмнө, хурал цуглааны үеэр эсвэл хэвлэмэл баримт (энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг) тараах замаар түүний ажил хэрэгт ихээхэн хүндрэл учруулахуйц цуу яриа (энэ хуулийн 187 дугаар зүйл) гаргасан бол гурван сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. (2)Дээрхтэй ижил нөхцөлийг хангаж гүтгэлэг хийсэн бол зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заасан. Монгол, Орос, Хятад, Герман улсын эрүүгийн хууль, (Орчуулж нэгтгэсэн анхны хэвлэл), орч. Ж.Эрдэнэбулган, М.Уянга, Б.Тамир, Б.Батбаяр, Т.Золбоо, Уб., Соёмбо принтинг, 2021, 434 дэх тал.

талаар оруулдаг онцлогтой.⁶⁰ Энэ талаар Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик хэмээх (2021) судалгаанд “ХБНГУ, ОХУ–ын эрүүгийн хуулийн гүтгэхтэй холбоотой зүйл, заалтыг Монгол Улсын эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан худал мэдээлэл тараах гэмт хэргийн зүйл, заалттай харьцуулан авч үзэхэд манай улс худал мэдээлэл тараах гэмт хэрэгт гүтгэлэг тарааж буй этгээдийн субъектив санаа зорилгыг шаардахгүй байхаар хуульчилснаараа ялгаатай байна. Манай улсын эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан уг гэмт хэрэг нь онолын хувьд санаатай гэмт хэрэг мөн боловч хууль зүйн техникийн хувьд бусдын нэр төрийг гутаах зорилгоор тараасан байх шалгуурыг орхигдуулсан нь сул тал болж, практикт сөрөг үр дагавар үүсгэж байгаа болно. Уг гэмт хэрэгт худал мэдээлэл тарааж буй этгээдийн субъектив санаа зорилго чухал ач холбогдолтой юм. Үүнийг ХБНГУ, ОХУ–ын эрүүгийн хуульд илүү тодорхой тусгасан байгаа нь манайхаас дэвшилттэй байна. Харин манай улс худал мэдээлэл тараах гэмт хэрэгт хэргийн объектив шинж чанарыг гол шинж болгон авч үзэж, хэргийн чухал бүрэлдэхүүн болсон гэмт санаа зорилго болох субъектив талыг орхигдуулсан нь ХБНГУ, ОХУ–ын эрүүгийн хуультай харьцуулан авч үзэхэд ухралт болжээ”⁶¹ гэж харьцуулан дүгнэсэн байна. Тус судалгаанд “Гүтгэлгийн холбогдолтой асуудлыг нэг хуулиар, нэг арга замаар шийдэх боломжгүй. Тухайлбал, хэвлэлийн эрх чөлөөнд хамаарах, иргэд төрөө хянах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй холбоотойгоор учир дутагдалтай зохицуулалт олон байна. Бусад улс оронд төрийн албан хаагч болон олон нийтийн зүтгэлтэн ямар нэг асуудлаар олон нийтийн хэлэлцүүлэгт өртвөл эхлээд аль нэг шүүхэд хандахаасаа өмнө хэлэлцэгдэж байгаа асуудалтай холбогдуулан тайлбар хийх үүрэгтэй байдаг. Монгол энэ төрлийн зохицуулалт байхгүй тул өөрийг нь шүүмжилсэн эсхүл төрийн албыг ил тод болгох гэсэн үйлдлийг шууд хуулийн байгууллагаар таслан зогсоолгох гэж оролдож байна”⁶² гээд “Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хууль тогтоогч тодорхойлохдоо субъектив талыг орхигдуулсан байдал (уг гэмт хэргийн объектив болон субъектив талыг тэнцвэргүй тодорхойлсон), шүүхийн практикт худал мэдээлэл тараасан гэмт хэргийг шалгах, шийдвэрлэхдээ мэдээллийг тараасан субъектив санаа зорилгод ач холбогдол өгөхгүй, объектив талын шинжээр буруутгаж байгаа нь олон улсын жишиг зарчимд нийцэхгүй байна”⁶³ гэж онцлон дурджээ.

Г.Худал мэдээлэл тараах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал

Худал мэдээлэл тараах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын 2024 оны 12 дугаар сарын 17–ны өдрийн “Хариу хүргүүлэх тухай” 4/7931 тоот албан бичигт “... Прокурорын тухай

⁶⁰ Ц.Цэлмэг, Д.Майцэцэг, Харьцуулсан эрүүгийн эрх зүй, Уб., Сэлэнгэ пресс, 2021, 149 дэх тал.

⁶¹ Д.Оросоо, Ц.Цэлмэг, С.Дэнсмаа, Г.Туул, Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик, (Илт худал мэдээлэл гэх ойлголтын эрүүгийн эрх зүйн асуудал), Уб., 2021, 53 дахь тал.

⁶² Д.Оросоо, Ц.Цэлмэг, С.Дэнсмаа, Г.Туул, Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик, (Илт худал мэдээлэл гэх ойлголтын эрүүгийн эрх зүйн асуудал), Уб., 2021, 56 дахь тал.

⁶³ Мөн тэнд

хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт “Прокурор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор гэмт хэрэг, зөрчил гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулах мэдэгдэл бичнэ”, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар бүх шатны төрийн байгууллага энэ хуулийн 30.1—д зааснаас гадна дараах үүрэг хүлээнэ”, 27.1.3 дахь заалтад “эрхлэх асуудлынхаа хүрээнд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомжийг мэдээлэх, сурталчлах, сургалт зохион байгуулах” гэж хуульчилсан. Прокурорын байгууллагаас хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэн, гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар мэдэгдэл бичих, олон нийтэд подкаст нэвтрүүлэг бэлтгэж мэдээлэх, яриа таниулга хийх, сургалт зохион байгуулж, хууль тогтоомжийн талаар гарын авлага бэлтгэн иргэд, олон нийтэд хүргэх зэрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна”⁶⁴ гэж дурдсан.

2. Гүтгэх гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтын түүхэн хөгжлийн талаархи эргэцүүлэл

Харьцуулсан эрх зүйн түүхэн судалгаа болох Ж.Цэвээний Улсын эрх хэмээх бүтээлд “. . . хүн хэн ч атугай дотроо санасанаа илтгэн гаргаж хэлэх . . .”⁶⁵ болон “. . . хүн бүр мэдсэн санаснаа илтгэн бичиж олон түмэнд үзлээ хэвлэн тархаах эрх буй. Гагцхүү тэрслүү хортой зүйлийг номлож, улсын ба хүний ёсыг эвдэхүйд хүрвээс үл болно. Хэрэв тэрслүү хортойг номлож тархаах буй аваас тухайд тогтоосон дүрмийн ёсоор шийтгэж ял торгомой. Үүнд өгүүлэх нь, мэдсэн санасан сайн үзлийг олон боловсон улс дам дам дамжуулан улам бүр хөгжүүлэн ард түмнийг аливаа эрдэмд боловсруулахыг хичээнэ. Хэрэв эрдэмтний зохиосон бичсэн зүйлийг энэхэн тэрхэн хэмээн үл ойшоож цаазлан, харшилбаас олон түмэн эрдэм сурч ухаан нээгдэх зам таглагдаж улс хүчирхэг болж чадахгүй болно . . .”⁶⁶ гэх зэргээр үг хэлэх эрх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний талаар (100 гаруй жилийн өмнөөс) бичиж тэмдэглэж ирсэн байна. Хэдий тийм ч 1924 оны БНМАУ-ын анхдугаар Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн долоод “Элдэв хэргийг жинхэнэ ард түмнээр шүүмжлэх эрхийг хүндэтгэж, тус улсаас аливаа хэвлэх, нийтлэх явдлыг бүртгэн гүйцэтгүүлбэл зохино”⁶⁷ гэж байв. Үндсэн хуулийн тайлбарыг хэвлүүлэх тухай Засгийн газрын хорин тавдугаар хурлын тогтоол (Монгол Улсын 16 дугаар он зургаан сарын 25) гарч байсан бөгөөд БНМАУ-

⁶⁴ Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг бүртгэх, Мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга О.Мөнхбаатарын 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн “Хариу хүргүүлэх тухай” 4/7931 тоот албан бичигт

⁶⁵ Ж.Цэвээн, Улсын эрх, хөрвүүлсэн. С.Идшинноров, С.Ичинноров, ред. Ч.Өнөрбаяр, Уб., Адмон принтинг, 2014, 28 дахь тал.

⁶⁶ Ж.Цэвээн, Улсын эрх, хөрвүүлсэн. С.Идшинноров, С.Ичинноров, ред. Ч.Өнөрбаяр, Уб., Адмон принтинг, 2014, 29 дэх тал.

⁶⁷ Ж.Амарсанаа, О.Батсайхан, Монгол Улсын Үндсэн хууль (Баримт бичиг), ред. Б.Чимид, С.Төмөр, Уб., 2004, 43 дахь тал.

ын Үндсэн хуулийг зүйл анги дараалан товчоноор тайлбарласан дэвтэр бий.⁶⁸ Уг дэвтэрт “Урьдын эзэрхэг харгис засгийн үед бидний Монголын олон түмэн ардууд улс төрийн их хэрэгт хүрэлцэн шүүмжлэх байтугай орон нутгийн өчүүхэн бага хэрэгт ч үг хэлэх эрх огт үгүй байсан бөгөөд эдүгээ аваас бидний Монгол нэгэнт бүгд найрамдах ард улсын засгийг явуулж, харьяат олон түмэн ардуудад бүрэн эрх чөлөө олгосон нь мөнхүү олон түмэн ардууд улсын засгийн ба орон нутгийн захиргааны эрх баригчдын шийтгэн явуулсан элдэв хэрэг зүйлийн дотор хэрэв улсын засаг ба ард түмний эрх ашигт харшлал хорлол бүхий буюу гүйцэлдээгүй, нийлэлцээгүй зэрэг зүйл үзэгдэх сонсдох ахул даруй шүүмжлэн илтгэж, сонин сэтгүүлд хэвлүүлэн тарааж залруулах ба гүйцэтгүүлэх эрх буйн тул тийнхүү элдэв хэргийг жинхэнэ ард түмнээр шүүмжлэх эрхийг хүндэтгэж, тус улсаас элдэв хэвлэх нийтлэх явдлыг бүртгэн гүйцэлдүүлбээс зохино хэмээн тодорхойлон тогтоосон нь болой”⁶⁹ гэж тайлбарласан байна. Ийнхүү авч үзэхийн учир нь Монгол Улсын Үндсэн хуулиудад (1924, 1940, 1960, 1992 оны) тодорхойлсон үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх зэрэг эрх, эрх чөлөөний үзэл санаа, агуулга болон Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжид хуульчилж байсан гүтгэх гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтын түүхэн уламжлалын харилцан хамаарлын асуудлыг авч үзэх нь онолын төдийгүй практикын хувьд ихээхэн ач холбогдолтой гэж үзэж байна. Тодруулбал, 1926 оны БНМАУ-ын Шүүх цаазын бичгийн Бусдыг элдвээр доромжлох ба нэрийг нь гутаах нь гэсэн Хорин наймдугаар бүлгийн 192, 193, 194, 195 дугаар зүйлүүдэд нэрийг нь гутаах үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцож байв.

1940 оны БНМАУ-ын Үндсэн хуулийн Наян тавдугаар зүйлд “Хөдөлмөрчин ард түмний ашиг тусад иийлүүлэн мөн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын улсын байгуулалтыг бататган бэхжүүлэхийн төлөө, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын ард иргэдэд хуулиар батлан олгох эрх: 1.Чөлөөтэйгээр үг хэлэх. 2.Чөлөөтэйгээр хэвлэн нийтлэх. 3.Хурал ба индрийн хурлыг чөлөөтэйгээр явуулах ... нь тус тус чөлөөтэй болно”⁷⁰ гэж заасан. 1942 оны БНМАУ-ын Эрүүгийн хуулийн Хүний амь бие, эрүүл мэнд ба эрх чөлөө хийгээд нэр алдарт харшлах гэмт хэргүүд гэсэн Долдугаар бүлгийн 172 дугаар зүйлд нэр алдарт харшлах үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцсон байна.

1960 оны БНМАУ-ын Үндсэн хуулийн Наян долдугаар зүйлд “БНМАУ-ын төрийн байгууллыг хөгжүүлэн бэхжүүлэх зорилгоор хөдөлмөрчдийн эрх ашигт нийцүүлэн БНМАУ-ын иргэдэд: 1.Үг хэлэх; 2.Хэвлэн нийтлэх; ... эрх

⁶⁸ Монголын Үндэсний төв архив, Ф.26, Т.1, х.н.56

⁶⁹ Ж.Амарсанаа, О.Батсайхан, Монгол Улсын Үндсэн хууль (Баримт бичиг), ред. Б.Чимид, С.Төмөр, Уб., 2004, 72 – 73 дахь тал.

⁷⁰ Ж.Амарсанаа, Б.Чимид, Б.Баярсайхан, Д.Баянбилэг, Б.Батбаяр, А.Түвшинтулга, Р.Шажинбат, А.Энхбаатар, Г.Энхжавхлан, Х.Эрдэнэтуяа, Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл, Гуравдугаар боть, 1937 он – 1958 Х сар, ред. Б.Баярсайхан, Д.Баянбилэг, Уб., Мөнхийн үсэг, 2010, 65 дахь тал.

чөлөөг хуулиар батлан олгосон болно ...⁷¹ гэж заасан. 1961 оны БНМАУ-ын Эрүүгийн хуулийн Иргэдийн амь бие, эрүүл мэнд, эрх чөлөө ба нэр алдарт харшлах гэмт хэргүүд гэсэн Гуравдугаар бүлгийн 92 дугаар зүйлд гүтгэхийг гэмт хэрэгт тооцсон.⁷² Мөн түүнчлэн 1986 оны БНМАУ-ын Эрүүгийн хуулийн Иргэдийн амь бие, эрүүл мэнд, эрх чөлөө ба нэр алдарт харшлах гэмт хэрэг гэсэн Хоёрдугаар бүлгийн 117 дугаар зүйлд гүтгэхийг гэмт хэрэгт тооцсон байна.⁷³

1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалтад "... үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх ... эрх чөлөөтэй ..." ⁷⁴, мөн зүйлийн 17 дахь заалтад "... мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй ..." гэж тус тус заасан. Энэ зүйлийг хэлэлцэн баталсан тэмдэглэлүүдээс авч үзвэл, "1.БНМАУ-ын Бага Хурлын (БХ) гишүүдийн хувьд (1991.05.17., 1991.10.12., 1991.10.14-ний өдрүүдэд) 16 дахь заалтад 44 удаа, 17 дахь заалтад 33 удаа харин БНМАУ-ын Ардын Их Хурлын (АИХ) депутатуудын хувьд (1991.11.27., 1991.11.28., 1992.01.04-ний өдрүүдэд) 16 дахь заалтад 63 удаа, 17 дахь заалтад 134 удаа тус тус давхардсан тоогоор үг хэлсэн байна; 2.БХ-ын гишүүдийн хувьд "16 дахь заалтад 44 удаа, АИХ-ын депутатуудын хувьд 17 дахь заалтад 134 удаа асуулт асууж, хариулт авч байр сууриа илэрхийлж байсан нь хэлэлцүүлгийн хамгийн өндөр үзүүлэлт юм; 3.Хэлэлцүүлгийн эцэст "16 дахь заалтыг 307 депутат буюу 93 хувь нь зөвшөөрч, 16 хүн татгалзаж, б

⁷¹ Ж.Амарсанаа, Б.Чимид, Б.Баярсайхан, Д.Баянбилэг, Б.Батбаяр, А.Түвшинтулга, Р.Шажинбат, А.Энхбаатар, Г.Энхжавхлан, Х.Эрдэнэтуяа, Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл, Тавдугаар боть, 1958 X сар – 1970 он, ред. Б.Баярсайхан, Д.Баянбилэг, Уб., Мөнхийн үсэг, 2010, 165 – 166 дахь тал.

⁷² Эрүүгийн хуулийн 92 дугаар зүйлийн а дахь хэсэгт "Бусдын нэр алдрыг гутаахаар худал хуурмаг мэдээ зориуд тараавал нэг жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл олон нийтийн арга хэмжээ авахуулна" гэж, б дахь хэсэгт "Худал гүтгэлэг хэвлэлд нийтлэх буюу бусад аргаар тараасан, эсхүл гүтгэлийн хэрэгт урьд шийтгэгдсэн этгээд үйлдвэл хоёр жил хүртэл хугацаагаар хорих буюу буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэнэ" гэж, в дахь хэсэгт "Бусдыг хүнд гэмт хэрэгт холбогдуулж гүтгэвэл дөрвөн жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ" гэж тус тус заасан.

Ж.Амарсанаа, Б.Чимид, Б.Баярсайхан, Д.Баянбилэг, Б.Батбаяр, А.Түвшинтулга, Р.Шажинбат, А.Энхбаатар, Г.Энхжавхлан, Х.Эрдэнэтуяа, Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл, Тавдугаар боть, 1958 X сар – 1970 он, ред. Б.Баярсайхан, Д.Баянбилэг, Уб., Мөнхийн үсэг, 2010, 191 дэх тал.

⁷³ Эрүүгийн хуулийн 117 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Бусдын нэр төр, алдар хүндийг гутаасан илт худал гүжирдлэг тараасан бол нэг жил хүртэл хугацаагаар хорих буюу мөн хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, таван зуу хүртэл төгрөгөөр торгох буюу олон нийтийн өмнө буруушаах ял шийтгэх, эсхүл олон нийтийн нөлөөллийн арга хэмжээ авахуулна" гэж, 2 дахь дахь хэсэгт "Гүтгэлийг хэвлэлд нийтлэх буюу бусад аргаар олшруулан тараасан, эсхүл нэргүй захидлаар ирүүлсэн буюу гүтгэх гэмт хэрэгт урьд ял шийтгүүлсэн этгээд үйлдсэн бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл нэг мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ" гэж, 3 дахь хэсэгт "Хүнд гэмт хэрэгт холбогдуулан ялуулахаар гүтгэсэн бол дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ" гэж тус тус заасан. Ж.Амарсанаа, Б.Чимид, Б.Баярсайхан, Д.Баянбилэг, Б.Батбаяр, А.Түвшинтулга, Р.Шажинбат, А.Энхбаатар, Г.Энхжавхлан, Х.Эрдэнэтуяа, Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл, Долдугаар боть, 1985 V сар – 1992 он, ред. Б.Баярсайхан, Д.Баянбилэг, Уб., Мөнхийн үсэг, 2010, 91 дэх тал.

⁷⁴ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367> [Сүүлд үзсэн огноо:2024.12.23]

хүн түдгэлзсэн⁷⁵ бол 17 дахь заалтыг 270 депутат буюу 84 хувь нь зөвшөөрч, 34 хүн татгалзаж, 16 хүн түдгэлзэж⁷⁶ баталсан" зэрэг нь эдгээр зүйл, заалтад ихээхэн ач холбогдол өгч байсныг нотлон харуулж байна. 2002 оны Эрүүгийн хуулийн Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг гэсэн Арван зургадугаар бүлгийн 111 дүгээр зүйлд гүтгэхийг гэмт хэрэгт тооцож байсан.⁷⁷ Тиймээс эдгээр эрүүгийн хуулиудын дээрхи зохицуулалтын⁷⁸ агуулгын талаар дэлгэрүүлэн авч үзье.

А.Гүтгэх гэмт хэргийг хуульчилсан байдал, түүхэн уламжлал

Монгол Улсын хувьд гүтгэх гэмт хэргийн бүрэлдэхүүнийг дараахь байдлаар нийтлэг зохицуулж (тайлбарлаж) ирсэн түүхэн уламжлалтай байна. Үүнд:

1/ 1926 оны БНМАУ-ын Шүүх цаазын бичгийн Бусдыг элдвээр доромжлох ба нэрийг нь гутаах нь гэсэн Хорин наймдугаар бүлгийн талаар:

БНМАУ-ын Шүүх цаазын бичгийн 193 дугаар зүйлд "Аливаа хүн бусдыг доромжлох хорт /саналаар/ санаагаар худал хуурамч зүйлийг олонд тунхаглан зарлах бичиг зураг оруулан тарааваас 14 өдрөөс 1 жил хүртэл гяндан хорих буюу 25 – 600 төгрөг хүртэл торговол зохино" гэж, 194 дүгээр зүйлд "Бусдын нэр алдрыг гутаах зүйлийг олонд тунхаглан зарласан явдал уулаас үнэн болох буюу, улсыг ба ард түмний хэрэгт тустай болбол ял үл хэлэлцэнэ" гэж, 195 дугаар зүйлд "Бусдын нэр алдрыг худал хуурмагаар цуу үг тарааж гутаасныг ялласан тогтоолыг нөгөө этгээдэдээс хүсэх аваас олонд зарлаж болно" гэж тус тус заасан.⁷⁹

⁷⁵ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийг хэлэлцсэн БНМАУ-ын Бага Хурлын чуулганы болон Ардын Их Хурлын хуралдааны тэмдэглэлүүд, (түүвэр), эмх. С.Номынбаясгалан, Б.Баатарцогт, Э.Тамир, Уб., Адмон принтинг, 2023, 466 дахь тал.

⁷⁶ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийг хэлэлцсэн БНМАУ-ын Бага Хурлын чуулганы болон Ардын Их Хурлын хуралдааны тэмдэглэлүүд, (түүвэр), эмх. С.Номынбаясгалан, Б.Баатарцогт, Э.Тамир, Уб., Адмон принтинг, 2023, 506 дахь тал.

⁷⁷ Эрүүгийн хуулийн 111 дүгээр зүйлийн 111.1 дэх хэсэгт "Хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэг тараасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ" гэж, 111.2 дахь хэсэгт "Гүтгэлийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд тараасан, эсхүл доромжлох, гүтгэх гэмт хэрэгт урьд ял шийтгүүлсэн этгээд үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ" гэж, 111.3 дахь хэсэгт "Хүнд, онц хүнд гэмт хэрэгт холбогдуулан ялуулахаар гүтгэсэнээр хүнд хор уршиг учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёрөөс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ" гэж тус тус заасан. Ж.Амарсанаа, Б.Чимид, Б.Баярсайхан, Д.Баянбилэг, Б.Батбаяр, А.Түвшинтулга, Р.Шажинбат, А.Энхбаатар, Г.Энхжавхлан, Х.Эрдэнэтуяа, Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл, Арван гуравдугаар боть, 2002 он, ред. Б.Баярсайхан, Д.Баянбилэг, Уб., Мөнхийн үсэг, 2010, 32 дахь тал.

⁷⁸ Энэхүү өгүүллийн хавсралтаас "Эрүүгийн хуулиудын холбогдох эрх зүйн зохицуулалтын харьцуулалт"-ыг үзнэ үү.

⁷⁹ Ж.Амарсанаа, Б.Чимид, Б.Баярсайхан, Д.Баянбилэг, Б.Батбаяр, А.Түвшинтулга, Р.Шажинбат, А.Энхбаатар, Г.Энхжавхлан, Х.Эрдэнэтуяа, Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл, Дөрөвдүгээр боть, 1926 VI сар – 1936 он, ред. Б.Баярсайхан, Д.Баянбилэг, Уб., Мөнхийн үсэг, 2010,

2/ 1942 оны БНМАУ-ын Эрүүгийн хуулийн Хүний амь бие, эрүүл мэнд ба эрх чөлөө хийгээд нэр алдарт харшлах гэмт хэргүүд гэсэн Долдугаар бүлгийн талаар:

БНМАУ-ын Эрүүгийн хуулийн 172 дугаар зүйлд “Бусдын нэр алдарыг гутаах, аливаа худал хуурмаг мэдээг зориуд цуурхан тараасан байвал 6 сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх, ажлыг хийлгэх буюу таван зуун төгрөг хүртэл торгож шийтгэнэ. Тийнхүү бусдын нэр алдрыг гутаах буюу ямар нэгэн худал хуурмаг мэдээг бичиг хэвлэлд хэвлүүлэн гаргаж тараасан байвал нэгэн жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажлыг хийлгэх буюу мянган төгрөг хүртэл торгож шийтгэвэл зохино”⁸⁰ гэж заасан байна.

3/ 1961 оны БНМАУ-ын Эрүүгийн хуулийн 92 дугаар зүйл (Гүтгэх)-ийн талаар:

Нэгд, Г.Совдын БНМАУ-ын Эрүүгийн эрх: Тусгай анги хэмээх (1965) бүтээлд “Эрүүгийн хуулийн 92-р зүйлд бусдыг гүтгэх гэмт хэрэгт хариуцлага хүлээлгэх тухай заасан. Гүтгэх гэмт хэрэг бол бусдын нэр алдрыг гутаах зорилгоор түүний тухай үндэсгүй худал мэдээнүүдийг тараах явдал мөн. Иймд гэм буруутны тарааж байгаа мэдээ нь бусдын нэр алдрыг гутаах, үндэсгүй худал байх объектив хоёр үндсэн шинжтэй. Бусдын нэр алдрыг гутаах мэдээ нь эхний гуравдагч этгээдэд мэдэгдсэнээр бүрдэл төгссөн гэмт хэрэг гэж үздэг. ямар нэгэн хүнээс бусдын дутагдалтай асуудлыг тарааж муу хэлэх явдал нь хуурамч мэдээ биш учраас гүтгэсэн гэмт хэргийн бүрэлдүүн байж болохгүй. Гүтгэх гэмт хэргийн субъектив тал нь гэм буруугийн шууд санаатай хэлбэрээр илэрнэ. Өөрөөр хэлбэл гэм буруутан этгээд өөрийн тарааж байгаа бусдын тухай мэдээг хуурамч зүйл гэдгийг мэдсэн байх ёстой. Хэрэв тарааж байгаа мэдээ нь бодит байдлаар үнэний хувьтай байгаад түүний тухай тараагч этгээд буруу ойлголт авснаас үйлдсэн бол гэмт хэргийн бүрэлдүүн гэм буруугийн элемент байх ёсгүй болно. Бусдыг гүтгэх гэмт хэрэг нь эрүүгийн хуулийн 146-р зүйлд заасан худал мэдээлэх гэмт хэргээс гэм буруугийн зорилгоор ялгагдана. Гэм буруутан хохирогч этгээдийг гэмт хэрэгт ял шийтгүүлэх гэсэн зорилго байдаггүй. Гүтгэлгийг хэвлэл буюу бусад аргаар олон хувь болгон тараасан эсхүл гүтгэлгийн хэрэгт урьд шүүхээр ял шийтгүүлж байсан этгээдээс үйлдсэн бол объектив тал ба субъектээр хүндрүүлэн үзэх шалтгаан гэж 92-р зүйлийн <<В>> хэсгээр хариуцлага хүлээлгэнэ”⁸¹ гэж бичсэн байна.

Хоёрт, Ж.Авхиа нарын БНМАУ-ын Эрүүгийн эрх хэмээх (1979) бүтээлд “Гүтгэх гэдэг нь бусдын нэр алдрыг гутаахаар зориуд худал хуурмаг мэдээ

42 дахь тал.

⁸⁰ Ж.Амарсанаа, Б.Чимид, Б.Баярсайхан, Д.Баянбилэг, Б.Батбаяр, А.Түвшинтулга, Р.Шажинбат, А.Энхбаатар, Г.Энхжавхлан, Х.Эрдэнэтуяа, Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл, Гуравдугаар боть, 1937 он – 1958 X сар, ред. Б.Баярсайхан, Д.Баянбилэг, Уб., Мөнхийн үсэг, 2010, 191 дэх тал.

⁸¹ Г.Совд, БНМАУ-ын Эрүүгийн эрх: Тусгай анги, Уб., Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо, 1965, 126 – 127 дахь тал.

тараахыг хэлнэ. Эл хэргийн объект нь орчин тойрны хүмүүсээс бие хүнийг үнэлэх үзлийн үүднээс ойлговол зохих бусдын нэр алдар юм. Гүтгэх гэмт хэргийн хохирогч нь хэн ч байж болно. Объектив талын шинж нь бусдыг гутаан бузарласан худал зохиомол мэдээ сэлт тараах идэвхтэй үйл ажиллагаа байдаг. Тараах гэж худал хуурмаг мэдээ сэлтийг ямар нэг аргаар ганц хүнд боловч хэргэхийг хэлнэ. Мэдээ сэлтийг хиймлээр зохиох гэдэг нь амьдралд үнэн хэрэгтэй байхгүй зүйлийн талаар худал хуурмаг зүйлийг зохиох байдлаар илрэнэ. Бусдыг гутаан бузарласан, өөрөөр хэлбэл орчин тойрны нь хүмүүсийн дунд уг хүний нэр хүндийг унагах, хохирогчийг ёс суртахуунд харш зүйл хийсэн юм шиг итгэлийг бусдад төрүүлсэн мэдээ сэлт тараах нь гүтгэлийн гэмт хэргийн нэг онцлог шинж юм. Хэдийгээр нэр алдрыг гутаасан чанартай боловч үнэн бодит мэдээ сэлтийг тараах нь гүтгэлгийн гэмт хэрэг болохгүй. Бусдын нэр алдрыг гутаасан мэдээ сэлт ямар нэг хэлбэрээр тархсан гүтгэлгийг төгссөн гэмт хэрэг гэж үзнэ. Хуурамч мэдээ сэлт тархсаны улмаас ямар нэг хор хохирол учирсан эсэх нь гүтгэлгийн гэмт хэргийн бүрэлдэхүүнд ач холбогдолгүй юм. Энэ гэмт хэргийн субъектив тал нь шууд санаатай хэлбэртэй байдаг. Гэм буруутай этгээд бусдын нэр алдрыг гутаасан худал хуурамч мэдээ сэлт тарааж байгаагаар ухамсарлаж, түүнийгээ хүсэж үйлддэг байна. Сэдэлт (өш хонзон, хардлага, атаа жетөө, дүрсгүйтэх гэх мэт) нь ял шийтгэл оногдуулахад ач холбогдолтой байдаг болно. Субъект нь 16 насанд хүрсэн этгээд байна. ...”⁸² гэж бичсэн байна.

Мөн түүнчлэн гуравт, БНМАУ-ын Эрүүгийн хуулийн тайлбар хэмээх (1982) бүтээлд “1.Энэ гэмт хэргийн гол шинж нь: а) бусдын нэр алдрыг гутаахаар үндэсгүй мэдээ тараасан; б) уг мэдээнүүд нь худал хуурмаг шинж чанартай; в) нэр алдрыг гутаахад чиглэгдсэн байна. 2.Тараасан гэдэгт хохирогчийн тухай худал хуурамч баримтыг нэг буюу хэд хэдэн хүнд мэдээлэхийг хэлнэ. Харин уг худал баримтуудыг бусдад тараалгүй хохирогч этгээдэд өөрт нь хэлсэн бол гүтгэлэг биш, доромжлол гэж үзнэ. 3.Хэрэв хүний нэр алдарт хортой ч гэсэн үнэн бодит мэдээлэл байсан бол (жинхэнэ гэмт хэрэг үйлдсэн тухай мэдээлэх) гэмт хэрэг гэж үзэхгүй. 4.Гүтгэх гэмт хэргийн субъектив тал нь шууд санаатай байдаг. 5.Гүтгэлгийг үйлдэхдээ: а) хэвлэлд нийтлэх буюу нийтэд мэдээлэх бусад аргыг хэрэглэж тараасан; б) гүтгэлгийн хэрэгт урьд шийтгүүлсэн хүн дахин үйлдсэн бол энэ хэргийн хүндрүүлэх шалтгаантай бүрэлдэхүүн болдог. б.Бусдыг хүнд гэмт хэрэгт холбогдуулсан бол гүтгэлгийн онц хүндрүүлэн үзэх бүрэлдэхүүн болно”⁸³ гэж тэмдэглэсэн байна. Үүнээс гадна Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын хэрэгжилтийн талаарх БНМАУ-ын ээлжит (1985) хоёр дахь илтгэлд “гүтгэх (92 дугаар зүйл) зэрэг эрх зүйн зөрчилд хамаарах эрүүгийн хууль тогтоомж, иргэний хуулийн

⁸² Ж.Авхиа, Ж.Балжинням, Р.Гүнсэн, Н.Дашжамц, Г.В.Дашков, М.Дунчинсүрэн, Ц.Жалцав, Г.Совд, БНМАУ-ын Эрүүгийн эрх: Тусгай анги, ред. Ж.Авхиа, Уб., БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн Улсын дээд, тусгай дунд, техник – мэргэжлийн боловсролын хорооны хэвлэл, 1979, 176 – 177 дахь тал.

⁸³ Хамтын бүтээл, БНМАУ-ын Эрүүгийн хуулийн тайлбар, ред. Г.Совд, Уб., Улсын хэвлэлийн газар, 1982, 186 – 187 дахь тал

холбогдох заалтууд нь эрх зүйн тууштай хамгаалалтын баталгаа болдог гэдгийг БНМАУ-ын туршлага харуулж байна⁸⁴ гэж дурдсан. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын хэрэгжилтийн талаарх БНМАУ-ын ээлжит хоёр дахь илтгэлийг авч хэлэлцсэн тухай Хүний эрхийн хорооны хуралдааны тэмдэглэл, гаргасан (1986) зөвлөмжид “БНМАУ-ын төрийн ба эрх зүйн систем мэдээллийн эрх чөлөөг урвуулан ашиглахаас хамгаалдаг. БНМАУ-ын Эрүүгийн хуулийн 92 дугаар зүйлээр гүтгэх буюу бусдын нэр хүндийг гутаасан илтэд худал мэдээлэл тараахад хүлээлгэх хариуцлагыг тодорхойлдог⁸⁵ гээд “гүтгэх нь монголд ял шийтгэл хүлээлгэдэг зөрчил юм⁸⁶ гэж бичсэн байна.

4/ 1986 оны БНМАУ-ын Эрүүгийн хуулийн 117 дугаар зүйл (Гүтгэх)-ийн талаар:

Нэгд, Н.Жанцан нарын БНМАУ-ын Эрүүгийн хуулийн дэлгэрэнгүй тайлбар хэмээх (1989) бүтээлд “1.Гүтгэх гэж бусдын нэр алдрыг гутаахаар зориуд худал, хуурамч мэдээ тараахыг хэлнэ. Объектив талын шинж нь бусдын нэр хүндийг гутаасан худал, зохиомол мэдээ сэлт тараах идэвхтэй үйл ажиллагаагаар илэрнэ. Тараах гэдэг нь худал хуурмаг мэдээ, сэлтийг ямар нэг аргаар нэг буюу хэд хэдэн хүнд мэдээлэхийг хэлнэ. Мэдээ сэлтийг хиймлээр зохиох гэдэг нь амьдралд үнэн хэрэгтэй байхгүй зүйлийн талаар худал хуурмаг зүйлийг зохиох явдал юм. 2.Бусдын нэр хүндийг гутааж бузарласан, өөрөөр хэлбэл орчин тойрны хүмүүсийн дунд уг хүний нэр хүндийг унагах хохирогчийг ёс суртахуунд харш юм хийсэн юм шиг итгэлийг бусад хүмүүст төрүүлсэн мэдээ сэлт тараах нь гүтгэх гэмт хэргийн нэг ноцтой шинж мөн. Хэдийгээр нэр алдрыг гутаасан шинжтэй боловч үнэн бодит мэдээ сэлтийг тараах нь гүтгэлгийн гэмт хэрэг болохгүй. Бусдын нэр хүндийг гутаасан мэдээ сэлтийг ямар нэг хэлбэрээр тараасан бол түүнийг гүтгэлгийн төгссөн гэмт хэрэгт тооцно. 3.Энэ гэмт хэргийн субъектив тал нь шууд санаатай хэлбэрээр илэрнэ. Гэм буруутай этгээд бусдын нэр алдрыг гутаасан худал хуурамч мэдээ сэлт тарааж байгаагаа ухамсарлаж, түүнийг хүсэж үйлддэг байна. Сэдэлт нь өш хонзон, хардлага, атаа жетөөгийн аль нэг байх бөгөөд ял оногдуулахад ач холбогдолтой юм. ...”⁸⁷ гэж бичсэн байна.

⁸⁴ ХЭҮК, Хүний эрхийн олон улсын гэрээ ба Монгол Улс, Хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит илтгэлүүд, НҮБ-ын гэрээний хороод, хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлгээс Монгол Улсад өгсөн зөвлөмжийн эмхэтгэл, (1971 – 2020), Нэгдүгээр боть, эмх. Г.Агар – Эрдэнэ, Ч.Ариунаа, Э.Туул, Уб., Бэмби сан, 2021, 32 – 33 дахь тал.

⁸⁵ ХЭҮК, Хүний эрхийн олон улсын гэрээ ба Монгол Улс, Хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит илтгэлүүд, НҮБ-ын гэрээний хороод, хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлгээс Монгол Улсад өгсөн зөвлөмжийн эмхэтгэл, (1971 – 2020), Нэгдүгээр боть, эмх. Г.Агар – Эрдэнэ, Ч.Ариунаа, Э.Туул, Уб., Бэмби сан, 2021, 50 дахь тал.

⁸⁶ ХЭҮК, Хүний эрхийн олон улсын гэрээ ба Монгол Улс, Хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит илтгэлүүд, НҮБ-ын гэрээний хороод, хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлгээс Монгол Улсад өгсөн зөвлөмжийн эмхэтгэл, (1971 – 2020), Нэгдүгээр боть, эмх. Г.Агар – Эрдэнэ, Ч.Ариунаа, Э.Туул, Уб., Бэмби сан, 2021, 66 дахь тал.

⁸⁷ Н.Жанцан, Б.Дангаасүрэн, Г.Совд, Н.Туяа, Ж.Авхиа, Л.Рэнчин, Ц.Нямдорж, Б.Янжмаа, Д.Алтангэрэл, Ц.Жалцав, К.Тажебакед, Б.Дангаасүрэн, Н.Баатаржав, М.Рандаабазар, Б.Хатанбаатар,

Мөн түүнчлэн хоёрт, С.Нарангэрэлийн Монгол Улсын эрүүгийн эрх зүй: Тусгай анги хэмээх (1998) бүтээлд “Энэ гэмт хэрэг нь бусдын нэр төр, алдар хүндийг гутаасан илт худал гүжирдлэг тарааснаар тодорхойлогдоно. Эл гэмт хэргийн хохирогч нь аливаа хүн тэр ч атугай бага насны, хэрэг хариуцах чадваргүй түүнчлэн таалал төгссөн хүмүүс ч байж болно. объектив тал нь илт худал гүжирдлэг тараасан идэвхтэй үйлдлээр илэрнэ. Илт худал гүжирдлэг гэж бодит байдалд огт нийцээгүй мэдээ сэлт байна. Энэхүү илт худал гүжирдлэг нь хохирогчийг гутаасан шинжийг агуулна. Гутаасан гэж хүний нэр төр, алдар хүндийг басамжилсан мэдээ сэлтийг хамааруулна. Эдгээр мэдээ сэлт нь үйл баримтад үндэслэсэн байх бөгөөд эрэгцүүлсэн бодлын байдлаар илрэх ёсгүй. Тараасан гэж эдгээр мэдээ сэлтийг нэг ч гэсэн хүнд мэдээлсэнийг ойлгоно. Худал боловч гутаагаагүй мэдээ сэлт тараасныг гүтгэх гэмт хэргээр зүйлчилж болохгүй. Энэхүү гэмт хэргийг бусдын нэр төр, алдар хүндийг гутаасан илт худал гүжирдлэгийг аливаа хэлбэрээр тараасан үеэс төгссөнд тооцно. Субъектив тал нь гэм буруугийн шууд санаатай байна. Гэм буруутай этгээд бусдын нэр төр, алдар хүндийг гутаасан илт худал гүжирдлэг тарааснаа ухамсарлаж үүнийг хүсэж үйлддэг. Хэрэв тухайн этгээд тараасан мэдээ сэлтээ бодит байдалд нийцсэн үнэн гэж итгэлтэй байсан боловч хэрэг дээр худал байвал Эрүүгийн хуулийн 117 дугаар зүйлээр эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй. Гүтгэх гэмт хэрэг нь өш хонзон, үзэн ядалт, хардалт зэрэг сэдэлтээр гол төлөв үйлдэгдэнэ. Субъект нь 16 насанд хүрсэн этгээд байна. . .”⁸⁸ гэж бичсэн байна.

Тэгвэл Монгол Улсын хуучин ба шинэ эрүүгийн хуулиудын харьцуулсан судалгаа хэмээх (2002) бүтээлд “Хуучин хууль (1986.12.05)–д “117 дугаар зүйл (Гүтгэх)–ийн 1.Бусдын нэр төр, алдар хүндийг гутаасан илт худал гүжирдлэг тараасан бол нэг жил хүртэл хугацаагаар хорих буюу мөн хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, арван мянгаас тавин мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ /1993 оны 2 дугаар сарын 15–ны өдрийн хуулиар өөрчилж, 1993 оны 6 дугаар сарын 7–ны өдрийн хуулиар зарим ялыг хассан/. 2.Гүтгэлгийг хэвлэлд нийтлэх буюу бусад аргаар олшруулан тараасан, эсхүл нэргүй захидлаар ирүүлсэн буюу гүтгэх гэмт урьд ял шийтгүүлсэн этгээд үйлдсэн бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл хорин таван мянгаас нэг зуун мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ /1993 оны 2 дугаар сарын 15–ны өдрийн хуулиар өөрчилсөн/. 3.Хүнд гэмт хэрэгт холбогдуулан яллуулахаар гүтгэсэн бол дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж байсан бол шинэ хууль (2002.01.10)–д “111 дүгээр зүйл (Гүтгэх)–ийн 111.1.Хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэг тараасан бол хөдөлмөрийн

Ц.Бүжинлхам, Б.Пүрэвдорж, Б.Даваасамбуу, Ч.Ганбат, БНМАУ-ын Эрүүгийн хуулийн дэлгэрэнгүй тайлбар, ред. Ж.Авхиа, Л.Рэнчин, Уб., Улсын хэвлэлийн газар, 1989, 147 дахь тал.

⁸⁸ С.Нарангэрэл, Монгол Улсын эрүүгийн эрх зүй: Тусгай анги, Уб., 1998, 106 – 107 дахь тал.

хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ. 111.2. Гүтгэлгийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд тараасан, эсхүл доромжлох, гүтгэх гэмт хэрэгт урьд ял шийтгүүлсэн этгээд үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ. 111.3. Хүнд, онц хүнд гэмт хэрэгт холбогдуулан яллуулахаар гүтгэснээс хүнд хор уршиг учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заасан гээд засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял хасагдсан; торгох болон хорих ялын хэмжээг өөрчлөгдсөн; баривчлах ял нэмэгдсэн”⁸⁹ гэж тус тус тэмдэглэсэн байна. Мөн түүнчлэн Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик хэмээх (2021) судалгаанд “Монгол Улсын хувьд 1986 оны болон 2002 оны эрүүгийн хуулиудад гүтгэх гэмт хэргийн объектив талыг “илт худал гүжирдлэг тараах” гэж субъектив талыг “бусдын нэр төрийг гутаах зорилгоор” гэж тодорхойлж байжээ”⁹⁰ гэж дурджээ.

5/ 2002 оны Эрүүгийн хуулийн 111 дүгээр зүйл (Гүтгэх)-ийн талаар:

Энэ зүйлийг Монгол Улсын дээд шүүхээс 2007 оны 10 дугаар сарын 29-ний өдөр “Эрүүгийн хуулийн 110, 111 дүгээр зүйлүүдийн зарим заалтыг тайлбарлах тухай” 40 дүгээр тогтоолоор тайлбарлаж байсан.⁹¹ Тодруулбал, Тус тогтоолын 2.3 дахь хэсэгт “Мөн зүйл, хэсэгт заасан “... худал гүжирдлэг...” гэдэгт илт худал мэдээлэл, баримт сэлтийг ойлгоно” гэж тайлбарласан байна. Уг тогтоолын хүчинтэй эсэх талаар тодруулсан хүсэлтэд Монгол Улсын дээд шүүхээс “Эрүүгийн эрх зүй дэх материаллаг хэм хэмжээ нь гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ял, хариуцлагыг хөнгөрүүлсэн, ашигтай байдлыг бий болгосон тохиолдолд буцаан хэрэглэгддэг тул эрүүгийн хуулий хүчингүй болгодоггүй. Иймд Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Эрүүгийн хуулийг баталснаар 2002 оны Эрүүгийн хууль хүчингүй болоогүй тул Монгол Улсын дээд шүүхийн 2007 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн “Эрүүгийн хуулийн 110, 111 дүгээр зүйлүүдийн зарим заалтыг тайлбарлах тухай” 40 дүгээр тогтоол мөн адил хүчинтэй байна”⁹² гэсэн хариу хүргүүлсэн. Энэ талаар Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик хэмээх (2021) судалгаанд “Монгол Улсын эрүүгийн эрх зүйд илт худал гүжирдлэг гэдэг ойлголт нь илт худал мэдээлэл

⁸⁹ Монгол Улсын хуучин ба шинэ эрүүгийн хуулиудын харьцуулсан судалгаа, Уб., 2002, 74 дэх тал.
⁹⁰ Д.Оросоо, Ц.Цэлмэг, С.Дэнсмаа, Г.Туул, Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик, (Илт худал мэдээлэл гэх ойлголтын эрүүгийн эрх зүйн асуудал), Уб., 2021, 63 дахь тал.
⁹¹ <https://legalinfo.mn/mn/claw/16468122061081/1648029881543240> [Сүүлд үзсэн огноо:2024.12.23]
⁹² Монгол Улсын дээд шүүхийн 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн “Хүсэлтэд хариу өгөх тухай” 02/4785 тоот албан бичигт

гэсэн агуулгыг давхар агуулж байна”⁹³ гэсэн дүгнэсэн байна.

Тэгвэл Г.Совд Монгол Улсын эрүүгийн хуулийн тайлбар хэмээх (2002) бүтээлд “1.Хүний нэр төр бол Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь хэсэгт заасан халдашгүй эрхийн нэг тул энэ хэргийн бүрэлдэхүүний объект нь хүний нэр төр, алдар хүндийн халдашгүй эрх юм. 2.Энэ гэмт хэргийн объектив тал нь хохирогчийн нэр төр, алдар хүндийг гутаасан худал мэдээ (гүтгэлэг) тараасан үйлдэл болдог бөгөөд тэр нь амаар, бичгээр, элдэв дүрс бичлэг, хуурцгаар болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр зэрэг хэлбэрүүдтэй байдаг. Гүтгэлгийг заавал олон хүнд тараасан байхыг шаардахгүй анхны хүнд мэдээлснээр бүрдэл төгсдөг. 3.Тарааж байгаа мэдээ нь нэгдүгээрт, хүний нэр төр, алдар хүндийг гутаах агуулгатай; хоёрдугаарт, илт худал зүйл байвал гүтгэлэг гэж үзнэ. 4.Уг хүний нийгэмд үнэлэгдэх зүй ёсны бодит үнэлгээг доройтуулан гажуудуулсан ойлголтыг олон нийтэд тараахад чиглэгдсэн мэдээллийг хүний нэр төр, алдар хүндийг гутаах агуулгатай гэж үзнэ. Иймд тарааж байгаа мэдээ худал боловч уг хүний нийгэмд үнэлэгдэх чанарыг доройтуулах шинжгүйгээр барахгүй магтаал чанартай болсон бол гүтгэлэг гэж үзэхгүй. 5.Гүтгэлэг илтэд худал байх шинж бол тарааж байгаа мэдээ нь уг хүний зан төлөв, үйл ажиллагааны үнэн бодит байдалд нийцэхгүй байхыг ойлгох ёстой. Тараасан мэдээ нь хүний нэр төр, алдар хүндийг гутаахаар мэдээ боловч бодит байдлаар тухайн хүний зан төлөв, үйл ажиллагаанд илэрсэн зүйл байсан бол гүтгэлэг гэж үзэж эрүүгийн хариуцлага хүлээлгэж болохгүй. 6.Энэ гэмт хэргийн бүрэлдэхүүний субъект нь 16 насанд хүрсэн хэрэг хариуцах чадвартай Монгол Улсын иргэн, гадаадын харьяат, аль ч улсын иргэн биш этгээд хэн ч байж болно. 7.Энэ гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив тал нь бусдын нэр төр, алдар хүндийг гутаах гэсэн шууд санаатай байдаг бөгөөд сэдэлт нь их төлөв өш хонзон санах, үзэн ядах, атаархан тэмцэлдэх явдлууд байдаг. Харин бусдын нэр төр, алдар хүндийг гутаах агуулгатай. Гүтгэлгийн бодит байдалд андуу ташаа дүгнэлт хийснээс болж тараасан бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх учиртай. . . .”⁹⁴ гэж бичсэн байна.

Мөн түүнчлэн Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар хэмээх (2013) бүтээлд “1.Энэ хэргийн шууд объект нь хүний нэр төр, алдар хүнд байна. 2.Энэ гэмт хэргийн объектив тал нь хохирогчийн нэр төр, алдар хүндийг гутаасан, муучилсан, худал мэдээлэл тараасан үйлдэл байна. Уг үйлдэл нь амаар, бичгээр, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон элдэв дуу, дүрс бичлэгийн зэрэг хэлбэрээр илэрч болно. Гүтгэлгийг хэнд тараасан, тухайлбал, ойр дотны хүмүүс, танилууд, хөндлөнгийн этгээдэд мэдээлсэн зэргийн алин болох нь хэргийн бүрдэлд онцын нөлөөлөхгүй бөгөөд бусдад тарааснаар төгссөн гэмт хэрэг болно. 3.Гүтгэх гэдэг нь бодит байдалд нийцээгүй, илт худал мэдээлэл,

⁹³ Д.Оросоо, Ц.Цэлмэг, С.Дэнсмаа, Г.Туул, Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик, (Илт худал мэдээлэл гэх ойлголтын эрүүгийн эрх зүйн асуудал), Уб., 2021, 27 дахь тал.
⁹⁴ Г.Совд, Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, Уб., 2002, 175 – 176 дахь тал.

гүжирдлэгийг бусдын нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор тараасан үйлдэл юм. Гутаах гэдэг нь уг хүний нийгэмд үнэлэгдэх зүй ёсны бодит үнэлгээг муутган, гажуудуулсан ойлголтыг тараахад чиглэгдсэн үйлдэл байна. Ингэхдээ субъект уг мэдээллийг өөрөө зохиосон, эсхүл бусдаас санаа авсны алин болох нь энэ хэргийн бүрдэлд нөлөөгүй бөгөөд гагцхүү уг мэдээлэл илт худал гэдгийг ухамсарлаж мэдсээр байж тараасан байдаг онцлогтой. 4.Тарааж байгаа мэдээ нь худал боловч уг хүний нийгэмд үнэлэгдэх чанарыг дордуулаагүй, харин ч хоосон магтаалын шинжтэй болсон бол гүтгэлэг гэж үзэхгүй. Учир нь энэ тохиолдолд тухайн үйлдэл нь хүний нэр төр, алдар хүндийг гутаасан шинж байхгүй. Тухайн тараасан мэдээ нь хүний нэр төр, алдар хүндийг гутаахаар боловч бодит байдлаар тухайн хүний зан төлөв, үйл ажиллагаанд илэрсэн зүйл байсан бол гүтгэлэг гэж үзэж эрүүгийн хариуцлага хүлээлгэж болохгүй. 5.Гүтгэх гэмт хэргийн субъект нь 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй этгээд хэн ч байж болно. 6.Энэ гэмт хэргийн субъектив тал нь бусдын нэр төр, алдар хүндийг гутаах гэсэн гэм буруугийн шууд санаатай хэлбэртэй байдаг. Сэдэлт нь өс хонзон санах, үзэн ядах, өрсөлдөөн, сөргөлдөөн, атаархал гэх мэт янз бүрийн байж болно. Гэхдээ бусдын нэр төр, алдар хүндийг гутаах зорилготой байдаг. ...”⁹⁵ гэж тэмдэглэсэн байна.

Өмнө дурдсан дээрх бүтээлүүдэд хэдэн оны (1961, 1986, 2002 оны) эрүүгийн хуулиуд үйлчилж байсан бэ гэдгээс үл хамааран нийтлэг байдлаар гүтгэх гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив болон субъектив шинж (санаатайгаар зориуд гэх зэргээр) нэгэн ижил агуулгаар тодорхойлогдож байв. Ингэхдээ гүтгэх гэмт хэргийн объектив шинжид бодит байдалд нийцээгүй, худал мэдээлэл тараах // худал хуурмаг мэдээ тараах, эсхүл худал хуурамч мэдээ сэлт тараах буюу худал зохиомол мэдээ сэлт тараах, эсвэл илт худал гүжирлэг тараах гэх зэрэг ойлголт бүхий үйлдлийг багтааж ирсэн төдийгүй энэ нь гүтгэх гэмт хэргийн агуулгыг тодорхойлж байв. Хэдий тийм боловч 2020 оны эрүүгийн хуулиар субъектив шинж (гутаах санаа зорилго) бүрхэг болж, хүний нэр төр, алдар хүндэд халдсан илт худал мэдээллийг тараасан бол худал мэдээлэл тараах гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан байна.⁹⁶

Б.Гүтгэхийг зөрчилд тооцох болсон нь

Гүтгэхийг зөрчилд тооцох эсэх талаар Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик хэмээх (2021) судалгаанд “Төрийн албан тушаалтан, иргэд эсхүл иргэд хоорондын асуудлыг эрүүгийн хуульд байлгах боломжгүй гээд хассан. Гэтэл тухайн үед УИХ-ын гишүүдийн санал хуваагдсан тул завсрын зохицуулалт болгоод Зөрчлийн тухай хуульд оруулсан байна. Энэ нь Зөрчлийн тухай хуулийн үндсэн үзэл баримтлал болох төр, иргэний

⁹⁵ Монгол Улсын дээд шүүх., Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, (Хоёр дахь хэвлэл), ред. Ж.Бямбаа, Уб., 2013, 304–305 дахь тал.

⁹⁶ Д.Оросоо, Ц.Цэлмэг, С.Дэнсмаа, Г.Туул, Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик, (Илт худал мэдээлэл гэх ойлголтын эрүүгийн эрх зүйн асуудал), Уб., 2021, 28 дахь тал.

хоорондын маргааныг зохицуулдаг харилцаа байтал үүнтэй зөрчилдүүлж хоёр иргэний хоорондын маргааныг оруулж ирсэн. Шилжилтийн үеийн зохицуулалт болгоод ядаж хүн гүтгэсэн гээд ял шийтгэл авахгүй, цагдан хоригдохгүй, гүйцэтгэх ажил хийгдэхгүй гэж үзсэн”⁹⁷ тухай дурдагджээ.

Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 4–ний өдөр баталсан Зөрчлийн тухай хуулийн 7.3 дугаар зүйл (Гүтгэх)—ийн 1 дэх хэсэгт “Хүний нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”⁹⁸ гэж заасан хэдий ч Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 5 дугаар сарын 11–ний өдөр баталсан Зөрчлийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулиар хүчингүй болгосон байна.⁹⁹ Мөн түүнчлэн Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 5 дугаар сарын 11–ний өдөр баталсан Зөрчлийн тухай хуулийн 6.21 дүгээр зүйл (Гүтгэх)—ийн 1 дэх хэсэгт “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”¹⁰⁰ гэж заасан бөгөөд Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 1 дүгээр сарын 10–ны өдөр баталсан Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар Зөрчлийн тухай хуулийн 6.21 дүгээр зүйл (Гүтгэх)—ийг хүчингүй болгосон байна.¹⁰¹ Өөрөөр хэлбэл, санкцийн хувьд хүн, эсвэл хуулийн этгээд гэдгээс үл хамааран торгуулийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.¹⁰² Ийнхүү 2017 оны 7 дугаар сарын 1–ний өдрөөс эхлэн 2020 оны 1 дүгээр сарын 10–ны өдрийг хүртэлхи хугацаанд Зөрчлийн тухай хуулиар гүтгэх зөрчилд шийтгэл оногдуулж байсан. Зөрчлийн тухай хуулиар гүтгэхийг нийтийн ёс суртахууны эсрэг зөрчилд тооцож байв.¹⁰³ Тодруулбал, Зөрчлийн тухай хуулийн 6.21 дүгээр зүйлд заасан зөрчил нь Захиргааны хэргийн шүүхийн харьяалалд хамаарахгүй, эрүүгийн хэргийн шүүхийн харьяалал байсан болно.¹⁰⁴

⁹⁷ Д.Оросоо, Ц.Цэлмэг, С.Дэнсмаа, Г.Туул, Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик, (Илт худал мэдээлэл гэх ойлголтын эрүүгийн эрх зүйн асуудал), Уб., 2021, 44 дэх тал.

⁹⁸ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11645> [Сүүлд үзсэн огноо:2024.12.23]

⁹⁹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12706> [Сүүлд үзсэн огноо:2024.12.23]

¹⁰⁰ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12695> [Сүүлд үзсэн огноо:2024.12.23]

¹⁰¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=103687&showType=1> [Сүүлд үзсэн огноо:2024.12.23]

¹⁰² Энэхүү өгүүллийн хавсралтаас “Зөрчлийн тухай хуулиудын холбогдох эрх зүйн харьцуулалт”–ыг үзнэ үү.

¹⁰³ Б.Цэдэндамбаа, Ц.Болор–Эрдэнэ, Зөрчлийн эрх зүй: Тусгай анги, Уб., Соёмбопринтинг, 2019, 39 дэх тал.

¹⁰⁴ Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 5–ны өдрийн “Хариу хүргүүлэх тухай” 02/872 тоот албан бичигт “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.8–д . . . цагдаагийн байгууллагын эрх бүхий албан хаагч Зөрчлийн тухай хуулийн . . . 6.21 дүгээр зүйлд . . . заасан зөрчлийг харьяалан шалган шийдвэрлэнэ гэж зохицуулж байсан” гэж дурджээ.

Энэ талаар Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик хэмээх (2021) судалгаанд “Зөрчлийн тухай хуулийн “гүтгэх” заалт хүчин төгөлдөр үйлчилж байхад иргэдийн зүгээс иргэний хэргийн шинжтэй нэр төр, алдар хүндтэй холбоотой иргэний маргааныг зориуд Зөрчлийн тухай хуулиар шийдвэрлүүлэх хандлага бий болжээ. Нэгэнт иргэний хэргийн шинжтэй тул Зөрчлийн хэрэг шалгах ажиллагааны явцад, мөн шүүхийн шатанд тухайн зөрчлийн хэрэг нь иргэний хэргийн шинжтэй маргаан бүхий нөхцөл байдал болох нь тогтоогдож, улмаар зөрчлийн хэргийн шинжгүй тул тухайн зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгож байв. Монгол Улсад Зөрчлийн тухай хуулиар гүтгэх зөрчлийг шийдвэрлэх болсон цагаас хойш 2017 онд 28, 2018 онд 486, 2019 онд 355 энэ төрлийн зөрчил бүртгэгдсэн байна. Гүтгэх зөрчлийг Зөрчлийн тухай хуульд оруулсан нь нэр төр, алдар хүндтэй холбоотой иргэний маргааныг давхардуулан Зөрчлийн тухай хуулиар шийдвэрлэх нөхцөл, шалтгааныг бий болгосон бөгөөд Зөрчлийн тухай хуулийн 21.6 дугаар зүйлд заасан гүтгэх зөрчил болон Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн зохицуулалт зарчмын онцлог ялгаа нь тодорхой бус, эрх зүйн давхардал үүсгэн, эрх зүйн хийдэл бий болгожээ. Үүнээс шалтгаалан Зөрчлийн тухай хуулийн “гүтгэх” заалтыг хүчингүй болгох шаардлага үүссэн”¹⁰⁵ гэж хэрэгцээ шаардлагын талаар бичжээ.

В.Гэм хорын асуудал

Монгол Улсын Их Хурлаас 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Иргэний хуулийн¹⁰⁶ 21 дүгээр зүйл (Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах)–д “21.1.Иргэний нэрийг хууль бусаар ашиглахыг хориглоно. 21.2.Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол эрх нь зөрчигдсөн этгээдийн шаардлагаар уг мэдээг тараасан хэлбэр, хэрэгсэл, эсхүл өөр хэлбэр, хэрэгслээр няцаах үүрэг хүлээнэ. 21.3.Бодит баримтыг бүрэн гүйцэд мэдээлээгүйгээс бусдын нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан бол энэ хуулийн 21.2–т заасан журмаар няцаах үүрэг хүлээнэ. 21.4.Хуулиар тогтоосон хувийн нууцад хамааралтай мэдээг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр тарааснаас гэм хор учирсан гэж үзвэл иргэн уг гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй. 21.5.Иргэний дүрсийг гэрэл зураг, кино, дүрс бичлэгийн хальс, хөрөг зураг болон бусад хэлбэрээр өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр нийтэлсэн, олон нийтэд үзүүлснээс гэм хор учирсан гэж үзвэл тухайн этгээд гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй. 21.6.Иргэний нийгэмд эзлэх байр суурьтай холбогдуулан түүнийг сурталчлах зорилгоор болон сургалт, эрдэм шинжилгээний ажил, ажил хэргийн хүрээнд олон нийтийг хамарсан үйл ажиллагааны явцад уг этгээдийг дүрсэлсэн, эсхүл тухайн этгээд өөрийгөө дүрслүүлсний төлөө хөлс, шан харамж авсан

¹⁰⁵ Д.Оросоо, Ц.Цэлмэг, С.Дэнсмаа, Г.Туул, Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик, (Илт худал мэдээлэл гэх ойлголтын эрүүгийн эрх зүйн асуудал), Уб., 2021, 48 дахь тал.

¹⁰⁶ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=299> [Сүүлд үзсэн огноо:2024.12.23]

бол түүний зөвшөөрөл шаардагдахгүй. 21.7.Нас барсан этгээдийн нэр, нэр төр, алдар хүндийг гутаасан, эсхүл түүний хувийн нууцтай холбоотой мэдээг энэ хуулийн 520 дугаар зүйлд заасан өвлөгчийн зөвшөөрөлгүйгээр олон нийтэд тараасан бол энэ зүйлд заасан журам нэгэн адил үйлчилнэ. 21.8.Энэ зүйлийн 21.7–д заасан тохиолдолд учирсан гэм хорыг эдийн хэлбэрээр нөхөн төлүүлэхийг шаардах эрхгүй. 21.9.Энэ зүйлд заасан эрхийг зөрчсөн этгээд бусдад учруулсан гэм хорыг хохирогч буюу сонирхогч этгээдэд энэ хуулийн 497¹⁰⁷, 511¹⁰⁸ дүгээр зүйлд заасан журмын дагуу арилгана” гэж заасан.

Энэ зүйлийг дараахь байдлаар нийтлэг тайлбарлаж ирсэн байна. Тодруулбал, Монгол Улсын иргэний хуулийн тайлбар: Ерөнхий анги хэмээх (2006) бүтээл¹⁰⁹ болон Монгол Улсын иргэний хуулийн тайлбар хэмээх (2022) бүтээл зэрэгт “21.1.Иргэний нэрийг хууль бусаар ашиглах нь тухайн иргэний өөрийн нэрээр олж авсан эрх, үүргээ хэрэгжүүлэхэд сөрөг үр дагаврыг бий болгодог төдийгүй тухайн иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж буй эрх зүйн эсрэг үйлдэл юм. Иргэний нэрийг хууль бусаар ашиглаж буй үйлдэл нь янз бүрийн хэлбэрээр илэрч болдог. Тухайлбал, бусдын нэрийг ашиглан иргэний эрх олж авах, бусдын нэрээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээ, мэдээлэл хийх, ингэснээрээ нэрийг ашигласан төдийгүй гуравдагч этгээдийн нэр төр, алдар хүндийг гутаах, бусдын нэрийг ашиглан ашиг хонжоо олох, олон нийтийг төөрөгдөлд оруулах гэх мэт. Иймээс иргэний нэрийг хууль бусаар ашиглахыг хуулиар хориглосон байна. Харин тухайн этгээдийн зөвшөөрлөөр буюу хуульд заасан үндэслэл журмын дагуу иргэний нэрийг ашиглаж болно. 21.2.Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд гэсэн ойлголт нь өөр хоорондоо нягт уялдаатай боловч бие даасан агуулгатай байдаг. Нэр төр, алдар хүнд гэдэг нь иргэнд хамааралтай бөгөөд ажил хэргийн нэр хүнд гэдэг нь иргэн, хуулийн этгээдэд аль алинд нь хамааралтай ойлголт юм. Нэр төр гэдэг нь иргэний зан суртахуун, ёс зүй, ажил үйлс, мэргэжлийн шинжийн

¹⁰⁷ Иргэний хуулийн 497 дугаар зүйл (Гэм хор учруулснаас хариуцлага хүлээх үндэслэл)–д “497.1.Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, сэтгэц, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэхүй/–ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй. 497.2.Гэм хор учруулсан этгээд ийнхүү гэм хор учруулсан нь түүний буруугаас болоогүй гэдгийг нотолбол хуульд зааснаас бусад тохиолдолд гэм хор учруулсны хариуцлагаас чөлөөлөгдөнө. 497.3.Гэм хор учруулахад хэд хэдэн этгээд оролцсон бол тэдгээр нь уг гэм хорыг хамтран хариуцах бөгөөд энэ тохиолдолд шууд гэм хор учруулсан этгээд төдийгүй, түүнийг уруу татсан, дэмжин тусалсан, түүнчлэн гэм хор учруулсны үр дүнг санаатай ашигласан этгээд нэгэн адил хариуцлага хүлээнэ” гэж заасан.

¹⁰⁸ Иргэний хуулийн 511 дүгээр зүйл (Эдийн бус гэм хорыг арилгах)–д “511.1.Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол эд хөрөнгийн хохирол арилгасныг үл харгалзан, эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ. 511.2.Эдийн бус гэм хорыг арилгах хэмжээг мэдээ тараасан арга хэрэгсэл, тарсан хүрээ, хохирогчийн сэтгэл санаанд учирсан үр дагавар зэргийг харгалзан нэхэмжлэгчийн шаардлагын хүрээнд мөнгөөр тооцож тогтоох бөгөөд мэдээ тараасан уг хэлбэр болон бусад аргаар няцаалт хийхийг гэм хор учруулсан этгээдэд үүрэг болгоно. . . . 511.6.энэ зүйлд энэ хуулийн 21.4, 21.5, 21.6–д заасан журам нэгэн адил үйлчилнэ” гэж заасан.

¹⁰⁹ Ё.Кают, Э.Шпанглер, П.Редел, Р.Хелмхаген, Д.Наранчимэг, Ц.Амарсайхан, Д.Дүгэржав, Н.Баярмаа, Монгол Улсын иргэний хуулийн тайлбар (Ерөнхий анги), Уб., ХЗҮХ –ийн хэвлэх үйлдвэр, 2006, 72 – 76 дахь тал.

талаархи эерэг үнэлгээ юм. Алдар хүнд нь нэр төртэй салшгүй холбоотой ойлголт юм. Алдар хүнд нь тухайн иргэнд нийгэм, найз нөхөд, хамт олон, бусад харилцагч, түншлэгчээс өгч байгаа үнэлгээнд үндэслэсэн тухайн иргэний өөрийнх нь хувийн үнэлэмж юм. Ажил хэргийн нэр хүнд гэдэг нь зах зээлийн харилцаанд оролцогч хувь хүн, хуулийн этгээдэд хамааралтай ойлголт бөгөөд тухайн этгээд ажил мэргэжлийн болон албан тушаалын үүргээ, бусдын өмнө хүлээсэн гэрээний болон бусад үүргээ хэрхэн биелүүлж байгаагаас ихээхэн шалтгаална. Тэрээр дээрх үүрэгтээ шударга хандаж, түүнийгээ хэрэгжүүлж байвал ажил хэргийн нэр хүнд нь тогтвортой байдаг. Иргэний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан гэдэгт бодит байдалд нийцэхгүй, өөр хэн нэгэн этгээдэд мэдээлсэн байхыг ойлгоно. Харин тийм мэдээ, мэдээллийг иргэнд өөрт нь мэдээлснийг гутаасан мэдээ тараасан гэж үзэхгүй. Уг мэдээ, мэдээлэл нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл, электрон шуудангаар, хурал цуглаан дээр төдийгүй тухайн иргэний ажил байдлын тодорхойлолт, өргөдөл, албан тоотой буюу амаар өөр этгээдэд хүргэгдсэн байхыг ойлгоно. Өөр нэг л этгээдэд уг мэдээ, мэдээлэл хүргэгдсэн байхад нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан гэж үзэх үндэстэй. 21.3.Бодит баримтыг бүрэн гүйцэд мэдээлээгүйгээс бусдын нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутааж болдог. 21.4.Зарим мэдээ, мэдээлэл нь бодит байдалд нийцсэн, үнэн мэдээ байж болох боловч хувь хүний нууцад хамаарах мэдээ байж болно. Хувь хүний нууцыг хуулиар хамгаалдаг. Ийнхүү хуулиар хамгаалсан нууцад хамаарах мэдээг тухайн иргэний өөрийнх нь зөвшөөрөлгүй нийтэд тараасан бол иргэн өөрт учирсан гэм хороо арилгуулахаар шаардах эрхтэй. 21.5.Иргэнийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр ямарваа нэгэн хэлбэрээр дүрслэн түүнийгээ нийтэд тарааснаас тухайн иргэнд гэм хор учирч болно. Ийнхүү дүрслэхдээ дүрслэгч нь тухайн иргэний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаах зорилго агуулаагүй ч гэсэн тухайн иргэний хувьд нэр төр, ажил хэргийн нэр хүндийг гутаагдсан гэж үзэх үндэстэй байж болно. 21.7.Иргэний нэр, нэр төр, алдар хүнд нь тухайн этгээдээс салшгүй амин хувийн эрх хэдий ч тухайн этгээд нас барсны дараа түүний нэр, нэр төр, алдар хүндийг гутаасан мэдээ тарааснаар өвлөгчийг нь сэтгэл санааны дарамтанд оруулах, оюун санааны гэмт хор учирч болно. Хувь хүн өөрийнхөө нэр, нэр төр, алдар хүндийг хамгаалуулах эрхтэй төдийгүй нас барсны нь дараа түүний хууль ёсны өвлөгчид нь дээрхи эрхийг хэрэгжүүлж болохоор зохицуулсан байна. Нас барагчийн нэр, нэр төр, алдар хүндийг гутааснаас эдийн бус гэм хор учирсан хэмээн дурын субъект шүүхэд хандах бус энэ хуулийн 520 дугаар зүйлд заасан хууль ёсны өвлөгчид нь энэ эрхийг хэрэгжүүлэхээр хязгаарлалт тогтоосон байна. 21.8.Энэ зүйлийн 21.7–д заасан тохиолдолд эдийн бус гэм хор учирсан гэж үзвэл өвлөгчид уг гэм хорыг гагцхүү эдийн бус хэлбэрээр буюу уг мэдээг няцаалгах л эрхтэй. 21.9.Энэ хэсэгт заасан сонирхогч этгээд

гэдэгт энэ зүйлийн 21.7 дахь хэсэгт дурдсан өвлөгчид хамаарна¹¹⁰ гэж дэлгэрэнгүй тайлбарласан байна. Энэ талаар Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик хэмээх (2021) судалгаанд “Иргэний хуулийн 21 дүгээр зүйлд заасан “гутаасан мэдээ” нь “худал мэдээлэл” болон “үнэн мэдээлэл”-ийг давхар агуулдаг. Иргэний хуулийн 21.3–т бодит баримтыг бүрэн гүйцэд мэдээлээгүйгээс нэр төрийг гутаасан бол няцаах үүрэг хүлээхээр зохицуулсан. Иргэний хуулиар зохицуулж буй гутаасан мэдээ буюу бодит баримтыг бүрэн гүйцэд мэдээлээгүйгээс нэр төрийг гутаасан бол уг асуудал нь Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэрэгт тооцогдох ёсгүй юм¹¹¹ гэсэн үндэслэл бүхий дүгнэлтийг хийсэн байна.

III. ДҮГНЭЛТ, САНАЛ

Дээрхийг нэгтгэн дүгнэхэд, Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 1 дүгээр сарын 10–ны өдөр Эрүүгийн хуульд “13.14 дүгээр зүйл. Худал мэдээлэл тараах” гэсэн зүйлийг нэмэлтээр оруулсан бөгөөд ингэхдээ уг гэмт хэргийн бүрэлдэхүүний хувьд субъектив шинжийг (санаа зорилгыг) орхигдуулан хуульчилсан гэж үзэж болохоор байна. Тодруулбал, 1926, 1942, 1961, 1986, 2002 оны Монгол Улсын Эрүүгийн хуулиудад гүтгэх гэмт хэргийн субъектив талыг тодорхой зааж өгдөг байжээ. Үүнээс гадна, бусад орнуудын эрүүгийн хуульд уг гэмт хэрэгт худал мэдээлэл тарааж буй этгээдийн субъектив санаа зорилгыг илүү тодорхой тусгасан байна. Үүнээс улбаалан иргэний хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэгдэж болох иргэний гэм хорын асуудлыг гэмт хэрэгт тооцох нөхцлийг бүрдүүлсэн, ихээхэн өргөн хүрээтэй онцлог хэв шинж бүхий гэмт хэрэг болсон гэж дүгнэж байна.

Учир нь эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлалын хувьд гүтгэх гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив шинж болж байсан тухайлсан тодорхой шинж болох худал мэдээлэл тараах үйлдлийг бие даасан гэмт хэрэгт тооцсон байна. Хэдийгээр ямар үйлдлийг гэмт хэрэгт тооцох эсэх нь хууль тогтоогчийн бүрэн эрхийн асуудал боловч энэ нь үндэсний эрх зүйн тогтолцооны үндсэн шалгуурт (үндсэн хуулийн үзэл баримтлал, суурь зарчим зэрэгт) нийцэж байх учиртай юм. Өөрөөр хэлбэл, эрүүгийн хууль тогтоомжид тавих үндсэн хуулийн зүй ёсны шаардлага болон үндэсний эрх зүйн соёл, түүхэн уламжлал гэх зэрэгт хэрхэн нийцэж, эсвэл эсрэгцэж (ондоошиж) байгаа зэргийг харгалзан “монгол хөрсөнд буулгаж чадаж байна уу үгүй юу” гэдгийг заавал үзэх ёстой байтал гүтгэхийг гэмт хэрэгт тооцохгүй зөрчилд тооцох, эсвэл эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлалыг /тодорхой төрлийн гэмт

¹¹⁰ Ё.Кают, Э.Шпанглер, П.Редел, Р.Хелмхаген, Д.Наранчимэг, Ц.Амарсайхан, Д.Дүгэржав, Н.Баярмаа, Монгол Улсын иргэний хуулийн тайлбар (Шинжлэх ухааны тайлбар), Дөрөв дэх удаагийн хэвлэлт, орч. Б.Жавхлан, Л.Эрдэнэ – Очир, Уб., Мэргэн Их Монгол, 2022, 37 – 39 дэх тал.

¹¹¹ Д.Оросоо, Ц.Цэлмэг, С.Дэнсмаа, Г.Туул, Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик, (Илт худал мэдээлэл гэх ойлголтын эрүүгийн эрх зүйн асуудал), Уб., 2021, 48 – 49 дэх тал.

хэргийн хувьд нэгэнт аль хэдийн хөдөлбөргүй тогтсон төрөл (гүтгэх) болон дүрс (худал мэдээлэл тараах) ойлголтын холбоо хамаарлыг/ алдагдуулан субъектив санаа зорилгыг орхигдуулан гэмт хэрэгт тооцох зэргээр тодорхой бус байдал цөөнгүй ажиглагдсаар байна.

Үүний үр дүнд, үндэсний эрх зүйн тогтолцоонд эрүүгийн эрх зүйн (гэмт хэрэгт тооцох эсэх), зөрчлийн эрх зүйн (зөрчилд тооцох эсэх) асуудлууд байна уу, эсвэл бусад салбар эрх зүйн (гэм хор гэх мэт) асуудал байна уу гэдгээс үл хамааран үг хэлэх эрх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө хууль тогтоомжийн хүрээнд хязгаарлагдмал байдлаар хэрэгжих нөхцөл бүрдэх эрсдэлтэй байна. Энэхүү тодорхой бус байдлаас шалтгаалан үндэсний эрх зүйн тогтолцоон дахь салбар эрх зүйн (хэвлэл мэдээллийн болон эрүүгийн, зөрчлийн, иргэний гэх мэт) системчлэл, харилцан хамаарал алдагдаж цаашлаад үндсэн эрхийн зөрчил¹¹² хүртэл үүсгэх нөхцөл бүрдэж болохыг үгүйсгэх аргагүй юм. Тухайлбал,

Энэ нь нэг талаас, нийгэмд нэгэнт тогтсон ойлголт уу, эсвэл зохиомол (зориуд) бий болгосон ойлголт уу гэдгээс үл хамааран аливаа хэлбэрээр (дамжуулсан, түгээсэн гэх мэт) үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх, эрх чөлөөний агуулгыг үндэсний эрх зүйн тогтолцоонд явцуугаар (хязгаарлагдмал байдлаар) авч үзэх нөхцөлийг бүрдүүлж байна. Энэ нь цаашлаад Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний үндсэн эрх (үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх) болон үүргийн (хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх) асуудалд холбогдох боловч “хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаах зорилгоор зориудаар илт худал мэдээлэл тараасан байх” шаардлагыг хууль тогтоогч тавиагүй (орхигдуулсан) нь Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн олон улсын гэрээнд тодорхойлсон иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарлаж болох “зохих” суурь стандартад нийцэхгүй болсон гэж үзэх үндэстэй байна.

¹¹² Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүний 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн “Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэж, нэгтгэн шалгах тухай” 109 дүгээр тогтоолын үндэслэлд “1.Үндсэн хуулийн цэцэд хандаж ирүүлсэн иргэн ...-ийн мэдээлэлд дурдсан асуудал нь Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх маргаанд хамаарч байх тул Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэж, Дунд суудлын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэх үндэслэлтэй байна. 2.Үндсэн хуулийн цэцэд хандаж ирүүлсэн иргэн ...-ийн мэдээлэлд тусгасан асуудал нь иргэн ...-аас ирүүлсэн мэдээлэлтэй агуулгын хувьд ижил нэг асуудал байх тул уг маргааныг нэгтгэн шалгаж, нэг хуралдаанаар шийдвэрлэх нь үндэслэлтэй байна. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалтад маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэн шалгаж байгаа гишүүн “нэг асуудлаар хоёр буюу хэд хэдэн өргөдөл, мэдээлэл, хүсэлт байгаа бол тэдгээрийг нэгтгэх тогтоол гаргах;” ажиллагааг хийхээр заасны дагуу нэгтгэн шалган шийдвэрлэх үндэслэлтэй байна” гээд “Иргэн С.Номынбаясгалангийн мэдээллийн дагуу Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалтын “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгаа бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасныг тус тус зөрчсөн эсэх асуудлаар Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэсүгэй” гэж шийдвэрлэсэн.

Иймд эцэст нь тэмдэглэхэд нэгд, эрүүгийн хуулийн дээрхи (Худал мэдээлэл тараах) зүйлийг бүхэлд нь хүчингүй болгох саналтай байна. Жишээлбэл, Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл (Худал мэдээлэл тараах)—ийг бүхэлд нь хүчингүй болгох;

Хоёрт, Хууль тогтоогч гүтгэхийг гэмт хэрэгт тооцох ёстой гэж үзсэн тохиолдолд эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал зэргийг харгалзан “худал мэдээлэл тараах” гэсэн зүйлээр бус харин “гүтгэх” гэх нэр томъёогоор оруулах шаардлагатай бөгөөд худал мэдээлэл тараах үйлдлийг гүтгэх гэмт хэргийн объектив шинж болгон субъектив санаа зорилгыг тодотгон хуульчлах;

Гуравт, Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн олон улсын гэрээнүүдэд мэдээлэл хайх, хүлээн авах эрх нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, эрх чөлөөний агуулгад багтдаг¹¹³ тул үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх зөрчигдсөн тохиолдолд мэдээлэл хайх, хүлээн авах эрх зөрчигдөх хууль зүйн эрсдэлийг бий болгож байна. Иймд хүний эрхийн холбогдох олон улсын хэм хэмжээний зарчим, агуулгад¹¹⁴ Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.14 дүгээр зүйлийг нийцүүлэх хууль зүйн хэрэгцээ шаардлага байна. Жишээлбэл, Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл (Худал мэдээлэл тараах)—ийн 1 дэх хэсэгт “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ” гэж заасны “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд” гэсний дараа “санаатайгаар зориуд” гэсэн хэсгийг нэмэх;

Дөрөвт, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар үндэсний хууль тогтоомжид тухайлбал, Прокурорын тухай хуулийн¹¹⁵ 36 дугаар зүйл (Прокурорын мэдэгдэл)—ийн 36.1 дэх хэсэгт “Прокурор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор гэмт хэрэг, зөрчил гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулах мэдэгдэл бичнэ” гэж; мөн түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн¹¹⁶ 29.6 дугаар зүйл (Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ)—ийн 1 дэх хэсэгт “Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг тогтоомогц мөрдөгч, прокурор нь зохих хуулийн этгээдэд тэрхүү шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ

¹¹³ Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйл болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг дурдаж болох юм.

¹¹⁴ Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан эрийг эдлэх нь онцгой үүрэг, хариуцлага оногдуулна. Тийм учраас түүнийг зарим талаар хязгаарлаж болох боловч тэр нь заавал хуулиар тогтоогдсон байх ёстой бөгөөд дараахь шаардлагаас үүдэн гарсан байх ёстой.” гээд “а/бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх; б/үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах” гэж заасан.

¹¹⁵ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12702> [Сүүлд үзсэн огноо:2024.12.23]

¹¹⁶ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12694> [Сүүлд үзсэн огноо:2024.12.23]

авахуулахаар мэдэгдэл бичиж хуулбарыг хэрэгт нь хавсаргана” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Хуулийн этгээд нь мөрдөгч, прокурорын мэдэгдлийн дагуу шаардлагатай арга хэмжээ авч, 1 сарын дотор тэр тухай мөрдөгч, прокурорт хариу мэдэгдэх үүрэгтэй” гэж; мөн хуулийн 32.3 дугаар зүйл (Мөрдөн байцаалт явуулсан хэргийн талаар прокуророос хянавал зохих асуудлууд)–ийн 1 дэх хэсэгт “Мөрдөгчөөс шилжүүлсэн хэргийн талаар прокурор доор дурдсан асуудлыг хянах үүрэгтэй:” гээд 1.9 дэх заалтад “гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг тодруулж чадсан эсэх, түүнийг арилгах талаар арга хэмжээ авсан эсэх” гэж тус тус заасныг харгалзан худал мэдээлэл тараах буюу гүтгэх гэмт хэргийн кримнологийн асуудлыг авч үзэх зэрэг саналуудыг дэвшүүлж байна.

IV. НОМ ЗҮЙ

Эрх зүйн эх сурвалж:

1. Хүний эрхийн түгээмэл тунхаглал 1948
2. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт 1966
3. Үндсэн хуулиуд 1924, 1940, 1960, 1992
4. Эрүүгийн хуулиуд 1942, 1961, 1986, 2002
5. Иргэний хууль 2002
6. Прокурорын тухай хууль 2017
7. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017

Монгол эх сурвалж:

1. Ж.Авхиа ба бусад, БНМАУ–ын Эрүүгийн эрх: Тусгай анги, ред. Ж.Авхиа, Уб., БНМАУ–ын Сайд нарын Зөвлөлийн Улсын дээд, тусгай дунд, техник – мэргэжлийн боловсролын хорооны хэвлэл, 1979
2. Ж.Цэвээн, Улсын эрх, хөрвүүлсэн. С.Идшинноров, С.Ичинноров, ред. Ч.Өнөрбаяр, Уб., Адмон принтинг, 2014
3. Х.Доржпалам, Монгол Улсын эрүүгийн эрх зүй, (Тусгай анги), ред. Ж.Эрдэнэбулган, Уб., Сэлэнгэ пресс, 2021
4. С.Нарангэрэл, Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг, ред. Х.Нямбаатаар, Уб., Адмон принтинг, 2021
5. С.Нарангэрэл, Ж.Эрдэнэбулган, Монгол Улсын эрүүгийн эрх зүй: Үзэл баримтлал, уламжлал, сургамж, (Нэгэн сэдэвт бүтээл), Уб., Соёмбо принтинг, 2019

6. С.Нарангэрэл, Монгол Улсын эрүүгийн эрх зүй: Тусгай анги, Уб., 1998
7. Т.Золбоо, Сургалтын эрүүгийн хууль, Ред. Ж.Эрдэнэбулган, Уб, Соёмбо принтинг, 2020
8. Н.Жанцан ба бусад, БНМАУ–ын Эрүүгийн хуулийн дэлгэрэнгүй тайлбар, ред. Ж.Авхиа, Л.Рэнчин, Уб., Улсын хэвлэлийн газар, 1989
9. Г.Совд, Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, Уб., 2002
10. Монгол Улсын дээд шүүх., Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, (Хоёр дахь хэвлэл), ред. Ж.Бямбаа, Уб., 2013
11. Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, Нэмж дэлгэрүүлсэн дөрөвдүгээр хэвлэл, Уб., Мөнхийн үсэг, 2021
12. Д.Оросоо, Ц.Цэлмэг, С.Дэнсмаа, Г.Туул, Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик (илт худал мэдээлэл гэх ойлголтын эрүүгийн эрх зүйн асуудал), Уб., 2021
13. Монгол, Орос, Хятад, Герман улсын эрүүгийн хууль, (Орчуулж нэгтгэсэн анхны хэвлэл), орч. Ж.Эрдэнэбулган, М.Уянга, Б.Тамир, Б.Батбаяр, Т.Золбоо, Уб., Соёмбо принтинг, 2021
14. ХЭҮК, Хүний эрхийн олон улсын гэрээ ба Монгол Улс, Хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит илтгэлүүд, НҮБ–ын гэрээний хороод, хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлгээс Монгол Улсад өгсөн зөвлөмжийн эмхэтгэл, (1971 – 2020), Нэгдүгээр боть, эмх. Г.Агар – Эрдэнэ, Ч.Ариунаа, Э.Туул, Уб., Бэмби сан, 2021
15. Г.Совд, БНМАУ–ын Эрүүгийн эрх: Тусгай анги, Уб., Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо, 1965
16. Ж.Амарсанаа, Б.Чимид, Б.Баярсайхан, Д.Баянбилэг, Б.Батбаяр, А.Түвшинтулга, Р.Шажинбат, А.Энхбаатар, Г.Энхжавхлан, Х.Эрдэнэтуяа, Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл, Гуравдугаар боть, 1926 VI сар – 1936 он, ред. Б.Баярсайхан, Д.Баянбилэг, Уб., Мөнхийн үсэг, 2010
17. Ж.Амарсанаа, Б.Чимид, Б.Баярсайхан, Д.Баянбилэг, Б.Батбаяр, А.Түвшинтулга, Р.Шажинбат, А.Энхбаатар, Г.Энхжавхлан, Х.Эрдэнэтуяа, Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл, Дөрөвдүгээр боть, 1937 он – 1958 X сар, ред. Б.Баярсайхан, Д.Баянбилэг, Уб., Мөнхийн үсэг, 2010
18. Ж.Амарсанаа, Б.Чимид, Б.Баярсайхан, Д.Баянбилэг, Б.Батбаяр, А.Түвшинтулга, Р.Шажинбат, А.Энхбаатар, Г.Энхжавхлан, Х.Эрдэнэтуяа, Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл, Тавдугаар боть, 1958 X сар – 1970 он, ред. Б.Баярсайхан, Д.Баянбилэг, Уб., Мөнхийн үсэг, 2010

19. Ж.Амарсанаа, Б.Чимид, Б.Баярсайхан, Д.Баянбилэг, Б.Батбаяр, А.Түвшинтулга, Р.Шажинбат, А.Энхбаатар, Г.Энхжавхлан, Х.Эрдэнэтуяа, Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл, Долдугаар боть, 1985 V сар – 1992 он, ред. Б.Баярсайхан, Д.Баянбилэг, Уб., Мөнхийн үсэг, 2010
20. Ж.Амарсанаа, Б.Чимид, Б.Баярсайхан, Д.Баянбилэг, Б.Батбаяр, А.Түвшинтулга, Р.Шажинбат, А.Энхбаатар, Г.Энхжавхлан, Х.Эрдэнэтуяа, Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл, Арван гуравдугаар боть, 2002 он, ред. Б.Баярсайхан, Д.Баянбилэг, Уб., Мөнхийн үсэг, 2010
21. С.Номынбаясгалан, Б.Баатарцогт, Э.Тамир, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийг хэлэлцсэн БНМАУ–ын Бага Хурлын чуулганы болон Ардын Их Хурлын хуралдааны тэмдэглэлүүд, (Түүвэр), ред. Б.Баярсайхан, М.Сүхбаатар, Уб., Адмон принтинг, 2023
22. С.Гантулга, Б.Энхболд, Эрүүгийн эрх зүй: Тусгай анги, Хоёр дахь хэвлэл, Уб., Мөнхийн үсэг, 2020



О.ХИШИГМӨНХ

ОТИС, Хууль, эдийн засгийн хувийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, хуульч



Г.ГАНТӨМӨР

ОТИС, Хууль зүйн сургуулийн багш, доктор, профессор

ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛ ҮЙЛДСЭН ЭТГЭЭДЭД ХЭРЭГЛЭХ АЛБАДАН СУРГАЛТЫН МӨН ЧАНАР, ОНЦЛОГ

THE ESSENCE AND FEATURES OF ENFORCED TRAINING ON LEGAL PERSONS THAT COMMITTED CRIMES AND CRIMINAL ACTIONS

Хураангуй: Хууль зүйн хариуцлагын нэг төрөл болох албадан сургалт нь бусад албадлагатай харьцуулахад хууль тогтоомжид хожуу тусгалаа олсон ба эд хөрөнгө хураах, эрх хязгаарлах зэрэг албадлагаас илүү үр нөлөөтэй байх боломжтой гэдгээрээ онцлог. Хуульд зан үйлд нөлөөлөх сургалтыг сайн дурын болон албадан гэсэн хоёр төрөлтэй байхаар заасан хэдий ч практикт албадан сургалт нь давамгайлж байгаа нь зөрчил, гэмт хэрэг гарсны дараа зан үйлд нөлөөлөх сургалтыг хийж байгаа нь анхаарах асуудал юм. Албадан сургалтыг баривчилсан, хоригдсон хугацаанд хийдэг тул тус сургалтын агуулга зорилгыг ойлгох, хүлээн авах сэтгэл зүй бэлэн бус тогтворгүй, бухимдалтай, эс хүлээн зөвшөөрөх хандлага нийтлэг байдаг нь түүний үр дүнд сөргөөр нөлөөлдөг. Эрх зүйн зохицуулалтын хувьд баривчлахаас өөр сонголтгүй шийтгэл оногдуулахаар заасан зөрчилд дээр сонгох санкцитай байх, сонгох санкцитай зөрчлүүдийн хувьд баривчлах, торгох шийтгэл нь харьцуулан сонгоход тохиромжтой байх шаардлагатай байна.

Abstract: Compulsory training, as a type of legal responsibility, is characterized by the fact that it is reflected in legislation later than other coercion and can be more effective than coercion, such as confiscation of property or restriction of rights. Although the law provides for behavior influencing training to be of two types: voluntary and compulsory, it is a matter of concern that in practice, compulsory training predominates, which is the practice of behavior influencing training after an incident or Crime. Since compulsory training is carried out during the period of arrest and detention, the psychology of understanding and accepting the content of the training is not ready, unstable, frustrated, or accepting is common, which negatively affects its effectiveness. In terms of legal regulation, it is necessary to have a selection sanction for violations that provide for punishment with no choice but to arrest, and for violations with a selection sanction to be suitable for comparison of arrest and fine.

Түлхүүр үг: Зан үйл, Хүний эрх, Хариуцлага, Баривчлах, Зөрчил, Гэмт хэрэг

Keywords: Behaviour, Human Right, responsibilities, Arrest, Complect, Crime.

I. УДИРТГАЛ

Монгол Улс нь урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт ...өв тэгш, үндэсний ухамсарт эх оронч монгол хүнийг төлөвшүүлнэ, хүмүүнлэг, оюунлаг, ёс суртахуунтай.., монгол хүнийг бэлтгэнэ, гэр бүл хувь хүний хөгжлийн хэрэгцээг дэмжсэн орчин, нөхцөл бүрдүүлж, цогц үйл ажиллагааны чанарыг дээшлүүлнэ, хүнд ээлтэй амьдрах орчныг бүрдүүлнэ хэмээн заасан. Хөгжлийн бодлого нь Монгол Улсын өнөөгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилготой хэдий ч хэрэгжилтийг хангах хууль тогтоомж нь бодлогоо хэрэгжүүлэхэд түлхэц болох цогц байх шаардлагатай. Хүн төвтэй нийгмийг бүтээх, хүнийг зөв төлөвшил, хүмүүжилтэй болгох нь бидний амьдарч буй нийгэмд чухал асуудлын нэг юм. Хүнийг хүмүүжүүлэх үндэсний зан заншил, уламжлал ардын ухаан нь эрт үеэс уламжлагдан ирсэн хэдий ч нийгэм, эдийн засаг, улс төрийн гэх олон хүчин зүйлсээс шалтгаалж нийгмийн ёс суртахуун хүмүүжлийн доройтолд орсон нэгнээ хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх, эв эеийг хичээн зохицон амьдрах явдал үгүйлэгдэж байна. Энэ нь нийгэмд гэмт хэрэг, зөрчлөөр дамжин илэрч хүний тогтсон хандлага, зан үйлийг засах, өөрчлөх аргуудыг албадлагаар дамжуулан хэрэгжүүлэх ёстой.

Эрүүгийн болон зөрчлийн тухай хуульд заасан албадлагын арга хэмжээ болох талаасаа зан үйлд нөлөөлөх албадан сургалт нь албадан сургалт давамгайлах байдлаар тусгагдсан. Зөвхөн гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд сайн дурын болон албадан гэсэн хэлбэртэй байхаар хуульчилсан хэдий ч сайн дурын сургалт хэрэгжилт хангалтгүй байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар баривчлах байр нь баривчлагдсан этгээдийн зан үйлд нөлөөлөх, зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулах, хорих анги нь монгол хэлээр уншиж, бичиж чадахгүй Монгол

Улсын иргэн-хоригдолд монгол хэл, бичиг үсэг эзэмшүүлэх, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт ял шийтгүүлсэн болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, согтууруулах ундаа хэрэглэх зуршилтай хоригдлын зан үйлд нөлөөлөх сургалтыг зохион байгуулахаар заасан. Харин Зөрчлийн тухай хуулиар баривчлах шийтгэл хүлээлгэхээр заасан 11 зөрчлийн 7-д нь албадан сургалтад хамруулахаар заасан нь цөөнгүй гэмт хэрэг, зөрчилд албадан сургалт хийхээр зохицуулсныг харж болно.

Албадан сургалт нь албадлагын арга хэмжээний хүмүүмүүлэх, зөв зан үйлд сургах, ухааруулах, ойлгуулах, тогтсон үзэл хандлагыг өөрчлөх давтан үйлдэхээс сэргийлэх зорилготой нийцэх, үр дүнд суурилсан сургалт байх онцлогтой ба сургалтын үр дүнд нь нийгэмд тухайн төрлийн гэмт хэрэг, зөрчил буурахад нөлөөлөх учиртай. Иймд агуулгыг агуулгыг практик ач холбогдол, нийгмийн хэрэгцээ шаардлагатай уялдуулан албадан сургалтын онцлогийг өнөөгийн эрх зүйн зохицуулалтын түвшинд авч үзэж практикт хэрэгжилтийг хангах сайжруулах талаар тодорхой санал, зөвлөмж гаргахыг зорьсон болно.

II. АЛБАДАН СУРГАЛТ ХУУЛЬ ЗҮЙН ХАРИУЦЛАГЫН НЭГ ТӨРӨЛ БОЛЖ ХУУЛЬЧЛАГДСАН ТҮҮХЭН ХӨГЖИЛ

Хариуцлага¹ хэмээх ойлголтыг үг зүйн болон хууль зүйн шинжлэх ухааны талаас тодорхойлсон олон тодорхойлтууд байдаг. Хариуцлага хэмээх ойлголтыг өргөн ба явцуу хүрээнд тодорхойлж болох ба төрөөс тогтоосон эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн буруутай этгээдэд хүлээлгэх эрх зүйн арга хэм хэмжээг хариуцлага гэнэ. Хариуцлага хүлээлгэх тухай ойлголт нь эртний Ромын эрх зүйгээс эхлэлтэй ба эртний Ромын эрх зүйд “Хуульгүй гэмт хэрэг байхгүй” (Nullum crimen sine lege) гэж хууль ёсны зарчмыг бэхжүүлж байжээ. Сократ ёс суртахууныг ухааралтай холбон тайлбарлахдаа зөв зан үйл нь зөвийн талаарх ухаарсан мэдлэгээс шалтгаалдаг гээд гэмт хэрэг нь энэ талаар гэгээрлийн ажил хангалттай сайн явуулж чадаагүй буюу хүүхэд, залуусын хүмүүжлийн ажлын доголдолтой холбоотой гэсэн гаргалгааг хийж байжээ. Үүнээс үзвэл аливаа үйлийн зөв бурууг ялган тайлбарлаж чадсан тохиолдолд тухайн хүн буруу үйлдэл хийж, гэмт явдалд татагдан орох магадлал буурна² гэж үздэг байсан нь ухааруулах, ойлгуулахын үр нөлөөг чухалд үздэг байсныг илтгэж буй юм.

Улмаар эртний улсуудад иргэдийнхээ ёс суртахуун, хүмүүжилд чиглэсэн ажлуудад анхаарч гэмт хэрэг, зөрчил бол хүний өөрийн хүсэл зоригийн үр

¹ Монгол Улсын Шинжлэх ухааны академийн “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар тольд зүй тогтлоор илэрч гарах жинхэнэ үнэн байдлын аливаа үзэгдлүүдийн хоорондын холбоо ба харьцах зүй тогтол, жам ёс, байгалийн хууль, сэтгэхүйн хууль, засаг төрийн дээд эрхийг барих байгууллагаас улсын хэмжээгээр бүх нийтийг заавал дагаж мөрдүүлэхээр баталсан албан ёсны дүрэм, журам, хууль сахигч хууль сахих, хуулиар захирах, хуулийн хариуцлага хууль ёс, төрийн хуульд үндэслэн гаргасан эрх зүйн актыг нэг мөр сахин биелүүлэх ажиллагаа хэмээн тэмдэглэсэн байна.

² Т. Азжаргал “Хууль зүйн хариуцлага” УБ 2023 х.28 дах тал

дүн биш харин нийгмийн гажуудал, ухаарал мэдлэгийн хомсдол, үүнээс үүдсэн амьдрах чадварын дутагдлаас хамаардаг гэж үздэг байжээ. Тухайлбал эртний Грекийн гүн ухаантан Платон нь гэмт явдал нь нийгмийн шалтгаантай гэсэн үзэл баримтлалыг томъёолж, нийгмийн байгууламжийг өөрчилснөөр гэмт явдлыг хязгаарлах боломжтой гэж дүгнэж хууль зөрчсөн гэмт явдал бол нийгэм өөрөө өвчилсний ноцтой шинж тэмдэг гээд ядуурал, ялгарал зааг хэр хэмжээнээс хэтэрсэнтэй холбоотой³ гэж тайлбарлажээ. Энэ үзэл баримтлал үнэ цэнээ алдаагүй ба одоогийн зөрчил, гэмт хэргийн шалтгаан нөхцөлтэй ч уялдахын зэрэгцээ, нийгмийн суурь асуудлын шалтгааныг илрүүлэн шийдвэрлэх нь чухлыг харуулж байна.

Монгол Улсын Засгийн газраас 1923 онд “Цагдан сэргийлэхийн эрх хэмжээний дүрэм”, “Цагдан цээрлүүлснийг зөрснийг яллах хуулийг⁴ баталж байжээ. Уг хуульд захиргааны журам зөрчсөн, тухайн үедээ эрүүгийн шинжгүй зөрчилд арга хэмжээ авах анхны хууль бөгөөд захиргааны зөрчлийн хүнд, хөнгөнийг харгалзан 1-15 хоног хорих, 1-15 төгрөгөөр торгууль оногдуулахаар заасан нь хэв журам сахиулах, хэрэг зөрчилтэй тэмцэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн эрх зүйн акт байсан. Энэ хуулийн “Нийтийн хууль” хэмээх 12 зүйлээс тогтох ба нэгдүгээр бүлэгт зөрчил үйлдсэн хүнд оногдуулдах 7 төрлийн торгууль тогтоож, аливаа хорих шийтгэлийг Цагдан сэргийлэх хорооны газарт даалгаж, зөрчил гаргагчдыг хөнгөтгөн үзвэл донгодон шийтгэх тухай заажээ. Ийнхүү Цагдан сэргийлэх байгууллага анх захиргааны журмаар баривчлах, нийгмээс тодорхой хугацаагаар тусгаарлан шийтгэл оногдуулдаг үйл ажиллагааг хэрэгжүүлж байжээ.

Мөн хуульд дээр дурдсан шийтгэлийг хэрхэн оногдуулдах, Цаазын бичгийн хоёр зүйлээс дээшихэд халдвал зохих шийтгэлийг ялган салгаж, хүндрүүлэн яллавал зохих (тухайлбал, хорих хугацааг 30 өдөр, торгох хэмжээг 30 төгрөгт хүрвээс зогсоох гэх мэт), ялыг хэрхэн гүйцэтгэх зэрэг хуулийг хэрэглэх нийтлэг зүйлийг тусгайлан тогтоожээ. Улмаар “Засгийн хэрэгт холбогдох”, “Олны түгшүүр хорлолд холбогдох”, “Харилцан нэвтрэхэд холбогдох”, “Мэдээ нэвтрүүлэхэд холбогдох”, “Бие ба амийг хамгаалахад холбогдох”, “Эд хөрөнгөд холбогдох”, “Цээрлэлийг зөрчсөн ял” гэж 2-9 дүгээр зүйл, 13-15 дугаар зүйлд зөрчлийг төрөлжүүлэн заасан байна. Эндээс үзэхэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй, эсвэл гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан үйлдэлд торгох, донгодох, түр хугацаагаар хорих зэрэг харьцангуй хөнгөн шийтгэл ногдуулж байжээ. Мөн гэмт явдлын үйлдэгсэдтэй тэмцэх ба үүрд хулгай хийж амьдрахаас сэргийлэх хэргийг засан сайжруулах газруудаас гадуур гүйцэтгэхийн тулд уул газруудаас суллагдагдсыг тэтгэж

³ Plato (424/423-343/347 BC) was an Athenian philosopher during the Classical period in Ancient Greece, Ancient Greece, founder of the Platonist school of thought the Academy, the first institution of higher learning in the Western world.

⁴ Монгол Улсын Засгийн газрын 1923 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн арваннэгдүгээр хурлаар “Цагдан сэргийлэхийн эрх хэмжээний дүрэм, Цагдан цээрлүүлснийг зөрснийг яллах хуулийг” тус тус баталж байжээ.

туслах тусгай комитетууд байгуулагдана гэж зааж шийтгэлийн зорилго, чиг үүргээс улбаалан засан сайжруулах газар, үйлдсэн хэрэг, зөрчлийн байдал, учир шалтгааныг харгалзан үзэхийг хуульчлан хэрэгжүүлж байсан сайн эрх зүйн уламжлал, авуштай туршлага байна.

Социалист нийгмийн үед дийлэнх үйлдэгдэж байсан захиргааны шинжтэй зөрчил нь (одоогийн зөрчлийн үйлдэл) архидан согтуурах явдал байсан ба 1960-аад оны сүүлээс архидан согтуурах явдалтай тэмцэхэд анхаарлаа хандуулж эрх зүйн төдийгүй үзэл суртал, эдийн засаг, зохион байгуулалтын арга хэрэгслийг өргөнөөр ашиглаж гэмт хэрэг, нийгмийн хэв журам зөрчих явдалтай хамтран тэмцэх ажлын үр нөлөөг сайжруулах, согтуурлаас урьдчилан сэргийлэхэд бүх нийтийн анхаарлыг чиглүүлэх төрөл бүрийн арга хэмжээг авч хэрэгжүүлж байжээ. Тухайлбал, нийгмийн хэв журам зөрчигчид, танхайрагчидтай явуулах тэмцлийг хүчтэй болгох тухай Монгол Ардын Намын Төв Хорооны 1967 оны 263 тоот тогтоол гарган, уг тогтоолд “уж согтууран хэрэг өдүүлэх явдалтай тэмцэх явдал бол нам, улс олон нийтийн үйлдвэр, албан газар, соён гэгээрүүлэх байгууллага, хөдөлмөрийн хамт олон, иргэн нэг бүрийн чухал зорилт, нэр төрийн хэрэг” гэж үзэж бүх нийтийг хариуцлагажуулах, хүмүүжүүлэх, ёс суртахуунтай байх асуудлыг нэн тэргүүнд тавьж байв.

БНМАУ 1974 онд “Олон нийтийн газарт хэрүүл маргаан үүсгэх, бусдыг өдөөн хоргоох, айлган сүрдүүлэх, цээртэй үгээр хараах, үйлчилгээний газрын журмыг гажуудуулах, дарааллын журам зөрчих, байр орон сууцанд бусдын тайван амгалан байдлыг алдагдуулах, барилга байгууламж, гудамж талбай, зүлэг модыг гэмтээх, бохирдуулах зэргээр нийгмийн хэв журмыг санаатайгаар зөрчиж, жижгээр танхайрсан этгээдийг 10-30 хоног хүртэл хугацаагаар баривчлах буюу 300 төгрөг хүртэл торгох⁵” тухай тусгажээ.

БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1961 оны “Олон нийтийн хэв журам эвдэж танхайрагчдад хариуцлага хүлээлгэх тухай” 301 дүгээр зарлиг, “Нийгмийн тустай хөдөлмөрөөс зайлсхийгчидтэй тэмцэх явдлыг хүчтэй болгох тухай” 302 дугаар зарлигуудыг биелүүлэх үүднээс Улаанбаатар хотын АДХГЗ-ны 1962 оны дөрөвдүгээр сарын 05-ны 57 дугаар тогтоол баталж байжээ. 1992 онд “Захиргааны хариуцлагын тухай” хууль батлагдан танхайрах, согтуурах, галт зэвсэг болон амьсгал боогдуулах, нулимс асгаруулах бодис хууль бусаар олж авах, авч явах, хадгалах, хүйтэн зэвсэг хууль бусаар авч авах, хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчих, шүүхийг үл хүндэтгэх, шүүн таслах ажиллагаа хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан шүүгч, иргэдийн төлөөлөгчийг заналхийлсэн, доромжилсон, прокурорыг үл хүндэтгэх, цагдаагийн албан хаагч, тагнуулын ажилтны хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, заналхийлэх, цагдаагийн байгууллагад худал мэдээлэл өгөх,

⁵ БНМАУ ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн “Танхайрагчид, нийгмийн хэв журам зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг чангатгах тухай” 1974 оны 111 дүгээр зарлиг

цагдаагийн алба хаагч, туслах ажилтны хууль ёсны шаардлагыг зориуд үл биелүүлсэн, биелүүлэхгүй байхыг уриалсан, эсэргүүцсэн, төрийн байгууллагын ажилтны нэр барих, хууран мэхэлсэн, төрийн төлөөлөгчийн хууль ёсны шийдвэрийг биелүүлэхгүй байх, саад болох, биед нь халдсан зэрэг үйлдэлд торгох эсхүл баривчлах шийтгэлийг 7-30 хоногоор ногдуулдаг байсан нь одоогийн Зөрчлийн тухай хуульд буй торгох эсхүл баривчлах шийтгэлийг сонгон өмнөх хуулиудад байсныг харуулж байна.

Өмнөх хууль тогтоомжийн зохицуулалтаас үзэхэд төрөөс гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх асуудалд анхаарч хөдөлмөрөөр хүнийг хүмүүжүүлэх, хүн нэг бүр хариуцлагатай, нийгмийн шударга гишүүн байх асуудлыг чухалчлан авч үздэг байжээ.

III. АЛБАДАН СУРГАЛТЫН МӨН ЧАНАР, ТӨРӨЛ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Эдүгээг хүртэл хугацаанд хууль зүйн хариуцлага болох талаасаа хууль тогтоомжийг сахиулах, хууль зөрчсөн этгээдийг засан хүмүүжүүлэх, цээрлүүлэх үүргээр хэрэглэгдэж хувь хүний үүрэг хариуцлагыг ухамсарлуулан нийгэмд дэг журмыг тогтоох агуулгаар хөгжиж ирсэн байна. Тийм ч учраас эрх зүйн харилцааны хүрээнд шалтгаан ба үр дагаврын тухай зүй тогтол түүний илрэх үндсэн гол хэлбэр мөн⁶ ба хууль зүйн хариуцлага нь эрх зүйн мөн чанар, түүний чиг үүрэг, зарчим нийгмийн зорилгыг илүү тодорхой илэрхийлнэ. Хууль зүйн хариуцлага гэсэн ойлголтын олон талт, нарийн төвөгтэй байдал нь эрх зүйн зөрчил, эрх зүйн хэм хэмжээ, төрийн албадлага, эрх зүйн харилцаа, эрх зүйн хэрэглээ, эрх зүйн зан үйлтэй илүү нягт холбоотой гэж үздэг байна.

Зөрчил үйлдсэн этгээдэд хэрэглэх албадан сургалт нь эрх зүйн буюу төрийн албадлагын нэг төрөл болохын хувьд албадлагын ойлголтыг авч үзэх шаардлагатай. Төрийн албадлагын арга хэмжээг албадан хангах арга хэмжээ, албадан хамгаалах арга хэмжээ гэж ангилдаг⁷. Албадан хангах арга хэмжээнд эрх зүйн зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон байцаан шийтгэх албадлага⁸ хамаардаг.

Албадан сургалт нь үүрэг хүлээлгэх албадлагын нэг төрөл юм. Албадан сургалт гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдүүдийн зан үйлд нөлөөлөх, өөрчлөх нь сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх хэлбэр төдийгүй эрх зүйн мэдлэг олгож буй хэрэг юм. Албадан сургалтын зорилго нь зөрчил гаргасан хүний зан үйлд нөлөөлөх тул зан үйл гэдэг ойлголтыг авч үзэх нь зүйтэй. Хүний зан үйлийн илрэх хэлбэр, сэдэл зорилго, үр дагавар олон янз байна. Эрх зүйн

нөлөөллийн хүрээнд буюу эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж хууль зүйн үр дагавар агуулж байгаа зан үйлийг эрх зүйн зан үйл гэнэ. Эрх зүйн зан үйл нь нийгмийн харилцаанд эерэг болон сөрөг байдлаар нөлөөлж байдаг. Эерэг зан үйлийг сайшаах, дэмжих, урамшуулах, сөрөг зан үйлийг албадлага хэрэглэж хориглох, хязгаарлах, хариуцлага хүлээлгэх ёстой. Эрх зүйн зан үйл нь хууль ёсны зан үйл ба эрх зүйн зөрчил, эрх зүйг зөрчсөн гэм буруугүй үйлдэл гэсэн төрөлтэй байна.⁹ Зан үйлд нөлөөлөх албадан сургалт нь эрх зүйн зарим төрлийн гэмт хэрэг, зөрчил гаргасан этгээдийн эрх зүйн эсрэг үйлдэлд буюу эрх зүйн зөрчилд үндэслэн албадлага хэрэглэж буй явдал юм.

Албадан сургалтыг Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Жендерын эрх тэгш байдлыг хангах тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулиудад тус тус явуулахаар заасан.

Эрүүгийн хуульд заасан үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээнд зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах¹⁰ төрөлд арга хэмжээ хамаарна. Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад ял эдэлж байгаа өсвөр насны хүнд ерөнхий, мэргэжлийн боловсрол олгох, хөдөлмөрлөх, амьдрах ухааны дадал олгох сургалт зохион байгуулна. Шүүх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг гэм бурууг нь ухамсарлуулах, хохирлыг нөхөн төлүүлэх, хөдөлмөрлөх, амьдрах зөв арга барилд сургах, гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ авах үүргийг хүлээлгэнэ¹¹. Баривчлах байр нь баривчлагдсан этгээдийн зан үйлд нөлөөлөх, зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулна¹² гэж тус тус заасан. Үүнээс харахад хоригдох байранд шавь төвтэй зан үйлээ засах албадан сургалт байх, баривчлах байранд урьдчилан сэргийлэх, дахин гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс татгалзуулах зорилгоор хийгдэх агуулгыг уг хуулиар тодорхойлсон байна.

Зөрчлийн тухай хуульд уг хуулийн тусгай ангид өөрөөр заагаагүй бол шүүх баривчлах шийтгэл оногдуулахаар заасан зөрчил үйлдсэн хүнд албадан сургалтад хамруулах албадлагын арга хэмжээг хэрэглэж болно. Албадан сургалт нь арваас тавин цагийн хугацаатай байна¹³. Зөрчлийн тухай хуульд албадан сургалттай холбоотой харилцааг хуулиар зохицуулна¹⁴ гэж заасан. Зөрчлийн тухай хуулиар олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, танхайрах, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, жагсаал цуглаан зохион байгуулах журам зөрчих, гамшигаас хамгаалах тухай хууль

⁶ Т. Азжаргал “Хууль зүйн хариуцлага” УБ., 2023. х.21 дэх тал

⁷ Ч.Нямсүрэн “Эрх зүйн ерөнхий онол” УБ., 2017 х.358 дах тал

⁸ Ж.Долгорсүрэн. “Захиргааны хариуцлага” УБ 1998 х.58 дах тал

⁹ Ч.Нямсүрэн “Эрх зүйн ерөнхий онол” УБ., 2017 х.337 дах тал

¹⁰ Эрүүгийн хууль (2015) 7 дугаар зүйлийн 7.3.2.2

¹¹ Эрүүгийн хууль (2015) 8 дугаар зүйлийн 8.7.2

¹² Эрүүгийн хууль (2015) 147 дугаар зүйлийн 147.5

¹³ Зөрчлийн тухай хууль (2017) 4.5 дугаар зүйлийн 4.5.1,2,3,4

¹⁴ Зөрчлийн тухай хууль (2017) 4 дүгээр зүйлийн 4.5.4

зөрчих, хүүхдийн эрхийг зөрчих, бэлгийн дарамт учруулах, генетик нөөцийн тухай хууль зөрчих¹⁵, хулгайлах, хөрөнгө завших, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчлүүдэд 7-30 хоног баривчлах шийтгэл хүлээлгэхээр тус тус заасан байна.

Зөрчил үйлдсэн үйлдсэн хүнийг хуульд заасан хугацаагаар тусгай зориулалтын байранд саатуулахыг баривчлах шийтгэл гэнэ. Баривчлах шийтгэлийг шүүгч ногдуулах зохицуулалтай. Энэ нь Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцах, хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй¹⁶ гэсэн суурь зохицуулалтаас улбаатай төдийгүй хуулиар хориглосон үйлдэлд хариуцлага хүлээлгэх нь гарцаагүй байх зарчимтай салшгүй холбоотой юм. Баривчлах шийтгэл хүлээлгэхээр өмнө дурьдсан 11 зөрчлийн 7-д нь албадан сургалтад хамруулах, 9 зөрчилд торгох эсхүл баривчлах шийтгэлийг сонгох санкцитайгаар хуульчилсан байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд зааснаар гэр бүлийн зөрчилдөөнтэй асуудлыг хүч хэрэглэхгүйгээр шийдвэрлэхэд чиглэсэн зан үйлд нөлөөлөх сургалт сайн дурын болон албадан гэсэн хэлбэртэй байна. Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтыг энэ чиглэлээр магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллага хэрэгжүүлж болно. Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтын хөтөлбөр, журмыг Хууль зүйн, Нийгмийн хамгаалалын, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг хорих ял шийтгүүлсэн этгээдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, баривчлах, албадан сургалтад хамруулах шийтгэл хүлээсэн этгээдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх, цагдаагийн байгууллага зохион байгуулна. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, журмыг Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална¹⁷ гэж заасан. Энэ хуулиар зан үйлд нөлөөлөх сургалт нь сайн дурын болон албадан гэсэн төрөлтэй байхаар зохицуулсан хэдий ч практикт албадан сургалт нь илүүтэй хэрэгжиж сайн дурын сургалт явуулсан талаар мэдээлэл, судалгаа хомс байна. Баривчлагдсан этгээдэд явуулсан албадан сургалтын 75 хувийг дангаараа гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг зөрчсөн хүнд явуулсан¹⁸ нь нийгэмд гэр бүлийн хүчирхийлэл тулгамдсан асуудал болохыг нөгөө талаасаа албадан сургалтын үр нөлөөг нэмэгдүүлэхэд анхаарах нь зайлшгүй чухал асуудлыг болохыг илтгэнэ.

¹⁵ Зөрчлийн тухай хууль (2017) 7.18 дугаар зүйлийн 7.18.1.2 энэ заалтыг 2021.12.30ны өдөр нэмсэн

¹⁶ Монгол Улсын Үндсэн хууль (1992)19 дүгээр зүйлийн 19.1,3

¹⁷ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 2016 44 дүгээр зүйлийн 44.1-44.5

¹⁸ Д.Чинзориг “Баривчлах шийтгэл гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт” докторын зэрэг горилсон судалгааны ажил УБ.,2024 х.4 дэх тал

Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд гэр бүлийн харилцаанд хүйсийн шинжээр шууд ялгаварлан гадуурхсан этгээдийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу зохион байгуулдаг зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулж болно¹⁹ гэж заасан байна. Зөрчлийн тухай хуулиар шүүхийн шийдвэрийн дагуу хариуцлага хүлээлгэх ба Зөрчлийн тухай хуульд хариуцлага хүлээлгэхээр заасан бүрэлдхүүнд уг агуулга хамаарахааргүй байгаа нь хууль хоорондын уялдаа холбоог хангах шаардлагатайг харуулж байна.

Хүүхэд хамгааллын тухай хуульд шүүхийн шийдвэрээр албадан сургалтыг хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага нь хүүхэд хамгааллын чиглэлээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хамтран зохион байгуулна²⁰ гэж заасан байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан сургалтын хөтөлбөрийн агуулгаар явуулж болох эсэх, сургалтаар хүлээгдэх үр дүн нь ижил эсэх нь тодорхойгүй байна. Одоогийн хэрэгжиж байгаа сургалтын хөтөлбөр нь хохирогчийн онцлогийн харгалзан боловсруулагдаагүй учраас үйлдэлд нь хамааралгүй агуулгаар сургалт явуулах үр дүнгүй байх нөхцөл, шалтгаан болж байна. Иймд үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийн ялгаа, хохирогчийн онцлогийг харгалзсан агуулгаар албадан сургалт орох шаардлага байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд баривчлах байр нь баривчлагдсан этгээдийн зан үйлд нөлөөлөх, зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулна²¹. Мөн уг хуульд хорих анги нь монгол хэлээр уншиж, бичиж чадахгүй Монгол Улсын иргэн-хоригдолд монгол хэл, бичиг үсэг эзэмшүүлэх, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт ял шийтгүүлсэн болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, согтууруулах ундаа хэрэглэх зуршилтай хоригдлын зан үйлд нөлөөлөх сургалтыг зохион байгуулна²². Хоригдол хорих ял эдлэх хугацаанд сахилгын зөрчил гаргаагүй, хуваарилсан ажил, үйлчилгээг чанартай хийж гүйцэтгэсэн, сургалт-хүмүүжлийн ажил болон нийгэмшүүлэх хөтөлбөрт идэвхтэй хамрагдсан, хууль тогтоомж, хорих ангийн дотоод журмыг мөрдөж байгаа байдал, өөрийн зан үйл, хувийн байдлаараа хорих ангийн дарга, алба хаагчаас эерэг үнэлгээ авсан тохиолдолд түүнд шагналын хоног олгоно²³ гэж заасан.

Ялтан ял эдлүүлэх журмыг зөрчөөгүй, өөрийн зан үйл, хувийн байдлаараа ял эдлүүлэх ажиллагаанд саад учруулаагүй бол түүнд 1 сард 5 хүртэл хоногийн шагналын хоног олгож болно²⁴ гэж заасан нь зан үйлийн хувьд эерэг болсон

¹⁹ Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011) 26 дугаар зүйлийн 26.3

²⁰ Хүүхэд хамгааллын тухай хууль (2016) 18дугаар зүйлийн 18.2.6

²¹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (2017) 147 дугаар зүйлийн 147.5

²² Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (2017) 222 дугаар зүйлийн 222.1

²³ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (2017) 224 зүйлийн 224.1

²⁴ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (2017) 175 дугаар зүйлийн 175.1

засарч хүмүүжиж байгаа этгээдийг урамшуулах зорилготой зохицуулалт юм. Зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан хүнд шийдвэр гүйцэтгэгч зан үйлд нөлөөлөх сургалтын агуулга, хөтөлбөрийг танилцуулна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага зан үйлээ засах сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан хүний зан үйлд нөлөөлөх сургалт явуулах мэргэжлийн нэгж, сургалтын хөтөлбөртэй байна. Сургалт явуулах журмыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга батална. Албадлагын арга хэмжээ авагдсан хүний зан үйлд нөлөөлөх сургалтыг зөвшөөрөл бүхий төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно²⁵. Хоригдлыг эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, ур чадвар, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах болон хүсэл, сонирхолд нь үндэслэн эерэг зан үйлд төлөвшүүлэх бусад хэлбэрээр нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулна²⁶.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь баривчлах байр болон хорих анги дах албадан сургалтыг зохион байгуулж байна. Шүүхийн шийдвэрийн дагуу зан үйл засах, нөлөөлөх сургалтыг зохион байгуулж гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг төлөвшүүлэх, нийгэмшүүлэх, эерэг зан үйлийг өөртөө дадал болгоход дэмжлэг үзүүлэх сургалтыг хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлж байна. Албадан сургалт нь зан үйл засах, зан үйлд нөлөөлөх гэсэн хоёр өөр агуулгаар эрүүгийн хууль болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд томъёологдсон байна. Сургалт нь хүний зан үйлийг засахаас илүүтэй зан үйлд нөлөөлөх гэсэн агуулгаар байх нь оновчтой юм. Хорих ангид явагдах албадан сургалтын хувьд хөтөлбөр бүрэн агуулгаараа хэрэгжих, үр дүн нь ч түүнээс шалтгаалж гарч байгаа бол баривчлагдах 7-30 хоногийн хугацаанд хөтөлбөрийн агуулгыг бүрэн өгч багтахгүй байх асуудал гардаг.

Дээрх хуулиудаас гадна албадан сургалт батлагдсан хөтөлбөрийн дагуу явагддаг. Уг хөтөлбөрт баривчлах байрны дотоод журамд зааснаар баривчлах төв байр нь сургалтын танхимтай байх бөгөөд шүүхийн шийтгэвэрт заасан хугацаагаар албадан сургалтад хамруулна, сургалт нь баривчлагдсан хүний зан үйлд нөлөөлөх, зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх бөгөөд хөтөлбөрийн дагуу явагдана, сургалтыг төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болохоор заасан. Зан үйлд нөлөөлөх сургалт нь сэтгэл зүй, эрх зүйн болон бясалгалын гэсэн төрөлтэй²⁷ байна. Сэтгэл зүйн сургалт:

- Архинд донтолт болон түүний хор уршгийн талаар;
- Хүчирхийлэл үйлдэх зан үйлийг хэрхэн зохицуулах;

²⁵ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (2017) 189 дугаар зүйл

²⁶ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (2017) 219 дугаар зүйлийн 219.1

²⁷ Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын “хөтөлбөр батлах тухай” 2017.04.04 А/73 тушаалын нэгдүгээр хавсралт “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр” 8.1

- Уур бухимдлыг хэрхэн зохицуулах, стрессийг даван туулах;
- Харилцах ур чадвараа дээшлүүлэх;
- Бэлгийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх;
- Өөрийн үнэлэмжийг дээшлүүлэх;
- Хүчирхийллээс үүдэх хүүхдийн сэтгэл зүйн асуудал сөрөг үр дагавар;
- Гэр бүлийн сэтгэл зүйг төлөвшүүлэх чиглэлээр байна.

Эрх зүйн сургалтыг Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор явуулах бол бясалгалын сургалтыг эрх бүхий байгууллагын даргын тушаалаар баталсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулж явуулна гэж заасан. Тухайн оролцогчийн зан үйлийн өөрчлөлтөд тохирсон сэтгэл зүйн сургалтыг эрх зүйн сургалттай хослуулан явуулна. Оролцогчийн хувийн байдал, үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийн шинжийг харгалзан тэдний сэтгэл зүйн онцлогт тохирсон хэд хэдэн сургалтыг хослуулан явуулж сургалтыг хослуулан явуулахдаа төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран гүйцэтгэж болох зохицуулалтай.

Эрүүгийн хуульд зааснаар ялын зорилгыг хангахад шаардлагатай гэж үзвэл оногдуулсан ял дээр нэмж албадлагын арга хэмжээ авч болно²⁸, шүүхээс зан үйлээ засах сургалтад хамрагдах үүргийг хүлээлгэж²⁹ болохоор, Зөрчлийн тухай хуульд албадан сургалтад хамрагдах албадлагыг баривчлахтай шийтгэлтэй хамт ногдуулахаар заасан хэдий ч зан үйлд нь нөлөөлөх эсхүл зан үйлийг нь засах сургалт байх уу гэдэг дээр тодорхой зохицуулалт байхгүй байна.

IV. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛ ҮЙЛДСЭН ЭТГЭЭДЭД ХҮЛЭЭЛГЭХ АЛБАДАН СУРГАЛТЫН ОНЦЛОГ

Албадан сургалт нь хууль зүйн хариуцлагын нэг төрөл болохынхоо хувьд урьдчилан сэргийлэх, хүмүүжлийн нөлөө үзүүлэх, эерэг зан үйл төлөвшүүлэх чиг үүрэгтэй. Эдгээр чиг үүрэг хангагдснаар нийгэмд дэг журам, шударга ёс тогтож гэмт хэрэг, зөрчил буурахад нөлөө үзүүлэх ач холбогдолтой.

Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулиар албадан сургалтыг албадлагын арга хэмжээнд хамаарахаар зааж үндсэн ял шийтгэлтэй хамт хэрэглэж болдог онцлогтой хариуцлагын хэм хэмжээний нэг төрөл байхаар хуульчилсан. Мөн албадан сургалт нь эрх зүй, сэтгэл зүй, бясалгалын төрөлтэй байгаа нь хууль зүй, сэтгэл судлалын салбарт аль алинд хамаардаг онцлогтойг харуулж байна. Энэ нь ял, шийтгэл хүний бие махбодид нөлөөлөхөөс илүү сэтгэл

²⁸ Эрүүгийн хууль (2015) 7.2 дугаар зүйлийн 7.2.1

²⁹ Эрүүгийн хууль (2015) 7.3 дугаар зүйл 7.3.2.2

санаанд нөлөөлөх замаар засан хүмүүжүүлэх, дахин гэмт хэрэг, зөрчлийг үйлдэхээс нь урьдчилан сэргийлэх зорилготой салшгүй холбоотой юм.

Хүснэгт 1. Сүүлийн 4 жилд баривчлах шийтгэл хүлээсэн этгээдийн тоо

№	2020	2021	2022	2023
Нийслэл ³⁰	8400	7234	9766	8274
Орон нутаг ³¹	8491	8043	9766	10284
Нийт	16891	15277	18931	18558

Сүүлийн 4 жилийн хугацаанд зөрчил гаргасны улмаас баривчлах шийтгэл хүлээсэн этгээдүүдийн тоо төдийлэн буурахгүй байгаа нь судалгаанаас харагдаж байна. 2024 оны 8 дугаар байдлаар баривчлах төвд шүүгчийн шийтгэврээр 3069 хүн хүлээн авснаас 137 нь 2 удаа, 23 нь 3 удаа, 4 нь 4 дэх удаа, 1 этгээд 5 дах удаагийн давтамжтайгаар шийтгэл хүлээсэн байна. Мөн баривчлагдсан хүмүүсийн үйлдсэн зөрчлийн 75 хувь орчим нь гэр бүлийн хүчирхийлэл, 15 орчим хувь нь тээврийн хэрэгсэл согтуугаар жолоодох, 10 орчим хувь нь танхайрах, бэлгийн дарамт учруулах, хүүхдийн эрх зөрчих, мансуурах зөрчил эзэлж байна³². Үүнээс харахад 2 төрлийн зөрчил 90 хувийг эзэлж байна. Энэ нь нийгэмд хамгийн их ямар асуудал тулгамдсан байгааг харуулахыг зэрэгцээ, бууруулах ямар арга зам байж болохыг тодорхойлох нь чухал болохыг илтгэж байна. Гэмт хэрэг, зөрчил үйлдсний дараа зан үйлд нөлөөлөх сургалтыг хийж буй одоогийн зохицуулалт зөрчлийн хуулийн шийтгэл нь хүн, хуулийн этгээдийн зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, зөрчил үйлдсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх, шударга ёсыг тогтооход оршино³³ гэж заасантай нийцэхгүй байна.

Хамгийн түгээмэл үйлдэгдэг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан сайн дурын сургалтын хэрэгжихгүй байгаа шалтгаан нь сайн дурын нэртэй албадлага байж болохгүй, хариуцлага хүлээлгээгүй, гэм бурууг эрх бүхий албан тушаалтан, байгууллага тогтоогоогүй байхад зан үйлд нөлөөлөх сургалтыг хийж болохгүй байгаатай холбоотой юм. Иймд нэршлийн хувьд сайн дурын, албадан гэж нэрлэсэн зохицуулалтыг цаашид хэрэгжилт болон хүнд нөлөөлөх, тусах байдал, үр нөлөө, зорилгыг нь харгалзан зан үйлд нөлөөлөх сургалт гэж нэрлэх нь тохиромжтой байж болох юм.

Зөрчлийн тухай хуулиар баривчлах шийтгэл ногдуулахаар заасан 12 төрлийн үйлдэл дээр 7-30 хоногийн хугацаатай байхаар заасны олон нийтийн газарт биеэ зүй бусаар авч явах, танхайрах, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эрхийг зөрчих, бэлгийн дарамт учруулах, хулгайлах, хөрөнгө завших гэсэн

³⁰ <https://police.gov.mn/resource/information/File/2024/01/09/wa372k16jif1t0lj/Зөрчил.pdf> Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн зөрчил, түүний шийдвэрлэлтийн байдал судалгааны статистик 2020-2023

³¹ <https://police.gov.mn/resource/information/File/2024/01/09/wa372k16jif1t0lj/Зөрчил.pdf> Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн зөрчил, түүний шийдвэрлэлтийн байдал судалгааны статистик 2020-2023


³² Д.Чинзориг “Баривчлах шийтгэл гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт” докторын зэрэг горилсон судалгааны ажил 2024 он х. 4

³³ Зөрчлийн тухай хууль (2017) 3 дугаар зүйлийн 3.1.1

7 зөрчил дээр албадан сургалтад хамруулахаар шууд заасан байна. Зарим зөрчлийн үйлдэл дээр сонголтгүй албадан сургалтад хамрагдах, баривчлах шийтгэл хүлээлгэхээр заасан. Үүнд:

- Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон, хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан, бусадтай харилцахыг хязгаарласан, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна³⁴.
- Ахмад настны тэтгэвэр, тэтгэмжээ ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна³⁵.
- Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг албадан сургалтад хамруулж долоо хоногоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна³⁶ гэсэн 3 зөрчлийн үйлдэл дээр сонгох хариуцлагагүй байхаар заасан байна. Эдгээр зөрчил хүнд зөрчилд хамаарахаар хуульчилсан гэж ойлгож болно. Учир нь баривчлах шийтгэл нь үндсэн шийтгэлийн зэрэгцээ хүнд шийтгэлийн нэг юм. Гэтэл эдгээрээс хүнд хор аюул учруулах боломжтой зөрчлийн үйлдлүүд дээр сонгох хариуцлагатай, бага хэмжээний торгох шийтгэл хүлээлгэхээр заасан нь хууль тогтоогчийн зүгээс зайлшгүй эргэх харах хэрэгтэй зохицуулалт гэж үзэж байна.

Зөрчлийн тухай хуулиар баривчлах шийтгэл хүлээлгэхээр заасан үйлдлүүд дээр сонгох санкци нь зуун нэгж байхаар заасан 3, 400-1000 нэгж байхаар заасан 6 төрлийн зөрчил байгаа нь хүнд шийтгэлийг бага хэмжээний мөнгөн торгох шийтгэлтэй адилтган хариуцлага хүлээлгэх буй зохицуулалт нь шийтгэлийн зорилго, урьдчилан сэргийлэх, ялгаварлан гадуурхахгүй байх, шударга ёсны зарчимтай нийцэхгүй байна.



³⁴ Зөрчлийн тухай хууль (2017) 5.4 дүгээр зүйл Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих 5.4.4.1-5.4.4.4

³⁵ Зөрчлийн тухай хууль (2017) 5.4 дүгээр зүйл Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих 5.4.4.5 энэ заалтыг 2024 оны 06 дугаар сарын 05ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулж тухайн өдрөөс эхэлж хүчин төгөлдөр болсон.

³⁶ Зөрчлийн тухай хууль (2017) 8.6 дүгээр зүйл Хулгайлах 8.6.1

Хүснэгт 2. Сүүлийн 5 жил байдлаар албадан сургалтад хамруулахаар заасан гэмт, хэрэг зөрчлийн тоон судалгаа

№	2019	2020	2021	2022	2023
Гэр бүлийн хүчирхийлэл ³⁷	210	101	99	97	99
Хулгайлах ³⁸	1671	1614	4579	1598	6077
Авто тээврийн хэрэгсэл хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг зөрчих ³⁹	1138	1030	915	1074	1084
Хүүхдийн эсрэг гэмт хэрэг ⁴⁰	31	17	31	54	68
Хөрөнгө завших ⁴¹	601	398	348	613	678
Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг ⁴²	4371	4855	4842	3894	2999
Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ ⁴³	124		63	96	119

Шүүхээс гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг шийдвэрлэсэн тоо их биш хэдий ч энэ төрлийн зөрчил 2019 онд 8548, 2020 онд 10306, 2021 онд 10319, 2022 онд 10094, 2023 онд 10319, 2024 оны 9 сарын байдлаар 7173⁴⁴ бүртгэгдсэн нь буурахгүй өсөх хандлагатай, ихэнх нь Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээж байгааг харуулж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хоригдох хугацаанд албадан сургалтад хамруулдаг нь байнга гэх үйлдэлтэй нь холбоотой юм.

Хулгайлах, автотээврийн хэрэгсэл хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, хөрөнгө завших зөрчил сүүлийн жилүүдэд нэмэгдэж байна. Ялангуяа зөрчлийн ихэнхийг авто тээврийн хэрэгсэл хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг зөрчих журам зөрчих зөрчил эзэлж буй нь энэ төрлийн зөрчилд албадан сургалт явуулах, согтуурах явдалтай тэмцэх нэн шаардлагатай асуудал одоо ч хэвээрээ байгааг харуулж буй юм. Хулгайлах, хөрөнгө завших үйлдэл нь хүний шунахайрах сэдэл, хэвшмэл дадалтай холбоотой учраас торгох шийтгэл ногдуулсан зөрчлүүд дээр ч гэсэн зан үйлд нөлөөлөх сургалтад хамруулах нь дахин үйлдлээ давтахаас сэргийлэхэд ач холбогдолтой. Иймд зөвхөн гэр бүлийн хүчирхийлэл дээр ч бус бусад төрлийн их гарч буй зөрчлүүд дээр зан үйлд

³⁷ https://www.judcouncil.mn/site/news_full/13967 Монгол Улсын шүүхийн тайлан 2019-2023 оны тайлангаас ава^a

³⁸ Монгол Улсын шүүхийн тайлан 2019-2023 оны тайлангаас ав^{aa}

³⁹ Монгол Улсын шүүхийн тайлан 2019-2023 оны тайлангаас ав^{aa}

⁴⁰ <https://police.gov.mn/resource/information/File/2024/01/09/qqy06rolmg3zjca/Хэрэг.pdf> цагдаагийн байгууллагын хэмжээнд 2023 онд бүртгэгдсэн гэмт хэрэг статистик мэдээлээс авав.

⁴¹ <https://police.gov.mn/resource/information/File/2024/01/09/qqy06rolmg3zjca/Хэрэг.pdf> цагдаагийн байгууллагын хэмжээнд 2023 онд бүртгэгдсэн гэмт хэрэг статистик мэдээлээс ав^a

⁴² <https://downloads.1212.mn/Crime%202023.pdf>

⁴³ https://www.judcouncil.mn/site/news_full/13967

⁴⁴ Статистикийн мэдээллийн нэгдсэн сан 2018-2024 оны 09 сар хүртэл бүртгэгдсэн зөрчлийн мэдээлэл

нөлөөлөх сургалтад хамрагдах зохицуулалтыг бий болгох боломжтой юм.

Хүүхдийн эсрэг гэмт хэрэг судалгаанаас харахад анхаарал татахаар их шүүхээр шийдвэрлэгдээгүй хэдий ч гэр бүлийн хүчирхийллийн зөрчил, гэмт хэргийн хохирогчид хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настнууд байдаг гэдгийг мартаж үл болно. Мөн хүүхэд өөрийнх эсрэг гэмт хэрэг үйлдсэн ч хаана хэнд хэлэхээ мэдэхгүй байх, хандахгүй нуух тохиолдол их байдаг тул тоон судалгаа нь гарч буй бүх гэмт хэрэг, зөрчлийг илэрхийлэхгүй гэдгийг санах зүйтэй юм.

V. ДҮГНЭЛТ, САНАЛ

Эрт үеэс эхлэн улсууд зөв зан үйл нь зөвийн талаарх ухаарсан мэдлэгээс шалтгаална, гэмт хэрэг, зөрчил нь гэгээрлийн ажил хангалттай сайн явуулж чадаагүй буюу хүүхэд, залуусын хүмүүжлийн ажлын доголдолтой холбоотой, аливаа үйлийн зөв бурууг ялган тайлбарлаж чадсан тохиолдолд тухайн хүн буруу үйлдэл хийж, гэмт явдалд татагдан орох магадлал буурна гэж үздэг байсан нь зан үйлд нөлөөлөх сургалтын чухлыг баталж буй юм. Монгол Улс түүхэн уламжлалын хувьд эртнээс одоогийн баривчлах шийтгэлийг ногдуулан засан хүмүүжүүлэх арга хэмжээг авч нам, улс, олон нийт, үйлдвэрийн газар, соён гэгээрүүлэх байгууллага, хөдөлмөрийн хамт олон, иргэн нэг бүрийн зорилт, нэр төрийн хэрэг гэж үзэж байсан нь нийтээрээ ач холбогдол өгч байсныг харуулж байна.

Хууль зүйн хариуцлагын нэг төрөл болох албадан сургалт нь гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийн баривчлагдсан, хоригдсон байх хугацаанд нь ял, шийтгэлтэй хамт хэрэгждэг онцлогтой. Энэ нь үйлдсэн гэмт хэрэг, зөрчлөөс шалтгаалан давтан үйлдэхгүй байхад нөлөөлөх, хүмүүжүүлэх, зан үйлийг нь засах зорилготой салшгүй холбоотой юм. Одоогийн хуульд байгаа албадан сургалтад хамрагдахаар заасан зохицуулалтуудын ихэнх нь албадан сургалт байхаар заасан ба гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд л сайн дурын хэлбэртэй байхаар байгаа боловч хэрэгжилт тодорхойгүй байна. Бусад албадлагын төрөлтэй харьцуулахад үр дүн нь зан үйлд нь нөлөөлөх замаар гэмт хэрэг, зөрчлөө давтан үйлдэхгүй байх ухамсар, дадлыг өөртөө бий болгоход чиглэгдгээрээ онцлог юм.

Албадан сургалтад хамруулах баривчлах шийтгэл нь зарим төрлийн зөрчлийн үйлдэлд сонголтгүй эсхүл торгох шийтгэл нь хэт бага байхаар хуульчлагдсан нь хуулийг хэрэглэх буй албан тушаалтанд ялгамжтай байдлаар хэрэглэх боломжийг олгох, хариуцлага хүлээж буй хүнд ч шударга бус, тохиромжтой биш байна. Тухайлбал Зөрчлийн тухай хуульд заасан гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, хулгайлах зөрчил дээр зөвхөн баривчлах шийтгэл байгааг хууль тогтоогчийн зүгээс анхаарч сонгох санкцитай болгох шаардлагатай байна.

Зөрчлийн тухай хуульд заасан олон нийтийн газарт биеэ зүй бусаар авч явах, танхайрах, хүүхдийн эрх зөрчих гэсэн зөрчлүүд дээр сонгох санкци нь зуун нэгж байхаар заасан байгааг цаашид баривчлагдах 7-30 хоногтой дүйцэх хэмжээний болгон нэмэгдүүлэн өөрчлөх нь зүйтэй юм. Ингэснээр хариуцлага шударга, тэгш, ялгаварлан гадуурхахгүй байх суурь зарчимтай нийцэх юм.

Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд гэр бүлийн харилцаанд хүйсийн шинжээр шууд ялгаварлан гадуурхсан этгээдийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу зохион байгуулдаг зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулж болно гэж заасан ба Зөрчлийн тухай хуульд хариуцлага хүлээлгэхээр заасан бүрэлдхүүнд уг агуулга хамаарахааргүй байгаа нь хууль хоорондын уялдаа холбоог хангах шаардлагатайг харуулж байна.

Албадан сургалтыг баривчлагдсан, хоригдсон байх хугацаанд шүүхийн шийдвэрээр хийж буй учир сайн дурын байх боломжгүй, шийдвэргүйгээр сургалтад хамруулах асуудал яригдахгүй тул сайн дурын сургалт хэрэгжихгүй байна. Иймд хэрэгжилтийг хангах үүднээс сайн дурын сургалтаа зан үйлд нөлөөлөх сургалт гэж нэрлэн зан үйлийн хувьд давтан үйлдэх эрсдэлтэй торгох шийтгэлийг оногдуулсан этгээдэд дахин үйлдэхээс нь сэргийлэх зорилгоор уг сургалтыг явуулах боломжийг бүрдүүлэх эрх зүйн зохицуулалт хийх нь зүйтэй байна.

VI. НОМ ЗҮЙ:

Эх сурвалж:

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992
2. Эрүүгийн хууль 2015
3. Зөрчлийн тухай хууль 2017
4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 2016
5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль 2011
6. Хүүхэд хамгааллын тухай хууль 2016
7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017
8. Цагдан сэргийлэхийн эрх хэмжээний дүрэм 1923
9. Цагдан цээрлүүлснийг зөрснийг яллах хууль 1923
10. Монгол Улсын Их хурлын тогтоол “Алсын хараа 2050” 2020
11. Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын “хөтөлбөр батлах тухай” А/73 тушаалын нэгдүгээр хавсралт “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр” 2017

Монгол эх сурвалж:

1. Ж.Долгорсүрэн. “Захиргааны хариуцлага” УБ 1998
2. Ч.Нямсүрэн “Эрх зүйн ерөнхий онол” 2017
3. Т. Азжаргал, Т. Хууль зүйн хариуцлага. УБ., 2023
4. Монгол Улсын Шинжлэх ухааны академийн “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар
5. Д.Чинзориг “Баривчлах шийтгэл гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт” докторын зэрэг горилсон судалгааны ажил 2024
6. Монгол Улсын шүүхийн тайлан 2019-2023
7. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан 2018-2024 оны 09 сар хүртэл бүртгэгдсэн зөрчлийн мэдээлэл
8. Цагдаагийн ерөнхий газар мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба цагдаагийн байгууллагын хэмжээнд 2021 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал 2021
9. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчлийн хэргийн эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийн төлөв байдлыг судлах судалгааны тайлан 2021
10. https://www.judcouncil.mn/site/news_full/13967
11. <https://police.gov.mn/resource/information/File/2024/01/09/wa372k16jif1t0lj/Зөрчил.pdf> Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн зөрчил, түүний шийдвэрлэлтийн байдал судалгааны статистик 2020-2023





ФЕРНАНДА ПИРИЕ., ЭРХ ЗҮЙН АНТРОПОЛОГИИ FERNANDA PIRIE, THE ANTHROPOLOGY OF LAW, 2012

ЛЕГАЛИЗМ

Легализм нь бусад утга агуулгын тайлбарын схемтэй харьцуулахад сэтгэлгээний хандлага бөгөөд биеэ авч явах арга хэлбэр гэдгээрээ хууль зүйн хувьд бусдаас ялгарах онцлогтой. Энэ нь аль хэдийн яригдсан олон жишээнүүдээс тодорхой харагдаж байна, жишээлбэл, эртний Грек, Англо-Саксончуудын боловсруулсан хууль зүйн кодекс ба хуулийн нарийн түвэгтэй байдал, өөрийн ухамсартайгаар эрудит хэлбэрийг бий болгох хандлагатай байдаг хууль ёсны хуулийн хэлбэрүүдийг үүнд авч үзэж болох юм. Дэлхий ертөнцийн хууль ёсны хандлага нь хүний зан үйлийг дүрэм, ангилал, ерөнхий байдлаар тайлбарлаж, зааж өгдөг. Ил тод дүрмүүд нь эерэг, сөрөг аль алинд нь тодорхой зан авирын шийтгэл, нөхөн төлбөр, бусад үр дагаврыг тодорхойлж, зөвшөөрч болно - хэн нэгэн ийм байдлаар хандсан эсэхээс үл хамааран дэлхий ертөнц ямар байх ёстойг ийнхүү тогтоодог. Ромын хууль, Английн нийтлэг хуулийн шүүхэд хандах зөвшөөрөл нь мөн хууль ёсны шинж чанартай байсан: тэдгээрт хууль зүйн арга хэмжээ авах тодорхой нэр томъёог тодорхойлсон бөгөөд энэ нь ангилал, холболт, үл хамаарах зүйлийн талаар маргаан үүсгэж, жишиг, зүйрлэл болон бусад мэргэшсэн хэлбэрийг ашиглахад хүргэсэн юм. Илүү энгийнээр хэлэхэд, хууль ёсны сэтгэлгээ нь баримт ба хууль, эсхүл 'байгаа' ба 'байх ёстой' гэснийг хооронд нь ялгаж салгадаг бөгөөд энэ нь маргааны хэрэгт хариулт өгч, дүрэм, журамд нийцсэн, тухайн хэргийн бодит байдлаас давсан шүүхийн шийдвэр гаргах өвөрмөц хэлбэрт тохирдог байна. Энэ бүлэгт хууль ёсны сэтгэлгээ үүсдэг шүүх дээр, хуульч, захирагчдын гарт болон шашны эрдэмтдийн үзэг дор гэх зэрэг өөр өөр нөхцөл байдлын талаар авч үзэх болно.

ХУУЛЬ БА ЁС ЗАНШИЛ

Антропологид нийгмийн ерөнхий хэм хэмжээ эсхүл зөрчилдөөнийг шийдвэрлэх үйл явцыг судлахдаа легализмд анхаарлаа төдийлөн хандуулдаггүй байв.² Гэсэн ч хууль ба зан заншлын хоорондох ялгааны талаарх тэдний хэлэлцүүлгийн явцад бид хуулийн энэ талын зарим онцлог шинж чанарыг анзаарч харсан юм. Пол Боханнан (1965) нь хуулийн онцлог

¹ Монголын Кримнологичдын холбооноос санаачлан Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс, МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Археологи, антропологийн тэнхим, Монголын Антропологийн холбоо нарын хамтран хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд "Fernanda Pirie, The Anthropology of Law, Clarendon Law Series, Oxford university press, 2013" хэмээх номын орчуулгыг цувралаар хүргэж байна. Энэхүү номыг дараах холбоосоор орж үзнэ үү. https://books.google.mn/books?id=SbbDAQAAQBAJ&printsec=frontcover&source=gbv_summary_r&cad=0#v=onepage&q&f=false (Сүүлд үзсэн огноо: 2022.10.31)

² Энэ бүлгийн эхний хэсгүүдэд орсон олон санаа, жишээн дээр би Пол Дрешд өртэй юм.

шинж чанарыг судлахын тулд маргаан шийдвэрлэх байгууллагуудад хандсан бөгөөд «хуулийг хууль зүйн байгууллагуудын үйл ажиллагаанд нийцүүлэх зорилгоор өөрчлөн найруулсан зан заншил гэж үзэж болно» гэсэн дүгнэлтэд хүржээ (1965:36). Тэрээр ёс заншлыг шүүхээр шийдвэрлэдэг болгохын тулд 'давхар институцчилсэн' байх ёстой гэж үзэж байв: «хуулийг нийгмийн төлөөлөгчид нарийн, танигдахуйц хүрээнд тусгайлан бүтээдэг, өөрөөр хэлбэл, хууль ёсны шинж чанартай, зарим талаараа бусдаас ялгарсан институцийн хүрээнд бүтээдэг» (1965: 34). Хууль-нийгмийн онолч Денис Галлиган шүүхийн шийдвэр гаргах ажиллагааны ижил төстэй загварыг санал болгосон юм: үндэслэлтэй, хэвийнд тооцогдох зан байдал нь тухайн хүн, тухайн нөхцөл байдалд хэрхэн биеэ авч явах талаар шийдвэр гаргах үндэс суурь болдог. Нийгэм улам бүр түвэгтэй болохын хэрээр үндэслэлтэй гэсэн ойлголтыг ийм шийдвэр гаргах үндэс суурь болгохын тулд нэгдмэл дүрмээр орлуулах шаардлагатай юм (2007: 70–75). Энэхүү 'институцчилал' болон бүгдэд ижил, тодорхой дүрмийг бий болгох нь легализмын шинж чанар юм.

Тус загварууд нь зан заншил эсхүл үндэслэлтэй гэсэн зүйлийн талаарх ойлголт болон хуулийн дүрэм хооронд харьцангуй жигд шилжилтийг буюу нарийн түвэгтэй нийгэмд шийдвэр гаргах асуудлуудтай нүүр тулж буй шүүхийн байгууллагуудаар хийгддэг шилжилтийг авч үздэг. Боханнаны онолын асуудлыг авч үзээд Стэнли Даймонд (1973) нь хууль ба зан заншил нь хоорондоо илүү их ялгаатай талаар нотолгоо гаргаж ирсэн юм. Түүх, антропологийн хэд хэдэн жишээг судалж үзээд тэрээр хуулиуд нь эхний шатандаа 'хууль нь ердийн дэг журмын эсрэг' гарч ирдэг ... тэд нийгэм дэх шинэ, гэнэтийн эрх мэдлээр хэрэгжүүлж буй нийгмийн зорилтуудын шинэ багцыг төлөөлдөг' гэсэн дүгнэлтэд хүрчээ (1973: 327). Улс орнууд өргөжин тэлэхийн хэрээр ажиллах хүч авах, арми нэмэгдүүлэх, татвар авах, хүнд суртлыг дэмжих, хүн амаа хянах хэрэгцээ шаардлага бий болсон үед хууль боловсруулагддаг гэж тэрээр хэлсэн байдаг (1973: 332). Робертсын (2005) нэгэн адил тэрээр хууль тогтоомжийн хөгжлийг засгийн газрын өсөлттэй нягт холбож үздэг. Ийм нөхцөлд улс хууль батлах явдал нь ёс заншил, дадал хэвшлийн хагарлыг илтгэдэг байна. Гирцын (1983: 217) тэмдэглэснээр хууль нь ёс суртахууны болон нийгмийн хэм хэмжээг ерөнхийд нь дагаж мөрдсөний үндсэн дээр бий болдоггүй: ерөнхийдөө зөвшилцөлд хүрээгүй эсхүл шинэ, маргаантай байж болзошгүй нийгмийн практикийн хэлбэрийг хөнгөвчлөхөд илүү хэрэгтэй байдаг байна. Гэсэн хэдий ч, өмнөх бүлгүүдэд авч үзсэнчлэн, эрх зүйн сэтгэлгээний үүсэл, хууль зүйн боловсруулалтыг эрдэмтдийн хийсэн бүтээлтэй, мөн төр улс үүсч хөгжсөнтэй холбон үзэж болох бөгөөд зарим тохиолдолд зан заншлыг бичин тэмдэглэх, зохицуулах ерөнхий оролдлого хийгдсэн байх магадлалтай юм. Даймондын дүн шинжилгээгээр хуулийн цөөн хэдэн жишээг тайлбарлах боломжтой мэт харагдаж байна.

Иймд хууль нь ёс заншлаас үүсч болох ч энэ нь мөн захирагчийн амбицыг илэрхийлэх, эсхүл нийгмийн практикийн шинэ хэлбэрийг дэмжих, шашны

үзэл санааг илэрхийлж ч болох юм. Үүний сэдэв болон гарал үүсэл нь төдийлөн их зүйлийг тайлбарлаагүй юм. Үүний оронд бид легализмыг нийгмийн сэтгэлгээний тодорхой хэлбэр гэж ойлгох хэрэгтэй.

ШҮҮХИЙН ХҮРЭЭН ДЭХ ЛЕГАЛИЗМ

Антропологич Ллойд Фоллерс (1969) Басога буюу одоогийн Уганда улсын талаар нарийвчилсан судалгаа хийхдээ өөрийн шүүхийн 'легализм' гэж тодорхойлсон зүйлийн талаар авч үзсэн юм. Басога нь 70 гаруй жилийн турш колоничлолын дор амьдарч байсан бөгөөд тэдний шүүх үйл ажиллагаа нь мөн колонийн загвараар явдаг нь дамжиггүй юм. Гэсэн хэдий ч тэдэнд тодорхой хууль тогтоомж, шүүхэд хандах зөвшөөрөл, дэг журам гэж байгаагүй. Үүний оронд нэхэмжлэгч, шүүгч талууд түүний 'үзэл баримтлалын ангилал' гэж нэрлэдэг зүйлийг, ихэвчлэн гэрлэсэн хосуудын зөв зохистой зан байдал, эсхүл зохисгүй зан байдлын талаар, мөн гэрлэлтийг юу тодорхойлдог талаар аман байдлаар хэлэлцдэг байв. Өөрт нь зохисгүй хандсан эхнэр Согагийн хуулийн дагуу шийдвэр гаргуулан авсан ч тэрээр эцгээ 'хоргодох' хэргээр яллахгүйгээр гэр бүлдээ эргэж очих боломжгүй байв. Энэ тохиолдолд нөхөр нь сүйт бүсгүй авахад төлсөн мөнгөө буцаан авахыг шаардаж байгаа эсэхийг шүүх хэлэлцэх ёстой бөгөөд энэ нь гэрлэлтээ цуцалж, эцгийгээ яллахаас чөлөөлнө гэсэн үг юм. Оргонуулах ангиллууд, сүйт бүсгүйн үнэ, төрөл төрөгсдийн янз бүрийн нэр томъёо нь шүүхэд хэргийг хянан шийдвэрлэх хэрэгсэл болж, хуулийн шинж чанар болох 'ангиллын хөдөлгөөнт тогтолцоог' бий болгох асуудлыг хүрээг нарийсгадаг хэмээн Фоллерс тайлбарласан байдаг. Шүүх нь 'шийдвэр гаргахад шаардлагатай асуудлуудыг нарийсгаж, хүрээгээ нэгтгэсэн ойлголтуудыг хууль ёсны дагуу ангилж өгдөг' (1969: 20–21). Хүлээн зөвшөөрөгдсөн шалтгаанаар хэргийг шүүхэд шилжүүлсний дараа шүүгчид шүүгчид энэ хэсгийн хувьд тийм эсхүл үгүй гэсэн хариултыг олоход анхаарлаа төвлөрүүлсэн юм (1969: 28).

Фоллерсын үзэж байгаагаар ёс суртахууны хувьд хоёрдмол утгатай шийдвэр гаргахад дүрэм журам шаардлагатай байдаг байна. Нийгмийн хяналтын хууль ёсны хэлбэр нь хүний зан үйлийн үнэ цэнийг тодорхой тохиолдолд, тодорхой дүрмийг зөрчсөн эсэхийг эрх бүхий байгууллагаар тогтооход хангалттай нарийвчлалтай, ойлгомжтой норматив мэдэгдэл болгон бууруулахыг шаарддаг гэсэн Хартын (1961) үзэл санааг тэрээр дагажээ (1959: 17–22).³ Нөгөөтэйгүүр, хэрэв шүүхүүд хууль зүйн ойлголтыг ашигладаггүй бол шүүгчид хүн хоорондын зөрчилдөөний аливаа нөхцөл байдалд байгаа ёс суртахууны хоёрдмол утгатай олон тооны буруутгал, эсрэг нэхэмжлэлтэй тулгардаг. Антропологийн үүднээс тайлбарлахын тулд тэрээр хэлэхдээ, ангилал нь зөрчих гэсэн утгатай бөгөөд хууль зүйн ойлголт нь тодорхойлолтыг зөрчсөн; дараа нь энэ асуудлыг оруулах эсхүл хасах гэсэн өнцгөөс шийдэх

³ Үүнд тэрээр Левайгийн (1948) "Хууль зүйн үндэслэлийн тухай"-тай санал нэгджээ.

боломжтой юм гэсэн байна (1969: 32). Бордюгийн (1987: 820) тэмдэглэсэнээр, хууль нь хувийн ашиг сонирхлын эвлэршгүй зөрчилдөөнийг дүрмийн дагуу оновчтой аргументын солилцоо болгон хувиргадаг байна.

Хууль зүйн тогтолцоо, өдөр тутмын ёс суртахууны тогтолцоо нь ижил үйл явдлын талаар өөр өөр дүгнэлт гаргаж болох бөгөөд энэ нь хууль ба түгээмэл ёс суртахууны хооронд зөрчилдөөн үүсэхэд хүргэдэг. Фоллерсийн үзэж байгаагаар, энэ нь нэг юмуу хоёуланг нь өөрчлөхөд хүргэж болох боловч энэ нь үзэл санааны логик ба нийгэм дэх нийгмийн харилцааны нарийн түвэгтэй байдлын хооронд илүү ерөнхий, нарийн түвэгтэй харилцан үйлчлэлийг тусгасан байдаг байна: алийг нь ч нөгөөгөөр нь орлуулах боломжгүй юм (1969: 14-15). Басогагийн хувьд талууд нарийн хууль ёсны болон ёс суртахууны нэгдмэл байдлын давуу талыг эрэлхийлж байгаа нь сайн хэрэг байсан эсэхээс хамааран хууль ёсны болон ёс суртахууны хувьд маргах хандлагатай байгаа нь тодорхой байв. Үүнтэй ижил хандлага бусад туршилтуудад тэмдэглэгдсэн байдаг: Цицеро нь хэргийн ач холбогдол нь үйлчлүүлэгчийнхээ эсрэг байхад pro Caecina-г өмгөөлөхдөө хууль ёсны өндөр үндэслэлтэй аргууд гаргаж байв (Фрайер, 1985). Эртний Грекийн хүн амины гэмт хэргийн шүүх, далай тэнгисийн хэргүүдэд шүүх ажиллагаа нь хийсвэр, стандарт дүрмийг тогтмол ашигладаг байсан бол алдартай шүүхүүдэд 'хууль бус аргууд' нь шүүхийн бүрэлдэхүүнд шударга шийдвэр гаргахад туслах зорилгоор маргааны нөхцөл байдлын талаар мэдээлэл өгч, тухайн хэргийн онцгой нөхцөл байдлыг харгалзан үздэг байна (Лаани, 2005). Дундад зууны үед Английн орон нутгийн шүүхүүд хууль тогтоомжийг ашиглахаас илүүтэйгээр өмч хөрөнгийн талаар давж заалдах хүсэлтийг дэмжиж байв (Бонфилд, 1989). Нөгөөтэйгүүр, Балинезын тосгоны зохион байгуулалт нь үнэхээр хууль ёсны байсан юм: тосгоны оршин суугчид цөллөгийн үед биеэ авч явах тодорхой дүрмийг дагаж мөрдөх ёстой гэсэн санаагаа тууштай баримталдаг байсан ч цөлөгдөж магадгүй гэсэн сүрдүүлгээр, хүнд хэцүү байдалд байгаа хувь хүний хувьд өрөвдсөн байж магадгүй юм. (Гиртз, 1983: 186). Дүрэм болон ангилал нь нийгмийн харилцааг өөрчилдөг, өөрөөр хэлбэл тодорхой, бодитой стандартын дагуу, тэр ч байтугай легализмын ийм орон нутгийн шинжтэй, харьцангуй энгийн тохиолдлуудад дүрмүүд нь олон нийтийн эрх мэдэл, түүний дотор Балинез тосгоны зөвлөлийн эрх мэдлийг давсан бие даасан байдлыг олж авах боломжтой бөгөөд энд хааны айлчлалыг дурдахгүй өнгөрч болохгүй юм. Дүрэм нь практикаас тусдаа оршдог.

ЗАН ЗАНШЛЫН КОДИФИКАЦИ

Дундад зууны эхэн үеийн Европ дахь хууль тогтоомж, эрх зүйн үйл явц, бичвэрийн гайхалтай хөгжил нь олон түүхэн жишээг өгдөг бөгөөд тэдгээрийн тусламжтайгаар хууль, легализм, зан заншилтай хэрхэн уялдаж байгааг судлах боломжтой юм. Италийн эрдэмтэд Юстинианы багц хуулийг (Corpus Iuris) 'дахин нээсний' дараа дундад зууны үеийн хуульч эрдэмтэд Ромын

хууль тогтоомж, зарчмуудыг өөрсдийн шүүхийн практиктай, ялангуяа тэр үеийн Европын ихэнх нийгэмд ноёрхож байсан феодалын харилцааны бүтэцтэй уялдуулах үүргийг хүлээсэн юм (Стейн, 1999: 62–67). Европ даяарх бүх төрлийн шүүхүүд бусад зүйлсийн хажуугаар маргаантай асуудлыг шийдвэрлэдэг байв (Рейнолдс, 1997). Гэсэн ч Corpus Iuris бол Ромын сүүдэрт бүтээгдсэн 'хэрцгий' кодексоос хамаагүй илүү төвөгтэй, илүү дээд түвшний хуулийн хэлбэр юм (Вормалд, 1999; Барнвелл, 2000).

XIII зуун гэхэд Европын хэд хэдэн орны эрдэмтэд Ромын хуулийн ангиллыг ашиглах байдлаар өөрсдийн улсын хуулиудыг бичдэг байжээ. Тавдугаар бүлэгт үзсэн Гланвилл, Брэктон нарын Английн хууль тогтоомжийн цуглуулгууд нь Юстинианы агуу кодификацыг дуурайн Английн хуулийг оновчтой болгох гэсэн тодорхой оролдлого байсан; Фредерик II эзэн хаан Сицилийн хаант улсын Liber Augustalis буюу хуулийн кодексыг нийтэлсэн; болон Испанийн хаан III Фердинанд Siete Partidas буюу долоон хэсэгт кодексыг бий болгосон байна. Орон нутгийн түвшинд, ялангуяа Францын хойд хэсгийн орон нутгийн шүүхэд хэрэглэгдэж байсан ёс заншлыг бичин тэмдэглэх алхмууд хийгдсэн бөгөөд үүнд Бюваисисын ёс заншлын тухай Филипп де Бомануарын алдарт шастир багтжээ (Стейн, 1999: 64–67).⁴ Бусад *customals* (хийд, эдлэн газар, орон нутгийн ёс заншлын бичмэл цуглуулга) нь ихэвчлэн бие биеэсээ гаралтай, мөн *Corpus Iuris*-с санаа авсан байдаг байна (Кохен, 1993).

Энэ нь хууль, ёс заншил хоорондын харилцааны талаар дундад зууны туршид үргэлжилсэн ноцтой маргааныг үүсгэсэн бөгөөд бичигдсэн ба бичигдээгүй хууль, дадал зуршил, орон нутгийн зан заншлын төрөл бүрийн ялгаа болон хүмүүсийн хүсэл зоригийг хуулийн эх сурвалж болгон авч үзсэн юм. Тиймээс тухайн үеийн түүхэн судалгаа нь хууль тогтоомж, эрх зүйн сэтгэлгээг орон нутгийн түвшинд хэрхэн боловсруулж болох талаар ойлголт өгдөг байна. Улс төр, эрх зүйн орчин нь хуваагдмал, олон янз байдаг ч Иббетсон (2007) нь хууль ба зан заншлын хоорондын харилцааны талаар хоорондоо зөрчилддөг, мөн давтагддаг хоёр үзэл бодлыг илрүүлсэн байдаг. Нэг талаас, ёс заншил (*consuetudo*) нь хуулийн хэлбэр гэж үздэг байсан бөгөөд заримдаа *ius non scriptum* (бичигдээгүй хууль) гэж тайлбарлагддаг ба *lex et consuetudo* гэсэн хэллэг шиг *lex*-тэй хамт хэлэгддэг. Энэ бол Брактонь илэрхийлсэн үзэл бодол байв, яг л Английн хуулиудыг (*lex et Consuetudo*) бичигдээгүй гэж мэдэгдсэн шиг.⁵ Нөгөө талаас, ёс заншлыг хууль тогтоомжид харш, тэр ч байтугай үүнийг эсэргүүцдэг байдлаар тодорхойлсон бөгөөд зөвхөн зохих ёсоор нотолсон тохиолдолд шүүх дээр хүлээн зөвшөөрөгддөг зүйл хэмээн үзсэн байна.

⁴ Стейн (1999) нь, ялангуяа гуравдугаар бүлэгт, эдгээр нарийн түвэгтэй үйл явдлуудын талаар маш сайн тоймоор хангаж өгсөн юм.

⁵ Энэ нь илүү их үзэл суртлын хэлбэртэй байсан ч XVII зуунд Коук нь улс орны ёс заншилд Английн хууль тогтоомжийн эртний гарал үүслийг тавдугаар бүлэгт дурдсанчлан шаардахад дахин гарч ирэх ёстой байв.

Нэг үзэл бодлоос нөгөө рүү шилжих ерөнхий өөрчлөлт нь дундад зууны үед ажиглагдаж байгааг олж харж болно хэмээн Иббетсон (2007: 155) тайлбарлав. XIII зууны дунд үеэс эхлэн иргэний, сүмийн, нийтлэг, бүс нутгийн болон ерөнхий хуулиудын хооронд ялгаа гарч ирсэн бөгөөд тэрээр үүнийг нийгмийн санаатай 'хуульчлах' хэмээн нэрлэжээ. Шүүх дээр ёс заншлыг нотлох аргуудыг боловсруулсан ба үүнд 1270 онд Луис IX-ийн боловсруулсан *enquie par turbe* судалгаа багтсан бөгөөд ингэснээр орон нутгийн зан заншлыг парламентын хяналтан дор Франц, Фландерийн хууль тогтоомжид нэгтгэсэн болно (2007: 158-60). Англид манорийн шүүх нь 'эзэмшил газрын ёс заншлын дагуу' газраа өмчилсөн феодалын түрээслэгчидтэй харьцдаг байв. Гэсэн ч XIV зуунд шүүх бүрэлдэхүүн ёс заншил гэж юу болохыг тодорхойлох ёстой байсан бөгөөд Иббетсоны (2007: 167–69) үзэж байгаагаар тэд нээлт хийх нэрийн дор 'шүүхийн мөрдөх ёстой дүрмийг санаандгүй байдлаар бий болгосон байж магадгүй юм':

Суурь түвшинд ... нийтлэг хууль зүйн үнэт зүйлийг Английн ард түмэн ерөнхийдөө хүлээн зөвшөөрдөг боловч эдгээр үнэт зүйлээс үүдэлтэй дүрмийг нарийвчлан боловсруулах нь ийм популист үндэслэл байхгүй нь лавтай. Энэ бүгд нь хуульчдын хийсэн ажил юм (2007: 165).⁶ Европын эдгээр хөгжилд Ромын хуулийн оюуны нөлөө илт харагдаж байгаа боловч Иббетсоны тодорхойлсон ёс заншлыг албан ёсны болгох, өөрчлөх ажлыг төр, засгийн эрх бүхий байгууллагаас ямар нэгэн байдлаар шууд тулгаагүй болно. Энэ нь орон нутгийн шүүх, шүүгчдийн ажлын шинэ сэтгэлгээ, зохион байгуулалтыг төлөөлсөн хуульчдын хийсэн ажил байв.

Ватсон (2001: 103) нь зан заншлын хуулийг нь ихэнхдээ нутгийн иргэдийн хийдэг зан үйлээс гардаггүй гэж үздэг. Жишээлбэл, дундад зууны үед Германы тосгонд нэг үндэстэн, ижил шашин шүтлэгтэй, ижил хэлээр ярьдаг хүмүүс олон зууны турш эдийн засгийн ижилхэн нөхцөлд амьдарч байсан ч гэсэн гэрлэлт хосын үл хөдлөх хөрөнгийн төв байгууллагын хувьд маш өөр дүрмүүдтэй байдаг нь Поллок ба Майтланд (1968: 399-400) нарт ажиглагдсан байна. Тус бүрт шүүхийн шийдвэр гарсны дараа нэг хэлбэрийг хууль болгон тогтоожээ, ингэснээр аль ч газарт эцсийн үр дүн нь дурын зарим элементийг агуулах болно. Ёс заншил, зуршлаас хууль руу шилжих нь энгийн бөгөөд жигд хувьсал байгаагүй юм. Хожим нь, Иббетсоны (2007: 156) тайлбарласнаар дундад зууны үеийн эрдэмтэд зуршил буюу *mos*, зан заншил буюу *consuetudo* хоёрын хоорондын ялгааг гаргаж ирсэн байна. Сүүлийнх нь шүүхээр хүлээн зөвшөөрөгдөж болох боловч энэ нь зөвхөн хатуу нөхцөлд бөгөөд дараа нь зөвхөн шинжлэх ухааны хууль гэх мэт үндэслэлтэй нийцдэг бол хүлээн зөвшөөрөгдөх боломжтой юм (2007: 172–74). Хэргийн баримтад

⁶ Хоёрдугаар бүлэгт хэлэлцсэн сүүлийн үеийн колоничлолын болон колоничлолын дараах жишээнүүд нь ёс заншлыг шүүх хүлээн зөвшөөрсөн нь түүнийг өөр зүйл болгож байгааг харуулж байна: Өмнөд Африкийн шүүгчид хичнээн их хичээсэн ч тэд «уугуул хуулиудыг» шүүхэд хууль ёсны хүчин төгөлдөр болгохын тулд илүү тодорхой дүрмүүд, зарчмуудын багц болгон өөрчлөхөөс өөр аргагүй юм.

зан заншлыг хэрэглэх нь сэтгэлгээ, зан үйлийн өөрчлөлтийг илэрхийлдэг байна.

Энэхүү хууль зүйн өөрчлөлтөд дүн шинжилгээ хийх зорилгоор Чэеттэ (1970, 1978) нь XII – XIII зууны Франц дахь шүүх хуралдааны өөрчлөгдөж буй хэлбэрүүдийг ялгах байдлаар хууль тогтоомжийн хөгжлийн талаар хэлэлцсэн юм. Тухайн цаг үе дэх эхэн үеийн жишээнүүдээс харахад шийдвэрүүдийг нь шүүхийн шийдвэрээр бус харин арбитрын болон буулт хийх замаар гаргаж байгааг харуулж байна. Үүний зорилго нь гэрээг баталгаажуулах, нэр төрийг хангах явдал байв: буулт хийхдээ шүүх, эвлэрүүлэн зуучлагчид нэр хүндийг гутаан доромжилсон байдлыг харгалзан үзэж, нийтээр дагаж мөрддөг тусгай дүрмүүдээс илүү ерөнхий зарчмуудыг баримталдаг байв (1970: 291–95). Ийм хэргийг эзэн биегүй хууль дүрэмд хандахгүйгээр шийдвэрлэгддэг; тэд ёс суртахууны нэгдлээр тодорхойлогддог байв. Шударга ёс нь хувь хүмүүст, тэдний тодорхой нөхцөл байдал, гомдол, шаардлагыг авч үзэх юм. Хууль, зан байдлын идеал, улс төрийн дүрэм, нийгмийн хэм хэмжээ гэсэн ойлголтуудыг тодорхой хүмүүсийн тодорхой зүйлийг хийж буй тухай мэдэгдэл болгон илэрхийлэгдсэн байдаг (1978: 158–61). Дундад зууны шүүхэд хуульч эрдэмтдийн үүрэг бол түүх ярих явдал байв: тэд ном зохиол, хуулийн аль алиных нь зохиогч байсан (Блох, 1977: 5).

XIII зуунд Францад бичмэл хууль тогтоомжууд гарч ирсэн нь дотроо 'хөдлөх эд хөрөнгө' ба 'үл хөдлөх хөрөнгө', 'өв залгамжлал' ба 'бэлэглэл', 'түрээслэгч' ба 'эзэн' гэсэн илүү абстракт болон объектив байдлаар тодорхойлж болох ангиллуудын хөгжүүлэлтийг багтаасан хэмээн Чэеттэ үргэлжлүүлсэн юм. Эдгээр нь Согагийн тайлбарласантай төстэй ойлголтуудыг ангилдаг. Чэеттэгийн олж мэдсэнээр ийм ойлголтуудыг ашиглах нь өдөр тутмын амьдралын шууд байдал, хянахад бэрх тодорхой бус байдал, олон эшлэл, хувь хүний амьдралын туршлагаас салангид, тодорхой цагт хамаарахгүйгээр хүчин төгөлдөр байх дүрмийн хөгжүүлэлтийн хамт дагалддаг байна (1970: 289; 1978: 170). Тэдний тодорхой цагт хамаарахгүй байдал нь Чэеттэгийн нэрлэдгээр 'санаатайгаар бүтээсэн аман дүрмийн тогтолцоо'-г бий болоход (1978: 163), буюу хууль ёсны аргаар бодож, маргахад хүргэсэн юм.

«Яагаад ийм өөрчлөлт гарсан юм бэ?» гэж Чэеттэ асууна (1970: 289). Шийдвэр нь илүү 'оновчтой' байдаг шүүх нь хүмүүсийн сонирхлыг татах ёстой гэж олон түүхчдийн адил үзэж болохгүй; хувь хүмүүс нь, ямар ч үндэстнээс илүү, хувиа хичээхээс илүүтэйгээр объектив төвийг сахихыг илүүд үздэг. «Төвийг сахисан, объектив дэг жаяг бол маш чухал үнэ цэнэ юм» (1970: 290). Хууль ёсны сэтгэлгээний өсөлт нь энэ үед Юстинианы кодексын шинэ нээлт, түүний нэр хүндтэй холбоотой байж болох юм: хэдийгээр Ромын эрх зүйн ангиллууд бүрхэг болсон байсан ч хэм хэмжээний тогтолцоо нь маргааныг зохицуулах ёстой гэсэн санаа нь өмнөд Европоос хэзээ ч бүрэн арилаагүй юм хэмээн Чэеттэ (1970: 297) онцлон тэмдэглэсэн байна. Гэсэн хэдий ч 1250

оны орчимд гарсан гэнэтийн өөрчлөлтүүдийн цорын ганц тайлбар нь гэж үзэхэд Ромын хууль тогтоомжийн нөлөө нь хэт өргөн бөгөөд ерөнхий байв. Блох (1977: 8–10) нь эдгээр үйл явдлыг Франц дахь хааны засаглал, эрх мэдэл өргөжсөнтэй холбож үздэг. Хаадууд шинээр олж авсан газар нутагт өөрийн түшмэлүүдээ суулгасан боловч уламжлалт аргын дагуу тэдэнд засаглах зөвшөөрлийг өгсөн юм. Тиймээс ийм практикийг бичгээр тогтоох шаардлагатай юм. Гэхдээ тэд хувийн өш хонзон авах феодалын тогтолцоог шүүхийн бүтцээр сольж, Парисын парламентыг төв болгон давж заалдах тогтолцоог бий болгох талаар санаа тавьж байв: 'Шүүхийн байгууллагыг аажмаар өөрчилснөөр хаант засаглал нь хуулийн хэл, хууль зүйн институцийн талаар бүрэн мэдлэгтэй болсон юм'. Чэеттэ нь өөрчлөлтийг орон нутгийн бусад хүчин зүйлстэй холбож үздэг: улс төрийн үйл явдал нь орон нутгийн эрх баригчдын эргэн тойронд цугларсан бүлгүүдийг задрахад хүргэсэн; хаант засаглалаас хангасан шүүхийн шударга ёсны засаглал нь ямар нэгэн эрх мэдэл тулгасан хүмүүстэй тэмцэх боломжийг олгодог болохыг тосгоны оршин суугчид, хотын консулууд, ноёд хаад гээд бүгд олж тогтоожээ. Харин шүүхүүд оюуны тусгай арга барилаар нийгмийн харилцааг цаашид хууль ёсны болгоход хүргэсэн юм. 1300 он гэхэд хүмүүс эхлээд эрхээ бодитой тодорхойлсон гэж үзэж, дараа нь шүүхээр, боломжтой бол хааны шүүхээр, батлуулахыг эрэлхийлдэг байв (1970: 298–99). Хэдхэн арван жилийн дотор бүхэл бүтэн тогтолцоо боловсруулагдсан юм.

Эрх зүйн сэтгэлгээ болон туршлага бий болсныг үргэлж түүний нийгмийн тодорхой хүрээнд ойлгох ёстой, өөрөөр хэлбэл бид дэлхий даяар ижил (нарийн түвэгтэй) хэв маягийг давтагдана гэсэн хүлээлттэй байх ёсгүй юм. Гэсэн хэдий ч легализм нь маш өөр өөр нөхцөлд өргөн тархсан байдаг байна.

ДҮРЭМ БА АНГИЛАЛ

Легализм гэдэг нь дэлхий ертөнцийг хэм хэмжээ, хийсвэр ангиллын хувьд ерөнхийд нь тодорхойлох хандлага юм бол үүнд юу хамаарах вэ?

Хартын (1994) хууль зүйн ухааны үндсэн судалгааны гол цөм нь дүрэм бөгөөд энэ нь тэр үеэс хойш эрх зүйн онолчдын хувьд нэгэн үндсэн сэдэв болж ирсэн юм. Тэрээр аргументыг боловсронгуй болгох үедээ зургаагаас арав дугаар бүлэгт хэм хэмжээг хувь хүний биеэ авч явах байдлыг үргэлж зааж, хориглосон мэт хандах хандлагатай гэж үзсэн байна. Түүний үндэслэлийг бататгадаг эрх зүйн загвар нь тодорхой нэгэн зан байдлыг хууль бус болгодог зүйл юм. Гэсэн хэдий ч Онорегийн (1977) онцлон тэмдэглэсэнээр нийтлэг эрх зүйн тогтолцооны хүрээнд 'жинхэнэ хууль'-ийг судалж үзэхэд хуулиуд биеэ авч явах байдлыг шууд ямар нэгэн байдлаар зааж өгөх, хориглох нь ховор байдаг хэмээжээ. Үүний оронд тэдгээр хуулиуд нь ангилал үүсгэж, хил хязгаараа тогтоох хандлагатай байдаг бөгөөд өөр өөр ангилалд багтдаг

хүмүүс болон эд зүйлсийн эрх ба үүрэг бүхий байр суурийг тодорхойлж, онцгой тохиолдлууд болон хязгаарлалтуудыг оруулж өгснөөр бусад хууль тогтоомжийн хамрах хүрээг тодорхойлдог. Хууль нь олон нийтийн байгаад зогсохгүй бодит эсхүл боломжит онцгой тохиолдлуудаас нэгэн зэрэг хамаарч байдаг. Цаашдын хэм хэмжээ нь нотлох баримт, дүрэм журмын асуудлыг зохицуулж, шүүх материаллаг хууль хэрхэн хэрэгжиж байгааг шийдвэрлэхэд нь арга замыг бий болгож өгдөг (1977:112). Ангилал, байр суурийг тодорхойлсон хуулиуд нь зан байдлыг шууд норм болгох (норматив), тодорхой заах эсхүл хориглох нь ховор байдаг; Онорегийн хэлснээр хүмүүсийг мөлжлөгөөс эсхүл өөрсдийнх нь мунхаглалаас хамгаалах зорилгоор, жишээлбэл гэрээслэл болон гэрээний хүчин төгөлдөр байдлын шалгуурыг хангах зорилгоор ихэнхдээ тэрхүү хуулиудыг санаачлан гаргаж ирдэг. Англид гэрээг хүчин төгөлдөр болгоход шаардагдах харилцан амлалт өгөхийг авч хэлэлцэх тухай хууль нь 'нэгэн төрлийн хууль зүйн патернализм' юм. Санаатай үйлдсэн гэмт хэргийн (mens rea) тухай хуульд хүртэл яллагдагчийг гэмт хэрэгт буруутгахаас өмнө сэтгэцийн төлөв байдлыг нь шалгаж баталсан байх ёстой ба энэ нь хийсэн хэргийнхээ үр дагаврын хариуцлагыг хүлээх боломжтой хүмүүсийг цагаатгах зорилгоор хуульд үйлчилдэг (1977: 105). Онорегийн дүгнэлтийг бүрэн эхээр нь оруулах нь зүйтэй юм.

Хууль нь хүн төрөлхтөн ба тэдгээрийн хоорондын харилцаа, өвөрмөц талаас нь үзвэл амьд эсхүл амьгүй объектуудын тухай юм. Энэхүү өндөрлөгт хүрэхийн тулд энгийн амьдралын өгөгдлийг өөрийн гэсэн дүр төрх, хувцаслалт, тогтсон журам бүхий тусгай жүжиг болгон хувиргах шаардлагатай бөгөөд үндсэн шинж байдлаа олж чадаагүй шинэ дүр төрх, харилцаа холбоо бий болсныг дурдахгүй өнгөрч болохгүй. Энэхүү жүжгийг тайзан дээр тавихын тулд хууль нь үйл явдал, үйл ажиллагаа, хувь хүн, нөхцөл байдлыг онцгой байдлаар ангилж, дараа нь зохих ангилалд хамруулж, жүжгийн дүрүүдийн (dramatis personae and res) хууль ёсны байр суурь, тэдний жүжиглэх, зовлон шаналлыг харуулах байдал, тэдний хоорондын харилцаа холбооны талаар дүгнэлт гаргадаг (1977: 112).

Финнисийн (1980:283) хэлснээр хууль нь бодит амьдрал дахь нөхцөл байдал, орчинд тохирсон байхаар 'хувцаслалт ба харилцаа'-г бий болгож өгдөг.

Хууль зүйн сэтгэлгээ нь дэлхий ертөнц хэрхэн яаж оршин тогтнохыг тодорхойлдог - феодалуудын эдэлж болох эд хөрөнгийн өмчлөлийн ангиллууд, түүнчлэн Сога (Soga - Африкийн зүүн хэсэгт орших Викториа нуурын хойд эрэгт байдаг банту хэлээр ярьдаг хүмүүс) эр өөрт хамааралгүй эмэгтэйг унадаг дугуйгаараа авч явах ёсгүй гэхчлэн тэгэх ёстой, тэгэх ёсгүй гэсэн ёс заншлыг тодорхойлдог. Түүнчлэн энэхүү хууль зүйн сэтгэлгээ нь өөрийн гэсэн ангилал, үзэл баримтлалыг хэрхэн тайлбарлах талаар тогтмол урьдчилан харж байдаг: энэ нь үйл ажиллагааны чиглэл ба тэдгээрийн

шалтгаануудын талаар нийтлэг хэлэлцүүлэг хийх боломжийг олгодог (Постема, 2002: 618).

Гэсэн хэдий ч легализм нь бүхэлдээ хэм хэмжээний талаарх асуудал биш юм. Бурдио нь (1987:820, fn. 28) Францын хууль зүйн төсөл боловсруулахдаа индикатив төлөвийг ашиглахыг онцолж байсан ба аливаа юмсын өөрсдийнх нь бодит шинж чанар байсан мэт яг байгаагаар нь дүрслэхийг мөн онцолсон юм: «Хууль тогтоогч хэм хэмжээг шууд тогтоохоос илүүтэйгээр хууль зүйн байгууллагыг тодорхойлохыг илүүд үздэг. Энэ нь ялангуяа нийтлэг эрх зүйн тогтолцоонд нэн хамаатай бөгөөд Хартыг нийтлэг хууль тогтоомжийн талаар тааруухан онол боловсруулсан хэмээн шүүмжилж байсан юм (Симпсон, 1987). Ромын иргэний эрх зүй (ius civile) ч гэсэн үндсэндээ тодорхой заасан хэм хэмжээний тогтолцоо байгаагүй юм: хуулийн хэрэг үүсгэхийн тулд шүүхэд хандах зөвшөөрөл эсхүл дүрмийг нарийн үг хэллэгтэйгээр бичсэн байх шаардлагатай боловч шүүгчдийн гаргасан зарчим, тэдний хэрэгжүүлж, боловсронгуй болгосон ангилал, дүрмүүд нь л зөвхөн тэдний шүүхийн шийдвэрт далд хэлбэрээр байдаг. Постема (2002) нь нийтлэг эрх зүйг тодорхой заасан дүрэм журмуудаас илүү хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, үндэслэл гаргах хэлбэрүүдээс бүрддэг хэмээн онцлон тэмдэглэсэн байдаг. Гэсэн хэдий ч тодорхой дүрэм журамгүй байлаа ч шүүхийн хүрээнд далд дүрэм, зарчим, ангилал нь эрх бүхий шийдвэр гаргах үндэс суурийг тавьж чадна. Жишээлбэл, дундад зууны үеийн Английн хамгийн анхны хэргүүд дотор аргумент нь тодорхой логик, зүйрлэл, силлогизм, 'таагүй байдал' эсхүл бэрхшээлээс үүдэлтэй аргумент, утга учрыг нь алдагдуулсан (reductio ad absurdum - логик үр дагавар нь утгагүй эсхүл зөрчилдөж байгааг харуулах замаар таамаглал худал болохыг нотлох арга), өмнөх шийдвэрүүдээс авсан хуулийн заалтын эшлэл зэргийг ашиглан ангилал, зарчмуудыг ойлгомжтой болгосон (Брэнд, 2007; 2012: 191). Энэ нь ёс суртахууны онцлог шинж чанартай хэлэлцүүлгээс өөр төрлийн маргаан дагуулсан шүүхийн үндэслэлийг бий болгосон юм. Шүүх ажиллагааны явцад Сога ангилал, зарчмуудыг ашиглалт нь хууль ёсны үндэслэлтэй ижил төстэй тогтолцоог бүрдүүлжээ. Лукасын (1977:89) хэлснээр ёс суртахууны хувьд хувь хүний сэдэл, зорилго чухал байдагчлан үнэн зөв байдлыг дээд зэргээр онцолдог бол харин хуулийн хувьд нийцлийг онцлон чухалчилдаг байна.

Цаашилбал Исламын ертөнцийн шүүхийн үйл явц нь үзэл баримтлалыг ангилах, аргумент, тайлбарын нарийн боловсронгуй хэлбэрийг ашигладаг болохыг тэмдэглэсэн байна. Дөрөвдүгээр бүлэгт дурдсан Магрибын (Хойд Африк) XIV-XV зууны үеийн баримт бичгүүдийг Пауэрс (2002) судалж үзэхэд олон тооны хууль зүйн хэргүүдийн явц болон муфти (mufti - шашны асуудлаар шийдвэр гаргах эрх бүхий Исламын шашинт хуульч мэргэжилтэн), хуульч эрдэмтэн, кади (qadi - Исламын хуулийн дагуу шийдвэр гаргадаг мусульман шүүгч), шүүгч нарын үйл ажиллагааны хоорондын харилцан хамаарлыг тайлбарласан байдаг. Пауэрс үүнийг дүгнэж хэлэхдээ муфти

нар тодорхой нийгэм Исламын шашинтай байх нь ямар утгатай болохыг тодорхойлохын тулд эрх бүхий хууль зүйн эх бичвэрүүдийг ашигласан бол эрэгтэй, эмэгтэй хүмүүс нийгэмд эзлэх байр сууриа хэлэлцэхийн тулд хуулийг ашигласан: нийгэм ба эрх зүйн сэтгэлгээ нь бие биенээ бүрдүүлжээ (2002: 11). Тодруулбал кади нь муфтигээс заавар зөвлөгөө авахаар хэзээ бас яаж хүсэлт гаргасныг ийнхүү тайлбарласан байна. 'Тэрээр шүүхэд заргалдагч талуудын нэрс, тэдний ярьсан зүйлийг хуулийн хийсвэр томьёо, эзэн бие нь тодорхойгүй хэл рүү зүй ёсоор нь хөрвүүлэн бичсэн'; Муфтигийн фатва (fatwa – албан хууль ёсны дүгнэлт) ч мөн адил хийсвэр нэр томьёотой байсан (2002: 232). Түүний хэлснээр шүүх ажиллагааны явцад нийгмийн харилцааны тасралтгүй урсах мэдээллийг тохирсон логик горимоор эмх цэгцэд оруулсан илэрхийллийн нэгэн цогц болтол нь боловсруулдаг. Энэхүү боловсруулсан мэдээллийг нь зөвшилцөл, зөрчилдөөнийг хуулийн тусгай толь бичигт тусгагдсан эрх зүйн хэм хэмжээний дагуу хөрвүүлэн бичдэг нотариатч эсхүл хуульч эрдэмтэн хариуцдаг байна (2002: 295).

Хууль зүйн хэм хэмжээ болон харилцааг нэгэнт тогтоосон бол Фоллерсын (1969) Сога шүүх хурлыг дүрслэн хэлж өгсөн ойлголтыг бодит нөхцөл байдалд ангилах нь энгийн зүйл биш болж магадгүй юм. Нөхцөл байдал улам бүр түвэгтэй болж, ялангуяа Пауэрсын тодорхойлсон өмчийн маргаантай асуудлуудаар дүрслэгдэж болох бөгөөд энд зөвхөн өмчлөл, ашиглалтын талаарх үндсэн ойлголтууд зөрчилдөөний мөн чанарыг тодорхойлсон төдийгүй хэл шинжлэлийн тайлбарын онолууд нь аргументийг улам боловсронгуй болгосон. Жишээлбэл, XV зууны Фез дэх өв залгамжлалын маргааны үеэр зөрчил нь бичгээр олгосон хишиг хандив, түүнийг үндэслэгчийн таамагласан санааны тайлбар дээр үндэслэсэн байв. Эх бичвэр болгон бичсэн тайлбарын хүлээн зөвшөөрөгдсөн онолын дагуу үндэслэгчийн үгсийг Коран сударт хадгалагдсан Бурханы үгтэй харьцуулж байсан. Тэрхүү үгсэд бурханлаг хуульчийн үг мэт хандаж, сайтар дагаж мөрдөж, биелүүлэх ёстой байв (2002: 165). Исламын хуульч эрдэмтэд өвөрмөц утгыг ердийн хэлнээс үүдэлтэй гэж үзсэн: «Үнэндээ мэргэжлийн утгыг хүртэл ихэвчлэн маргааныг шийдвэрлэхэд гол үүрэг гүйцэтгэдэг түгээмэл сул үг болон холбоос үгсээс үүдэлтэй гэж үзсэн» (2002: 165-66). Муфти нар «өөрсдийн үүрэг даалгавраа хэлний онолыг хууль зүйн хэрэгсэлд ашиглах, хэл шинжлэлийн дүн шинжилгээнийхээ үр дүнг хэргийн бодит байдалд нэгтгэх» гэж ойлгосон (2002: 66).

Ерөнхий ба хийсвэр ангиллууд нь илэрхий ба далд хэм хэмжээнүүдийн хамт тодорхой төрлийн аргументийг боломжтой болгодог. Дэлхий ертөнцийг хийсвэр ойлголт, тэдгээрийн хоорондын харилцааны хувьд төлөөлж, дүн шинжилгээ хийдэг бөгөөд энэ нь Хиндү, Ром, Исламын хуулийн хөгжилд аль хэдийн тэмдэглэгдсэн нарийн боловсронгуй аргументийн хэлбэрүүдийг хөгжүүлэх боломжийг олгодог. Аргументийг тайлбар, зүйрлэл, урьдах жишээ дүрмийн дагуу хэлэлцдэг бөгөөд тодорхой хэрэгт хэрэглэхийг зохицуулах зорилгоор боловсруулж болох журам, нотлох баримтын хэм хэмжээ

дурдаагүй болно.

Легализм нь тодорхойлолт, ялгаа, зөв хариултыг баттай хэлдэг: энэ нь тодорхой хэлбэрийн шүүхийн тогтоол гаргахыг шаарддаг (Бурдио, 1987: 820); Хууль зүй нь бүх зүйл эмх цэгцтэй, энгийн байх нь хэвийн зүйл гэж үздэг (Лич, 1977: 19); Энэ нь эцсийн шийдвэрийг гаргадаг (Постема, 2002: 613). Басогогийнхан (Basoga /Busoga/ - Бусога гэдэг нь 'Согагийн нутаг' гэсэн утгатай бөгөөд Басого эсхүл Сога (ганц бие Мусога) хүмүүсийн 11 ноёдын хаант улс юм)-ы дунд байдаг харьцангуй энгийн дүрэм, ангилал ч гэсэн хүнд нөхцөлд шийдвэр гаргах хэрэгсэл болж чаддаг. Дагаж хэрэгжүүлэх хууль тогтоомжгүй бол шүүгчид нөлөө бүхий шийдвэр гаргахад хэцүү байсан бөгөөд шүүхийн үйл явцыг зөвхөн талуудын хоорондын тохиролцоогоор хийж болох Төвөдийн бүс нутгийн жишээг харьцуулан үзэж болох юм. Энэ нь баримтууд маргаантай байсан тохиолдолд аль нэг нь ярьсан зүйлээ өөрчлөх хүртэл талуудыг ташуурдах эсхүл сүмд тангараг өргүүлэхээр явуулж болно гэсэн үг юм (Пири, 2007б: 159–63). Нэг жишээ дурдахад, ХХ зууны эхэн үеэс эхлэн хүн амины хэргийн маргаанд оролцсон хоёр тал хоёулаа ташуурдуулсан ч гэсэн хоорондоо зөрчилдсөн хэвээр байсан юм. Шүүгч сарлагийн арьсыг дотор, цустай талыг нь дээш харуулан газарт тавьж, талууд шоо хаяж, бурхдаас шударга ёсыг шаардаж, хэргийг зохих ёсоор нь шийдсэн юм (Кассинелли, Эквалл, 1969: 176).⁷

Хууль нь шийдвэр гаргах үндэс суурийг тавьж чаддаг бөгөөд Гулливерийн (1979) онцолсон шүүхийн шийдвэр ба эвлэрүүлэн зуучлал хоёрын хоорондох ялгаа нь чухал ач холбогдолтой юм. Антропологийн судалгаа нь ялгааг арилгах хандлагатай байсан боловч хууль ёсны шүүхийн шийдвэрийг маргаан шийдвэрлэх өөр нэг арга гэж үзжээ. Шүүхийн шийдвэр нь шийдвэр гаргах эрхийг хүлээн зөвшөөрөгдсөн эрх мэдлийг хэрэгжүүлдэг гуравдагч этгээдийн гарт өгдөг бөгөөд үүнд нөлөө бүхий дүрмийг ашиглах шаардлагагүй (1979: 20). Улс төрийн дэмжлэгтэй шүүгчид хүртэл өөрсдийгөө эцсийн шүүхийн шийдвэр гаргах эрх мэдэлтэй гэж үзэхгүй байж магадгүй гэдгийг Төвөдийн шүүхийн жишээ харуулж байна. Энэ нь улс төрийн эрх мэдлийг бус, шүүхийн шийдвэр гаргах нөөцийг хангадаг хууль юм (Постема 2002: 617–18). Хууль зүйн дүрэм, зарчмууд нь дэлхий ертөнц ямар байх ёстой талаар тодорхой баримтлал гаргахдаа нийтлэг эрх зүйн эхэн үеийн шүүхүүдээс олж тогтоосон баримтын төрлүүд нь шүүхийн шийдвэр гаргах үндэс суурийг бүрдүүлж өгсөнтэй адил зөв хариултыг олж тогтоох боломжийг олгодог.⁸ Энэ нь

⁷ Асад (1983) нь арван гуравдугаар зууны Европт эрүү шүүлтийг шүүхэд гэм бурууг нь хүлээлгэх хэрэгсэл болгон хөгжүүлэх талаар хэлэлцсэн бөгөөд шүүх хуралдааныг хүнд хэцүү сорилт, амины дэнчинтэй тулаан, ариун тангаргаар солихын тулд 1215 оны Латеран Зөвлөлөөс эрүү шүүлтийг хөхүүлэн дэмжиж байжээ. Үнэнийг хэлсэн ярьсан үг өгүүлбэрээр дамжуулан тогтоохыг зарим зохиолчид шударга ёсыг оновчтой болгох алхам гэж үздэг боловч Асад нь тухайн үеийн Христийн шашныг тодотгон харуулсан бие махбодын хатуужил, нүглээ наманчлах, биеийн зовлон зүдгүүрийг ялгаагүй чухал ач холбогдолтой гэж үздэг.

⁸ 1996 онд Нэгдсэн Вант Улсад Лорд Вулфын зөвлөмжийг дагаж мөрдсөний дагуу оролцогч талуудыг эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцохыг хуульч, шүүгчид аль аль нь уриалах гэж оролдоход

эцсийн шийдвэрийг гаргах боломжийг олгодог шүүгчийн эрх мэдэл гэхээсээ илүү хуулийн эрх мэдэл юм.

БИЧИГ ҮСЭГ

Дундад зууны Франц улсын легализмийн хөгжил нь Чейеттийн бичиг үсэгт тайлагдсантай холбоотой юм. 'Бичиг үсэг тайлагдаагүй' нийгэмд бичиг үсэгт тайлагдах явдлыг зөвхөн тодорхой ангиллаар хязгаарладаг нийгэмд шүүхийн давж заалдаж болох дүрэм, зарчмуудыг цээжилсэн байх ёстой; амьдрал дээр тэдгээр дүрэм зарчмууд нь ихэвчлэн хийсвэр нэр томьёотой гэхээсээ илүү хувь хүмүүсийн тухай хүүрнэл хэлбэртэй байдаг (1978: 158–61). Нөгөө талаар хуулийн үүрэг бол дүрэм, ангиллыг тодорхой болгох явдал юм. «(Бичгийн) гэрээнд бид үнэн зөв илэрхийлэх, үгийн сонголт найруулгыг ойлгомжтой байлгахад хичээж буйг олж хардаг. . . Хэллэг бүр нь мэргэжлийн болон хууль ёсны шинж чанартай байдаг бөгөөд энэ нь ихэнхдээ орчуулахын аргагүй байдаг '(Жоннс, 1904: iv, Гудигээс иш татав 1986:147). Ийн хууль хөгжин гарч ирсэн нь бичиг үсэг тайлагдан бичгийн мэдлэгтэй болсонтой ихээхэн холбоотой байдаг гайхах зүйл үгүй билээ. Олон тооны түүхийн болон антропологийн жишээг судалж үзвэл бичгээр гаргасан хууль нь нийгэм өөрийн үйл хэргийг зохион байгуулах шинэ хэв маяг»-ийг илэрхийлдэг хэмээн Гуди (1986: 129) онцлон тэмдэглэсэн байна. «Бичиж гаргах нь өнгөрсөн үеийг (жишгээр) хэрхэн ашиглаж болох, ирээдүйг (хууль тогтоомжоор) хэрхэн зохицуулах болох тухай санаагаа өөрчлөхөд тусалдаг» (1986: 154). Тэрээр хэлэхдээ өндөр түвшний хийсвэр ойлголт, албан ёсны шинжтэй биш байсан ч гэсэн бичиж тэмдэглэх нь хэм хэмжээний ерөнхий илэрхийлэлд түлхэц болж өгдөг бөгөөд өөрөөр далд байж болох зүйлийг олон нийтэд ил тод болгодог; мөн энэ нь бүх нийтэд жигд, нэгдсэн ерөнхий болгох үйл явцад дэмжлэг болдог. Бичсэн хууль нь цаашид улам боловсронгуй болгох судлагдахуун болж, хууль зүйн ухааныг бий болгодог гэжээ (1986: 166). Түүний нэгтгэн дүгнэж хэлснээр бол нэгдсэн ерөнхий байдал, хийсвэр ойлголтын ийм үйл явцыг Месопотамийн анхны хуулиуд, Теодосиус, Юстинианы шастир туурвил, дундад зууны Их Британийн хууль ёсны журам, XX зууны колоничлолын үеийн кодификаци (систем, төлөвлөгөөний дагуу хууль, дүрмийг зохион байгуулах үйл ажиллагаа, үйл явц)-аас харж болно (1986: 168).⁹

Бичмэл дүрэм журмыг нэвтрүүлэх чадварыг түгээмэл болгох тал дээр Гудигийн онцлон тэмдэглэсэн нь Бурдиогийн бичмэл хуулийн талаарх ярьсан зүйлтэй

тэдэнд тулгарч буй бэрхшээлийн талаар эргэцүүлэн бодож болно. Нэгэнт заргыг шүүх журмаар мөрдүүлэхээр эхлүүлсэн бол талууд тодорхой хариулт өгөх явцад бие биенээ өрсөлдөгчид гэж үздэг: Хэрэв шүүхийн тогтолцоо хариу өгөх төлөвтэй байвал талууд харилцан буулт хийх нь үр дүнгүй болох юм шиг байдаг.

⁹ Гудигийн өмнөх «бичиг үсэг тайлагдсантай холбогдсон судалгааны ажил» (Гуди ба Ватт 1963)-д бичиж тэмдэглэх нь тодорхой төрлийн логик сэтгэлгээг бий болгодог гэж үзсэн нь нэлээдгүй шүүмжлэлд өртсөн (Халверсон 1992; Парри 1985) хэдий боловч тэрээр хуулийн талаарх судалгааны ажилдаа илүү хянуур ханддаг.

давхцаж байна.

Бичиж тэмдэглэх нь 'нийтлэг' дүрмүүд, юун түрүүнд зарчмуудыг таньж мэдэх тайлбарыг бүх нийтийн болгох боломжийг нэмж өгдөг; мөн бичвэр нь дамжуулан үлдээх боломжийг нэмэгдүүлж өгдөг. Ингэж дамжуулан үлдээх нь бодитой байх ёстой. . . Энэ нь нийтийн хэрэглээнд орж, газарзүйн (нутаг дэвсгэрийн) болон цаг хугацааны (үеийн) хил хязгаараас давж гарах боломжтой байх ёстой. . . бичмэл хууль нь эх бичвэрийг бие даасан болгох үйл явцад сайнаар нөлөөлдөг. Үүнийг тайлбарласан ба энэ нь тайлбар болон бодит байдлын хооронд өөрөө холбогдон орсон байдаг. Тухайн үед хууль зүйн салбарынхны 'Эрх зүйн ухаан' гэж нэрлэдэг зүйл нь тэгж хэлэгдэх боломжтой болсон юм: өөрөөр хэлбэл энэ өөрийн гэсэн хэм хэмжээ, логиктой эрдэм шинжилгээний мэдлэгийн тодорхой хэлбэр мөн бөгөөд оновчтой уялдаа холбоотой бүх гадаад шинж тэмдгийг гаргах чадвартай юм. (Бурдио 1987: 844–45)

Гэсэн хэдий ч Бурдиогийн нэгэн адил Гуди бичиг үсэггүй нийгэмд хууль, зан заншлын хооронд ямар ч ялгаа байхгүй гэж хэлэх үедээ бичгийн шийдвэрлэгч хүчин зүйлийн нөлөөг хэтрүүлэн хэлсэн байж магадгүй юм. Хууль зүйн хэргүүдийг бүртгэж, хууль тогтоомж бичих үед хэлбэр болон агуулгын хувьд үзэл баримтлал, дүрэм журам, ухагдахууны мөн чанар өөрчлөгддөг гэж тэрээр нотолдог (1986: 142).

Гэхдээ цаасан бичигдээгүй байлаа ч хууль ёсны үзэл санааны боломж боллоцоог үл ойшоож болохгүй. Фоллерсын тайлбарлаж байсан шүүх ажиллагаанууд ихэвчлэн аман үйл явц дээр тулгуурладаг байсан ч тодорхой илэрхийлж ангилсан ойлголтуудыг ашигладаг. Эдгээрийг аман ангилал, тангараг, номлол, давтагдсан хэллэгүүдээс олж болно. Грекийн эртний хуулиудыг аль хэдийн цаасан дээр бичигдсэн байсан үед ч гэсэн дуулж байсан гэх гайхмаар олон нотлох баримтууд байдаг бөгөөд хуулиудыг бичгээр бүртгэн тэмдэглэсний дараа ч гэсэн ам дамжин яригдах нь чухал хэвээр байсан мэт санагддаг. хэмээн Томас (1995: 63) онцлон тэмдэглэсэн байна. Бичиг үсэг, бичгийн хэлбэрийг маш их хүндэлдэг Хинду болон Исламын ертөнцөд аман дамжин яригдах нь давамгайлах ёстой гэдгийг би өмнө нь тэмдэглэж байсан (Мессик 1993; Фуллер 2001). Дармасастра(dharmasastra - эртний санскрит бичвэрүүдийн цуглуулга бөгөөд Хиндүчүүдийн ёс суртахууны зарчим хувь хүний өөртөө, гэр бүлийнхэнтэйгээ харилцах зан үйлийн хариуцлага, үүрэг, ёс зүйн талаарх тайлбар)-ийн бичмэл уламжлал нь бурхдын анх хэлсэн шүүлт дээр үндэслэдэг гэж үздэг. Веда(эртний Энэтхэгээс гаралтай шашны томоохон бичвэрүүд) нь зөв дуу авиаг яг таг дуурайж хуулбарлахын тулд тасралтгүй давтан хэлэх, цээжилснээ шалгуулах, авиа зүйн дүрмийн нарийн төвөгтэй системийг хамарсан үйл явцыг багшаас сурагч руу шууд дамжуулах замаар суралцах бөгөөд одоо ч энэ нь хадгалагдан үлджээ (Парри 1985: 207-08). Ам дамжин түгэн дэлгэрэх нь үзэл суртлын хувьд давуу талтай ч

ой санамж нь буруу зөрүү санах талтай байдаг гэж үздэг бөгөөд бичмэл текст нь эртний мэргэн ухааны илүү найдвартай хөтөч болсон явдлаас бичгээр үйлдсэн бичвэрийн парадоксик нэр хүндтэй болсон бололтой гэж Парри хэлсэн байна. Гэсэн хэдий ч нөлөө бүхий 'эх бичвэр'-ийг цэвэр утга зохиолын баримт бичиг гэж ойлгодоггүй ба 'жинхэнэ хувилбар' нь анхны бөгөөд ариун шүүлт юм. Үүнийг сэргээхийн тулд бичгийн болон аман эх сурвалжийг аль алийг нь ашиглах шаардлагатай байж магадгүй юм (1985: 213). Исландын хууль тогтоогч нь хуулийг тогтмол давтамжтайгаар уншиж байх үүрэгтэй байсан бөгөөд Скандинавд хуулийг 'засахын тулд' тогтоосон хугацаанд ам дамжин ард түмэнд мэдээлдэг заншил байсныг Керн (1939: 168) бичиж тэмдэглэжээ. Харин дэлхийн нөгөө өнцөгт АНУ-ын Амиш нийгэмлэг нь тэдний 'суртал номлол' буюу сургаал нь 'туйлын тодорхой бөгөөд олонд тодорхой танигдсан, үндсэн сургаалуудыг агуулсан, давтагддаг аман уламжлалын тусламжтайгаар үеэс үед дамжин хамгаалагдаж байдаг' хэмээн нотолдог (Ковер, 1983/84:30-аас иш татсан бөгөөд тэрээр нэрээс бусад бүх зүйлд хууль байдаг гэж өөрийн санааг хэлсэн байдаг).¹⁰

Төвдийн бүс нутгийн захад байдаг Мустангаас авсан нэгэн жишээнд Рэмбл (2008: бүлэг 9) өөрийн шинжилсэн зүйлээ хуулийн хоёр хэлбэр гэдгийг олж мэдэжээ. Бичмэл үндсэн хуулийг арван хоёр жилд нэг удаа хянаж үзэх ёстой байсан ч бурхны цээрлэлийг хүртэж болзошгүй олон нийт рүү чиглэсэн янз бүрийн гэмт хэргийг тодорхойлсон тангараг жил бүр амаар давтагддаг байв. Түүний хэлснээр аль алиных нь энэхүү хувьсашгүй мөн чанар нь тэдэнд давуу байдлыг бий болгож өгсөн. Ялангуяа тангаргийг зохих үнэлгээнд үндэслэн өөрчлөх боломжгүй байсан: үүнийг олон нийтийн хэлэлцүүлгээр боловсруулан гаргаагүй бөгөөд яруу найргийн хэлбэрээр, тогтсон тооны, халдашгүй өнгөрсөн үеийн бурхны сан хөмрөгт битүүмжлэн хадгалж байдаг. Энэ нь сүнс хий үзэгдлийн талаарх үлгэр домгийн зарчмуудыг илтгэн харуулдаг ба заавал дагаж биелүүлэх ёстой хамгийн биет бус зүйл юм. (Рэмбл, 2008: 310)

Харин үндсэн хууль өөр байсан. Рэмблийн хэлснээр тэрхүү арван хоёр жил тутамд нэг удаа хянаж үздэгээс харахад үндсэн хуульд хүртэл тусгагдсан олон нийт бие даасан байдлаас хэзээ ч захирагдах байдал руу шилждэггүй гэдгийг батлан харуулж байна. Арван хоёр жилийн хугацаанд хязгаарлалтын шинжтэй нийгмийн хүчин зүйл байсныхаа дараа уг баримт бичиг нь хамтын төлөөллийн статусаа алдаж, үүнийг зохион гаргаж ирсэн хүмүүсийн өмч болдог. Хувь хүний ухамсартай сонголт нь үүнийг эрс өөрчилж, зохих өөрчлөлт хийснийхээ дараа хязгаарлах ажлаа үргэлжлүүлэхээр үүнийг дахин өөрөөсөө тусгаарлаж, нийгмийн орчин руу дахин оруулж ирдэг (2008: 308–09). Чейеттигийн тодорхойлолтыг эргэн харваас 'Үгээр илэрхийлсэн

¹⁰ Түүнчлэн Их Британийн шүүхэд саяхныг хүртэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үндсэндээ аман хэлбэрээр явагдаж, бүх баримт бичиг түүний дотор эх сурвалжууд (бүртгэгдсэн хэргүүд)-ыг шүүх танхимд чангаар уншдаг байсан гэж үзэж болно.

дүрмүүд' нь аман бас бичгийн хэлбэрийнхээ хувьд ч ойлгомжтой тодорхой хэлэгдэх мөн давтан хэлэх боломжтой, давуу талтай гэж үнэлэгддэг, заавал биелүүлэх ёстой гэж хүндлэгддэг байна.

Европ дахь хууль зүй, бичиг үсгийн мэдлэгийн талаар хийсэн судалгааны ажил нь бичиг үсэгт тайлагдсан болон бичиг үсэг тайлагдаагүй хууль зүйн практик, зааварчилгааны харилцан нөлөөллийг ажиглаж, Английн нийтлэг эрх зүйн шүүх танхимуудад явагддаг 'тооллого' гэх мэт аман хэлбэрүүд хадгалагдан үлдэж, үйл ажиллагаагаа явуулснаас хойш удаан хугацаанд үргэлжилж байгааг тэмдэглэжээ. (Кланчи, 1979: 272–78). Дундад зууны Европт хууль болон бичиг үсэг нь дүрэм, дохио зангаа, зан үйлд суурилсан аман хэлбэрүүд байсныг Эстер Коэн (1993: 7–8) онцлон тэмдэглэжээ. Феодалын шүүхийн журам нь хууль зүйн болон нийгмийн хамтын нийгэмлэгийн үндсэн хууль болон батлагдсан хуулийг тодорхой илэрхийлэх, сахиулж мөрдүүлэх урьдчилсан нөхцөл болгон хамтын түүхийг илэрхийлэх замаар хүлээн зөвшөөрөгдсөн нийтийн итгэл үнэмшил, хүсэл тэмүүллийг агуулсан утга зохиолын тоглолттой төстэй байв. (Блох, 1977: 2). Уламжлалт ёс заншлыг бичиж үлдээх явцад аман ярианы үндэс суурь устаж алга болоогүй юм. Мөн дундад зууны үеийн Уэльсийн хуулийн номуудын талаар ярилцсаны дагуу бичгээр бичсэн үг нь түүнийг хүрээлж, бүрхэж, түүнтэй эн зэрэгцэж буй бичигдээгүй практиктай холбоотой байх ёстой хэмээн Прайс (2000: 32-33) хэлсэн байдаг. Бичиг үсгийг «хууль зүйн процедурын дийлэнх хэсгийг өөрчлөх технологи биш, харин эх болсон төрөлх хуулийг хадгалах, дамжуулах мөн хуульч мэргэжилтнүүдийг сурч боловсроход туслах нүдэнд харагдахуйц, бодит хэлбэрээр мэдлэгийг нь дээшлүүлэх хэрэгсэл» гэж үздэг байв. Уэльсийн хуулийн номууд нь бусад латин хэлээр бичигдсэн албан баримт бичгүүдээс ялгаатай нь нутгийн аялгууны хэлээр бичигдсэн байдаг: «хууль зүйн бичээсийг төрөлх хэлээ сурах үндсэн үүрэг шиг Уэльсийн хуулийг дагаж мөрдөх хэрэгсэл гэж үздэг байсан» бөгөөд «юун түрүүнд бичиг үсгийн мэдлэгийг хууль ёсны уламжлалын хүчин зүтгэгч гэж эрхэмлэдэг байсан (2000: 67). Энэ тохиолдолд Рэмблийн дүрсэлсэн Төвд тосгоны нэгэн адил хэлсэн үг нь албан бичиг баримт эсхүл тосгоны үндсэн хуулийн бичгээр бичсэн үгээс ялгаатай нь хууль ёсны уламжлалтай холбоотой байдаг. Бичих нь хууль зүйн шинэлэг байдал, нарийвчлал, тайлбар, эрх зүйг төгөлдөржүүлэх нөхцөлийг бүрдүүлж болох боловч энэ нь Рэмблийн биет бус байдлын нууц гэж нэрлэдэг зүйлийг алдагдуулж болзошгүй юм. Дундад зууны үеийн Кернийн тайлбарласнаар бичгээр гаргасан хуулийг өөрчлөгдөшгүй бөгөөд хатуу чанд гэж үздэг байсан ба энэ нь бүрэн хэмжээний кодификаци биш зөвхөн бүгдэд хүртээлтэй ердийн заншил дээр үндэслэсэн хуулийн нэг хэсэг байсан юм. Бичмэл дүрэм, капитулууд(Меровинги гүрний үеийн хааны тушаал захирамж) нь бичигдээгүй ердийн заншил дээр үндэслэсэн хуулийг дагаж мөрдөх шалгуур болж байнга чиглүүлж өгдөг байв (1939:167).¹¹

¹¹ Кернийн хэлснээр дундад зууны үед хуулийг бичиж тэмдэглэсэн хүмүүс объектив хуультай харьцах

Тиймээс бичигдсэн хууль нь хамгийн тохиромжтой, биет бус зүйлийг тусган харуулдаг гэсэн ойлголт давтагдаж байна; хууль зүйн бичмэл эсхүл бичмэл бус хэлбэрийн аль нь ч байлаа гэсэн зөвхөн хуулийн нэг хэсэг л болох болно.

ФОРМАЛИЗМ БА ТҮҮНИЙГ ШҮҮМЖЛЭГЧИД

Өмнөх бүлгүүдэд өгөгдсөн жишээнүүдийн давтагдаж буй онцлог нь легализмд үл итгэх байдлын илэрхийлэл юм: эхэн үеийн Ромын бүгд найрамдах улс, дунд зууны Английн нийтлэг эрх зүйд байсан дүрэм журмын эмхэтгэл болон зарга мэдүүлэхээр шүүхэд хандах зөвшөөрлийн тогтолцоо нь албан ёсны хэлбэртэй, хатуу чанд байснаараа алдартай бөгөөд энэхүү тогтолцоо нь Фрайер (1986:894)-ийн хэлээд байдаг илүү уян хатан нөхцөл шаардлагатай асуудлыг шийдвэрлэх хууль зүйн шийдлээр хангаж өгөх хэрэгтэй юм. Афины шүүхэд нэхэмжлэл гаргагчид сөргөлдөгч талаа хууль зүйн хэт мэдлэгтэй гэж шүүмжилдэг эсхүл өөрсдөө тийм зүйл хийсэндээ уучлал гуйдаг байсан (Кэри, 1994); Хятад хуульчдыг 'ялихгүй зүйлээр зарга хийгчид' гэж гутаан доромжилдог байсан (МакКормак, 1996: 25); мөн Шариатад суурилсан шүүх хуралдааныг процедурын хэт хязгаартай гэж үзэж болно (Кларк, 2012: 114). Дундад зууны Европын шүүхүүдэд Иббетсоны хэлснээр (2007: 169) 'ёс заншлыг хуульчлах' ба энэхүү халдашгүй тогтвортой байдал нь өнгөрсөн үедээ үнэнч байх, зөв үр дүнд хүрэх хүсэл хоёрын хоорондох хурцадмал байдлыг бий болгосон; мөн энэхүү хурцадмал байдал нь эдлэн газрын тухай ердийн заншил дээр үндэслэсэн хууль болон нийтлэг хуулийг тодорхойлоход хүрсэн юм. Бонфилд (1989)-ийн тайлбарласан манорийн шүүхүүд (феодалын үеийн Английн хамгийн доод шүүх байсан) материаллаг хуулийг хэрэгжүүлэхээс илүүтэйгээр өмч хөрөнгө дээр үндэслэн маргаантай асуудлыг шийдвэрлэдэг байсан бололтой; Хуулийн дүрэм журмыг ягштал дагаж мөрдөхөөс илүүтэйгээр шударга ёсны үр дүн анхаарал татаж байсан нь ойлгомжтой.

Платоны хуулийн уян хатан бус байдлыг хурцаар шүүмжилснийг эргэн харъя. Тэрээр 'Улс төрийн зүтгэлтэн' болон 'Хууль' гэсэн хоёр номдоо хоёуланд нь хуулийн харгис бурангуй ёст дэглэмийг шүүмжилж бичсэн байдаг: хууль нь түүний тушаалыг зөрчсөн аливаа зүйлийг хийхийг зөвшөөрдөггүй, асуулт асуухыг ч зөвшөөрдөггүй 'зөрүүд, мунхаг хүн' шиг юм; Энэ нь захирамжаа ханан дээр бичүүлж, үүнийгээ мөрдүүлдэг дарангуйлагч эсхүл харгис ноён мэт тушааж айлган сүрдүүлдэг (Наятингэйл, 1999: 114, 117). Гэсэн хэдий ч сайн хууль түгээгч байх боломжгүй гэж Платон хэлээгүй бөгөөд Хуулиудын дийлэнх хэсэг нь энэхүү төслийн мөн чанарыг тайлбарлахад зориулагдсан бөгөөд заналхийлэх болон тушаан захиргаадахгүйгээр хууль ёсны зан үйлийг зааж өгөх, өдөөх үүнд итгэл үнэмшил төрүүлэхээр хуулиудын 'оршил'-ыг

нь ховор байсан бөгөөд хэзээ ч объектив хуулийн бүрэн, системчилсэн кодификацыг сонирхож байгаагүй, харин хувь хүний субъектив эрхийг тодорхойлох тухай анхаарч үздэг байжээ (1939: 176)

бичих шаардлагатай болно; хууль нь эцсийн дүндээ тэнгэрлэг мэргэн ухааны бүтээл байх ёстой юм.

Платоны онцлон тэмдэглэсэн хуулийн уян хатан бус байдлын хор уршиг нь хууль эрх зүй, улс төрийн онолын хүрээнд илүү орчин үеийн мэтгэлцээнээс урган гарсан 'формализм' эсхүл 'легализм'-ийн шүүмжлэлүүдэд давтагдсан болно. Аливаа нийгмийн доторх олон тооны ашиг сонирхол, зорилгыг харгалзан үзвэл Чроустын (1963) хэлснээр өөрчлөгдөшгүй, төгс логик хуулиар тогтоосон ямар ч дээд, үнэмлэхүй үнэ цэнэ байж болно гэсэн санаа нь утга учиргүй юм. Хуулийн динамик чанарыг хадгалахад хоёрдмол утгатай байх нь үнэхээр чухал юм. Тиймээс, 'шийдвэр, хууль бүрийг урьд өмнө мэдэгдэж байсан таамаглалаас логик хэрэгцээ шаардлагаар урсан гарах ёстой гэж шаардах нь боломжгүй, утгагүй санал юм.' Хүний амьдралын туршлагыг логик эсхүл 'хууль ёсны' систем болгон хувиргах нь түүний гол утга санааг алдагдуулсантай адил болно (1963: 6–8). Улс төрийн онолч Жудит Шклар Легализм-ийн талаарх номдоо хууль ёсны үзэл бодлын хатуу чанд байдал, хуулийг ёс суртахуун, улс төрөөс илт ялгагдах салангид оршин байдаг гэж үзэх хандлагыг шүүмжилдэг (1964: 8–9).¹² Легализмийн хэт их аюулт нөлөөллийг орчин үеийн Британийн шүүх байгууллагын гишүүд хүртэл илэрхийлж байсан: Бермудийн Үндсэн хуульд заасан хүний эрхийн заалтыг тайлбарлахтай холбоотой хэрэг дээр Лорд Вилберфорс шүүх Их Британийн болон Хамтын нөхөрлөлийн шүүхийн аль алинд нь ихэвчлэн дурдагддаг дүрэм болох 'хүснэгтэлсэн легализмийн хатуу чанд байдал'-аас зайлсхийх ёстой гэж мэдэгджээ.¹³ Легализмийн ашиг тус, хор хөнөөлийн талаарх норматив маргаан нь урт удаан хугацаанд үргэлжилж байгаа бөгөөд энэхүү маргаан нь намжих шинжгүй байдаг нь тодорхой юм.

Эмпирик асуудлын хувьд нийгэм, улс төрийн янз бүрийн нөхцөлд өргөнөөр тархсан хууль зүйн сэтгэлгээг хатуу, албан ёсны дүрэм, ангиллын хор хөнөөлийн талаар онолын эргэцүүлэл байнга дагалдаж байдаг. Ялангуяа шударга ёс нь гол зорилго болж байгаа газар хууль зүйн дүрэм, ангилал нь зайлшгүй сул талтай байдаг бөгөөд бодит амьдралын нарийн түвэгтэй байдлыг бүрэн төгс гаргаж чаддаггүй гэдгийг антропологичид байнга хэлдэг. Шауэрийн (1988:547–48) тайлбарласанчлан дүрэмд тулгуурлан шийдвэр гаргах нь угийн тогтворжсон зүйл боловч хууль нь илүү дутуугүй бүгдийг ерөнхийд тусгасан байдаг. Өөрөөр хэлбэл Лукас (1977: 96) энэ асуудлыг нарийн тодорхойлсны хувьд хууль нь «чухамдаа хүмүүсийг анхаарч үздэггүй. Энэ нь хүмүүсийг биш харин ижил төсөөтэй эргүүдийг авч үздэг». Хууль нь ихэнхдээ шударга ёсыг амладаг боловч хэргийн нарийн ширийн зүйлийг анзаарч хардаггүй. Легализм ба шударга ёсны хоорондох хурцадмал байдлын талаар дараагийн бүлгүүдэд дурдах болно.

¹² МакКормик (1989) нь эсрэгээрээ «ёс зүйн хууль эрх зүй»г дэмждэг.

¹³ Дотоод хэргийн нарийн бичгийн дарга, Фишер [1980] АС 319, 329.

ЭРХ ЗҮЙ БА ОЛОН УРГАЛЧ ҮЗЭЛ

Легализм нь тодорхой хэв маягийн аргумент, шүүмжлэлтэй тусгах боломжийг олгодог (Дрэш, 2012: 12-14). Бид дэлхийг ерөнхий ангилалд, жишээлбэл, өөр өөр төрлийн гэрээнд хуваасны дараа хүчин төгөлдөр болох янз бүрийн нөхцөл, зөрчлийн төрөл, үр дагаврын талаар бид маргаж болно; өөр өөр хууль тогтоомжийг бие биенийх нь эсрэг тавьж, хязгаарлалт болон үл хамаарах зүйлийг тодорхойлж, хууль ёсны үндэслэл ба тайлбартай холбоотой дүрэм, зарчим нь шүүх хуралдаанд давамгайлах болно. Хуулийг практик нөхцөл байдалд хэрэгжүүлэх үед энэ нь зайлшгүй болох зүйл юм. Тохиромжтой байдал хэзээ ч төгс төгөлдөр байдаггүй бөгөөд шүүх тодорхой хэрэгт тулгарсан тохиолдолд дүрмийн хамрах хүрээг зааж өгөх шаардлагатай байдаг, эсхүл дүрэмд үл хамаарах зүйл эсхүл хязгаарлалт бий болгосноор илт шударга бус байдлаас зайлсхийх боломжтой. Онорегийн (1977) онцлон тэмдэглэснээр үндсэн хуулиудын хамрах хүрээ, тэдгээрийн хамаарлыг тодорхойлох нэмэлт дүрмийг боловсруулах шаардлагатай байна. Өмнөх бүлгүүдэд яригдсан Английн нийтлэг хууль, Исламын фик, Хиндугийн дармашастра номлолын илүү нарийн тогтолцоонд нарийн дүрмүүд голлох байр суурь эзэлдэггүй бөгөөд хууль зүйн тусгал, дүгнэлтийн хэлбэрүүд нь дотроо зүйрлэлээр тайлбарлах, тайлбарлалын боловсронгуй онолыг багтаасан байдаг.

Эдгээр бүх төрлийн хэрэгт аргумент үүсгэх эрх зүйн хэлбэр улам бүр нэмэгдэх хандлагатай байна. Энэ нь ялангуяа хуульч эрдэмтдийн хувьд үнэн боловч энэ нь гуравдугаар бүлэгт хэлэлцсэн эртний кодексоос мөн тодорхой харагдаж байна. Миллер (1990: 225) нь дундад зууны Исландын кодексын нарийн төвөгтэй байдлын талаар тайлбар хийсэн бөгөөд, түүний хэлснээр, албан ёсны транскрипц нь хууль боловсруулах чадварыг хязгаарладаггүй ажээ. Ямар ч тохиолдолд энэ нь үүнд нөлөөлсөн бололтой, хуулиуд бичигдээд удаагүй байхад иш татах хууль гаргах шаардлага гарч ирэв. Ромд мөн адил, янз бүрийн хуульч нарын санал бодол тархах, хоорондоо уялдаа холбоо байхгүйгээс үүдэлтэйгээр санал бодлыг эрэмбэлэх зорилгоор ишлэлийн дүрмийг хожмын эзэнт гүрний үед боловсруулсан байдаг (Николас, 1962:37). Кантор (2012:76) нь хожмын Ромын бүгд найрамдах хуулийн янз бүрийн эх сурвалжуудын дунд тодорхой шатлал байхгүй байгаа талаар тэмдэглэсэн байна. Фрайерын хэлснээр (1985:194), Ром нь бие даасан эрх зүйн сэтгэлгээний логик зөрчилдөөнтэй тулгарсан, энэ нь шүүхээр дамжуулан баталгааг эрэлхийлэх нь хуулийн нарийн түвэгтэй байдал, тодорхойгүй байдлыг хүлцэх чадварыг нэмэгдүүлдэг явдал юм.

Хууль экспортлох үед өөр нэг төрлийн дэлгэрэлт явагддаг. Ромчууд эзлэн түрэмгийлсэн зүүн мужуудын нутаг руу нүүж ирэхдээ хуулиа өөртэйгөө хамт авч явсан юм: Ромын иргэд өөрсдийнхөө хуулийн давуу талыг олж харсаар

байв.¹⁴ Үүний зэрэгцээ, Канторын (2012:78–79) тайлбарласнаар Ром нь эзлэн авсан мужуудынхаа ‘өвөг дээдсийн хуулийг’ хадгалахыг эрмэлздэг бөгөөд Ромын захирагчид орон нутгийн хуулийг хүлээн зөвшөөрдөг байсан юм. Ийнхүү Ромын эрх зүйн хэлбэрийн талаарх мэдлэг өргөн тархаж, холимог хуулиуд хөгжиж байхад МЭ II зууны эцэс хүртэл олон хууль тогтоомжууд хадгалагдан үлджээ. Гэсэн хэдий ч Ромчууд ямар хуулиуд хэнд, ямар нөхцөлд үйлчлэх ёстойг тодорхойлохын тулд ямар нэгэн хууль тогтоомжийн зарчмын зөрчилдөөн гаргаагүй байна. Хууль бол эзэнт гүрнүүдийн хэрэгжүүлэх ёстой удирдлагын тогтолцооноос илүүтэйгээр ард түмний нэхэмжилж болохуйц нөөц бололцоо байсан бөгөөд бүрэн эрхэт, уялдаа холбоотой байх ёстой байв. Канторын онцлон тэмдэглэснээр, энэ нь Разын “хууль бүр эрх зүйн тогтолцоонд хамаарах ёстой” (Раз, 1973: 1) гэсэн баталгаанд эргэлзээ төрүүлж байгаа бөгөөд энэ хууль нь үргэлж бүхнийг хамарсан, дээд зэргийн гэж үздэг байна (1979: 116-21).

Дрешийн (2012:14) онцлон тэмдэглэснээр, энэ бол янз бүрийн хууль эрх зүй зэрэгцэн оршдог гэж бодож байсан цорын ганц газар биш юм. Жишээлбэл, эртний Малайя adat perpateh (олон нийтийн эсхүл нийгэмлэгийн зан заншил)-ыг adat temengong (ноёдын тогтоосон ёс заншил)-аас, исламын шариатаас салгасан байдаг. Англид XIII зууны дунд үе гэхэд иргэний, сүмийн, ерөнхий, бүс нутгийн болон ерөнхий хуулиудын хооронд ялгаа бий болсон байв (Иббетсон, 2007: 155). Түүнчлэн хот, дүүрэг, тосгон, боомтын шүүх, мөн түүнчлэн худалдаачдын шүүх зэрэг олон тооны шүүхүүд байсан байна (Базиле нар, 1998:30). Эдгээрийн зарим нь, жишээлбэл, Лондонгийн шүүхүүд, Вестминстерийн хааны шүүхээс ялгаатай нь өөрсдийн зан заншлаа хадгалж, хүлээн зөвшөөрдөг боловч нийтлэг хуулийн системд сайн нэгтгэгдсэн байв; хааны хуулиар зохицуулагддаг ойн шүүхүүд нийтлэг хуульд хамрагдаагүй тодорхой асуудлыг шийдвэрлэдэг; арилжааны шүүхүүд нийтлэг хуулийг голчлон ашигладаг боловч өөрийн гэсэн үйл ажиллагааны дүрэмтэй байсан; цагаан тугалга олборлогчдын орд газрын шүүхүүд өөрсдийн зан заншлыг хэрэгжүүлдэг байсан бол манори шүүхүүд хууль, практикийг хослуулахыг эрэлхийлж байсан юм (Иббетсон, 2007: 170–71).

Хууль нь үргэлж нямбай, эмх цэгцтэй тогтолцоог бүрдүүлнэ гэж бид хүлээлттэй байх ёсгүй юм. XVIII зууны дараах Английн нийтлэг хууль гэх мэт хууль шүүхийн жишигт тулгарвал бид шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдээгүй зарим зөрчилдөөн, маргааныг олж харах болно. Үнэн хэрэгтээ, тодорхой нөхцөл байдалд зохих арга хэмжээг авахыг оролдсоноор шүүгчид хуулийг

¹⁴ Эхэндээ иргэний хууль (*ius civile*) нь Ромын иргэдийн бахархалтай эзэмшил байсан бөгөөд харийн хүмүүст (*peregrines*) ялгаваргүй хандаж чадахгүй байв. Ром бус хүмүүст хамаарах хууль нь олон улсын хууль (*ius gentium*) байв. Анх Ром дахь гадаадын иргэдэд хамааралтай байсан ч бүх ард түмний нийтлэг эрх зүйн тухай ойлголт болж хөгжиж, байгалийн хуулийн талаархи Грекийн үзэл санаатай холбоотой болж, Жастинианы үед бүх хууль тогтоомжид нийцэх ёстой загвар болж өргөжсөн утгыг олж авсан юм. (Валдрон, 2012: 33-35).

нэгэн зэрэг хүндрүүлж, цаашдын үйл явцыг зайлшгүй чиглүүлэх замаар асуудлыг улам дордуулж болзошгүй юм (Ватсон, 2001: 58–59). Ватсоны хэлснээр, Швейцарын холбооны байгууллагын хүрээнд хөрш зэргэлдээх муж, улсууд ноцтой санаа зовоосон асуудлаар өөр өөр хууль дүрмийг бий болгосон байна. Системийн уялдаа холбоогүй байх нь, ялангуяа үүнийг уламжлал гэж үздэг бол, аливаа хуулийн ердийн бөгөөд зайлшгүй тал юм: 'дамжуулагдсан өнгөрсөн үеийг оролцогч талууд өнөөгийнхөө эрх мэдэлтэй чухал хэсэг гэж үздэг' (Крайгиер, 1987: 34). Ийнхүү хууль нь үе дамжин 'их, бага оюун ухаан, алсын хараа, өөрийгөө ухамсарлах хувь нэмэр оруулсан хүмүүсийн хуримтлалыг агуулдаг'. Механизмууд нь уламжлалыг үгүйсгэх, хялбарчлах, засварлах мөн үлдсэн зүйлийг өөрөө өөртөө зориулж, хүчирхэгжүүлэхийн тулд байж болох ч энэхүү даалгавар нь тийм ч хялбар биш юм. Номлол нь дараагийн үеийнхний итгэж, төсөөлж, хэрэгжүүлж буй зүйлийг бүрдүүлэхийн тулд хэл соёлын нэгэн адил бага багаар хэлбэржиж үддэг (1987: 36).

Иймд эрх зүйн олон ургалч үзэл бол чухал бөгөөд өргөнөөр тархсан үзэгдэл боловч одоо дэлхийн өнцөг булан бүрт байдаг улсын хууль, зан заншил зэрэгцэн оршихоос хамаагүй илүү төвөгтэй зүйл юм; мөн дараагийн бүлэгт авч үзсэнчлэн үндэсний, олон улсын болон үндэстэн дамнасан хуулиуд зэрэгцэн оршихоос илүү олон зүйлийг багтаасан болно. Зарим хүмүүсийн хэлснээр колоничлол эсхүл Ромын дараах ертөнцийн онцлог шинж биш юм. Дүрэм, хууль зүйн практикийн хувьд олон тооны хууль тогтоомж нь зан заншил, захирагдах 'хууль' гэж тооцох өөр зүйлийг багтаасан, тодорхойлох төрийн болон давамгайлсан эрх зүйн тогтолцоо байхгүй тохиолдолд Европын түүхийг шударга хэмээн үздэг.

ОЛОН УРГАЛЧ ҮЗЭЛ БА ЭРХ МЭДЭЛ

Хуульч эрдэмтдийн гарт хууль ёсны сэтгэлгээний тархалт нь Исланд, Ромын ишлэлийн дүрмийг боловсруулсан хууль ёсны эрх мэдлийн асуудлыг мөн улам хүндрүүлж болзошгүй юм. Энэ бол ямар ч нутаг дэвсгэрийн эрх мэдэлд захирагддаггүй, асар их нөлөө бүхий оюуны тогтолцоо өргөн тархсан Исламд хурц хэлбэрээр үүсдэг асуудал юм. Исламын эрдэмтдийн хувьд эрх мэдлийн асуудал нь үндсэндээ шашны асуудал байдаг: шариатын тайлбар нь Коран сударт заасан Бурханы үгийн эрх мэдлийг үгүйсгэх хандлагатай байдаг байна. Исламын хуульчдад санаа зовдог зүйл бол хууль ёсны эрх мэдлийг хэрэгжүүлэх явдал биш харин 'нэр төдий бурханлаг', улмаар шариатын 'ойлгомжгүй' эх сурвалжид үнэнч байх явдал юм. (Кларк, 2010). Үнэн хэрэгтээ, МЭ 900 оноос хойш хууль зүйн үйл ажиллагаа нь уг сургаалын тайлбар, хэрэглээ, тайлбараар хязгаарлагдах ёстой гэж үзэх болсон байна. Гэсэн хэдий ч олон зуун жилийн турш хууль зүйн ном зохиол нь Мессикийн (1993:1-3) тайлбарласанчлан эцэс төгсгөлгүй нээлттэй, тайлбарлах боломжтой шариатын илтгэлийн талбар болж хөгжсөн юм.

Шариатыг орчин үеийн болгох, кодификаци оролдлогыг Османы дэглэмийн үед хийх үед түүнийг боловсруулсан гэж буруутгагдсан хүмүүс шариатын өргөн хүрээний ярианы улмаас бараг л ялагдал хүлээсэн бөгөөд үүнийг 'эрэггүй далай' гэж тодорхойлсон бөгөөд энэ нь Исламын олон сургуулийн эрдэмтдийн ашигладаг зүйрлэлийг давтдаг байна.

Мөн орчин үеийн Ливанд шашны эрдэмтдийн бүтээсэн 'гайхалтай оюуны бүтээгдэхүүн' болон 'фик-ын урсгал'-ыг Кларк (2010) дүрсэлжээ. Түүний ажигласнаар, Шиа шашинтай лалын шашинтнуудын дунд нэр хүнд нь мэргэжлийн хүмүүсийн харьцангуй албан бус шатлалд харьяалагдсан хэвээр байгаа бөгөөд ингэхдээ хязгаарлагдмал тооны 'дуураймал эх сурвалж' буюу маржа-ны дээд цэгт хүрдэг, өөрөөр хэлбэл, энэ бол үзэл бодлыг нь, фатва-г, дагаж мөрдөж болох эсхүл дагаж мөрдөх ёстой хүмүүс юм. Нөлөө өндөртэй, нэр хүндтэй эдгээр эрх мэдэлтнүүд одоо хүнд сурталтай зүйлсээр хүрээлэгдэж, оффисууд нь албан тушаалтнууд, шүүгчдээс бүрдээд байна. Нэг Аятолла өөрийн гэсэн 'шүүх'-тэй байдаг, жишээлбэл, санхүүгийн маргааныг түүний ажилтнуудын нэг нь шийдвэрлэдэг. Гэсэн хэдий ч Кларкийн олж мэдсэнээр бүтцээр дамжин өнгөрөх эрх мэдэл нь хувийн шинж чанартай хэвээр байгаа бөгөөд албан тушаалтнуудын ажил нь зураг, гарын үсэг, тамга байрлуулах замаар хувь хүний маржа-тай холбоотой байдаг. Тэрээр хэлэхдээ, аливаа утга учиртай зүйлийг бататгахын тулд эрх бүхий хүмүүсийн санал хүсэлтийг хүлээн зөвшөөрөгдсөн хүмүүстэй холбох шаардлагатай байдаг гэсэн юм (2010: 379). Эрх мэдэл бүхий хоёр хүн хамтдаа аз жаргалтай суухгүй байсан ч хүнд суртал нь албан ёсоор хувь хүнээс хамаардаг байна (2010: 367). Төрийн албан тушаалтнууд орчин үеийн Исламын ертөнцийн зарим хэсэгт шариатын тайлбарыг монопольчлохыг оролдсон хэдий ч түүний нээлттэй байдал, тайлбарлах чадвар хэвээр байгаа бөгөөд шинжлэх ухаан тархсаар байна. Үргэлж өсөн нэмэгдэж буй фатва буюу үзэл бодол болон бусад тайлбар бичвэрийн эсрэг тэмцэхийн тулд эрх мэдлийн талаарх нэхэмжлэл нь хүлээн зөвшөөрөгдсөн хүмүүстэй холбоотой байх ёстой юм.

Хууль зүйн тайлбарын тархалтаас үүдэлтэй асуудлууд нь хууль эрх зүйн бүх агуу уламжлалд бий болдог талаар өмнөх бүлгүүдэд үзсэн билээ. Энэтхэгийн эрдэмтэд Ведаг алдагдсан, тиймээс ойлгомжгүй хуулийн эх сурвалж гэж үзсэн байдаг. Дараа нь дармашастра нь энэ хуулийн эрх мэдэлтэй тайлбар болсон юм. Хинду шашны эрх зүйд хууль ёсны эрх мэдлийг өөр өөр хүмүүс, бүлгүүдэд хуваарилдаг байсан бөгөөд энэ нь Дэвисийн (2012) тайлбарласнаар хязгааргүй хууль ёсны олон ургалч үзлийн соёл гэж тодорхойлсон зүйл рүү хөтөлдөг. Ромд цөөн тооны хуульч эрдэмтэд ч гэсэн өөр өөр үзэл бодолтой байж болох тул иш татах дүрмийг хэрэгжүүлэх шаардлагатай байв. Мэдээжийн хэрэг, хүчирхэг захирагч хуульд кодификаци хийхийг тушааж болно. Юстиниан болон Наполеон хоёулаа хуулийг бүрмөсөн засч залруулах, цаашдын тайлбар хийхийг хориглох тухай эзэн хааны мэдэгдэл гаргасан боловч тэдний оролдлого эцэстээ Наполеоны хувьд хурдан бүтэлгүйтсэн

юм (Келли, 2002). Үүний эсрэгээр, Английн нийтлэг хууль тогтоомжид Бентхамын кодификаци хийх тухай уриалгыг үл тоомсорлож, оронд нь өмнөх шийдвэрт тусгагдсан хууль дээдлэх зарчим нь дараагийн шүүгчдэд заавал дагаж мөрдөх жишиг зарчим болдог гэсэн зарчмыг боловсруулсан юм. Симпсоны (1987) тэмдэглэснээр, XIX зуунаас өмнө нийтлэг хууль нь үндсэндээ зан заншлын нэг хэлбэр байсан, өөрөөр хэлбэл хуульч нарын хүлээн зөвшөөрсөн ерөнхий практик, зарчмууд болох хууль тогтоомж, зарчим, стандартуудын нэг хэлбэр байсан бөгөөд тэдний дунд мэргэжлийн өвөрмөц байдал, эв нэгдлийн мэдрэмж нь тууштай байдал, зөвшилцлийг бий болгох боломжийг олгодог байна. Гэсэн хэдий ч хэргийн түүх, шастир хэлбэрээр хууль эрх зүйн материалыг олшруулсан нь эрх мэдлийг зохицуулах албан ёсны зарчмуудыг боловсруулж, эцэст нь урьдын тогтолцоог бий болгох шаардлагатай болгосон гэж үзсэн байна. Гэсэн ч хууль 'системээс илүүтэйгээр төөрөгдөл мэт' хэвээр үлджээ (1987: 381).

Орчин үеийн хууль зүйн шинжлэх ухааны ихэнх бичээснүүд нь хуулийн эрх мэдэлтэй холбоотой байдаг, өөрөөр хэлбэл эрх зүйн хэм хэмжээний заавал байх ёстой байдлын онолын хувьд тууштай тайлбарыг бий болгох оролдлого хийхтэй холбоотой юм.¹⁵ Үүнийг ихэвчлэн жишээ нь «Бид яагаад хуулиа дагаж мөрдөх ёстой вэ?» эсхүл «шүүгчийн шийдвэрийг баталгаатай болгодог зүйл юу вэ?» гэсэн асуултаар илэрхийлэгддэг. Остины захирагчийн тушаалын онол, Хартын анхдагч ба хоёрдогч дүрмийн онолыг энэ асуудлын шийдэл гэж үзэж болох юм.¹⁶ Хоноре (1977), Лукас (1977) зэрэг хэд хэдэн онолчид хуулийг бусад төрлийн дүрмээс ялгаж салгах механизм байдаг гэж үздэг. Гэсэн хэдий ч Постемагийн (2002:616–20) тайлбарласнаар нийтлэг хуулийг гүйцэтгэх механизмаар баталгаажсан удирдамжийн хууль гэдэг утгаараа эрх бүхий дүрмийн багц гэж шинжлэх нь үнэмшилтэй биш юм. Шүүхийн үүрэг бол хуулийг хэрэгжүүлэхийг шаардах ажил биш; харин хуулиар тодорхойлсон талуудын байр суурийг тодорхойлж, ямар арга хэмжээ авах нь тохиромжтой болохыг тодорхойлох явдал юм. Материаллаг хууль нь эрх мэдэл, эрх мэдлийг ашиглан нарийн тодорхойлсон эрүүгийн шийтгэл эсхүл иргэний шийтгэлийг хэрэгжүүлэхийн тулд зөвхөн албадлагыг зөвтгөдөг. Энэ бол түүний хийдэг бүх зүйл биш юм: энэ нь ерөнхий болон институцийн аль алиных нь хэлэлцүүлгийг хийх боломжийг олгодог практик үндэслэлийн систем юм.

Дэлхийн дэвшилтэт эрх зүйн тогтолцоонд онолын хувьд ч гэсэн тууштай асуудал мэт санагдаж байсан зүйл бол эрх мэдэл бүхий хууль зүйн тайлбарын ангилал, эх сурвалжийг хязгаарлах явдал байв. Асуудал нь хэтэрхий бага биш, харин хэтэрхий их эрх мэдэлтэй холбоотой байсан юм.

¹⁵ Янсен (38.8) нь эрх мэдлийн албан бус эх сурвалжийн талаар нарийн мэдээлэл өгдөг бөгөөд албан ёсны хууль тогтоомж, эдгээр бичвэрийн ойлголтын хажуугаар ихэвчлэн хийдэгддэг байна.

¹⁶ Лухманн (1988) хүртэл шүүгчийн эрх мэдлийн тухай асуудлыг гуравдугаар бүлэгт дурдсанчлан чухал боловч «харнулт өгөх боломжгүй» асуулт гэж үздэг.

Хуулийн эрх мэдэл ба түүнийг тайлбарлагчдын эрх мэдлийг ялгаж салгаж авч үзэх шаардлагатай юм. Бурханы хууль, Веда, шариаат, иргэний эрх зүй, нийтлэг хууль нь бүгдийг буруу тайлбарлах энгийн ертөнцөөс тусдаа гарч, давж гардаг гэж үздэг бол хуульчид, эрдэмтэд өрсөлдөгчдийнхөө тайлбарыг өөрийнхөөрөө тайлбарлах эрх мэдлийг тогтоохын төлөө тэмцдэг байна.

Хуулийг сахих нь хамгийн энгийнээр бол практикаас ангид, өдөр тутмын амьдралын эмх замбараагүй бодит байдлыг дэг жаягтай болгоход ашиглаж болох бөгөөд энэ нь эквивалент, дараалсан эрэмбийг бэлгэддэг, мөн нийгмийн харилцааны боломж, түүнчлэн эрх мэдэл бүхий шүүлийг бий болгодог дүрэм, зарчим, ангиллыг бий болгодог. Гэхдээ хууль зүй нь чухам дүрмүүдийн хоорондын харилцаа, ангиллын ялгаа, тайлбарын канонуудыг эрэлхийлдэг сэтгэхүйн хэлбэр, хууль ёсны үндэслэлийг бий болгодог байна. Энэ төрлийн үндэслэл тархах үед үндсэн хууль гэж үздэг зүйлийн эрх мэдэл тодорхойгүй болж, үндсэн дүрэм, зарчмын мөн чанар нь парадоксик байдлаар тодорхойгүй болдог. Тиймээс бид эрх мэдэл, тогтолцоо, уялдаа холбоо гэсэн үзэл баримтлалд хэт их автаж, хуулийн талаар хэтэрхий ойлгомжтой, энгийн, системтэй байхыг хичээх ёсгүй. Бид хуулийг эмпирик үзэгдэл гэж ойлгохыг хичээдэг бөгөөд энэ нь хууль ёсны сэтгэлгээний хүсч буй олон талт байдал, тархалт, түүнчлэн хууль зүйн категорин олж авч болох хатуу байдал, формализмыг хүлээн зөвшөөрөхийг хэлдэг. Энэхүү хууль нь өндөр дэг журмыг бий болгож, шударга ёсыг дахин давтагдах эх үүсвэр болно гэж амлаж байна. Энэ талаар дүгнэлт хэсэгт эргэн авч үзэх болно. Дараагийн бүлгүүдэд хууль ёсны сэтгэлгээний бусад жишээнүүд, түүний ёс суртахуун, олон нийт, төртэй харилцах харилцааны талаар авч үзэх болно.

*Орчуулсан: Монголын Криминологичдын холбооны ахлах судлаач
С.Номынбаясгалан, судлаач О.Анударь, гэрээт судлаач З.Тамир*

UIN.MN
СУДАЛГААНЫ САН



Г.ЗОЛЖАРГАЛ

Соёлын гавьяат зүтгэлтэн, сэтгүүлч

ӨНӨӨДӨР ТА БУСДЫН ХУВИЙН АМЬДРАЛ РУУ
ӨНГИЙЖ, ХУВИЙН НУУЦЫГ ДЭЛГЭЖ БАЙГАА БОЛ
МАРГААШ ТАНЫ ХУВИЙН ОРОН ЗАЙД ХЭН НЭГЭН
ХАЛДАНА ГЭСЭН ҮГ
IF YOU INVADE PRIVATE SPACE OF OTHERS AND
REVEAL THEIR PERSONAL INFORMATION TODAY, IT
MEANS YOUR PRIVATE SPACE COULD BE INVADED
TOMORROW.

Соёл урлагийн их сургуулийн Радио телевиз медиа урлагийн сургуулийн хүндэт профессор, найруулагч, сэтгүүлч Г.Золжаргал. Тэрээр сэтгүүл зүйн салбарт баримтат нэвтрүүлэг, кино, хөрөг, нийтлэлийн чиглэлээр сэтгүүл зүйн салбарт 30 гаруй жил ажиллаж, олон бүтээлийг үзэгч, уншигчдад хүргэсэн.

Тэрээр «Уран бүтээлч байх гэвэл дарга, даамлаас хол байх хэрэгтэй. Мөнгө хэрэгтэй гэвэл тэдэнд ойр бай. Өөрийгөө, сэтгэлээ хир буртаггүй байлгах юу юунаас чухал. Гэхдээ өнөөгийн нөхцөлд тийм байх боломж нь бүрдээгүй байна. Сэтгүүлч, уран бүтээлчдийн дунд чин шударга хүн ховор байна. Энэ нь тэдний буруу биш. Сэтгүүлчид ахуйн хэрэглээнээсээ салаагүй, ядуу, мөнгөгүй, амьдралын боломжгүй байна. Хэчнээн ёс зүйтэй байлаа ч хүний амьдралд мөнгө чухал байр суурь эзлэх нь ойлгомжтой. Хэрэгцээ байгаа цагт мөнгийг нь авч хүссэнийг нь бичихээс өөр аргагүй. Түүний цаана Монголын

баялгийн хуваагаад халаасалсан улстөрчид, бизнесменүүд “худалдаж” авсан сэтгүүлчийнхээ үгээр бие биеэ шүршиж зугаацдаг. Сэтгүүлчид маань үүнээс аль болох хол байхыг хичээх хэрэгтэй” гэж нэгэнтээ хэлсэн байдаг.

Ингээд “Хүний эрх” сэтгүүлийн ээлжит зочноор Соёлын гавьяат зүтгэлтэн, сэтгүүлч Г.Золжаргалыг урилаа. Түүнтэй уран бүтээл, сэтгүүл зүйн салбарын алдаа онооноос илүүтэй хүний эрхийн асуудлаар ярилцсан ярилцлагаа хүргэе.

Улс эх орныхоо хамгийн гүнд нь явдаг сэтгүүлчдийг нэрлэ гэвэл та жагсаалтын дээгүүр бичигдэнэ гэдэгт итгэлтэй байна. Хүн өөрийнхөө амьдралын оршихуйг эргэж хараад дүгнэвэл их сонин дүгнэлт гарах байх. Энэ утгаараа та өөрийнхөө сэтгүүл зүйн салбарт үлдээсэн түүхийг сөхөж харвал юу гэж дүгнэх бол?

Сонирхолтой асуулт байна. Тухайн цаг үеийн сэтгүүл зүйн салбарын ажиллах зарчим өөр байлаа. “Яг одоо Дорнод руу яв” гэвэл шууд л явна. Дэгсдүүлж хэлбэл, онцгой байдлын аврагч гэх юм уу даа. Бидний уран бүтээлийн сэдэв тэнд байгаа юм хойно явж л таарна. Хамгийн гол нь тухайн сэдэв, асуудлыг иргэдэд хэрхэн, яаж хүргэх вэ гэдэг нь чухал. Мэдээ, сурвалжилгаа үзэгчдэд хүргэлээ. Бүрэн судалсан уу, эсвэл мэдлэг дутуу байна даа гэж бодох сөхөө байдаггүй байсан.

Залуу байхад юу л байна, зориг байна. Галзуу барын аманд ч гараа хийхээс буцахгүй гэдэг шиг сэдэвтээ шатна, асна. Дагаад яарна. Үүнээс болж алдаа гаргах эрсдэл нэмэгдэнэ. Тэр алдаа нь зөвхөн сэтгүүлч хүнээр дуусахгүй. Бүхэл бүтэн айл, гэр бүл, цаашлаад улс эх орон, нийгмийн асуудал болж хувирдаг учир маш их эрсдэлтэй.

Тиймээс залуу сэтгүүлчдэд хандаж нэг зүйл хэлмээр байдаг юм. Бидний хийж байгаа ажил бол маш эрсдэлтэй. Нийт монголчуудын оюун санаа, зүрх сэтгэлд нь тусах бүтээл туурвиж байгаа учраас олон талаас нь харж, бодолцож, зөв өнцгөөс нь мэдээлэх байх ёстой.

Би сургаал айлдаж байгаа юм биш үү. Нийгмийн урсгал зөв замаар явах эсэх нь мэдээж хууль эрх зүйн орчноос шалтгаална. Гэхдээ чиглүүлэгч луужин, нөлөөлөгч нь сэтгүүлчид.

Надад алдсан алдаа байна, оноо ч байна. Оносон зүйл нь гэвэл, хурдтай, зоригтой байж. Зарим зүйлийг мэдлэгээрээ “зодож” хийж. Мэдлэг дутуу, сайн судлаагүй, хөөрч хийсэн сэдвүүд дээр алдсан, хожим эргэж хараад багагүй гэмшсэн. Ер нь тэгээд өөртөө “гологдох” мэдрэмж их муухай.

Энэ асуудлыг би “алдаж” мэдээлснээс болж ийм зүйл болсон гэдэг ч юм уу, та кэйс ярих боломжтой юу. Та түрүүн хэллээ шүү дээ. Залуу байхад сэдэвтээ шатдаг, дагаад алдах эрсдэл нэмэгддэг гэж. Тиймээс сэтгүүлчдэд бага ч гэсэн туршлага болох байх гэж найдаж байна?

Том алдаа гэхээс илүүтэй эргэлзээ төрүүлж байсан бодит кэйс байсан. Жишээлбэл, иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “Хар хавтас” нэвтрүүлэг бэлтгэж байсан үе. 1990 он байх аа. Цагдаагийн байгууллагаас мэдээлэл авч найруулагчтайгаа хамт нэг аймагт ажилласан юм. Тухайн үед цэргийн алба 2 жил болчихсон байсан үе. Цэргээс дөнгөж халагдсан найзыгаа нутгийн залуучууд нь дайдж. Уусан, согтсон. Ингээд гэртээ очтол эхнэр нь 8-хан сартай хүүхэд тэврээд угтаж. Гэтэл биеэ хянах чадваргүй болтлоо согтсон залуу “Чи хэний хүүхдийг тэвэрчхээд инээгээд угтаж байгаа юм” гээд нөгөө нялх хүүхдийг хананд савчихсан. Аймшигтай байгаа биз.

Нөхцөл байдлыг нүдээр үзэж, сонсоход надад маш хэцүү байсан. Яаж мэдээлэх бэ. Иргэд яаж хүлээж авах бол гэдгээс эхлээд бодох зүйл олон байсан. Тэгтэл энэ хэргийг дуулиантайгаар мэдээлэхээс илүүтэй залуучуудад сургамж болгох өнцгөөр мэдээлэх нь зүйтэй гэж цагдаагийн алба хаагч хэлсэн юм.

Архи ууж болно. Гэхдээ хэтрүүлж хэрэглэж болохгүй. Дээр нь тухайн хэрэг үйлдсэн залуу цэргийн алба хааж байхдаа 5 хоногийн чөлөөгөөр гэртээ харьснаа мартсан уу. Эхнэр нь үнэхээр хуурсан уу, эсвэл хүчинд автсан уу гэдгээс эхлээд олон талаас нь харж мэдээлэх нь зүйтэй шүү гэж хэлсэн.

Тэр хэргийг мэдээлсэн үү?

Мэдээлсэн. Энэ хэргийн дараа их зүйл бодсон. Ийм харгис хэргийг мэдээлэхдээ маш болгоомжтой байхгүй бол хохирогч дахин хохирох эрсдэлтэй юм байна. Нөгөөтэйгүүр, цэргийн албанаас халагдаж байгаа бусад залуучуудад буруу сэдэл өгөх вий гэдгээс маш их айсан.

1990 он гэхээр МҮОНРТ-ийн редакц чанга шүүлтүүртэй байсан үе үү?

Ардчилсан хувьсгалын дараа нэг хэсэг үе сэтгүүлчид нээлттэй, чөлөөтэй ажиллах ёстой гэдэг зарчим барьдаг болсон юм. Нэг, хоёр өдрийн өмнө зураг авалтаа хийлээ, монтажилж, найрууллаа, эфирт гэдэг зарчим 2 жил шахам үргэлжилсэн. Тухайн үеийн сэтгүүлчдэд ямар асуудлыг хэрхэн, яаж мэдээлэх вэ гэдгийг эргэцүүлж бодох, шийдэх боломж байсан. Яагаад гэвэл, ахмад үеийн сэтгүүлчид дуугай өнгөрнө гэж байхгүй шүү дээ. Ингэж мэдээлж болохгүй, нийгэмд сөрөг нөлөө үзүүлнэ гэдгээс эхлээд сургаж, зөвлөнө. Дээр нь долоо хоног бүр редакцын шуурхай хийнэ. Хэн, ямар асуудлыг мэдээлэхдээ алдаа гаргасан, судалсан уу, судлаагүй юу гээд.

Гэтэл 1996 оноос хойш чөлөөт сэтгүүл зүйн хөгжил эхэлсэн. Борлуулалт сайн байж санхүүгийн эх үүсвэрээ шийдэх учир аль болох дуулиантай мэдээг шүүлтүүргүйгээр түгээж эхэлсэн. Шар хэвлэл гэхээр бүгд мэдэх байх.

Монголчууд эрх зүйт төрийг цогцлооно гэж ардчилсан хувьсгал хийсэн. Гэтэл “эрх чөлөө” гэсэн малгай дор Монгол Улсын Үндсэн хууль, бусад

дагалдах хуулиар баталгаажуулсан хүний эрхийг зөрчиж байгаа эсэхээ анзаарахгүйгээр бүгд “уралдсан”. Бүх нийтээрээ шүү. Өрсөлдөөний тухай ойлголтгүй хүмүүс түрүүлж мэдээлэх ёстой юм байна гэж бодохгүй гээд ч яах юм. Гэтэл тэр дуулиан дэгдээх, түрүүлж мэдээлэх гэдэг зүйлийн цаана хүний эрх ноцтойгоор зөрчигдөж байсан. Үүнийг хэн ч анзаараагүй. Хүний эрхийн Үндэсний Комисс 2001 онд байгуулагдсан билүү.

Улсын Их Хурлаас 2000 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг баталж, анхны гишүүд томилогдсоноор Монгол Улсад хүний эрхийн үндэсний байгууллага байгуулагдсан.

Комисс байгуулагдсаны дараа хүний эрхийн анхаарал татсан олон асуудлыг хөндөж байсныг санаж байна. Аливаа юманд цаг хугацаа хэрэгтэй. Үүн шиг хүний эрхийг хамгаалах тогтолцоог үр дүнтэй ажиллуулахад хугацаа орно. ХДХВ/ДОХ-ын халдвар авсан гэдэг ташаа мэдээллээс болж нөхөртөө зодуулж амь насаа алдсан эмэгтэйн үхэлд би маш их харамсдаг. ДОХ гэдэг үг нийгмийг айдаст автуулсан байсан учир тэр цуу яриаг сонссон нөхөр ийм аймшигтай гэмт хэрэг үйлдсэн. Ганц тэр эмэгтэй амь насаа алдаад дуусаагүй, хоёр хүүхдийнх нь амьдрал орвонгоороо эргэсэн. Өнөөдөр тухайн мэдээллийг мэдээлсэн сэтгүүлч тэнгэрт дэвшсэн байна. Монголын сэтгүүл зүй зөв замаар явахгүй байгааг өөрийн биеэр нотолсон доо, хөөрхий.

Мэдээллийг нягтлалгүйгээр мэдээлсэн сэтгүүл зүйн салбарын буруу юу, гэвэл буруу. Мэдээлэлгүй иргэд, мэдлэггүй сэтгүүлч ийм аюултай.

Энэ хэргийг нөгөө хувилбар нь 2024 оны зун гарлаа. Найман настай хүүхдийг хулгайлсан гэмт хэргийг бүх нийтээрээ дуулиан болгосон. Эцсийн үр дүнд гэмт хэрэгтэнд ямар нөлөө үзүүлсэн бэ, бодож үзэх хэрэгтэй.

Иргэдийн хүний эрхийн мэдлэг, боловсрол дутмаг байна. Би нэг зүйлийг боддог юм. Сэтгүүлч хүний суурь боловсрол, хүмүүжил маш чухал. Дээр нь хууль эрх зүйн мэдлэг, өрсөлдөөний талаарх ойлголт, ямар ч асуудлыг хүний эрхийн талаас харах чадвартай байх ёстой. Тэгэхгүй бол ямар ч эрсдэлийг үүсгэж мэднэ.

Тухайн хувь сэтгүүлчээс гадна редакцын бодлого, удирдлагын алсын хараа чухал байх?

Тэгэлгүй яах вэ. Чавхны чулууг мэдэх үү.

Мэдэлгүй яах вэ.

Сэтгүүлчийг тэгж хэлэх тохиолдол байдаг. Редакцын удирдлага хууль эрх зүйн мэдлэгтэй байх ёстой. Тэгэхгүй бол залуу сэтгүүлчдийг чадавхыг үл харгалзан мэдээл гээд шууд явуулчихдаг. Асуудлаа сайн судалсан сэтгүүлч бол “чавхны чулуу” болсон ч байгаа зөв ононо. Гэтэл удирдлагуудаасаа буруу,

эсвэл зорилготой “чиглүүлэг” авсан сэтгүүлч хүний нүдийг тэс “цохино”. Ийм л аюултай.

Сэтгүүлчид “хоточ нохойн” үүргээ гүйцэтгэж байна уу гэвэл маш сайн гүйцэтгэж байна. Гэхдээ хоёр үзүүртэй жад барьсан гэдгээ зарим нь төдийлөн ойлгохгүй байх шиг санагддаг.

Би өнөөдөр магтуулж болно. Шагнуулж болно. Гагцхүү миний бүтээсэн бүтээл хүний эрхийг зөрчилгүй, улс эх орны тусгаар тогтнолд сөргөөр нөлөөлдөггүй байх ёстой.

Нэгэнт шар хэвлэлийн талаар дурдсаных нэг асуулт асуумаар байна. Тухайн үеийн шар хэвлэлийг хараад танд ямар бодол төрдөг байсан бэ?

Дээр таны хэлсэнчлэн чөлөөт зах зээлийг хөгжүүлэх, олон ургалч үзэл санааг нутагшуулахад томоохон түлхэц болсон. Гэвч хувь хүний нууцыг ямар ч шалгуургүйгээр нийтэд дэлгэж байгааг хараад эмзэглэдэг байлаа. Тэр хүн энэ буудал тэрэнтэй хамт байжээ гээд л... Энэ мэдээллийг хэзээ нэг цагт үр хүүхэд нь олж үзнэ, уншина. Тэр үед ямар мэдрэмж авч сэтгэл зүйд нь яаж нөлөөлөх бол. Хувь хүн өөрийн амьдралын зам мөрийг зурж, хариуцах ёстой. Үүнийг би хүлээн зөвшөөрнө. Гэвч өнөөдөр та хэн нэгэн хүний хувийн амьдрал руу өнгийж, хувийн нууцыг дэлгэж байгаа бол маргааш таны хувийн орон зайд хэн нэгэн халдана гэсэн үг. Энэ бол дан ганц сэтгүүлч биш иргэд олон нийтэд хамааралтай асуудал.

Тэр үеийн шар хэвлэл хэлбэрээ өөрчилж, олон нийтийн сүлжээ болсон юм шиг санагддаг.

Би бас тэгж боддог. Технологийн дэвшлийг зөвөөр ашиглавал өргөн хүрээтэй боломж нээж өгдөг. Харин эсрэгээр нь ашиглавал хэзээ нэг өдөр таны эрх зөрчигдөнө.

Цахим орчин дахь хүний эрхийн асуудал хурцаар тавигдаж байна. Сэтгүүлчдийн зүгээс залуу үеийн сэтгүүлчид харьцангуй хүний эрхийн мэдрэмжтэй, хууль хэрэглээний өргөн мэдлэгтэй болсон гэж дүгнэдэг. Энэ нь оргүй биш юм шиг санагддаг. Та юу гэж боддог вэ?

Би бас тэгж боддог. Цахим хэрэглээг харвал, хүний эрхийн мэдрэмжтэй байя, бусдын эрхийг зөрчихгүй байя гэж уриалж байгаа иргэдийн дийлэнх нь залуучууд байна. Тэдний цөөнгүй нь залуу сэтгүүлчид байгаа нь харагддаг. Үүнийг хараад надад “Бидний ирээдүй гэрэлтэй байна. Жаахан ч гэсэн тэднийг дэмжээд өгөх юм сан” гэдэг бодол төрдөг.

Мэргэжлийн сэтгүүл зүй, цахим орчин дахь сэтгэгдлээс ялгарах ёстой. Юун төлөө мэргэжлийн гэдэг тодотголтой билээ. Гэтэл цахим сайтуудад бичигдсэн зүйл нь иргэдийн сэтгэгдлээс ялгардаггүй. Ингэхээр л сэтгүүл зүйн

салбар “муухай” харагдаж байгаа юм л даа. Редакцын бодлоготой байх, мэргэжлийн байна гэдэг чинь өөр зүйл шүү дээ.

Монгол Улс яагаад олон улсын гэрээ, конвенцод нэгдсэн юм бэ. Хүний эрхийг баталгаажуулах гэж. Гэтэл “миний эрх” нэрийн дор бусдын эрхийг зөрчдөг байдал даамжирч байна. Байж болохгүй зүйл.

Иргэдийн боловсролд хэрэгтэй мэдээ, мэдээлэл бичиж, нийтлэхээр тоож уншиж, үзэх нь цөөн хэр нь ийм хэрэг гарчээ, тэгжээ гэж бичихээр олон зуун мянгаараа уншиж, дор бүрнээ шүүмжилж, хэлэлцүүлж байгаа харагддаг. Эндээс л шүүмжлэлтэй хандмаар санагддаг.

“Харанхуй масс” гэж ярьдаг даа. Бүдүүлэг үг. Гэхдээ үнэн нь тэр. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд иргэдийг соён гэгээрүүлэх чиглэлд төр бага анхаарч ирсэн. Бэлэн мөнгө, халамжаар угжиж ирсэн гэх юм уу даа. Ам руугаа бэлэн хоол хийлгэж ирсэн хүмүүс бусдыг шүүмжлэхээс өөр юу хийх юм бэ. 30 жилийн хугацаанд хуримтлагдсан асуудлыг засахын тулд дахиад багадаа 30 жил шаардагдах байх. Өнөөдөр 30 давхар байтугай барилгыг 1, 2-хон жилийн дотор барьж чаддаг болж. Гэтэл хүний уураг тархи дотор 30 жил хуримтлагдсан тэр оюун санааны барилгыг алдааг засахад түүнээс илүү хугацаа шаардлагатай.

Та өөрөө хүний эрхийн байгууллагад ажилладаг хүний хувьд мэдэж байгаа. Хүний эрхийн сургалтад нэг удаа хамрагдаад тэр дороо хүний эрхийн хандлагатай болчихдоггүй биз дээ. Давтан сургалтад хамрагдаж байж наад захын ойлголт, мэдлэгийг ухамсартаа тусгаж авдаг. Тэгэхээр нийт массыг зөв төлөвшилтэй болгоход хэдий хэр хугацаа, хөрөнгө хүч, хөдөлмөр зарцуулагдах нь ойлгомжтой.

Ганцхан жишээ ярья. Хүүхдийнхээ дэргэд архидан согтуурдаггүй, эсвэл элдэв зохисгүй харилцаа, хандлага гаргадаггүй эцэг, эх байна уу гээд хайгаад үзье. За бараг гарч ирэхгүй дээ. Архи уудаггүй юм гэхэд эхнэр, нөхөр болгон хүүхдийнхээ хажууд их, бага хэмжээгээр маргалддаг. Маргалдахдаа ёс бус үг хэллэг хэлдэг, бүр нэгнээ хүчирхийлдэг байх.

Танай ХЭҮК-ын Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлд гэр бүлийн хүрээнд үйлдэгдэж байгаа хүчирхийллийг баримттай нь бичсэн байна лээ. Би уншсан. Ганцхан энэ баримтаар л өнөөдрийн Монголын гэр бүл тогтолцоо ямар байгааг, хүүхдийн эрх яаж зөрчиж байгааг харж болохоор байна шүү дээ.

Багаасаа ийм орчинд өссөн хүүхэд ирээдүйд ямар харилцаа, хандлагатай болж өсөх вэ. Тиймээс л сэтгүүлч хүнд их, дээд сургуулийн боловсролоос илүүтэй гэр бүлийн хүмүүжил, суурь хүмүүжил чухал гээд байгаа юм.

Өнөөдөр миний бэлтгэсэн мэдээ, сурвалжилга маргааш, эсвэл 5, 10 жилийн дараах нийгэмд яаж нөлөөлөх вэ гэдгээ заавал бодолцох ёстой.

Дуулиан тарьснаараа алдартай, сайн сэтгүүлч болдог юм биш. Өнөөдөр хүн бүрийн оюун санаа сэргэж байна. Эерэг, зөв мэдээлэл түгээдэг сэтгүүлчийг хүндэлдэг, хөхиүлэн дэмждэг болсон. Энэ бол ахиц дэвшил.

Эрх гэдэг нь эрх, үүрэг, хариуцлагын нэгдэл гэдэгтэй та санал нийлэх үү?

100 хувь санал нийлнэ. Хүн бүр Үндсэн хуулиа ядаж нэг удаа уншаасай гэж би хүсдэг. Үндсэн хуульд та ямар эрхтэй бэ гэдгээс эхлээд хүлээх үүргийг тодорхой заасан. Танд эрх байгаа цагт үүрэг хүлээх нь ойлгомжтой. Үүрэг хүлээж байгаа бол хариуцлага гэдэг зүйл зайлшгүй яригдана.

Жишээлбэл, та орон сууцанд амьдардаг бол байрны төлбөрөө хугацаанд заавал төлөх ёстой. Гэтэл төлбөрөө төлөхгүй олон сар болбол контор өрөнд орно. Контор өрөнд орвол цахилгаан шатнаас эхлээд нийтийн эзэмшлийн талбай гэрэлтүүлэг, цэвэрлээ үйлчилгээ зогсохоос аргагүй. Миний ойрын жишээ л дээ. Олонх айл нь төлбөрөө төлөөгүй гээд цахилгаан шатны үйлчилгээг зогсоотол “Контор оршин суугчдын эрхийг зөрчлөө” гээд бөөн хэл ам болсон. Угтаа бол төлбөрөө төлөөгүй айлуудаас болж бусад айл, өрхийн эрх зөрчигдөж байгаа биз дээ. Тэгэхээр та эрх эдэлж байгаа бол үүргээ хүлээх ёстой. Энэ бол туйлын үнэн. Монголчууд үүргээ ухамсарлаагүй ард түмэн гэж би боддог.

Үүргээ ухамсарлаж, ойлгоогүй цагт хэдэн мянган хууль баталж, хүний эрх яриад хэрэггүй.

Ярилцсанд баярлалаа. Таны ажил үйлсэд амжилт хүсье.

*Ярилцсан:
ХЭҮК-ын Хэвлэл, мэдээлэл хариуцсан
мэргэжилтэн Г.Нацаг-Эрдэнэ*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН